

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



# ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2024 №01 (88)  
22 дахь жилдээ

## СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

### ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

**Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Пүрэвдорж БАТБААТАР**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бадам БАТЗОРИГ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Жигжидсүрэн БОЛДБААТАР**

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

**Галбат ГАНТӨМӨР**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

**Жамсран ДОЛГОРСҮРЭН**

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

**Думбурай МЯГМАРЦЭРЭН**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Наваанпэрэнлэй ЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Очирхуяг ЗОРИГТ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Чойжил НЯМСҮРЭН**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

**Тамжид ОЮУНЧИМЭГ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

**Заяатхүү ТӨРМАНДАХ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**ХВАН И ГАБ**

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

**Вандан-Иш АМАРСАНАА**

ДОКТОР (Ph.D)

**Улсын бүртгэлийн дугаар 237**

## СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

### ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

**Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**Вандан-Иш АМАРСАНАА**

ДОКТОР (Ph.D)

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Батсүх АЛТАНСҮХ**

ДОКТОР (Ph.D)

**Шаравдорж АРИУНБИЛЭГ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Лувсан БАТ-ОЧИР**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Сэнгээ ГАНТУЛГА**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Энхсайхан ДАШГААДАН**

ДОКТОР (Ph.D)

**Буриад ЛХАГВАРАГЧАА**

ДОКТОР (Ph.D)

**Амарсайхан МАНЛАЙ**

ДОКТОР (Ph.D)

**Жаргалсайхан МӨНХБОЛД**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Намжилдорж МӨНХЗУЛ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Бат-Ерөөл МӨНХДОРЖ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Бадарч НАРМАНДАХ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Жутьяа НЯМДУЛАМ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Шархүү ЧУЛУУНБАТ**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Батзэвэг ЭНХБОЛД**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Магмадорж ЭРДЭНЭБАЯР**

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Дорж ЭНХТӨР**

ДОКТОР (Ph.D)

## ГАРЧИГ

|                                                                                                                                                                                                   |                       |            |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|------------|
| <b>ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>                                                                                                                                      |                       |            |
| Влияние способа на систему уголовного права                                                                                                                                                       | <i>К.Д.Николаев</i>   | <b>5</b>   |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал<br>(Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн жишээн дээр) | <i>Н.Сайнбаяр</i>     | <b>7</b>   |
| Орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны хэв шинж                                                                                                                                     | <i>А.Баасанцэрэн</i>  | <b>13</b>  |
| Галт зэвсгийн ойлголт, төрөл, эрүүгийн эрх зүйн учир холбогдол                                                                                                                                    | <i>Ц.Очгэрэл</i>      | <b>18</b>  |
| Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт, түүнтэй тэмцэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал                                                                                                                | <i>У.Уранцэцэг</i>    | <b>30</b>  |
| Мөнгө угаах гэмт хэргийн субъектив шинж                                                                                                                                                           | <i>А.Хүдэр-Эрдэнэ</i> | <b>38</b>  |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг хуульчилж ирсэн түүхэн уламжлал                                                                                                | <i>С.Болдбаатар</i>   | <b>44</b>  |
| Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн ойлголт, нийгмийн аюулын шинж                                                                                                                               | <i>Б.Энхцогт</i>      | <b>53</b>  |
| Хүчиндэх гэмт хэргийн ойлголт, нийгмийн аюулын шинж                                                                                                                                               | <i>Т.Одбаатар</i>     | <b>60</b>  |
| Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн талаарх зарим асуудал                                                                                                                                           | <i>А.Мөнхбат</i>      | <b>68</b>  |
| Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн түүхэн уламжлал                                                                                                                    | <i>Б.Мягмаржав</i>    | <b>74</b>  |
| <b>КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>                                                                                                                                          |                       |            |
| Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн криминологи шинж                                                                                                                                   | <i>Б.Баярболд</i>     | <b>79</b>  |
| Гэмт хэрэгтэн бие хүний тухай ойлголт, мөн чанар                                                                                                                                                  | <i>Ш.Алтансоёмбо</i>  | <b>83</b>  |
| Өсвөр насны хүн хүчиндэх гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй зарим хүчин зүйл                                                                                                                         | <i>М.Болор</i>        | <b>91</b>  |
| Монгол Улс дахь амиа хорлох үйлдлийн нөхцөл байдал, хор уршиг                                                                                                                                     | <i>Б.Алтангэрэл</i>   | <b>96</b>  |
| Цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчлийг бууруулах арга зам                                                                                                                            | <i>Ж.Болдбаяр</i>     | <b>102</b> |
| Цахим орчинд өсвөр үеийнхнийг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах гэмт явдлын ойлголт, төрөл                                                                                                          | <i>З.Одмаа</i>        | <b>114</b> |
| Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага                                                                                                                        | <i>Т.Саруултөгс</i>   | <b>122</b> |
| <b>ХУУЛЬ САХИУЛАХҮЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>                                                                                                                                    |                       |            |
| Сургалтын онол, арга зүйн зарим асуудал                                                                                                                                                           | <i>Д.Бямбахуу</i>     | <b>127</b> |
| <b>ЭРДЭМТЭН, СУДЛААЧИЙН БАЙР СУУРЬ</b>                                                                                                                                                            |                       |            |
| Монгол Улс дахь эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн                                                                                                                                   | <i>Х.Батбаяр</i>      | <b>135</b> |

# ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ВЛИЯНИЕ СПОСОБА НА СИСТЕМУ УГОЛОВНОГО ПРАВА

### THE INFLUENCE OF THE METHOD ON THE CRIMINAL LAW SYSTEM

*К.Д. Николаев*

*Заместитель начальника кафедры уголовного права  
Омской академии МВД России кандидат юридических наук, доцент*

**Аннотация:** Рассматривается способ, как внешний системообразующий фактор уголовного права. С приведением соответствующих примеров отмечается, что в данном качестве способ оказывает существенное влияние на формирование, развитие и функционирование уголовного права, а также на принятие и применение уголовного закона.

**Abstract:** The method is considered as an external system-forming factor of criminal law. With the relevant examples, it is noted that in this capacity, the method has a significant impact on the formation, development and functioning of criminal law, as well as on the adoption and application of criminal law.

**Ключевые слова:** Система уголовного права, способ, внешний фактор, формирование, развитие, функционирование, применение уголовного закона.

**Keywords:** Criminal law system, method, external factor, formation, development, functioning, application of criminal law.

Влияние способа на систему уголовного права можно наглядно продемонстрировать, если рассматривать способ как один из внешних системообразующих факторов уголовного права. В контексте рассматриваемой проблемы следует говорить о формировании, развитии и функционировании уголовного права, а также о принятии и применении уголовного закона. Также можно говорить о способе реализации в объективной действительности мер по подготовке и принятию уголовного закона, а также мер по практическому правоприменению.

Так, под способом принятия уголовного закона следует понимать совокупность приемов, методов и процедур его разработки (подготовки) и вступления в силу. Способ применения уголовного закона – это совокупность приемов, методов и процедур непосредственного применения на практике норм уголовного права (правоприменение в уголовно-правовой сфере). Способ применения норм уголовного права включает уголовно-правовую, уголовно-процессуальную и уголовно-исполнительную составляющие.

Относительно способа принятия уголовного закона следует указать, что в настоящее время уголовный закон, являясь федеральным законом, разрабатывается и принимается в соответствии с процедурой, общей для всех федеральных законов. Согласно этой же процедуре принимаются изменения и дополнения в Уголовный кодекс Российской Федерации. В общем виде процедура принятия федеральных законов отражена в ст.ст. 105-107 Конституции Российской Федерации, а процедура вступления в силу регламентируется федеральным законом от 14 июня 1994 г. № 5-ФЗ «О порядке опубликования и

вступления в силу федеральных конституционных законов, федеральных законов, актов палат Федерального Собрания».

В случае изменения обстановки, например, при ведении военных действий, будет действовать законодательство «военного времени» и способ принятия, вступления в силу и применения уголовного закона будет иным. С целью ускорения процедуры, отдельные уголовно-правовые нормы (или соответствующие нормативные правовые акты) будут приниматься и вводиться в действие иначе, чем в настоящее время, например, указами (Верховного главнокомандующего) или постановлениями (коллегиального органа, например, Государственного комитета обороны). Вполне вероятно будут упрощены процедуры расследования и рассмотрения уголовных дел, а также приведения приговоров в исполнение. Эти «военные» способы принятия, вступления в силу и применения уголовного законодательства будут действовать до изменения обстановки, т.е. до периода окончания «военного времени», когда можно будет вновь вернуться к демократическим процедурам принятия законов.

Учитывая изложенное, способ напрямую связан с обстановкой, которая, в самом общем виде характеризуется уровнем развития производительных сил и производственных отношений, государственных и общественных институтов, юридической техники и иных обстоятельств, имеющих важное значение на определенной территории и в определенное время для уголовного права и законодательства.

Например, при определении путей развития уголовного права (или уголовного закона), при изложении формулировок конкретных уголовно-правовых норм может использоваться так называемый «гражданский активизм» (опросы, интернет-голосования, публичные дискуссии и т.д.) – активно развивающийся в настоящее время способ определения общественного мнения. При этом надо применять соответствующие методики, обеспечивающие репрезентативность выборки, и учитывать неодинаковую степень активности разных категорий граждан при выражении мнения по тем или иным вопросам (в том числе и по вопросам уголовного права). Необходимо избегать манипуляции общественным сознанием, а так же того, чтобы активное «пассионарное» меньшинство навязало свою точку зрения большинству.

На способ можно взглянуть через призму модели построения, развития и функционирования уголовного права (законодательства) в различных правовых семьях (романо-германской, англо-саксонской, мусульманской и др.). Для каждой правовой семьи присущ характерный для нее основной (генеральный) способ построения, развития и функционирования уголовного права (законодательства). Например, для романо-германской правовой семьи характерна кодификация законодательства, в англо-саксонской правовой семье существенное значение имеет правоприменительный прецедент, для мусульманской правовой семьи главенствующую роль играют религиозные нормы, которые находят прямое отражение в уголовно-правовых нормах, теснейшим образом связаны с ними (Шариат). Таким образом, для каждой правовой семьи выделяется индивидуальный, характерный для нее основной (генеральный) способ построения, развития и функционирования системы уголовного права (законодательства) и правовой системы в целом.

Итак, способ напрямую влияет на систему уголовного права, выступая внешним системообразующим фактором, существенным образом отражающемся на формировании, развитии и функционировании уголовного права, а также на принятии и применении уголовного закона.

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ  
АСУУДАЛ**  
**(Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн  
жишээн дээр)**

VEHICLE TRAFFIC SAFETY, SOME OF THE  
CRIMINAL MATTERS AGAINST THE RULES OF USE

*Н.Сайнбаяр*

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын  
эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** Нийгмийн харилцааг зохицуулж буй хууль нь ойлгомжтой тодорхой байж гэмээнэ сая олон салаа утгагүйгээр ойлгогдож, хүний эрх эрх чөлөөг хангах чухал хэрэгсэл болдог. Иймийн тулд хууль бүтээх үйл явцад салбар эрх зүйн мэргэшсэн судлаачдаас гадна, практик байгууллагын төлөөллийг түлхүү оролцуулах нь нийгмийн харилцааг оновчтой зохицуулсан хэм хэмжээ бүтээх ач холбогдолтой юм.

Сүүлийн үед батлагдан гарч байгаа зарим хууль, тэр дундаа нийгмийн чухал хэсэг харилцааг зохицуулдаг Эрүүгийн хуульд орж буй нэмэлт, өөрчлөлтүүд нь амьдралд хэрэгжихэд хүндрэл бэрхшээл үзүүлж болохуйц байдлаар боловсруулагдсан байгаад судлаачийн хувиар дүн шинжилгээ хийхийг зорьсон. Иймд энэхүү судалгааны ажлаар Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн ахуйн асуудлыг цогцоор нь авч үзсэн болно.

**Abstract:** Laws that regulate social relations can be understood without many nuances that may seem obvious and clear, and become an important tool for ensuring human rights and freedoms. For this reason, it is important to involve more representatives of practical organizations in the law-making process, in addition to specialized legal researchers, to create norms that regulate social relations optimally.

As a researcher, I aimed to analyze some of the recently approved laws, including the amendments and changes to the Criminal Code, which regulate important social relationships, that may cause difficulties in their implementation. Therefore, in this research work, the problem of the criminal household specified in the 5th section of Article 27.10 of the Criminal Law is comprehensively considered.

**Түлхүүр үгс:** Автын гэмт хэрэг, гэмт хэргийн ахуй, согтуурсан жолооч, зам тээврийн осол.

**Keywords:** Car crime, criminal life, drunk driver, traffic accident.

### **Үндсэн хэсэг**

Нийгмийн хөгжлийн асуудлыг төр зохион байгуулах голлох чиг үүрэгтэйгээр оролцдог. Энэхүү чиг үүргийнхээ хүрээнд хэрэгцээ шаардлагад нийцсэн хууль батлах замаар нийгмийн харилцааг зохицуулна.

Хууль бүтээх хэрэгцээ шаардлага нь тухайн нийгэмд үүсч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг агуулгаараа нарийн дэг журмын дагуу явагдаж, тодорхой шаардлагыг хангасан байхыг шаарддаг. Тухайлбал, аливаа хуулийн төслийн хэл зүй, найруулгын хувьд үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичсэн<sup>1</sup> байх ёстой г.м.

---

<sup>1</sup> Хууль тогтоомжийн тухай хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №25. 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь хэсэг.

Энэхүү шаардлага нь хууль тогтоогчийн зүгээс тухайн хуулийг хэрэгжүүлэгчдийн хуулийг салаа утгаар мушгин гуйвуулж, хүний эрх, эрх чөлөөнд үндэслэлгүйгээр халдах явдлыг хязгаарлах нэг төрлийн баталгаа болох учиртай. Хуулийн нэр томъёо, ухагдахуун нь шууд ойлгогдож байж сая эрх зүйн соёл, ухамсар төлөвшдөг зүй тогтолтой.

Хууль хэрэглээний тулгамдсан асуудлыг практикт хууль тогтоогчийн зүгээс тайлбар гаргах, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас тайлбар гаргах зэргээр зохицуулж болдог боловч энэ нь хууль бүтээх үйл ажиллагаанд дээрх зарчмыг баримтлаагүйг илэрхийлнэ.

Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тодорхойлон Эрүүгийн хуулиар нэг бүрчлэн зааж өгсөн. Мэдээж хувьсан өөрчлөгдөж буй цаг хугацааны эрхээр шинээр бий болж буй нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэг гэж хариуцлага хүлээлгэх асуудал ямагт байсаар ирсэн, байх ч болно.

Гэмт хэргийн зүйлчлэл, түүнийг шалгаж тогтоохтой холбоотой бүхий л асуудлыг тухайн гэмт хэргийн “ахуй” гэж тодорхойлж, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг цогцоор нь авч үзэж судлах нь илүү үр дүнтэй юм.

Гэмт хэргийн ахуйн асуудал нь тухайн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн шинж, хамаарал, уялдаа холбоог хэлж байгаа бөгөөд энэ нь практикт хэрэглээний өндөр ач холбогдолтой гэж үзсэн. Хууль бүтээх үйл ажиллагаанд мөн гэмт хэргийн ахуйн асуудлыг тусгах нь алдаатай, хийдэлтэй, олон салаа утгагүй хэм хэмжээ бий болгоход хувь нэмэртэй юм.

Хуулийн ухагдахуун, ойлголт нь практикт ноцтой гэж хэлж болохоор төөрөгдлийг бий болгох зүйл заалт Эрүүгийн хуульд багагүй байдагийн нэгэн тод жишээ нь 2023 оны 12 сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг юм.

Тухайн хэсэгт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэжээ.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн байх гэдгийг хууль хэрэглэх эрх бүхий субъектүүд харилцан адилгүй ойлгохоор байна.

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно гэж хуулийн тайлбар хэсэгт оруулжээ. Гэтэл Зөрчлийн тухай хуульд тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон<sup>2</sup>, Хуурамч улсын бүртгэлийн дугаар бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон<sup>3</sup> бол, Замын хөдөлгөөний дүрэмд

<sup>2</sup> Зөрчлийн тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24. 14.7 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг.

<sup>3</sup> Мөн тэнд. 14.7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.

хориглосон нөхцөлөөр жолооч урсгал сөрсөн<sup>4</sup>, Жолооч замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 50-иас дээш хувиар хэтрүүлсэн<sup>5</sup> зэрэг зөрчлүүдэд жолоодох эрхийг хасах шийтгэл оногдуулдаг нь дээрх зүйл заалтаар Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүйгээс гадна, эдгээр зөрчлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд заасан тайлбараар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн гэж үзэхээргүй болж байна. Ингэснээр Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 1, 2, 5 дахь хэсгийн 5.2 дахь заалт, 55 дахь хэсэгт тус тус зааснаар хариуцлага хүлээлгэх боломжгүйд хүргэж байна. Харин хуулийн тайлбарт “энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэсэн найруулга хийх нь оновчтой юм.

Хуулийн концепц нь жолооч согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, үүнийхээ төлөө хариуцлага хүлээж тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан этгээд хариуцлагын хугацаа дуусаагүй байхдаа давтан согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх агуулгаар байх ёстой байсан боловч диспозицоос өөр утга илэрхийлэгдэж байна. Жишээлбэл, 2024.02.06-ны өдөр Зөрчлийн тухай хуульд заасны дагуу согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсны улмаас 1 жилийн хугацаагаар жолоодох эрхээ хасуулсан хүн, 2025.02.06-ны өдөр хугацаа дуусаж, зохих журмын дагуу эрхээ сэргээлгэсэн гэж үзэхэд, 2030.03.04-ний өдөр согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож яваад саатуулагдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхээр байгаа.

Учир нь хуулийн диспозицид “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж заасан бөгөөд, тайлбар хэсэгтээ үүнийг ялган зөвтгөөгүйн улмаас зөвхөн энэ төрлийн гэмт хэрэгт ялтайд тооцох хугацаа гэх өмнөх Эрүүгийн хуулийн ухагдахуун хязгааргүй үргэлжлэхээр байна.

Мөн зүйлийн тайлбар хэсэгт “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промилль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промилль (%) илэрснийг ойлгоно гэж тодорхойлжээ. Согтуурсан гэх ойлголт нь цэвэр анагаах ухааны ойлголт бөгөөд хүний биеийн организмаас шалтгаалж амьсгал дахь спиртийн агууламж ижил хэмжээтэй алкоголь хэрэглэсэн ч харилцан адилгүй үр дүн тодорхойлогддог.

Хүний биеийн онцлогоос хамаарч харилцан адилгүй согтуурсан гэх хэмжээгээр тодорхой хууль зүйн үр дагавар, хариуцлага хүлээх нь Үндсэн хуульд заасан “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалттай зөрчилджээ. Өөрөөр хэлбэл, архи согтууруулах ундааны хэмжээ нь тухайн гэмт хэргийн хувьд нийгмийн аюулын шинжийг тодорхойлох чухал үзүүлэлт тул хөдөлбөргүй тогтоох шаардлагатай.

ОХУ-д гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тээврийн хэрэгслийн жолоочийн согтуурлын зэргийг тодорхойлохдоо заавал цусны шинжилгээгээр тогтооно гэсэн Улсын дээд шүүхийн тайлбар бүхий зохицуулалттай.

Амьсгал дахь спиртийн агууламж 0.2% болон түүнээс дээшхи хэмжээ нь цусанд агуулагдаж буй 0.5%-ийн промилльтой чанарын хувьд ямар харьцаатай болохыг тодорхойлох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хүн ямар хэмжээний согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед дээрх үзүүлэлтийг бий болгодог, мөн

<sup>4</sup> Мөн тэнд. 14.7 дугаар зүйлийн 30 дахь хэсэг.

<sup>5</sup> Мөн тэнд. 14.7 дугаар зүйлийн 32 дахь хэсэг.

эдгээр нь хоорондоо ямар харьцаатай зэргийг зайлшгүй тодорхойлж үзэх шаардлагатай.

Зарим хүн нас барсан тохиолдолд тухайн хүний ходоодны агууламжаас согтууруулах ундааны зүйл илэрдэг ч цусанд нэвчиж амжаагүй байдгаас тухайн хүний согтуурлын байдалд хууль зүйн дүгнэлт өгөх боломжгүйд хүрдэг.

Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн диспозицид өөр нэг хэлбэрийн үйлдэл заасан нь “согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу” шалгуулахаас зайлсхийсэн бол гэж зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, согтуурсан болон мансуурсныг шалган тогтоох тодорхой журам байхыг шаардаж, тэрхүү журмаар шалгуулахаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зайлсхийхийг хэлж буй юм.

Тэгвэл Монгол Улсын хэмжээнд согтуурсан болон мансуурсан эсэхийг тодорхойлох харилцааг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/138, А/131 дугаартай Монгол Улсын Эрүүл мэнд, Спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар “Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам”-аар зохицуулдаг аж. Мөн Цагдаагийн албаны тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаартай тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулалт, хянан шалгах журам” зэрэгт хүний согтуурсан, мансуурсан эсэхийг шалгах процессыг тусгаж өгсөн байна. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлд: Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүнийг согтуурсан, мансуурсан эсэхийг дараахь аргаар шалгана:

32.1.1.харилцан ярилцах аргаар сэтгэцийн байдал, хэл ярианы өөрчлөлт, нүдний хүүхэн харааны хэвийн байдлыг магадлах;

32.1.2.өөрийнх нь зөвшөөрснөөр шулуун шугамын дагуу алхуулж, тэнцвэрээ олж байгаа эсэхийг магадлах;

32.1.3.зориулалтын тусгай хэрэгслээр шалгах зэрэг болно. Цагдаагийн албаны хуульд зааснаар согтуурсан, мансуурсныг харилцан ярилцах байдлаар, шулуун шугамын дагуу алхуулж, тэнцвэрийг нь шалгах, мөн тусгай хэрэгслээр шалгах зэрэг аргуудыг хэрэглэж болохоор байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд цагдаагийн алба хаагчийн эрх, үүргийн талаар зааж өгсөн бөгөөд уг зүйлийн 8.2.3-д жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зориулалтын техник, хэрэгсэл ашиглан шалгаж тогтоох эрхтэй гэж заажээ. Энэ хуульд зааснаар жолоочийн согтуурсан, мансуурсныг заавал зориулалтын техник хэрэгслээр шалгахаар заасан.

Хэдийгээр салбарын хууль тогтоомжуудад жолоочийн мансуурсан, согтуурсан байдлыг шалгах харилцааг зохицуулсан байгаа ч нарийвчлан зохицуулсан “Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам”-ыг баримтлана.

Журамд заасны дагуу согтууруулах ундааны зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зориулалтын багаж ашиглаж хувь хэмжээг тодорхойлох, эсхүл шүүх эмчийн дүгнэлт гаргуулах шаардлагатай эсэхийг зориулалтын тандагч багаж ашиглан тандалт хийж болно<sup>6</sup> гэж заасан. Өөрөөр

---

<sup>6</sup> Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам. Дугаар А/138, А/131. 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр. Монгол Улсын Эрүүл мэнд, Спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан журам. 1.3 дахь хэсэг.

хэлбэл, багаж ашиглах болон шүүх эмчийн дүгнэлтээр гэсэн хоёр хувилбараар тодорхойлох зохицуулалттай байна.

Тусгай багажаар шалгах аргаар бол Стандартчилалын төв байгууллагаас баталгаажуулсан, зориулалтын багаж ашиглана<sup>7</sup>. Стандартчилалын төв байгууллагаас баталгаажуулсан баримтгүй аливаа багаж хэрэгслээр шалгасан нь тухайн жолоочийг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэж үзэх үндэслэл болохгүйг анхаарах.

Журмын 1.6-д Гэмт хэргийн шинжтэй зам тээврийн осол гарсан үед жолоочийн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зөвхөн цусан дахь агууламжаар тогтооно гэж заасан нь Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн тайлбартай зөрчилдөж байгаа хэдий ч зам тээврийн осол гарсан үед гэж заасан нь мөн зүйлийн 5 дахь хэсэгт хамаарахгүй гэж үзэж болохоор байна.

Уг журмын 2.4-д Зам тээврийн осолд холбогдсон, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээд нь шалгуулах чадваргүй, согтуурал шалгах багажаар шалгуулахаас татгалзсан тохиолдолд цус, шээснээс дээж авч, Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжилгээ хийлгэх тогтоолын хамт хүргүүлнэ гэж тодорхой заажээ. Өөрөөр хэлбэл, согтуурал шалгах багажаар шалгуулахаас татгалзсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх бус харин тухайн хүний цус, шээснээс дээж авч, Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжилгээ хийлгэх тогтоолын хамт хүргүүлэх бөгөөд ямар ч тохиолдолд тандагч багажаар эсхүл цусны шинжилгээгээр согтуурлын хэмжээг заавал тодорхойлохыг зааж өгсөн байна. Иймд Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу” шалгуулахаас зайлсхийсэн гэх үйлдлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нь харагдаж байна.

Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тодорхойлж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны асуудал хэдий ч тухайн үйлдлийг тодорхой, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой томъёолсноор хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах бас нэгэн чухал арга хэрэгсэл болдгийг мартах учиргүй.

### **Дүгнэлт**

Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт хийв. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн диспозиц, тайлбар хэсэг нь утга зүйн хувьд оновчтой бус байна. Учир нь тус хуулийн диспозицид “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж заасан бөгөөд, тайлбар хэсэгтээ үүнийг ялган зөвтгөөгүйн улмаас зөвхөн энэ төрлийн гэмт хэрэгт ялтайд тооцох хугацаа гэх өмнөх Эрүүгийн хуулийн ухагдахуун хязгааргүй үргэлжлэхээр байна. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн гэж урьд өмнө нь болон тухайн үед хасуулсан зэрэг нөхцөл байдлыг ялган зааглаагүй байна.

2. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын хүрээнд Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан диспозицид заасан обьектив талын “согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн” гэх үйлдлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ямар ч боломжгүй ажээ.

3. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд тусгасан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэх тайлбарын үр дүнд Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн зөрчлөөр хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл үүсчээ.

---

<sup>7</sup> Мөн тэнд. 1.4 дэх хэсэг.

4. Зөрчлийн шинжтэй үйлдлийг давтан гаргах нь гэмт хэрэгт тооцогдох анхны тохиолдол бөгөөд зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн эсэх нь гэмт хэрэгт тооцоход нөлөөлөхгүй нь шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна гэж үзэхээр байна.

### **Санал**

Дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн диспозицоос “согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн” гэх үйлдлийг хасах;

2. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэх тайлбар хэсэгт “... эрх хассан хугацаа нь дуусаагүй байгаа” гэх нэмэлтийг оруулж, шинээр найруулах;

3. Мөн “тайлбар” хэсэгт “Уг тайлбар нь Зөрчлийн тухай хуульд хамаарахгүй” гэх агуулгыг нэмж хуульчлах зэрэг болно.

### **Ашигласан материал**

1. Хууль тогтоомжийн тухай хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №25.

2. Зөрчлийн тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

3. Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам. Дугаар А/138, А/131. 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр. Монгол Улсын Эрүүл мэнд, Спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан журам.

# ОРЧИН ҮЕИЙН ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ХЭВ ШИНЖ

## MODERN INTERNATIONAL CRIMINAL LAW SYSTEM PATTERNS

*А.Баасанцэрэн  
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн  
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,  
цагдаагийн хурандаа*

**Товч агуулга:** Өгүүлэлд олон улсын эрх зүйн бүлийн тухай ойлголт, ангиллын талаарх судлаачдын үзэл баримтлал дээр үндэслэн, тухайн эрх зүйн бүлүүдийн тогтолцооны төсөөтэй болон ялгаатай шинжүүдийг судалж, нээн илрүүлэхийг зорилоо.

**Abstract:** The article aims to explore and discover similarities and differences in the system of legal groups based on researchers' views on the concept and classification of international legal families.

**Түлхүүл үгс:** Ром-Германы, Англи-Саксоны ба Социалист эрх зүй, Еврей ба мусулманы эрх зүй, тогтолцоо систем, авторитар улс төрийн дэглэм, эрх зүйн бүл, эрх зүйн хэв маяг, шинж.

**Keywords:** Romano-Germanic, Anglo-Saxon and socialist law, Jewish and Muslim Law, System Systems, authoritarian political regimes, legal families, legal styles and characteristics.

Эрх зүйн тогтолцооны типологи (ангилал) гэдэг нь үндэсний эрх зүйн тогтолцоог тодорхой шалгуураас хамааран төрлөөр нь хуваарилахыг хэлэх, хэвшмэл зүйл юм.

Шинжлэх ухаанд эрх зүйн тогтолцоо (legal families)-ны ангилал маш өөр байдаг. Орчин үеийн эрх зүйн тогтолцоонд зориулсан хамгийн том бүтээл бол Францын хуульч Рене Давидын “Орчин үеийн эрх зүйн үндсэн тогтолцоо (1964)” бүтээл гэж үздэг<sup>8</sup>. Энэ зохиогч нь хууль, эрх зүйн техник, үзэл суртлын онцлогийг харгалзан, хуулийн зургаан гэр бүлийг тодорхойлдог бөгөөд гурван үндсэн эрх зүйн (Ром-Герман, Англи-Саксон ба Социалист эрх зүй) бүл ба үндсэн бус гурван хууль (Мусульман, Хинду, Еврей) зэрэг юм. Германы эрдэмтдийн хоёр боть цуглуулгад К.Цвайгерта и Х.Кетца хувийн эрх зүйн чиглэлээр харьцуулсан “Хууль зүйн танилцуулга (1961-1969)”<sup>9</sup> бүтээлд Ромын, Германы, Скандинавын, нийтлэг хууль, социалист хууль, Алс Дорнодын эрх зүй, Исламын эрх зүй, Хинду эрх зүй гэх найман эрх зүйн бүлийг харгалзан, эрх зүйн хэв маягт ялгаж байна.

Оросын зарим хуульч, эрдэмтэд мөн хууль, эрх зүйн тогтолцооны ангилсан байдаг. Тухайлбал, С.С.Алексеев “Хуулийн онол (1994)” бүтээлдээ Ром-Германы хууль, Англи-Саксоны хууль, Ази, Африкийн хэд хэдэн орны шашны болон нийтийн эрх зүйн тогтолцоо, авторитар улс төрийн дэглэмийн дагуу эрх зүйн тогтолцоог тодорхойлжээ<sup>10</sup>. Оросын өөр нэг эрдэмтэн М.Н.Марченко “Харьцуулсан эрх зүйн чиглэл (2008)” бүтээлдээ Ром-Герман, Англи-Саксоны эрх зүйн тогтолцоо,

<sup>8</sup> Рене Давида. Основные правовые системы современности. 1964 г.

<sup>9</sup> Цвайгерта К., Кетца Х. Введение в сравнительное правоведение в сфере частного права. 1961-1969 гг.

<sup>10</sup> Алексеев С.С. Теория права. 1994 г.

социалист ба пост-социалист орнуудын эрх зүйн тогтолцоо, шашны эрх зүйн тогтолцоо, Еврей ба Лалын эрх зүй гэсэн ангилал дэвшүүлсэн байдаг<sup>11</sup>.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд орчин үеийн эрүүгийн эрх зүйн тогтолцооны ангиллыг эрх зүйн тогтолцооны ерөнхий хэв шинжийн (Өмнө дурдсанчлан, ийм хуваагдлын хэд хэдэн шалгуур байдаг: үзэл суртал, түүх, эх сурвалж) үндсэн дээр санал болгож байна. Тиймээс эрдэмтэн А.В.Наумов Р.Давидын үзэл бодлыг үндэс болгон авч, “Оросын эрүүгийн эрх зүй: лекцийн курс (2004)” бүтээлийнхээ эхний ботид эрүүгийн эрх зүйн дараах үндсэн тогтолцоог нэрлэжээ. Үүнд:

- Ром-Герман;
- Англи-Саксон;
- Социалист;
- Муслим<sup>12</sup>.

“Гадаад орнуудын Эрүүгийн эрх зүй (2008)” сурах бичгийн зохиогчдын санал болгосон өөр ангиллын дагуу гэр бүлүүдийг ялгаж үздэг. Үүнд:

- Нийтлэг эрх зүй;
- Эх газрын эрх зүй;
- Шашны (Лалын) эрх зүй;
- Олон нийтийн эрх зүй;
- Зан заншлын эрх зүй<sup>13</sup>.

Эрх зүйн тогтолцоо, тэр дундаа эрүүгийн эрх зүйн тогтолцооны хэв шинж харьцангуй байгааг дээрх ангиллаас харж болно. Хэрэв бид хуулийн социалист систем гэж нэрлэдэг бол хөрөнгөтний системийн талаар ярих естой, хэрэв бид Лалын систем гэж нэрлэдэг бол Христийн шашны (каноник систем) тухай ярих естой, хэрэв бид Англи-Саксоны системийг онцолсон бол Ираны системийг санаж болно гэх мэт.

*Ром-Германы эрх зүйн бүл* (Түүний хоёр дахь нэр нь Иргэний хууль) нь эртний Ром, Ромын эзэнт гүрэн нуран унасны дараа Баруун Европт амьдарч байсан Герман овог аймгуудтай холбоотой юм. Энэ нь Европ тивийн мужуудад (үүнтэй холбогдуулан үүнийг эх газрын хуулийн систем гэж нэрлэдэг), түүнчлэн бусад зарим мужуудад, жишээлбэл, Францын хуучин колониудад өргөн тархсан байдаг. 1810 оны Францын эрүүгийн хууль, XIX зууны Германы Эрүүгийн хууль тогтоомж нь энэ тогтолцоог бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Ром-Германы эрх зүйн тогтолцооны онцлог шинжүүд:

- Бичсэн хуулийг эрэлхийлэх, хуулийг Эрүүгийн хуулийн цорын ганц норматив эх сурвалж гэж хүлээн зөвшөөрөх, Эрүүгийн хуулийн заалтуудыг кодчилох, түүнчлэн жишиг, зан заншлын хуулиас татгалзах;

- Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг маш ерөнхий томъёолох (нэлээд өргөн хүрээний үйлдэлд хэрэглэх зориулалттай)-ыг шаарддаг, эрүүгийн эрх зүйн хориглолтын хийсвэр тайлбарыг эрүүгийн эрх зүйн үзэл санаагаар илэрхийлсэн.

*Англи-Саксоны эрх зүйн бүл* нь Ром улс нуран унасны дараа Британийн арлуудад амьдардаг овог, аймгууд (англ ба саксон)-аас нэрээ авсан (энэ хуулийн тогтолцооны хоёр дахь нэр нь нийтлэг хууль юм) байдаг. Энэ нь АНУ, Канад, Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг болон бусад зарим оронд, жишээлбэл Их Британийн хуучин колониудад түгээмэл байдаг.

Англи-Саксоны эрх зүйн тогтолцооны онцлог шинжүүд:

---

<sup>11</sup> Марченко М.Н. Курс сравнительного правоведения. 2008 г.

<sup>12</sup> Наумов А.В. Российское уголовное право: Курс лекций. 2004 г.

<sup>13</sup> Наумов А.В. Уголовное право зарубежных стран. 2008 г.

- Энэ нь хууль тогтоомжоос гадна үүссэн шүүхийн ёс заншил хэлбэрээр үүссэн;

- Түүнд хуулийн кодчилсон салбар байхгүй;

- Ирээдүйд бус, харин өнөө үед чиглэсэн, одоо байгаа хуулийн хэм хэмжээний тодорхой бус байдал, хохирол;

- Тодорхой хэргүүд дээр асар олон тооны шүүхийн шийдвэр хуулийн эх сурвалж болж байгаа нь дараа дараагийн хэргүүдийг авч үзэхэд жишиг хэм хэмжээ байсан.

Эцэст нь хэлэхэд, сүүлийн үед хуулийн ерөнхий тогтолцоонд бичгийн хуулийн үүрэг, хуулийн эх газрын тогтолцоонд шүүхийн практик нэмэгдэж байгаа чиг хандлагын талаар хэлэх хэрэгтэй.

*Социалист эрх зүйн бүл* нь ЗХУ-ын хууль гэж ОХУ-д 1917 оны 10 дугаар сарын буюу октябрын хувьсгалын үр дүнд үүссэн.

Түүний өвөрмөц онцлог:

- Коммунист үзэл суртал ноёрхож байгааг хүлээн зөвшөөрөх;

- Коммунист намын бодлогод хуульд захирагдах;

- Ангийн байдал.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа социалист эрх зүй ЗХУ-аас гадна бусад зарим мужуудад бий болсон. ЗХУ задран унаснаар Оросын эрх зүй, тэр дундаа эрүүгийн эрх зүй, эх газрын эрх зүйн тогтолцоонд эргэн орж, социалист эрх зүй БНХАУ, БНАСАУ, Куба, Вьетнамд үлджээ.

*Исламын эрх зүйн бүл* нь Лалын шашин-Исламын шашны салшгүй хэсэг юм. Энэ нь дундад зууны үед (VII-VIII зуун) үүссэн. Үүний дараа түүний түүхэнд тогтвортой байдлын үе ирэв. Гэсэн хэдий ч, XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн лалын шашинт олон орны эрүүгийн эрх зүй 1810 онд Францын Эрүүгийн кодчилогдсон (Наполеоны Эрүүгийн эрх зүй), Итали, Английн нийтлэг хуулийн хэм хэмжээн дээр суурилсан үед эрх зүйн “Баруунжилт” эхэлсэн юм.

XX зууны дунд үеэс эхлэн хуулийг Исламчлах ажил эхэлсэн бөгөөд энэ нь одоо Саудын Араб, Иран, Пакистан, Ливи, Судан, Афганистан (Талибаны хяналтан дор) гэх мэт орнуудад түгээмэл ажиглагдаж байна.

Исламын эрх зүйн өвөрмөц онцлог:

- Шариатын хэм хэмжээ, өөрөөр хэлбэл, Исламын эрх зүй, теологийн хэм хэмжээний багц, Коран сударт үндсэндээ хууль тогтоомжийн эх сурвалж, түүнчлэн хууль тогтоох, хууль сахиулах практикт тусгагдсан болно;

- Архаизм, casuistry, бичгээр системчилсэн хэм хэмжээ дутмаг.

Исламын Бүгд Найрамдах Иран улс (IRI)-ын жишээг ашиглан Шийтийн сүсэгтнүүд 1979 оноос хойш эрх мэдэлтэй байсан бол лалын шашны хуулийн ийм шинж чанарыг шашин шүтлэгийн үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдал гэж тэмдэглэж болно. Тиймээс Ираны Эрүүгийн хуульд зааснаар, лалын шашинтан бус хүнийг алах нь цаазаар авах ял оноодог боловч, шийтгэлээс чөлөөлөх боломжтой хэвээр байна. Өөр нэг жишээг дурдахад, Эрүүгийн хуульд Муслим эмэгтэйтэй завхайрсан мусульман хүнд 100 сормуус хэлбэрээр шийтгэл оногдуулахаар заасан боловч Муслим эмэгтэйн эсрэг Муслим бус хүний ижил үйлдэл нь цаазаар авах ялтай. Мусульман бус эмэгтэйн эсрэг лалын шашинтнуудын үйлдсэн завхайрлын төлөө Ирилагийн Эрүүгийн хуульд ямар ч хариуцлага хүлээлгэхгүй байгаа нь гайхах зүйл биш юм.

*Олон нийтийн эрх зүйн бүл* нь бүхэлдээ Азийн зүүн хэсэгт өргөн тархсан байдаг. Өөрөөр хэлбэл, Алс Дорнод, Зүүн өмнөд Азийн орнуудад түгээмэл тархжээ. Энэ бүлийн хамгийн том төлөөлөгчид бол Хятад, Солонгос, Япон улс юм. Эдгээр орны эрх зүй нь нийгмийн үзэл санаагаар тодорхойлогддог бөгөөд энэ нь эв найрамдал, эвлэрэл, зөвшөөрлийн санаа гэсэн үг юм. Нийтлэг сайн, сайхныг энд

хувь хүний ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж ирсэн. Бидний үед ч гэсэн Күнзийн үзэл суртал нь өөрчлөгдөөгүй хэвээр байгаа бөгөөд нийгмийн гол нэгж нь ахмадууд, багачуудын онцгой харилцаатай бүл бөгөөд аливаа дургүйцлийг хориглодог. Ийм дэг журам тогтооход гол ач холбогдол нь ёс суртахуун, үзэл бодол, боловсрол, шүүмжлэлийн хэм хэмжээтэй холбоотой байдаг тул хуулийг хүмүүсийн хооронд дэг журам тогтоох туйлын арга гэж үздэг уламжлалтай.

Ерөнхийдөө энэ бүлийн орнуудад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээ нь нарийн төвөгтэй бөгөөд Ром-Герман (Япон), социалист (Хятад, Вьетнам), Англи-Саксон (Хонконг), Лалын (Индонез, Малайз) эрх зүйн тогтолцооны элементүүдийг агуулдаг. Үүний зэрэгцээ, эдгээр орнуудын хууль, эрх зүйн үзэл суртал нь нийгмийн үзэл санаа, үүрэг, ёс суртахуун, хүндэтгэлийн уламжлалт үзэл санаанд нөлөөлсөөр байна.

*Зан заншлын эрх зүйн бүлд* ихэвчлэн Төв ба Өмнөд Африкийн орнууд, түүний дотор Мадагаскар арал багтдаг. Эдгээр орнуудын хууль, эрх зүйн тогтолцоо нь зан заншилд дуулгавартай байх замаар тодорхойлогддог (өвөг дээдсийн ой санамжийг хүндэтгэх, байгалийн хүчнээс айх гэх мэт), мөргөлдөөнд оролцогч талуудыг эвлэрүүлэх санаа, гэр бүлийн санаа (сүүлийнх нь зөвхөн тодорхой ёс зүйн дүрмийг зөвшөөрдөг төдийгүй тэдгээрийг дагаж мөрдөхийг хянадаг).

Зан заншлын эрх зүйн түүх нь төрийн өмнөх (колончлолын өмнөх), колончлолын ба төрийн (тусгаар тогтнолын үе шат) гэсэн гурван үе шатыг дараалан дамжин өнгөрчээ. Өнөөдөр Африкийн улсуудын үндэсний эрх зүйг (Исламын хойд ба Алс Өмнөд хэсгээс бусад) бүхэлд нь дуалист (эсвэл эрлийз) гэж тодорхойлж болох бөгөөд зан заншлын эрх зүйн хэм хэмжээ нь зөвхөн хууль, эрх зүйн мэдлэгийг тодорхойлдог төдийгүй Ром-Герман, эсвэл Англи-Саксоны эрх зүйн тогтолцооны хэм хэмжээтэй зэрэгцэн оршдог, мөн тэдгээрийн зарим нь, жишээлбэл, Соломоны арлуудад заншлын хууль үүнийг хуулийн албан ёсны эх сурвалж гэж хүлээн зөвшөөрдөг байна.

### **Дүгнэлт**

1. Монгол Улсад 1921 оноос өмнө зан заншлын эрх зүй давамгайлж байсан бол 1921-1990 оны хооронд зан заншил, ёс суртахуун, Ром-Герман, Социалист эрх зүйн шинжийг давамгайлсан хууль тогтоомж мөрдөгдөж ирсэн нь 1924 онд Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль, 1926 оны анхны Шүүх цаазны бичиг (орчин үеийн нэршлээр “Эрүүгийн хууль” гэх болсон) нь Коминтерны даалгавраар ЗХУ-ын хуулийг хуулбарлан, хэрэглэж ирсэнтэй холбоотой байна.

2. 1990 оноос хойш Монгол Улсын өнөөгийн эрх зүйн тогтолцоо нь зарим төрлийн хуульд дээрх олон төрлийн эрх зүйн шинжээс Ром-Герман, Англи-Саксон ба Социалист эрх зүй, Олон нийтийн эрх зүй, Зан заншлын эрх зүйг агуулсан шинжтэй байна. Нэг талаас, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэх боловч зарим асуудлыг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлах, иргэн хүн ямар нэгэн байдлаар хохирсон гэж үзвэл, шууд шүүхэд гомдол гаргах нь Англи-Саксоны эрх зүйн бүлийн шинжийг агуулж байна.

3. Ёс зүй, ёс суртахуун, зан заншлын хэм хэмжээг хэтэрхий хуульчлах явдал сүүлийн жилүүдэд гарч байгаа нь нэг талаас ард иргэдийг эрх зүйн ухамсар муутай байдлаас шалтгаалах боловч, нөгөө талаас хэтэрхий хуульчлах, ёс зүйн хэм хэмжээ, эрх зүйн хэм хэмжээний ялгаатай байдал алдагдахад хүрч байна.

### **Ашигласан материал**

1. Алексеев С.С. Теория права. 1994 г.
2. Марченко М.Н. Курс сравнительного правоведения. 2008 г.

3. Наумов А.В. Российское уголовное право: Курс лекций. 2004 г.
4. Наумов А.В. Уголовное право зарубежных стран. 2008 г.
5. Рене Давид. Основные правовые системы современности. 1964 г.
6. Цвайгерта К., Кетца Х. Введение в сравнительное правоведение в сфере частного права. 1961-1969 гг.

# ГАЛТ ЗЭВСГИЙН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ

## THE CONCEPT AND TYPES OF FIREARMS, AND THEIR CRIMINAL LEGAL SIGNIFICANCE

*Ц.Очгэрэл  
ДХИС-ийн докторант,  
цагдаагийн хурандаа*

**Товч агуулга:** Өгүүлэлд галт зэвсгийн хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэрэгтэй хийх тэмцлийн хүрээнд галт зэвсгийн ойлголт, төрөл, тэдгээрийн эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг нээн гаргах оролдлогыг хийлээ.

**Abstract:** In the article, an attempt was made to discover the concepts and types of firearms and their criminal law significance in the context of the fight against crimes related to the illegal circulation of firearms.

**Түлхүүр үгс:** зэвсэг, галт зэвсэг, галт зэвсгийн хууль бус эргэлт, галт зэвсгийн зориулалтын шинж, галт зэвсгийн чанарын шинж, галт зэвсгийн эрх зүйн шинж.

**Keywords:** weapons, firearms, illegal trafficking of firearms, purpose characteristics of firearms, quality characteristics of firearms, legal characteristics of firearms.

Хүн төрөлт бодгаль эволюци хөгжлийнхөө эхэн үед ан ав хийж хоол хүнсээ бэлтгэх, бусад руу халдан довтолж эзэмшил нутгаа тэлэх, өөрийгөө болон омог нэгтнээ аюул заналаас хамгаалах зорилгоор мод, чулуу, хүрэл зэрэг «хүйтэн» зэвсэг хэрэглэж байсан болох нь археологийн болон антропологийн олдворуудаар баттай нотлогдож байх бөгөөд түүхийн шинжлэх ухаанд хүний хөгжлийн эрт баларын эдгээр мөчлөгийг «чулуун зэвсгийн», «хүрэл зэвсгийн», «төмөр зэвсгийн» үеүд хэмээн нэрлэж хэвшжээ.

Харин дарины тэсрэх хүчний тусламжтайгаар «галт» (халуун) зэвсэг бий болгон ашиглаж эхэлсэн нь харьцангуй хожуу үед (960-1279) хамаарна. XIV-XV зууны үеэс дарь, сум, буудах төхөөрөмж бүхий галт зэвсэг хийж эхэлсэн бөгөөд энэ үеэс «галт зэвсгийн эрин» эхэлсэн хэмээн судлаачид<sup>14</sup> үзэж байна. Улмаар 1800-аад оноос эхлэн гар буу, винтов зэрэг бууны хийц, эд ангиуд сайжирч, цэргийн зэвсэглэлд нэвтэрч эхэлсэн байдаг. Энэ цаг үеэс эхлэн галт зэвсэг улам бүр боловсронгуй болж, хөнгөн авсаархан байхын сацуу түүний хөнөөх чадвар нь нэмэгдсээр иржээ.

XX зуунд өрнөсөн дэлхийн дайнууд, түүнчлэн техник-технологийн хөгжлийн шууд нөлөөлөл дор аж үйлдвэр өндөр хөгжсөн улс орнуудад зэвсгийн үйлдвэрлэл эрчимтэй өрнөж, XXI зууны эхний он жилүүдэд үйлдвэржилтийн үйл явц нь улам бүр хурдасч ирсэн нь зэвсгийн хууль ёсны болон хууль бус эргэлтийг урьд өмнө байгаагүй хэмжээнд буюу огцом тэлэлтийн хэмжээнд хүргэсэн билээ.

<sup>14</sup> Хүү-Ухна А. Зэвсэглэлийн түүх: орчин үе, хэтийн төлөв. Уб., 2016. 11 дэх тал.

Зэвсгийн эргэлт, түүний хэлбэрийн талаарх асуудлыг хөндөхийн өмнө зэвсгийн тухай, ялангуяа түүний нэг төрөл болох галт зэвсгийн талаарх ойлголтыг нээн гаргах шаардлагатай хэмээн үзлээ.

«Зэвсэг» гэх үг нь (орос. - оружие), (англ.- weapon, armament) акад. Б.Чадраагийн «Монголын үндэсний нэвтэрхий толь» -д «дайсны амьд хүч, түүний техник төхөөрөмжийг устгахад хэрэглэдэг хэрэгслийн нэр»<sup>15</sup>; акад. С Нарангэрэлийн «Эрх зүйн эх толь бичиг»<sup>16</sup>-т «зэвсэг бол нийтлэг утгаараа хамгаалах болон довтлоход ашигтай төхөөрөмжлөгдсөн техникийн аливаа хэрэгсэл» гэсэн утгатай гэж бичжээ.

Монгол Улсын хууль тогтоомжид «зэвсэг» гэдэг ерөнхий ухагдахууныг хуульчилсан тодорхойлолт тусгалаа олоогүй байдаг бөгөөд харин Галт зэвсгийн тухай хуульд<sup>17</sup> «галт зэвсэг» гэж дарины шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг; «галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл» гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг; «сум» гэж галт зэвсэгт зориулагдсан хонгио, бялт, дарин цэнэг, хошуу бүгд нэг биет болж угсрагдсан, эсхүл гол төмөрт хийж буудлага үйлдэх зориулалттай бүрдэл хэсгийг ойлгоно гэж заажээ.

Акад. С.Нарангэрэл Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд «зэвсэг» хэмээх ерөнхий ойлголтыг «галт зэвсэг» гэх тухайлсан явцуу ойлголтоор төлөөлүүлэн тусгаж хуульчилсан нь олон улсын түвшинд зэвсгийн тухай эрх зүйн ойлголтыг нээн гаргахад учир дутагдалтай, зарим ойлголт, тодорхойлолтыг нэгтгэж орхигдуулсан болох нь «Зэвсгийн тухай»<sup>18</sup> Холбооны хуульд (ОХУ) тусгасан заалтуудтай харьцуулан үзэхэд харагдаж байна. Монгол Улсын «Галт зэвсгийн тухай хууль»-аас гадна «Зэвсгийн тухай ерөнхий хууль» байхгүй байгаа нь эрх зүйн томоохон хийдэл юм<sup>19</sup> гэж үзсэн нь анхаарал татаж байна.

А.Н.Лебедевийн<sup>20</sup> үзэж байгаагаар гол төмөр, цохигч механизм, цэнэгийг тэслэх төхөөрөмж зэрэг нь нэгдмэл бүтээцийг үүсгэж, техникийн үндэс нь дарины тэсрэх хүчийг (эсвэл түүний орлуулагчийг) ашиглан хүний биед гэмтэл учруулах нөхцлийг бүрдүүлж байгаа л бол энэ нь хичнээн энгийн, болхи хийцтэй төхөөрөмж байсан ч үүнийг галт зэвсэг гэж үзэхээс өөр аргагүй юм.

Дээр дурдсанаас үүдэлтэйгээр хийн буу (пневматик зэвсэг), түүнчлэн дарин цэнэгээс өөр эх үүсвэр ашиглан буудлага үйлддэг орчин үеийн зарим зэвсгийн

<sup>15</sup> Чадраа Б. Монголын үндэсний нэвтэрхий толь (Mongolian national encyclopedia). УБ., 2009. 627 дахь тал.

<sup>16</sup> Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг (Dictionary of Law). УБ., 2007. 222 дахь тал.

<sup>17</sup> Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2015). //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015. №31.

<sup>18</sup> Федеральный закон РФ «Об оружии» от 13.12.1996. №150-ФЗ.

<sup>19</sup> Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг (Dictionary of Law). УБ., 2007. 222 дахь тал.

<sup>20</sup> Лебедев А.Н. Об огнестрельном оружии как предмете посягательства на общественную безопасность. // Вестник Московского университета. Серия 11. Право. 1977. №1. С. 73.

төрлийг (цөмийн, лазерийн, гэрлийн г.м.) галт зэвсэгт хамааруулах нь оновчтой бус хэмээн В.Д.Малков<sup>21</sup> үзсэн байдаг.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд «галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл» гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг ойлгохоор заасан байдаг. Бидний үзэж байгаагаар «галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл» нь дарины тэсрэх хүчний тусламжтайгаар бус, шахсан хийн үйлчлэлээр, эсвэл нумны тийрэлтийн хүчээр сумыг хөдөлгөөнд оруулдаг тул «галт» зэвсгийн шинжийг огт агуулахгүй байна. Ийм тул эдгээр төрлийн зэвсгийг галт зэвсэгтэй адилтган авч үзэх боломжгүй юм.

Галт буюу хөнөөх хүчин чадал ихтэй «халуун» зэвсгээс ялгаатай нь хийн буу, нум сум, арбалет (хавчаахай, хөндлөн нум) зэрэг нь хөнөөх чадал багатай, дарины тэсрэх хүчийг ашигладаггүй тул судлаачид гол төлөв эдгээрийг галт зэвсгийн ангилалд оруулдаггүй, зарим тохиолдолд «хүйтэн зэвсэг» гэж авч үзсэн байна.

Ю.Ткачевский<sup>22</sup> «галт зэвсэг гэж винтов буу (түүн дотроо бага калибрын), янз бүрийн системийн гар буу (түүн дотроо бага калибрын), гар буу – пулемет (пистолет-пулемет), тайрмал винтов буу зэргийг хэлнэ» гэж энгийнээр тайлбарласан байна.

«Иргэд галт зэвсгийг олж авах, хадгалах гэмт явдалд хяналт тавих тухай Европын жишиг конвенци»<sup>23</sup>-д «галт зэвсэг гэж зэвсгийн чанартайгаар бэлтгэсэн, тохируулж тоногдсон, тугалга, сум, үрэл, бусад хэрэглэл, хорт хий, шингэн болон бусад бодисыг тэсрэлтийн, хийн, агаарын даралтын тусламжтайгаар, эсхүл өөр аргаар (эдгээрийн аль нэг нь байж болох) түлхэн гаргаж чадах (зөвхөн зарим нь тэсрэлтийн түлхэх хүчийг ашиглах) аливаа зүйлийг ойлгоно» гэж тодорхойлсон байна. Уг конвенцид галт зэвсгийн ойлголтыг хэт өргөн хүрээтэйгээр, байг ямар аргаар устгахаас үл хамааран галт зэвсэгт тооцож болохоор тайлбарласан байдаг.

Европын жишиг (хүрээ тогтоосон) конвенцид зарим улс, түүний дотор Монгол Улс, нэгдэн ороогүй тул түүний заалтууд бидний тухайд хууль зүйн учир холбогдол бага юм.

Хураан авсан төхөөрөмж, хэрэгсэл нь галт зэвсэг мөн эсэхийг тодорхойлох хүлээн зөвшөөрөгдсөн, тогтсон шалгуур өнөө хэр байхгүй байгаа нь гэмт хэргийг зүйлчлэх үед алдаа гарах магадлалыг бий болгодог. М.С.Пестуны<sup>24</sup> үзэж байгаагаар галт зэвсэг мөн болохыг илтгэх гол шинж нь тухайн төхөөрөмж, хэрэгсэл нь дайралт хийх, довтлох, өөрөөр хэлбэл, амьд хүчийг устгах шинжийг агуулж байгаа эсэхэд оршиж байдаг.

Үүнээс үзэхэд галт зэвсэг нь:

а) амьд байг зайнаас, механикаар устгахад зориулагдсан байх;

---

<sup>21</sup> Малков В.Д. Хищение огнестрельного оружия, боевых припасов и взрывчатых веществ. М., 1971. С.36.

<sup>22</sup> Ткачевский Ю. Ответственность за хищение оружия, боевых припасов и взрывчатых веществ. // Сов. юстиция, 1968. №7. С.19.

<sup>23</sup> Иргэд галт зэвсгийг олж авах, хадгалах гэмт явдалд хяналт тавих тухай. Европын жишиг конвенц. (Страсбург, 28.06.1978).

<sup>24</sup> Пестун М.С. Понятие самодельного огнестрельного оружия. М., 1964. С.178.

б) дарин болон бусад цэнэгийн шаталтаар үүссэн энергийн хүчний тусламжтайгаар чиглэсэн хөдөлгөөнд орсон (ниссэн) сум байг устгадаг байх.

Бидний үзэж байгаагаар дээрх шалгуур нь өнөө цагт дэлхийд эргэлтэнд буй зориулалт, техникийн бүтэц, механизмын ажиллах зарчим зэргээс үл хамааран асар олон загвар, систем, төрлийн галт зэвсгийг хамруулан авч үзэх боломжийг олгож байна.

Нөгөө талаас техник, технологийн хөгжил, дэвшил нь зэвсгийг тасралтгүй сайжруулах, шинэ загварыг бүтээх хүчин зүйл болж, эдгээрийн үр дүнд шинэ шинэ галт зэвсэг бий болсоор байгаа тул хатуу тогтсон шалгуур, шинжээр галт зэвсгийн ойлголтыг зааглах, тодорхойлох боломж улам бүр хязгаарлагдаж байна.

Хууль зүйн ном бүтээл, түүнчлэн шүүхийн практикт «галт зэвсэг»-ийн эрүүгийн эрх зүйн ойлголтыг нэгтгэж буй үндсэн, чухал дараах шинжүүдийг нэрлэж байна: Үүнд: зориулалтын шинж (байг устгахад зориулагдсан байх) болон эрх зүйн шинж орж байна. Эдгээр шинж нь ямар ч галт зэвсэгт илэрч байдаг болохыг тэмдэглэх хэрэгтэй.

Харин А.Васецов<sup>25</sup> аливаа хэрэгсэл, эд зүйл галт зэвсэг мөн болохыг тодорхойлоход дараах гурван шинжийн нийлбэр зайлшгүй хэмээн үзэж байна. Үүнд: 1) галт зэвсгийн зориулалтын шинж; 2) галт зэвсгийн чанарын шинж; 3) галт зэвсгийн эрх зүйн шинж; орох бөгөөд түүний үзэж байгаагаар эрүүгийн эрх зүйд «галт зэвсэг» гэдэг нь амьд болон бусад байг устгахаар тусгайлан бүтээсэн, ийнхүү устгах хүчин чадалтай, түүнийг бэлтгэх, биедээ авч явах, ашиглахад төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл шаардагддаг хэрэгсэл, зүйл юм.

Мөрдөн байцаалтын практикт «хураан авсан буу нь бүрэн эвдэрсэн, үүний улмаас буудлага үйлдэх боломжгүй тул галт зэвсгийн чанарын шаардлагыг хангахгүй байна» гэсэн шинжээчийн дүгнэлтээр хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдол байдаг.

Л.Д.Гаухман «галт зэвсэг» гэдэг нь цэнэгийн тэсрэлтийн үед үүссэн хийн даралтын хүчээр сумыг шидэж, зөвхөн амьд байг устгахаар зориулагдсан, тохируулж тоногдсон, ахуйн өөр зориулалт үгүй, биедээ авч явах, ашиглах эрх авахын тулд дотоод хэргийн байгууллагын тусгай зөвшөөрөл шаардагддаг зүйл юм<sup>26</sup> гэж үзжээ.

Дээр дурдсанд үндэслэн дүгнэж үзвэл зориулалтын шинж нь – үндсэн, чанарын шинж нь - нэмэгдэл, эрх зүйн шинж нь – үүсмэл шинжтэй гэж хэлж болохоор байна.

Галт зэвсгийн зориулалтын шинж нь галт зэвсгийг бэлтгэх, үйлдвэрлэх үеэс эхлэн хийц, эд ангийн бүтээц зэрэгт тусгайлан суулгаж өгсөн, тэдгээрийн онцлог, өвөрмөц байдлаар илэрхийлэгдэх галт зэвсгийн үндсэн шинж юм. Зориулалтын шинж нь тухайн эд зүйл, хэрэгслийг бэлтгэсэн аргаас нь үл хамааран түүнийг галт зэвсэг болохыг тодорхойлох үндсэн шинж байдаг. Монгол Улсын Галт зэвсгийн

---

<sup>25</sup> Васецов А. Закон РФ Об оружии и квалификация преступлений, совершаемых с применением оружия. // Рос.юстиция. 1995. №2. С. 37.

<sup>26</sup> Гаухман Л.Д. Борьба с насильственными посягательствами. М., 1969. С. 39; Курс советского уголовного права. Т.6. С. 338;

тухай хуулиар галт зэвсгийн зориулалтыг «амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах» хэмээн заажээ.

Тийм учир амьд биетийг гэмтээх, хөнөөх устгахад галт зэвсгийн бүтээц, хийц, эд ангийн онцлог бүрэн зориулагдсан байна гэсэн үг юм. Галт зэвсгийн бүтээцийн зориулалт нь түүнийг зохион бүтээх, турших, бэлтгэх явцад бүрэн илрэн гарч ирдэг онцлогтой.

В.Е.Зварыгин<sup>27</sup> галт зэвсгийн зориулалтын шинжийн талаар сонирхолтой жишээ татсан байдаг. Тухайлбал, сүхээр хүнийг гэмтээж болно, гэхдээ сүх бол мод хагалахад зориулагдсан эд (түүний бүтээцийн онцлог нь ч үүнийг илэрхийлдэг). Тийм болохоор «Зэвсгийн тухай» Холбооны хуулийн үзэл санаагаар сүх яав ч галт зэвсэг биш юм. Энэ нь зориулалтын шинж галт зэвсгийн үндсэн шинж болохыг нотолж байна.

В.Д.Малков<sup>28</sup> галт зэвсэг бүтээцийн онцлог, гадаад хэлбэр (гар буу, тайрмал буу, бянт бүхий гол төмөр залгаж төхөөрөмжилсөн буу, түүнчлэн автомат үзэг, тамхи асаагуур болон бусад эд зүйлээр халхавчилсан төхөөрөмж) зэргээс үл хамааран амьд байг устгахад зориулагдсан байдаг гэж үзжээ.

Ийнхүү Л.Д.Гаухман, В.Д.Малков, М.С.Пестун нар галт зэвсэг нь 1) байг устгахад; 2) амьд байг (амьд хүчийг) устгахад; зориулагдсан гэж үзсэн нь анхаарал татаж байна.

Харин А.Васецов галт зэвсэг нь «амьд болон бусад байг устгахаар тусгайлан зориулагдсан хэрэгсэл, зүйл» гэж үзсэн байдаг. Монгол Улсын хууль тогтоомжоор галт зэвсэг нь «амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгахад» зориулагдсан тухай дээр дурдсан билээ.

Галт зэвсэг нь байг устгахад зориулагдсан гэж үзвэл дохионы болон гарааны буу нь гэрлэн болон дуун дохио өгөх зориулалттайн хувьд галт зэвсэгт хамаарахгүй юм.

«Зэвсгийн тухай» Холбооны хуульд (ОХУ) «зэвсэг» гэж «амьд болон бусад байг устгах, дохио өгөхөд бүтээцийн хувьд зориулагдсан төхөөрөмж, зүйл» гэж үзсэн байдаг.

Үүнтэй холбоотойгоор эрүүгийн эрх зүйн ном бүтээлд зарим судлаач байр сууриа илэрхийлсэн байдаг. Тухайлбал, дохионы бууг зэвсэг хэмээн үзсэн нь хуулийн алдаа юм. Учир нь дохионы хэрэгсэл нь амьд байг устгахад бус гэрлэн, утаан, дуун дохио өгөхөд зориулагдсан байдаг. Хуулийн энэ тодорхойлолтоор бол дохио өгөхөд зориулагдсан бүхий л төхөөрөмж, хэрэгслийг, жишээлбэл, автомашины дуут дохионы төхөөрөмж, цагдаагийн шүгэл, замын уулзвар дээрх гэрлэн дохио зэргийг зэвсэг гэж үзэхээс өөр аргагүй болно. Ийм тул «Зэвсгийн тухай» (1996) Холбооны хуулиас дохионы зэвсгийн ойлголтыг хасах, өөр байдлаар тодорхойлох хэрэгтэй гэж үзжээ.

«Иргэд галт зэвсгийг олж авах, хадгалах гэмт явдалд хяналт тавих тухай Европын жишиг конвенци» -д уг асуудлыг өөр байдлаар шийдвэрлэсэн байдаг.

<sup>27</sup> Зварыгин В.Е. Незаконный оборот огнестрельного оружия: уголовно-правовой и криминологический аспекты. Дисс. ...канд. юрид. наук. Ижевск., 2002. С.15.

<sup>28</sup> Малков В.Д. Хищение огнестрельного оружия, боевых припасов и взрывчатых веществ. М., 1971. С.12.

«Галт зэвсэг» гэсэн ойлголтоос түгшүүрийн болон бусад дохио өгөх зориулалттай аливаа хэрэгслийг хассан байдаг. Гэхдээ эдгээр хэрэгслийг дохио өгөх зориулалтаар нь ашигласан үед энэ нь галт зэвсэг биш болохыг зааж өгсөн байдаг. Энэ конвенцийн дагуу хэрэв эдгээр хэрэгслийг дохио өгөхөөс гадна эрүүл мэндэд гэмтэл учруулах зорилгоор ашигласан бол энэ тохиолдолд дохионы буу нь галт зэвсэг мөн юм.

Галт зэвсэг нь амьд байг устгахад зориулагдсан гэж үзвэл ахуйн, үйлдвэрлэлийн болон бусад зориулалттай янз бүрийн буудах төхөөрөмжүүд, тухайлбал, барилгын гар буунууд (хадаас хадах, хатуу гадаргуйг нүхлэх зориулалттай) зэргийг буудлагын энергийг ашигладаг хэдий ч галт зэвсэгт хамруулан ойлгож болохгүй юм. Учир нь эдгээр бууны зориулалт төдийгүй, бүтээцийн элементүүд нь амьд байг устгах хэрэгсэл биш болохыг харуулдаг.

Зэвсэгтэй төсөөтэй хэлбэр, бүтэцтэй ахуйн ба үйлдвэрлэлийн зориулалттай, мөн спортын зарим бүтээгдэхүүн, тухайлбал алх, сүх, сахлын хутга, бейсболын цохиур зэрэг нь эрүүгийн эрх зүйн ойлголтын хувьд «Зэвсгийн тухай» (1996) Холбооны хуульд заасан «зэвсгийн чанартай зүйл», Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан «тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл» гэсэнтэй дүйцэхээр байна.

Мөрдөн байцаалтын практикаас үзэхэд гэмт хэрэгтнүүдийн гэмт хэрэг үйлдэх үед ашигласан эд зүйл нь үйлдвэрийн хийцийн зарим загварын зэвсгээс ч илүү хөнөөл, хор хохирол учруулах явдал гардаг бөгөөд энэ тохиолдолд хэрхэн шийдэх асуудал онолын хувьд ч, арга зүйн хувьд ч тодорхойгүй байсаар байна хэмээн А.П.Литвин<sup>29</sup> үзсэн байдаг.

Тухайн тохиолдолд зэвсгийн чанартай ашигласан зүйл нь зэвсгийн нэгэн адил амьд биетэд хөнөөл учруулах чадвартай гэдэг өнцгөөс асуудалд хандах нь шүүхийн практикт олонтоо байна. Гэхдээ зэвсэг болон зэвсгийн чанартай ашигласан зүйлийг ижилсгэж ойлгож болохгүй юм. Учир нь тухайн зүйлийн шинж (эрүүл мэндэд хохирол учруулах чадвар) гэдэг нь нэг зүйл, харин тухайн зүйлийн зориулалт, түүнээс үүдэлтэй бүтээцийн онцлог гэдэг бол өөр зүйл юм. Эдгээрээс хамааран тэдний эрүүгийн эрх зүйн учир холбогдол ялгаатай байдаг. Бусад зүйлийг зэвсгийн чанартай ашиглах нь гэмт хэргийн хор уршгийг нөхцөлдүүлэх ба энэ нь гэмт хэргийн үйлдлийн аргыг тодорхойлж өгдөг. Үйлдлийн арга, түүнээс үүдсэн хор уршгаас гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ ихээхэн хамааралтай.

Галт зэвсэг нь нийгмийн хор аюулын чанарын шинжийг өөрчлөх боломж олгодгоороо онцлогтой, өөрөөр хэлбэл, тодорхой төрлийн гэмт хэрэг (олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг) нь учруулсан хохирлоос үл хамааран заавал бус объекттой бүрэлдэхүүн (факультатив) мөн эсэхийг тогтооно гэсэн үг юм.

---

<sup>29</sup> Литвин А.П. Некоторые вопросы уголовно-правовой борьбы с преступлениями, связанными с незаконным владением огнестрельным и холодным оружием, боевыми припасами и взрывчатыми веществами (Проблемы дальнейшего укрепления законности в деятельности ОВД). Киев., 1984. С.135.

Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг хэвтээ төвшинд ангилсан 2 дахь ангилалт байдаг ба энэ нь шууд объектод хамаатай<sup>30</sup>.

Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг нь нийгмийн хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн эрх ашиг, сонирхолд шууд халдаж хор уршиг учруулсан байх ба ийм гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд давхар объекттой гэмт хэрэг гэж нэрлэдэг. Давхар объекттой гэмт хэргийн улмаас халдлагад өртөж байгаа хэд хэдэн шууд объектыг тэдгээрийн шинж чанарыг харгалзан: а) үндсэн ; б) нэмэгдэл; в) давхар буюу заавал бус; гэж ангилна.

Энэ ангилал нь гэмт этгээдийн үйлдлийн улмаас зөрчигдсөн хэд хэдэн шууд объектоос аль нь үндсэн объект болохыг тогтоох, үүнд үндэслэн гэмт хэргийг зөв зүйлчлэхэд ач холбогдолтой байдаг<sup>31</sup>.

Хэрэв дээрэмдэх гэмт хэргийн үед царилыг айлган сүрдүүлэх зорилгоор ашигласан бол давхар объект үүсэхгүй, харин зөвхөн үндсэн шууд объект (өмчлөх эрхийн эсрэг харилцаа) ба нэмэгдэл шууд объект (хүний эрүүл мэндийн эсрэг харилцаа) үүснэ. Гэтэл гэмт хэргийн үед галт зэвсэг ашигласан бол үндсэн болон нэмэгдэл объектын сацуу, давхар объект (олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг) үүснэ.

Чухам үүнд галт зэвсгийн (амьд байг устгах) зориулалтын шинжийн эрүүгийн эрх зүйн учир холбогдол оршиж байна гэж үзэж болно. Л.Д.Гаухман, А.Н.Лебедев болон бусад эрдэмтэд галт зэвсэг нь зөвхөн амьд байг устгах зориулалттай гэж үзсэн нь ч үүнтэй холбоотой юм.

Гэтэл «Зэвсгийн тухай» (1996) Холбооны хуульд галт зэвсэг нь байг механикаар устгах зориулалттай зүйл гэж үзсэн, гэхдээ ямар байг устгах зориулалттай болохыг огт дурдаагүй орхисон нь эрүүгийн эрх зүйн онол, практикын хүрээнд асуудал үүсгэж байна гэж зарим судлаач үзжээ.

Галт зэвсгийг дээр дурдсанаар тайлбарлах нь галт зэвсгийг ахуйн шинжтэй болон бусад зориулалттай зүйлээс ялган зааглах боломжийг үгүйсгэж байна гэж В.Д.Малков<sup>32</sup> үзэл бодлоо илэрхийлээд «Зэвсгийн тухай» хуульд «зэвсэг», «галт зэвсэг»-ийн ойлголтыг шинэчлэн дараах байдлаар тодорхойлох саналыг дэвшүүлсэн байна.

Түүний үзэж байгаагаар «зэвсэг» гэдэг нь бүтээцийн хувьд амьд байг устгах зориулалттай, түүнчлэн бусад байг устгах, дохио өгөх зориулалтаар ашиглаж болох төхөөрөмж, хэрэгсэл юм. Харин «галт зэвсэг» гэдэг нь амьд байг зайнаас, дарины болон бусад цэнэгийн энергийн тусламжтайгаар чиглэсэн хөдөлгөөнд орсон сумаар, механикаар устгах зориулалттай зэвсэг юм гэж үзсэн нь эрүүгийн эрх зүйн хувьд оновчтой томъёолол мэт санагдаж байна.

Галт зэвсгийн чанарын шинж нь зориулалтын шинжийн нэмэгдэл шинж болж тайлбарлагдана. Галт зэвсгийн тусгай зориулалт, түүнтэй нөхцөлдсөн бүтээцийн онцлогууд нь эдэлгээний явцад алдагдаж, өөрөөр хэлбэл, эвдэрч элэгдэж болно. Гэхдээ галт зэвсгийг хэрэглэхэд тэр нь буудлага үйлдэх бүрэн

<sup>30</sup> Авхиа Ж., Ганболд Б. Хүн амины гэмт хэргийн зүйлчлэлийн зарим асуудал. // Эрдэм судлал сэтгүүл. 2003. №2. 54 дэх тал.

<sup>31</sup> Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Уб., 2011. 47 дахь тал.

<sup>32</sup> Малков В.Д. Хищение огнестрельного оружия, боевых припасов и взрывчатых веществ. М., 1971. С.20.

чадамжтай, эд анги, бүтээцийн хэсгүүд нь гох дээр дарсны дараа даринь тэсрэлт үүсгэх, сум, үрлийг гол төмрөөс шидэж гаргах боломжийг олгох техникийн нөхцлийг хангасан байх учиртай юм.

Эрүүгийн хуульд галт зэвсэг бүрэн ажиллагаатай байх шаардлагыг тусгаагүй байдаг, учир нь галт зэвсэг (төхөөрөмж, хэрэгсэл)-ийг амьд байг устгахаар бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, уг зориулалтдаа нийцэж байгаа, өөрөөр хэлбэл, уг галт зэвсгээр буудлага үйлдэж болох тохиолдолд түүнийг хууль бус эргэлтэд оруулсны төлөө эрүүгийн хариуцлага үүсдэг.

«Галт зэвсгийн буудлага үйлдэх чадамж» гэдэг нь галт зэвсгийг зориулалтын дагуу ашиглаж болох, эсхүл зориулалтын дагуу ашиглах нөхцлийг бүрдүүлж болох (эвдрэл, гэмтлийг нь засварлах замаар хөнөөл учруулах шинжийг нь сэргээх) байдал юм.

Тийм тул, зориулалтын дагуу ашиглах бодит боломжтой, түүгээр буудлага үйлдэж болохоор байгаа бол галт зэвсэг (төхөөрөмж, хэрэгсэл)-ийг буудлага үйлдэх чадамжтай зэвсэг гэж ойлгож болно. Хэрэв хураан авсан зэвсэг нь буудлага үйлдэх боломжийг үгүйсгэсэн эвдрэл, гэмтэлтэй байгаа бол гэм буруутанд Эрүүгийн хуулийн 20.4., 20.5., 20.6. дугаар зүйлүүдэд заасан хариуцлагыг оногдуулж болохгүй.

Гэхдээ эвдрэл, гэмтэл, элэгдлийн учир зэвсэглэлээс хасагдсан боловч засвар үйлчилгээ хийсний дараа буудлага үйлдэх чадамжтай болсон галт зэвсгийг хууль бус эргэлтийн зүйл гэж үзэхээс аргагүй юм.

Галт зэвсэг нь буудлага үйлдэх чадамжтай, эсхүл зориулалтын дагуу ашиглах нөхцлийг бүрдүүлсний дараа (засвар, үйлчилгээ хийсний дараа) буудлага үйлдэх чадамжтай болох, түүнчлэн галт зэвсэг хадгалагч нь тийм санаа зорилготой (засварлаж ашиглах) байгаа тохиолдолд галт зэвсэг хууль бусаар хадгалсан үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулна.

Хэрэв буудлага үйлдэх чадамжгүй галт зэвсгийг буудлага үйлдэх чадамжтай болгох санаа зорилго агуулалгүйгээр түүнтэй холбоотой ямар нэгэн хууль бус үйлдэл хийсэн тохиолдолд үүнийг нийгмийн хор аюултай үйлдэл гэж үзэхгүй.

Галт зэвсгийн буудлага үйлдэх чадамж нь зөвхөн нэг удаагийн буудлага үйлдэх боломжоор бус нэг дор хэд хэдэн удаа буудлага үйлдэх боломжоор үнэлэгдэнэ гэж В.Тихий<sup>33</sup> үзсэнтэй бид санал нийлэхгүй байна. Учир нь энэ байр суурь зэвсгийн чадамжийн тухай ойлголтыг хэт явцууруулж байна. Хэрэв галт зэвсгээр нэг удаа буудлага үйлдэж болж байвал тэр нь галт зэвсгийн шинж чанараа алдаагүй байна гэсэн үг бөгөөд гэмт хэрэг үйлдэх, тэр тусмаа хүнийг алах зэрэг хүнд гэмт хэргийг үйлдэх техникийн боломж нь хадгалагдаж байна гэсэн үг юм.

Ийм тул галт зэвсгийн буудлага үйлдэх чадамж нь хамгийн наад зах нь нэг удаа буудлага үйлдэх боломжоор, эсвэл тодорхой нөхцөл бүрдүүлсний дараа (засварласны дараа) буудлага үйлдэх боломжтой болох байдлаар тодорхойлогдоно.

---

<sup>33</sup> Тихий В. Уголовная ответственность за небрежное хранение огнестрельного оружия. // Сов. Юстиция. 1977. №13. С.26.

Тодорхой төхөөрөмж, хэрэгсэл галт зэвсэг мөн эсэхийг тодорхойлох, тэр нь амьд байг устгах чадамжтай эсэхийг тогтооход тусгай мэдлэг шаардагдана. Эдгээр тохиолдлуудад шүүх-баллистикийн шинжилгээг хийж дээрх асуудлуудыг шийдвэрлэнэ.

Э.Тенчовын үзэж байгаагаар галт зэвсэг буудлага үйлдэх чадамжтай эсэх нь шинжээчийн дүгнэлтээр болон өөр гэмт хэрэг үйлдсэн баримтаар тогтоогдоно<sup>34</sup>. Жишээлбэл, өмнө нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан галт зэвсгийг хэсэг хугацааны дараа хураан авахад уг галт зэвсэг нь буудлага үйлдэх чадамжгүй болох нь тогтоогдсон хэдий ч, уг галт зэвсгээр өмнө нь гэмт хэрэг үйлдэх үед буудлага үйлдэж байсан (буудлага үйлдэх чадамжтай байсан) гэж үзэж, бүрэн ажиллагаатай галт зэвсэг хууль бусаар хадгалсан үйлдэлд хариуцлага оногдуулна.

Галт зэвсгийн буудлага үйлдэх чадамж нь гэмт хэрэгтний хүсэл зориг, ухамсраар мөн тайлбарлагдана. Хэрэв гэмт хэрэгтэн буудлага үйлдэх чадамжгүй галт зэвсэг олж авснаа ухамсарлаагүй (галт зэвсгийг хэвийн ажиллагаатай гэж найдсан) тохиолдолд галт зэвсгийг олж авах халдлага төгс гүйцэтгэгдсэн үйлдэл гэж зүйлчлэгдэнэ. Хэрэв хэн нэгэн илт ажиллагаагүй галт зэвсэг олж авснаа ухамсарласан, түүнийг буудлага үйлдэх чадамжтай болгох санаа зорилго агуулаагүй тохиолдолд энэ үйлдэл нь гэмт шинжгүй гэж үзнэ. Учир нь энэ нь зэвсгийн чанарын шинжийг агуулаагүй тул галт зэвсэг биш юм.

Хэрэв хэн нэгэн галт зэвсэг олж авахдаа энэ нь буудлага үйлдэх чадамжгүй болохыг мэдсэн атлаа түүнийг засварлах замаар буудлага үйлдэх чадамжтай болгох санаа зорилго агуулсан бол үйлдлийн эрүүгийн эрх зүйн үнэлгээ нь төхөөрөмж, хэрэгсэл нь галт зэвсэг мөн эсэхийг тогтоосон шинжээчийн дүгнэлт, түүнийг засварлах замаар буудлага үйлдэх бодит боломж үүсэх эсэхээс хамаарна. Хэрэв галт зэвсэг тухайн мөчид ажиллагаагүй байх боловч, тодорхой эд ангийг нэмж тоноггосноор буудлага үйлдэх боломж үүсэхээр бол галт зэвсгийг хууль бусаар олж авсан үйлдэл гэж үзнэ.

В.Д.Малковын үзэж байгаагаар, хэрэв тухайн төхөөрөмж, хэрэгсэл нь шүүх-баллистикийн шинжилгээгээр галт зэвсэг биш гэж тогтоогдсон ч энэ тохиолдолд галт зэвсэг олж авах халдлага илт хийгдсэн, түүний зэрэгцээ галт зэвсэг хууль бусаар бэлтгэхэд бэлдсэн гэж үзнэ<sup>35</sup>.

Галт зэвсгийн эрх зүйн шинж нь галт зэвсэгтэй холбоотой эрх зүйн онцгой дэглэм үйлчилж байдагт оршино. Энэ нь иргэд, байгууллага галт зэвсэг олж авах, хадгалах, түүнийг зарим субьектэд албаны зорилгоор тавьж олгох тусгай зөвшөөрлийн систем юм.

Галт зэвсэг нь бусад эд зүйлээс эргэх чадвараараа ялгаатай. Иргэний эрх зүйн хувьд объектын эргэх чадвар нь түүнийг шилжүүлэх боломжоор илэрхийлэгдэх ба үүнээс үүдэн объектыг 1) чөлөөт эргэлтэнд буй; 2) хязгаарлагдмал; 3) эргэлтээс хураан авсан; гэж 3 ангилна.

<sup>34</sup> Тенчов Э. Рассмотрение судами дел о незаконном ношении, хранении, изготовлении или сбыте оружия или взрывчатых веществ. // Сов. Юстиция. 1972. №20. С. 13.

<sup>35</sup> Малков В.Д. Хищение огнестрельного оружия, боевых припасов и взрывчатых веществ. М., 1971. С. 13.

Иргэний өмчлөлд байгаа объектын эрхийг хязгаарлаагүй, эсвэл эргэлтээс хураан аваагүй бол эрх дамжуулах байдлаар бусдад шилжүүлж (өвлүүлж) болно.

Галт зэвсэг нь чөлөөт эргэлтэд байдаггүй объектод хамаарна. Зарим төрлийн галт зэвсэг хязгаарлагдсан эргэлтэд, зарим нь иргэний эргэлтээс гарсан байна.

Иргэний хууль тогтоомжийн дагуу зарим объект иргэний эргэлтийн зөвхөн зарим оролцогчдод хамааралтай байх ба түүнийг өмчлөх, эзэмшигчээс хөндийрүүлэх харилцаа нь зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжинэ.

Галт зэвсэг болон галт хэрэгсэл нь зөвхөн зөвшөөрөл бүхий хэрэглэгчдэд олгогдох бүтээгдэхүүний жагсаалтанд орсон байх ба уг жагсаалтыг Засгийн газар батална. Эргэлтээс хураан авсан галт зэвсгийг бусдад шилжүүлж, зарж борлуулж болохгүй.

Эрх зүйн шинжээрээ галт зэвсэг 2 ангилагддаг: 1) хязгаарлагдмал эргэх чадвартай; 2) эргэлтээс хураан авсан;

Эхний тохиолдолд эрх зүйн онцгой дэглэм (зөвшөөрлийн харилцаа) нь олон нийтийн аюулгүй байдлын ашиг сонирхлоор галт зэвсгийн эргэлтийг зохицуулж буйтай холбоотой байна.

Хоёрдахь тохиолдолд эрх зүйн онцгой дэглэм (зэвсэг үйлдвэрлэхтэй холбоотой зөвшөөрлийн харилцаа) нь батлан хамгаалах хүчин чадал, улсын аюулгүй байдлыг хангах төрийн монопол үйл ажиллагаатай холбоотой байна.

Галт зэвсгийн эрх зүйн шинж нь түүний зориулалтын болон чанарын шинжээс үүсмэл байна. Учир нь галт зэвсгийн тусгай зориулалт, бүтээцийн онцлог, түүнчлэн буудлага үйлдэх чадамж зэрэг нь эрх зүйн онцгой дэглэм (галт зэвсгийн эргэлт дэх хязгаарлалттай байдал болон эргэлтээс хураан авсан байдал)-ийг нөхцөлдүүлнэ.

Тийм болохоор зөвхөн эрх зүйн, зориулалтын ба чанарын шинжүүдийн нийлбэр нь галт зэвсэг нь хууль бус эргэлтийн зүйл мөн эсэхийг тодорхойлох боломжийг олгох ба эдгээрийн аль нэг шинж нь үгүй бол уг төхөөрөмж, хэрэгсэл нь галт зэвсэг мөн гэж үзэх боломжийг үгүйсгэж байна

Ийнхүү галт зэвсгийн ойлголтыг тодруулах явцад түүний олон төрөл, зүйл байгаа болох нь тогтоогдож буйн зэрэгцээ мөрдөн байцаалт, шүүхийн практик, эрүүгийн эрх зүйн учир холбогдол талаас нь судалж үзвэл шийдвэрлэгдээгүй тулгамдсан олон асуудал амь бөхтэй оршсоор байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль (2015) шинэчлэн найруулагдаж батлагдсанаар Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хуулиар хангах, галт зэвсэг, сумны эргэлтэд хяналт тавих, аюулгүй ажиллагааг мөрдүүлэх боломж бүрдсэн бөгөөд «галт зэвсэг, сум»-ны хуульчилсан ойлголтыг өгөх, тэдгээрийг ангилах, галт зэвсгийн эргэлтийг тэдгээрийн зориулалтыг харгалзан хязгаарлах зэрэг харилцааг зохицуулж эхэлсэн билээ.

## **Дүгнэлт**

1. Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд «галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл» гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг ойлгохоор заасан байдаг. Бидний үзэж байгаагаар «галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл» нь дарины тэсрэх хүчний тусламжтайгаар бус, шахсан хийн үйлчлэлээр, эсвэл нумны тийрэлтийн хүчээр сумыг хөдөлгөөнд оруулдаг тул «галт» зэвсгийн шинжийг огт агуулахгүй байна. Ийм тул эдгээр төрлийн зэвсгийг галт зэвсэгтэй адилтган авч үзэх боломжгүй юм.

2. Техник, технологийн хөгжил, дэвшил нь зэвсгийг тасралтгүй сайжруулах, шинэ загварыг бүтээх хүчин зүйл болж, эдгээрийн үр дүнд шинэ шинэ галт зэвсэг бий болсоор байгаа тул хатуу тогтсон шалгуур, шинжээр галт зэвсгийн ойлголтыг зааглах, тодорхойлох боломж улам бүр хязгаарлагдаж байна.

3. Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийг эрүүгийн эрх зүй, цэргийн эрх зүй болон харьцуулсан эрх зүйн хүрээнд цаашид үргэлжлүүлэн судлах, ялангуяа зэвсгийн ойлголтыг бүрдүүлж буй онолын үндэслэлүүдийг гүнзгийрүүлэн судлах, боловсруулах, галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой практик судлалын эх сурвалжуудад дүн шинжилгээ хийх, тэдгээрт судлаачдын анхаарлыг хандуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага оршсоор байна.

## **Ашигласан материал**

1. Авхиа Ж., Ганболд Б. Хүн амины гэмт хэргийн зүйлчлэлийн зарим асуудал. // Эрдэм судлал сэтгүүл. 2003. №2.
2. Васецов А. Закон РФ Об оружии и квалификация преступлений, совершаемых с применением оружия. // Рос.юстиция. 1995. №2.
3. Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Уб., 2011.
4. Гаухман Л.Д. Борьба с насильственными посягательствами. М., 1969. С. 39; Курс советского уголовного права. Т.6. С. 338;
5. Зварыгин В.Е. Незаконный оборот огнестрельного оружия: уголовно-правовой и криминологический аспекты. Дисс. ...канд. юрид. наук. Ижевск., 2002.
6. Иргэд галт зэвсгийг олж авах, хадгалах гэмт явдалд хяналт тавих тухай. Европын жишиг конвенц. (Страсбург, 28.06.1978).
7. Лебедев А.Н. Об огнестрельном оружии как предмете посягательства на общественную безопасность. // Вестник Московского университета. Серия 11. Право. 1977. №1.
8. Литвин А.П. Некоторые вопросы уголовно-правовой борьбы с преступлениями, связанными с незаконным владением огнестрельным и холодным оружием, боевыми припасами и взрывчатыми веществами (Проблемы дальнейшего укрепления законности в деятельности ОВД). Киев., 1984.
9. Малков В.Д. Хищение огнестрельного оружия, боевых припасов и взрывчатых веществ. М., 1971.
10. Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2015). //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015. №31.
11. Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг (Dictionary of Law). Уб., 2007.
12. Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг (Dictionary of Law). Уб., 2007.
13. Пестун М.С. Понятие самодельного огнестрельного оружия. М., 1964.

- 14.Тенчов Э. Рассмотрение судами дел о незаконном ношении, хранении, изготовлении или сбыте оружия или взрывчатых веществ. // Сов. Юстиция. 1972. №20.
- 15.Тихий В. Уголовная ответственность за небрежное хранение огнестрельного оружия. // Сов. Юстиция. 1977. №13.
- 16.Ткачевский Ю. Ответственность за хищение оружия, боевых припасов и взрывчатых веществ. // Сов. юстиция, 1968. №7.
- 17.Федеральный закон РФ «Об оружии» от 13.12.1996. №150-ФЗ.
- 18.Хүү-Ухна А. Зэвсэглэлийн түүх: орчин үе, хэтийн төлөв. Уб., 2016.
- 19.Чадраа Б. Монголын үндэсний нэвтэрхий толь (Mongolian national encyclopedia). Уб., 2009.

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

## THE CONCEPT OF DOMESTIC VIOLENCE, HISTORICAL TRADITION

У.Уранцэцэг  
ДХИС-ийн магистрант

**Товч агуулга:** Өгүүлэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг үе үеийн эрүүгийн хууль, шүүх цаазны бичиг болон эртний эх сурвалжуудад хэрхэн хуульчилсан талаарх уламжлалыг судлах замаар, түүхэн үечлэлийг шинжлэн, орчин үеийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлохыг зорилоо.

**Түлхүүр үгс:** Гэр бүл, гэр бүлийн гишүүн, хүчирхийлэл, заналхийлэл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч.

**Abstract:** The article seeks to identify contemporary conditions and trends by examining the traditions of how domestic violence has been legalized in contemporary criminal law, judicial texts, and ancient sources.

**Keywords:** Family, Family member, violence, threats, guardian.

Хүн төрөлхтний түүхээс харахад, гэр бүлийн зорилго нь гишүүдийнхээ болон нийгмийн сайн сайхан байдлыг хадгалах явдал<sup>36</sup> ба гэр бүл нь хүнийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх төв болгон ашигладаг<sup>37</sup> байна. Харин гэр бүлийн үндсэн чиг үүргүүдийн нэг бол биологийн болон нийгмийн үүргийн хувьд хүмүүсийн үйлдвэрлэл, нөхөн үржихүйн тогтолцоог бүрдүүлэх явдал юм<sup>38</sup>.

Гэр бүлийн харилцааны хэвийн байдлыг хангах, хамгаалах бодлого төрийн бодлогын хамгийн чухал асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогддог төдийгүй, монголчуудын “Төрийн хэлхээ өрх гэр, төрлийн хэлхээ эцэг, эх” гэж ярьдаг нь гүн утга агуулгатай билээ.

Профессор Т.Намжил “Гэр бүл бол эр, эмийн харьцаагаар гол цогц болгосон эцэг, эх, үр хүүхэд зэргийг багтаасан, гэр, төрлийн хоорондох харьцааны нийгмийн зохион байгуулалтын хэлбэр<sup>39</sup>, профессор Ш.Сүхээ “Гэр бүл гэдэг нь эр, эмийн болон цусан төрлийн холбоонд үндэслэн, гишүүд нь ахуй амьдралын нийтлэг тал, ёс зүй, зан суртахууны хувьд бие биеийнхээ өмнө хүлээх хариуцлага, харилцан туслалцаанд тулгуурласан харилцаа”<sup>40</sup> гэж тус тус тодорхойлжээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй, халдашгүй, дархан байх эрхтэй”<sup>41</sup> хэмээн жам ёсны эрхийг нь бататган, хэнийг ч зовоон тарчилгах, харгис хэрцгий, хүний ёсноос гадуур харьцах явдал, эрүү шүүлт тулгах, шийтгэхийг хориглосон байдаг бол гэр бүлийн хүчирхийлэл нь дээрх

<sup>36</sup> Alhussain, Khalid, Shah, Drishti, Thornton, James, Kelly, Kimberly. Familial Opioid Misuse and Family Cohesion: Impact on Family Communication and Well-being. Addictive Disorders & Their Treatment 2019;18(4): p 194–204.

<sup>37</sup> Lander L, Howsare J, Byrne M. The impact of substance use disorders on families and children: from theory to practice. Soc Work Public Health. 2013; 28:194–205.

<sup>38</sup> Schneider, David. A Critique of the Study of Kinship. Ann Arbor: University of Michigan Press. 1984. P 182.

<sup>39</sup> Намжил Т. Монголын гэр бүлийн харилцааны уламжлал, шинэчлэлийн зарим асуудлууд. Эрдэм шинжилгээний, судалгааны ажлын эмхэтгэл. Уб., 1998. 226 дахь тал.

<sup>40</sup> Сүхээ Ш. Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлал, дэвшлийн асуудал. 1988. 68 дахь тал.

<sup>41</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Уб., 1946. 3 дугаар зүйл.

хориглолтоос хальж, гэр бүлийн гишүүдийн халдашгүй, чөлөөтэй байх эрхээс гадна бусад эрх, ашиг сонирхолд халдаж байдаг.

Хэдийгээр гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг олон улсын хэм хэмжээ, эрх зүйн баримт бичгээр хамгаалсан боловч гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий нийтэд тулгамдсан, түгээмэл асуудал болж ирсэн нь нууц биш бөгөөд, эмэгтэйчүүдийн 70 хувь нь амьдралынхаа явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байжээ.

Гэр бүлийн хүрээнд аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүй хэмээх түгээмэл тогтсон тодорхойлолт бий. Уг ойлголтыг судлаач Б.Хулан, Н.Энхчимэг нар “Энэ ойлголт нь гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал гэж үздэг уламжлалт хандлагын үүднээс өгсөн тодорхойлолт”<sup>42</sup> гэж үзжээ.

Доктор (Ph.D) П.Оюунчимэг “Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь зөвхөн “хүчин” гэсэн явцуу ойлголт бус, гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр давамгайлж, бие болон сэтгэл санааны хувьд доромжлон, дарамт үзүүлж, эд хөрөнгийн гэм хор учруулж байгаа зан үйлдэл бөгөөд нэгнийхээ бүрэн эрх, эрх чөлөөг зориуд санаатайгаар хязгаарлахад хүргэсэн, хүйсийн тэгш бус харьцааны илрэл”<sup>43</sup> гэж хүчирхийллийн хэлбэрүүдийг тусгах замаар өргөн хүрээний тодорхойлолт өгчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар “Гэр бүлийн хүчирхийлэл” гэдэг нь эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг ойлгохоор заасан<sup>44</sup>. Уг үйлдэл, эс үйлдэхүй нь гэр бүлийн гишүүд төрөл садны хүмүүс, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан хүмүүс, бэлэвсэн буюу хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан эсэхийг үл харгалзан хүүхэд нэгтэй хүмүүсийн дунд, мөн гэр бүлийн хуулийн дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлж байгаа эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны дүнд харилцаатай болсон хүмүүс болон гэр аж ахуйг хамтран эзэмшиж байгаа хүмүүсийн дунд үйлдэгддэг.

Ихэнх тохиолдолд гэр бүлийн хүчирхийллээс ангижрах эцсийн сонголт нь гэр бүлээ цуцлуулах явдал болсоор байна. Нийт гэрлэлт цуцлалтын 41% нь хүчирхийллийн улмаас шалтгаалсан гэрлэлт цуцлалт эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь гэрчгүй үйлдэгддэг, нөгөө талаас өөрсдийн ойр дотны хүмүүсээ байнга хүчирхийлдэг хүмүүс хохирогчийг маш сайн хянаж чаддаг учраас хэн нэгэн хөндлөнгөөс оролцоход, энэ хяналтаа ашиглан хүчирхийллийг илчлэх гэсэн хүсэл зоригийг нь мохоодгоос гадна далд үзэгдэл учир илрүүлэх үйл явц төвөгтэй байдаг.

<sup>42</sup> Хулан Б. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2017. 15 дахь тал. Энхчимэг Н. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч судлалын асуудал. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022. 8 дахь тал.

<sup>43</sup> Оюунчимэг П. Гэр бүлийн хүчирхийлэл-хүний эрх. // Хүний эрхийн үндэсний комисс гурван жилд 2001-2003. Илтгэл, ярилцлага, лекцүүдийн эмхэтгэл. УБ., 2004. 81 дэх тал.

<sup>44</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5. 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.1 дэх заалт.

2016 оны гэмт хэргийн цагаан номонд “Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд ЦЕГ-т энэ асуудлыг хариуцсан хэлтэс, тусгайлсан мэргэжилтэн томилогдон ажиллаж байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2016 оны 12 дугаар сард хэлэлцэн баталж, 2017 оны 2 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан хэрэгжсэнээр хүн амын тоо, гэмт хэргийн гаралтыг харгалзан, уг нэгжийг байгуулан ажиллаж эхэлжээ. Үр дүнгийн хувьд тодорхой хугацаа шаардагдана”<sup>45</sup> гэж тэмдэглэсэн байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бодит амьдралд гаргуулахгүй байж, бүрэн дүүрэн тэмцэхэд ямар цаг хугацаа шаардагдах нь тодорхой бус, зөвхөн хууль гаргах замаар хязгаарлалт тогтоосноор аажимдаа гэр бүлийн хүчирхийлэл үгүй болно гэж үзэж байгаа бол эндүүрэл болно.

Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн талаар 2007 онд хийгдсэн харьцуулсан судалгааны ажлын үр дүн сонирхол татаж байна. Уг судалгааны ажилд “Цагдаагийн байгууллагад бүртгэгддэг 100.000 (нэг зуун мянга) орчим зөрчлийн 20-30 хувийг танхайрах зөрчил эзэлж байгаа боловч бодит байдал дээр уг зөрчлийн дийлэнх нь гэр бүлдээ агсам тавьсан, сэтгэл зүйн дарамт учруулсан, байнга зодсон шинжтэй үйлдлүүд байна. Нэг жилд бүртгэгддэг 30 орчим мянган танхайрах зөрчлийн 60 гаруй хувьд нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу торгох, эсхүл 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулдаг байна. Сард 3-4 танхайрах зөрчилд баривчлах шийтгэл оногдуулахаар шүүхэд шилжүүлдэг бөгөөд, эдгээр нь мөн чанартаа бүгд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд байдаг” гэсэн судалгаа гарсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлээс үйлдэлтэй сөрөг үр дагавар нь танхайрах зөрчлөөр үл хязгаарлагдаж байгаа нь харамсалтай байна. Тодруулбал, нэг жилд 300 орчим бүртгэгддэг хүнийг санаатай алах гэмт хэргийн 80 орчим хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгддэг ажээ<sup>46</sup>.

Криминологийн судалгаанаас үзвэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг урьд нь гэмт хэрэг, зөрчил гэсэн ойлголтод тооцдоггүй байснаас шалтгаалж, онц хүнд гэмт хэрэг буюу хүнийг санаатай алах, хүнд гэмтэл санаатай учруулах зэрэг хэргийн үзүүлэлтэд шууд нөлөөлж байгааг нотолсон байна<sup>47</sup>.

Эрт үеэс гэр бүлийн хоорондын харилцааг зохицуулах шинжтэй хууль тогтоомж хэрэгжиж ирсээр өдийг хүрсэн бөгөөд гагцхүү орчин үед гэр бүл судлал /англиар – family studies, оросоор – семейведение/ нь бие даасан мэдлэгийн салбар болон хөгжиж байна. Гэхдээ орчин үед энэ төрлийн харилцаанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо гэнэт боловсронгуй болсон гэвэл учир дутагдалтай зүйл болох бөгөөд түүхийн олон шат дамжлагаар дамжиж, сайжирсаар өнөөгийн хэмжээнд ирсэн болохыг дурдах нь зүйтэй.

Манай Монголчууд гэр бүлийн харилцаанд ёс заншлын болон эрх зүйн зохицуулалтыг хослуулан хэрэглэж ирсэн өвөрмөц түүхэн уламжлалтай ард түмэн билээ. Тухайлбал, Их засаг хууль, XVI-XVIII дугаар зууны үеийн Монгол цаазын бичгүүд болон “Арван буянт номын цагаан түүх”, “Алтан хааны цааз”, “Эрхэмжийн арван найман хууль”, “Монгол-Ойрадын их цааз”, “Халх журам”-д эр, эм болох, сүй тавих, инж солилцох, өрх гэр үүсгэх зэрэг гэр бүлийн харилцааг зохицуулсан олон

<sup>45</sup> Мөн тэнд. 34 дэх тал.

<sup>46</sup> Төрмандх З., Цоодол Г. Homicide. Хамтын бүтээл. УБ., 2008.

<sup>47</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад ашигласан судалгааны тайлан. УБ., 2014.

хэм хэмжээ бий бөгөөд өрх гэр, түүний хүрээнд үйлдэгдсэн гэмт үйлдлийг хатуу, чанга шийтгэл оногдуулахаар заасан байдаг.

Их засаг хуульд гэр бүлийн ариун ёс, зан заншил, шашин суртлын эсрэг зарим үйлдлийг гэмт хэрэгт тооцож байсныг судлаачид тогтоосон байдаг. Тодруулбал, хөвгүүд, охид нь эцэг, эхээ үл хүндэлсэн, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагасан, харьяат иргэд нь захирагчаа үл хүндэлсэн зэрэг нь нийгмийн хор аюул багатай зүйл мэт боловч гэмт хэрэгт тооцогдож, цаазаар авах хүртэл хүнд ял хүлээж байжээ<sup>48</sup>.

Их засагт (1206) хүн бүр гэр бүлийн ёсыг бүү зөрч, бүү хулгайл, гэрчлэхээс бүү татгалз, битгий худлаа хэл, хөгшин ядууг хүндлэн хамгаал гээд хүн алах, хулгай дээрэм хийх, садарлах, худал хэлэх, худалдаа хийхдээ алдаа гаргаж бусдыг хохироох, бусдыг гүжирдэх, эзнээсээ оргосон боолыг барьж өгөхгүй байх, түүнийг нуух, дэмжлэг үзүүлэх, хадгалуулсан эд хөрөнгийг удаа дараа үрэгдүүлэх, морио зодох, улсын нууц задруулах зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож байжээ<sup>49</sup>. Уг хууль нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох эрх зүйн зохицуулалтын хувьд хамгийн анхны хэм хэмжээ тусгагдсан гэж дүгнэж болохоор байна. Тодруулбал, 134 ...Эцэг эх нь хүртэл хүүхдийнхээ хэрүүл маргааныг хайхардаггүй, дийлдсэн нь эзэнд зарга мэдүүлж болох ба зарга мэдүүлсний дараа нөгөө хүн түүнд халдваас ална<sup>50</sup> гэсэн энэ заалтад хүчирхийллийн хохирогчийг хамгаалах сонирхолтой зохицуулалт байх ба хатуу хариуцлага хамгаалагдсан, хэрэгжих боломж өндөртэй зохицуулалт байсан байна.

Алтан хааны цааз<sup>51</sup>-д гэр бүлийн хэрэгт жирэмсэн эмийн ураг хөндөх, эр нь эмийнхээ үсийг тастах, хувцсыг урах, самууран явах охиноо тулган эрд өгөх, санаа муутай хүнтэй зөвшилцөх, цохиж зодох, ам хэлээр дайрах зэргийг хамааруулж, шийдэхээр зааж, жанчих, торгох, харайх, барайхыг талах (хөрөнгө хураах), ачих зэрэг ялын төрөл, хэлбэр хэрэглэгдэхээр тусгагджээ<sup>52</sup>. Тодруулбал, эр нь эмэгтэйн үсийг тасалбаас таван есөөр торго<sup>53</sup>. Нүдийг тэсэлбээс нэг удаа ташуурдаж, есөн есөөр торгож, хүн тэмээний аль нэгээр өр босго. Шүд хугалбаас гурван есөөр торгож хүн, тэмээний аль нэгээр өр босго. ...Хүний гар хөлийг хугалж, тахир дутуу болговоос есөн есөөр торгож, нэг хүнээр өр босго зэрэг зохицуулалтаас үзвэл бие махбодын шинжтэй гэр бүлийн хүрээн дэх үйлдлийг зохицуулах оролдлого байсан байна гэж дүгнэж болохоор байна.

Мөн Эхнэрээ нөхөр бээр хурц үзүүртэй мод чулуугаар цохивоос гурван есөөр торго. Эхнэр бээр нөхрийгөө амаараа доромжилбоос нэг эдээр торго гэх заалтаас харвал гэр бүлийн хүчирхийллийн хамгийн түгээмэл бие мах бодийн хүчирхийллийн хэлбэрийг хуульчилж байсны жишээ юм. Эцэг, эх нь охиноо элдэв аргаар эрд өгвөөс есөн есөөр торго гэх энэ заалтаас үзвэл бэлгийн эрх чөлөөний асуудал буюу жендерийн үүдэлтэй бэлгийн хүчирхийллээс хамгаалсан зохицуулалт гэж болохоор байна.

Монгол-Ойрадын их цаазын 28 дугаар зүйлд “Бэр хадам эх, эцгээ жанчвал гурван ес ав, дунд жанчвал хоёр ес ав, бага жанчвал нэг ес авах болов”, “Эцэг

<sup>48</sup> Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Б.Баярсайханы хөрвүүлэг. УБ., 2003. 12-18 дахь тал.

<sup>49</sup> Ням-Осор Н. Эзэн Чингисийн Их засаг хуулийн тайлбар. УБ., 2001. 46 дахь тал.

<sup>50</sup> Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. 1206-1910. УБ., 2010. 40 дэх тал.

<sup>51</sup> МУИС-ХЗС, Улаанбаатар эрдэм судлал дээд сургуулиас эрхлэн гаргасан. Түмэдийн Алтан хааны үеийн хууль цаазын бичиг. цуврал-3, УБ., 2002.

<sup>52</sup> Ганболд, Б. Гэмт хэргийн зүйлчлэлийн онол. УБ., 2005. 21 дэх тал.

<sup>53</sup> Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. 1206-1910. УБ., 2010. 82 дахь тал.

хөвүүн, бэрээ сургаж жанчвал ялгүй, буруугаар жанчвал ес ав, дундаас тав, багаас нэг морь ав. Хадам нь бэрээ жанчвал хоёр ес ав. Дундаас ес, багаас тав ав”, мөн 29 дүгээр зүйлд “Хүү нь эцэг, эхээ албал, хэн хүн нь барьж ноёнд нь хүргэ. Бэрх тэргүүтэй ес ид, биеэс бусыг нь тараах болов. Эцэг нь хүүгээ алвал халуун аминаас бусдыг нь авах болов”<sup>54</sup> гэх зэргээр хуульчилсан байжээ.

XX дугаар зууны эхэн үеийн Эрүүгийн хуулиудын гол агуулга нь ардчилсан төрийн Эрүүгийн хууль цаазын бодлого, зарчмыг тогтоон түүнийг ард олонд ойлгуулан таниулахад чиглэж байсан ба мөн гэр бүлийн харилцааны асуудлыг тусгаж ирсэн байна. Тухайлбал, БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазын бичгийн 82 дугаар зүйлд “Эр, эм бололцоход харшгүй учир шалтгааныг нуун дарагдуулах ба ард иргэдийн эр, эмийн байдлыг бүртгэн тэмдэглэх явдлыг эрхлэн гүйцэтгэх газруудад худал хуурмагаар мэдүүлсэн бол 6 сар хүртэлх хугацаагаар хорих буюу мөн хугацааны дотор албадан ажил хийлгэх, эсвэл 600 төгрөг хүртэл торгож ял шийтгэвэл зохино”<sup>55</sup> гэж гэр бүл зохиож, батлуулах үйл ажиллагааны асуудлыг хуульчилсан байдаг бол БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйлд “Эр, эм болоход харштай учир шалтгааныг нуун дарагдуулах буюу ард иргэний эрх амын байдлыг бүртгэх явдлыг эрхэлсэн албан байгууллагад санаатайгаар худал хуурмагаар мэдүүлсэн байвал нэгэн жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэх, эсвэл 1000 төгрөг хүртэл торгож шийтгэвэл зохино”<sup>56</sup> гэж эр, эмийн гэрлэлтийг бүртгэх харилцааг хуульчлан, зохицуулж байсан нь харагдаж байна.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуульд “Гэр бүл бүртгүүлэхэд харшлах зүйлүүдийг санаатай нуун дарагдуулсан бол 1 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 500 төгрөг хүртэл торгох эсхүл олон нийтийн арга хэмжээ авхуулна” гэж зааснаар анхлан “Гэр бүл” гэх нэр томъёог хууль тогтоомжид хэрэглэж байжээ.

Монгол Улсын 1986 оны Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд тусгайлан авч үзсэн заалт хараахан тусгагдаагүй. 1986 он хүртэлх хугацааны Эрүүгийн хууль тогтоомжид гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудлыг хуульчлаагүй нь гэр бүлийн гишүүдийн хоорондын асуудал нь зөвхөн тухайн гэр бүлийн гишүүдийн өөр хоорондын харилцаа учир төр хөндлөнгөөс оролцож, зохицуулах нь зохимжгүй зүйл гэж үзсэнтэй хамаатай болов уу. Эртнээс монголчууд “Олгой хагаравч тогоондоо, толгой хагаравч малгайндаа”, “Эр, эмийн хооронд илжиг бүү жороол” гэх зэргийн зүйр цэцэн үгсийг түгээмэл ашиглаж, аж амьдралынхаа үйл ажиллагаанд баримтлах нэг ёсны зарчим болгодог байсан нь гэр бүлийн харилцааг гадны бус, тухайн гэр бүлийн гишүүдийн хоорондоо зохицуулах зүйл болгохыг эрмэлзэж ирсний баталгаа юм.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлэг (Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг)-т гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар тусгайлан хуульчлаагүй байсан боловч 2012-2016 оны шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль боловсруулагдаж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан ба энэ талаар Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 120 дугаар зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө

<sup>54</sup> Алтангэрэл Т., Энхээ Ц. “XVI-XVIII зууны Монгол цаазны бичгүүд”. Уб., 2003. 125 дахь тал.

<sup>55</sup> Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. Уб., 1998. 86 дахь тал.

<sup>56</sup> Мөн тэнд. 126 дахь тал.

эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”<sup>57</sup> хэмээн үндсэн бүрэлдэхүүнд хөнгөн гэмт хэрэг байхаар хуульчилснаас гадна хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан. 2002 оны Эрүүгийн хуульд оруулсан уг өөрчлөлт нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд үүссэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хэвийн явдал гэж үзэн, үл хайхрах явдалтай тэмцэхэд чиглэсэн сайн алхам болсон байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” гэсэн зөрчлийг шинээр, нэмж тусгасан. Зөрчлийн диспозицод “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан”<sup>58</sup> үйлдлээс гадна “Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй”<sup>59</sup> эс үйлдэхүйг зааж, шийтгэл оногдуулахаар тусгасан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг зөрчилд тооцохоос гадна Эрүүгийн хуульд тусгай зүйл ангиар хуульчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон нь шинэлэг зохицуулалт болж чаджээ. Тодруулбал, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:

1.1. зодсон;

1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;

1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ<sup>60</sup>. Уг гэмт хэргийг зөрчлөөс байнга байх шинжээр ялган заагласан.

Ийнхүү гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдлыг зөрчлөөс гадна гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон нь төрөөс гэр бүлийн хүчирхийлэлд чухал ач холбогдол өгч, эрүүгийн эрх зүйн бодлогоор тэмцэж байгаагийн илрэл юм.

### **Дүгнэлт**

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаарх судалгаанаас дүгнэхэд, гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй ихэнх гэмт хэрэг, зөрчил болох

<sup>57</sup> Эрүүгийн хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5.

<sup>58</sup> Зөрчлийн тухай хууль. УБ., 2022. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №38. 5.4 дүгээр зүйл.

<sup>59</sup> Мөн тэнд. 5.4 дүгээр зүйл.

<sup>60</sup> Эрүүгийн хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5. 11.7 дугаар зүйл.

танхайрахаас авахуулаад, хэрүүл маргаан, бусдын биед гэмт учруулах гэмт хэрэг зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэлтэй салшгүй байдлаар хамтран үйлдэгддэг байна.

2. Манай улсын эртний болон дундад үеийн Эрүүгийн эрх зүйн түүхэн дурсгалт эх сурвалжууд болон шинэ үеийн буюу 1921 оноос хойшхи шүүх цаазын бичгүүд, Эрүүгийн хуулиудад судалж буй “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг тусгайлан хуульчилж байгаагүй ба ёс, зан заншлын хэм хэмжээгээр шийдвэрлэж байсан нь тухайн түүхт цаг үеийн Монгол Улсын нийгэм, улс төрийн, эдийн засгийн байдал, эрх зүйн сэтгэлгээ, онолын хөгжлийн түвшинтэй холбоотой байжээ

3. Анхдугаар Үндсэн хуулиа тунхаглаж байсан он жилүүдээс хойш ардчилсан хувьсгал ялсан үе, түүнээс цаашлаад XXI зуун гарах хүртэлх түүхэн үечлэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дэвшилттэй алхам төдийлөн хийгдэж байгаагүй бөгөөд 2002, 2015 оны Эрүүгийн хуулиудад энэ төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцсон явдал нь гэр бүлийн хүчирхийлэлтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийг шинэ түвшинд гаргажээ.

### **Ашигласан материал**

1. Alhussain, Khalid, Shah, Drishti, Thornton, James, Kelly, Kimberly. Familial Opioid Misuse and Family Cohesion: Impact on Family Communication and Well-being. Addictive Disorders & Their Treatment 2019;18(4):

2. Lander L, Howsare J, Byrne M. The impact of substance use disorders on families and children: from theory to practice. Soc Work Public Health. 2013.

3. Schneider, David. A Critique of the Study of Kinship. Ann Arbor: University of Michigan Press. 1984.

4. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ., 1998.

5. Алтангэрэл Т., Энхээ Ц. “XVI-XVIII зууны Монгол цаазны бичгүүд”. УБ., 2003.

6. Ганболд, Б. Гэмт хэргийн зүйлчлэлийн онол. УБ., 2005.

7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад ашигласан судалгааны тайлан. УБ., 2014.

8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5.

9. Зөрчлийн тухай хууль. УБ., 2022. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №38. 5.4 дүгээр зүйл.

10. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. 1206-1910. УБ., 2010.

11. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. 1206-1910. УБ., 2010.

12. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Б.Баярсайханы хөрвүүлэг. УБ., 2003.

13. МУИС-ХЗС, Улаанбаатар эрдэм судлал дээд сургуулиас эрхлэн гаргасан. Түмэдийн Алтан хааны үеийн хууль цаазын бичиг. цуврал-3, УБ., 2002.

14. Намжил Т. Монголын гэр бүлийн харилцааны уламжлал, шинэчлэлийн зарим асуудлууд. Эрдэм шинжилгээний, судалгааны ажлын эмхэтгэл. УБ., 1998.

15. Ням-Осор Н. Эзэн Чингисийн Их засаг хуулийн тайлбар. УБ., 2001.

16. Оюунчимэг П. Гэр бүлийн хүчирхийлэл-хүний эрх. // Хүний эрхийн үндэсний комисс гурван жилд 2001-2003. Илтгэл, ярилцлага, лекцүүдийн эмхэтгэл. УБ., 2004.

17. Сүхээ Ш. Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлал, дэвшлийн асуудал. 1988.

18. Төрмандах З., Цоодол Г. Homicide. Хамтын бүтээл. УБ., 2008.
19. Хулан Б. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2017. 15 дахь тал.
- Энхчимэг Н. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч судлалын асуудал. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022.
20. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. УБ., 1946.
21. Эрүүгийн хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5.

## МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ШИНЖ

### MONEY LAUNDERING SUBJECTIVITY

А.Хүдэр-Эрдэнэ

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** Өгүүлэлд мөнгө угаах гэмт хэргийн субъектив талын оюун санааны хэлбэрийн нэгэн чухал онцлог болох “мэдсээр байж” гэх хэлбэрийн онцлог шинжийг судлахаас гадна мөнгө угаах гэмт хэргийн зорилгыг тодорхойлохыг зорилоо.

**Abstract:** The article seeks to examine an important feature of the mental form of the subjective aspect of money laundering, such as “knowingly”, as well as to identify the purpose of money laundering.

**Түлхүүр үгс:** Гэмт хэргийн субъектив тал, зорилго, мөнгөн дүн, нууц, далд, хувиргалт, өөрчлөлт.

**Keywords:** Subjective side of the crime, purpose, monetary amount, secret, hidden, transformation, change.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”<sup>61</sup> гэж гэм буруугийн асуудлыг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд заавал байх шинж болгон заасан.

Манай улсын эрүүгийн эрх зүйд гэм буруугүй үйлдэл, эс үйлдэхүйн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал нь харш юм. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”<sup>62</sup>, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”<sup>63</sup> гэж заасан нь үүний баталгаа юм.

Амьдралд үйлдэгдсэн тодорхой үйл явдлыг гэмт хэрэг мөн эсэхийг тогтооход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэм буруу гэгч нь гэмт хэргийн субъектив талын заавал байх, үндсэн шинжид хамаарч, аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тухайн үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн этгээдийн дотоод оюун санаа, сэтгэхүйн харьцааг харуулдаг онцлогтой.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь ерөнхий утгаараа нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг болохыг тодорхойлох үндсэн шинжүүдийн нэг юм. Гэмт хэргийн субъектив тал гэж “гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд болон түүний улмаас учирсан хор уршигт хандаж буй ухамсар, хүсэл зоригийн харьцааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг ч, илүү өргөн утгаар нь тайлбарлавал, гэмт этгээдийн өөрийн үйлдэж буй нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учирч болох хор уршигийг хэрхэн ойлгож, ухамсарлаж, хандаж байгаа сэтгэхүйн үйл ажиллагааг тодорхойлох

<sup>61</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг.

<sup>62</sup> Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<sup>63</sup> Мөн тэнд. 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

гэм буруу, гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал зэрэг шинжийг багтаасан, гэмт хэргийн бүрэлдэхүүний бие даасан бүрдэл хэсэг юм<sup>64</sup>. Манай улсын болон гадаадын эрдэмтэн, судлаачид гэмт хэргийн субьектив талыг янз бүрээр тайлбарласнаас үзэхэд, нэгдмэл ойлголт хараахан тогтоогүй гэж үзэх үндэстэй. Жишээлбэл, профессор Г.Совд “Гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын асуудал нь ...субьектын гэм буруугийн хэр хэмжээ, хэлбэрүүдийг тодорхойлдог чухал элемент”<sup>65</sup> гэж гэм бурууг субьектив талын агуулгад оруулан адилтгасан бол ОХУ-ын эрдэмтэн С.Дагель, П.Котов нар “Гэм буруу бол субьектив талын сэтгэл зүйн агуулга”<sup>66</sup> гэжээ. Энэ мэтээр гэмт хэргийн субьектив талын тухай ойлголтыг хэлбэр, агуулгаар нь өөр өөрийн үзэл санааны үүднээс тодорхойлох явдал эрдэмтдийн дунд түгээмэл байгаа болохыг дээр дурдсан эрдэмтдийн үзэл санаагаар хязгаарлаж, мөнгө угаах гэмт хэргийн субьектив талын шинжийг тодорхойлоход анхаарлаа хандуулъя.

Мөнгө угаах гэмт хэргийн хувьд Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг баталж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, улмаар 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн “Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай” хуулиар шинээр гэмт хэрэг болгон хуульчилсан. Мөнгө угаах гэх нэршил нь анх 1930-аад оны үед Америкийн Нэгдсэн Улсын Төрийн сангийн ажилтнууд Аль Капоне<sup>67</sup>-г эдийн засгийн гэмт хэрэгт сэжиглэн, нотлох баримт цуглуулсан үеэс эхлэлтэй. 1920-1933 оны хооронд Америкийн Нэгдсэн Улсад архины төрлийн бүтээгдэхүүнийг худалдах, савлах, гаднаас оруулж ирэх, тээвэрлэхийг хуулиар хориглодог байсан бөгөөд уг бизнесийг Аль Капоне эрхэлдэг байжээ. Энэ үед маш цөөхөн хүн крантны ус хэрэглэдэг байсан тул айлуудад угаалгын машин бараг л байгаагүй учир нийтийн угаалгын машинд хувцсаа угаадаг байв. Аль Капоне болон түүний бүлгийн хүмүүс Чикаго хот дотор болон түүний эргэн тойронд хувцас угаалгын хэдэн зуун газрыг эзэмшиж, хууль бус согтууруулах ундаанаас олсон орлогыг угаалгын газрын ашиг хэмээн халхалдаг байжээ<sup>68</sup>. Өөрөөр хэлбэл, энэ нэршил нь Аль Капоне өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудыг ашиглан хууль бус үйлдлээр олсон орлогоо угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг “L'expressee” сонинд “Хувцас биш, мөнгө угааж байна” гэж бичсэнээр анх гарсан гэж үздэг<sup>69</sup>.

Мөнгө угаахтай тэмцэх бодлогыг санаачлах болсон гол шалтгаан нь АНУ-ын хар тамхины хууль бус эргэлтийн эсрэг зарласан тэмцэл амжилтад хүрээгүйтэй холбон тайлбарладаг. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис үйлдвэрлэгч, нийлүүлэгч гэмт бүлэглэлийн гэмт хэргээс олсон ашиг, орлогыг илрүүлж, хураан авах замаар гэмт үйл явдлыг цаашид үргэлжлүүлэн үйлдэх чадамжгүй болгох, дархлааг нь үгүй хийх зорилготой байсан мөнгө угаахтай

<sup>64</sup> Бат-Очир Л., Гантулга С., Гантөмөр Г., Төгс-Очир Ж., Энхболд Б., Эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги, Сурах бичиг, УБ., 2020. 249 дэх тал.

<sup>65</sup> Совд Г. Дурдсан зохиол. УБ., 1973. 238 дахь тал.

<sup>66</sup> Дагель С., Котов П. Субъективная сторона преступления и её установления. М., 1974. С. 38.

<sup>67</sup> Итали гаралтай америкийн гангстер. 1920-1930 оны хооронд Чикаго хотын нутаг дэвсгэрт, мебелийн бизнес, хими цэвэрлэгээ гэх халхавч дор согтууруулах ундааны үйлдвэрлэл, контрабанд, мөрийтэй тоглоом, биеэ үнэлэлт зохион байгуулах гэх мэт хууль бус үйл ажиллагаа явуулж байсан. Эх сурвалж: Википедия. Свободная энциклопедия. [https://ru.wikipedia.org/wiki/%D0%90%D0%BB%D1%8C\\_%D0%9A%D0%B0%D0%BF%D0%BE%D0%BD%D0%B5](https://ru.wikipedia.org/wiki/%D0%90%D0%BB%D1%8C_%D0%9A%D0%B0%D0%BF%D0%BE%D0%BD%D0%B5).

<sup>68</sup> Матерс К. Гэмт хэргийг танихуй: Мөнгө угаах. Орчуулгын бүтээл. 13 дахь тал.

<sup>69</sup> Батзаяа Г. Мөнгө угаалт. Мөнгө угаах гэмт хэрэг, интернет банк, банкны салбарт мөнгө угаах, мөнгө угаахын эсрэг эрсдлийн үнэлгээ. УБ., 2009. 9 дэх тал.

тэмцэх тус улсын бодлого эцсийн дүндээ бүхий л төрлийн гэмт хэргийн ашиг, орлогыг илрүүлэх, хураах, улмаар уг гэмт явдлыг таслан зогсооход чиглэсэн бодлого болж хувирчээ<sup>70</sup>. Энэ тэмцлийн далайц өргөжсөөр, дэлхий нийтийн хэмжээний тэмцэл болсон гэхэд хилсдэхгүй бөгөөд үүний баталгаа нь НҮБ-ын батлан, гаргасан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” 2000 оны Палермогийн Конвенц юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн протоколд Монгол Улс тус тус нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар бүлэгт багтах бүх гэмт хэрэг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Мөнгө угаах гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй бөгөөд “хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүд шууд санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ”<sup>71</sup> гэх үзэл баримтлалын дагуу тус гэмт хэрэг нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэхдээ хэлбэрийн бүрэлдэхүүнтэй бүх гэмт хэрэг шууд санаатай хэлбэрээр үйлдэгддэггүй боловч ийм тохиолдол харьцангуй цөөн тааралдах бөгөөд тэдний тоонд мөнгө угаах гэмт хэрэг багтахгүй. Тэгэхээр мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн гэмт хэрэгт хамаардаг, хэлбэрийн бүрэлдэхүүнтэйн хувьд гэм буруугийн санаатай хэлбэрээр, тэр дундаа шууд санаатай хэлбэрээр үйлдэгддэг байна.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцоход зайлшгүй шаардлагатай нэг зүйл нь гэмт этгээд өөрийн үйлдлийг гэмт хэргийн замаар олдсон эд хөрөнгийг угаахад чиглэсэн гэдгийг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлддэг онцлог юм. Бохир мөнгийг үл хөдлөх эд хөрөнгө болгон хувиргах, эсхүл гадаад валют худалдан авах зэрэг тохиолдолд гэмт этгээдийн зорилго бохир мөнгийг хууль ёсны болгож, хувиргахад чиглэсэн байх ёстой.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн диспозицод уг гэмт хэргийн субъектив талын, оюун санааны хэлбэрийн нэгэн чухал онцлог болох “мэдсээр байж” гэх хэлбэрийг тусгасан. Манай улсад хууль зүйн тайлбар тольны дутмаг байдлаас хамаарч тодорхой нэр томъёог хууль зүйн үүднээс тайлбарлах боломж тааруу байдаг нь гадаадын зарим улсын хууль зүйн тайлбарыг эш үндэс болгохоос аргагүй байдалд хүргэж байгааг тэмдэглэе. Жишээлбэл, ОХУ-ын толь бичигт “илт тодорхой, илт мэдээжийн, дамжиггүй, эргэлзээгүй”<sup>72</sup> гэж тайлбарласан бол В.А. Никулина “мэдээж хэрэг гэдэг нь тухайн этгээд эд хөрөнгийн хууль бус эх сурвалжийн тухай мэдээгүй байх боломжгүй”<sup>73</sup> гэж, Н.Г. Кадников “...урьдчилан

<sup>70</sup> Unger B, 2013. Money Laundering Regulation: From Al Capone to Al Qaeda. B. Unger & D van der Linde (red.). Research handbook on money laundering. 16 дахь тал.

<sup>71</sup> Мурадов Э.С. Вопросы субъективной стороны преступлений в сфере экономической деятельности // Законодательство и экономика. 2004. № 5.

<sup>72</sup> Ожегов С.И. Словарь русского языка / Под ред. Н.Ю. Шведовой. 18-е изд., стереотип. М.: Русский язык, 1986. С.171.

<sup>73</sup> Никулина В.А. Отмывание “грязных” денег. Уголовно-правовая характеристика и проблемы соучастия. М.: Юрлитинформ, 2001. С. 85.

мэдсэн байхыг ойлгоно”<sup>74</sup> гэж, А.А. Шебунов “...урьдчилан мэдсэн байх, мэдэх”<sup>75</sup> гэж тус тус тайлбарласан.

Шүүгдэгч Б нь 2021 оны 08 дугаар сараас 2022 оны 02 дугаар сарын хооронд үргэлжилсэн үйлдлээр бусдын эд хөрөнгийг хулгайлж, нийт 23.458.700 (хорин гурван сая дөрвөн зуун тавин найман мянга долоон зуу) төгрөгийн хохирол учруулсанаас гадна Л-н эзэмшлийн айфоне 8 плас (I phone 8 plus) загварын гар утсыг хулгайлах гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, бусдад 180.000 (нэг зуун наян мянга) төгрөгөөр зарж, түүний эх үүсвэр, эзэмшигчийг нуун далдалж, эд хөрөнгийн эрхийг хувиргах замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлджээ<sup>76</sup>. Уг жишээ болон эрдэмтдийн тайлбараас үзэхэд, “мэдсээр байж” гэх ойлголт нь тухайн этгээд орлого, мөнгө, эд хөрөнгийн хууль бус эх сурвалжийн тухай урьдчилан, тодорхой мэдсэн, мэдээгүй байх боломжгүй буюу илт хууль бус аргаар олсон орлого, мөнгө, эд хөрөнгө болохыг баттай мэдсэн байхыг ойлгохоор байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Мөнгө угаах гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж, уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг ойлгоно”<sup>77</sup> гэж заасан. Өөр эх сурвалжид “Мөнгө угаах гэж илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсвэл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг хэлнэ”<sup>78</sup> гэж тодорхойлсон бол С.Нарангэрэл “Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилсөн үйлдэл”<sup>79</sup> гэж үзээд, “Мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан мөнгө буюу бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор хөрвүүлсэн үйл ажиллагаа”<sup>80</sup> гэж тодотгосон. Тэгэхээр уг нэр томъёоны утга санаа нь дараах байдлаар илэрч байна. Үүнд: эд хөрөнгийг бусад этгээд гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан болох нь эд хөрөнгийг хувиргагч (угаагч) этгээдэд хангалттай тодорхой, мэдээжийн (багцаалаагүй, тухайлаагүй, төсөөлөөгүй) байх, өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж олж авсан байх, тухайн этгээд урьдчилан мэдсэний үндсэн дээр гэмт хэргийн улмаас олсон орлого, мөнгө, эд хөрөнгийг угаах (хууль ёсны болгож хувиргах) үйлдэл хийсэн байх зэрэг багтана. Хэрэв тухайн этгээд урьдчилан мэдсэн болох нь хангалттай нотлогдоогүй тохиолдолд, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй болох ч боломжтой юм.

<sup>74</sup> Уголовное право России. Общая и Особенная части: Учебник для высших учебных заведений / Под ред. Н.Г. Кадникова. М.: Книжный мир, 2007. С. 476.

<sup>75</sup> Шебунов А.А. Легализация денежных средств и иного имущества, приобретенных незаконным путем: Дис... канд. юрид. наук. М., 1998. С. 122.

<sup>76</sup> [https://shuukh.mn/single\\_case/80489?daterange=2010-01-01%20-%202022-11-25&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/80489?daterange=2010-01-01%20-%202022-11-25&id=1&court_cat=2&bb=1).

<sup>77</sup> Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.1 дэх хэсэг. Эх сурвалж: legalinfo.mn/mn/detail/9242.

<sup>78</sup> Монгол Банк. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтын гарын авлага. УБ., 2018. 12 дахь тал.

<sup>79</sup> Нарангэрэл С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Анхны хэвлэл. УБ., 2021. 244 дэх тал.

<sup>80</sup> Мөн тэнд, 244 дэх тал.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн диспозицод “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн...” гэж заасан нь “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогыг *хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн*” гэх зорилгыг тодотгосон байна. Уг заалт нь гэмт хэрэг үйлдэж эд хөрөнгө олсон этгээдэд уг үйлдсэн хэрэгт оногдуулах хариуцлагаас зайлсхийхэд нь хоёрдогч этгээд туслах зорилгыг агуулсан гэхээсээ илүүтэйгээр, гэмт хэрэгтний (хоёрдагч этгээд) зорилго нь чухам гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хууль ёсоор эзэмших, ашиглах, захиран зарцуулахад чиглэсэн байдаг. Гэмт хэрэгтний туйлын зорилго нь гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг угаах бус, чухам гэмт хэргийн үр дүнг үнэмлэхүй ашигтай байдлаар эргүүлж, өөрийн хэрэгцээг ханган, баяжихад оршдог. Тэгэхээр мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоос гадна эцсийн дүндээ тухайн гэмт хэргийн улмаас олсон орлого, мөнгө, хөрөнгийг өөрийн тусын тулд буюу жам ёсны хэрэгцээгээ хангах зорилго агуулсан, өөрөөр хэлбэл, давхар зорилго агуулсан гэмт хэрэг юм. Нөгөөтэйгүүр, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогыг өөрчилсөн, шилжүүлсэн үйлдэл нь зорилгын хувьд мөнгө угаах гэмт хэргийн шинжээс гадна гэмт хэргийг үл мэдээлэх зөрчлийн шинжийг агуулж байна.

### **Дүгнэлт**

“Мэдсээр байж” гэх ойлголт нь тухайн этгээд орлого, мөнгө, эд хөрөнгийн хууль бус эх сурвалжийн тухай урьдчилан, тодорхой мэдсэн, мэдээгүй байх боломжгүй буюу илт хууль бус аргаар олсон орлого, мөнгө, эд хөрөнгө болохыг баттай мэдсэн байхыг шаардах шинжтэй.

Эд хөрөнгийг бусад этгээд гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан болох нь эд хөрөнгийг хувиргагч (угаагч) этгээдэд хангалттай тодорхой, мэдээжийн (багцаалаагүй, тухайлаагүй, төсөөлөөгүй) байх Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж олж авсан байх, тухайн этгээд урьдчилан мэдсэний үндсэн дээр гэмт хэргийн улмаас олсон орлого, мөнгө, эд хөрөнгийг угаах (хууль ёсны болгож хувиргах) үйлдэл хийсэн байх зэрэг багтах онцлогтой.

Гэмт хэрэгтний туйлын зорилго нь гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг угаах бус, чухам гэмт хэргийн үр дүнг үнэмлэхүй ашигтай байдлаар эргүүлж, өөрийн хэрэгцээг ханган, баяжихад оршдог. Тэгэхээр мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоос гадна эцсийн дүндээ тухайн гэмт хэргийн улмаас олсон орлого, мөнгө, хөрөнгийг өөрийн тусын тулд буюу жам ёсны хэрэгцээгээ хангах давхар зорилго агуулсан гэмт хэрэг бөгөөд үйлдлийн арга нь мөнгө угаах хэлбэрээр илэрдэг байна.

### **Санал**

Мөнгө угаах гэмт хэрэг нь үйлдлийн арга, халдлагын зүйлийн хамрах цар хүрээгээр хавьгүй их хэмжээний ойлголт болохыг харгалзан үзэж, энэ гэмт хэргийн субъектив талын шинжид хамаарах зүйлсийг удирдлага болгон, мөнгө угаах гэмт хэргийг хавьгүй өргөн хүрээгээр тодорхойлох;

Хувиргаж байгаа мөнгөн дүнгээс хамаарч, мөнгө угаах гэмт хэрэг гэж үзэх эсэх шалгуур тогтоох, хавьгүй бага хэмжээний мөнгөн дүнг өөрчлөн, хувиргасан асуудлыг үйлдлийн зорилгоос нь хамаарч мөнгө угаах гэмт хэргээр зүйлчлэх бус,

хууль бусаар олсон ашгийг хувиргах үйлдлээр тусгайлан тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог Эрүүгийн хуульд шинээр хуульчлах зэрэг саналтай байна.

### **Ашигласан материал**

1. Батзаяа Г. Мөнгө угаалт. Мөнгө угаах гэмт хэрэг, интернет банк, банкны салбарт мөнгө угаах, мөнгө угаахын эсрэг эрсдлийн үнэлгээ. Уб., 2009.
2. Бат-Очир Л., Гантулга С., Гантөмөр Г., Төгс-Очир Ж., Энхболд Б., Эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги, Сурах бичиг, Уб., 2020.
3. Дагель С., Котов П. Субъективная сторона преступления и её установления. М., 1974.
4. Матерс К. Гэмт хэргийг танихуй: Мөнгө угаах. Орчуулгын бүтээл. Монгол Банк. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтын гарын авлага. Уб., 2018.
5. Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1.
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.1 дэх хэсэг. Эх сурвалж: [legalinfo.mn/mn/detail/9242](http://legalinfo.mn/mn/detail/9242).
7. Мурадов Э.С. Вопросы субъективной стороны преступлений в сфере экономической деятельности // Законодательство и экономика. 2004. №5.
8. Нарангэрэл С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Анхны хэвлэл. Уб., 2021.
9. Никулина В.А. Отмывание “грязных” денег. Уголовно-правовая характеристика и проблемы соучастия. М.: Юрлитинформ, 2001.
10. Ожегов С.И. Словарь русского языка / Под ред. Н.Ю. Шведовой. 18-е изд., стереотип. М.: Русский язык, 1986.
11. Уголовное право России. Общая и Особенная части: Учебник для высших учебных заведений // Под ред. Н.Г. Кадникова. М.: Книжный мир, 2007.
12. Совд Г. Дурдсан зохиол. Уб., 1973.
13. Шебунов А.А. Легализация денежных средств и иного имущества, приобретенных незаконным путем: Дис... канд. юрид. наук. М., 1998.
14. Эрүүгийн хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7.
15. Unger B, 2013. Money Laundering Regulation: From Al Capone to Al Qaeda. B. Unger & D van der Linde (red.). Research handbook on money laundering.

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

## VEHICLE TRAFFIC SAFE HISTORICAL TRADITIONS OF CRIME RELATED TO THE SITUATION

С.Болдбаатар

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

**Товч агуулга:** Өгүүлэлд Монгол Улсад авто тээврийн түүхэн хөгжил хэрхэн явагдсан талаар дурдахаас гадна авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг хуульчилж ирсэн түүхэн уламжлалыг судалж, тэдгээрийн хөгжлийн зүй тогтлын талаар тодруулахыг зорилоо.

**Abstract:** In addition to describing the historical development of road transport in Mongolia, the article aims to examine the historical traditions of the legalization of crimes against traffic safety and operating regulations of motor vehicles and to clarify the patterns of their development.

**Түлхүүр үгс:** Тээвэр, зам, аюулгүй байдал, ашиглалтын журам, түүхэн хөгжил.

**Keywords:** Transport, Roads, Safety, Operating Procedures, historical development.

Хууль цаазын түүхэн уламжлалыг судлахын ач холбогдол нь тухайн үеийн нийгэм, улс төр, хууль цаазын онцлогийг танин мэдэх, тэдгээрийн ололттой талыг уламжлан, алдаа дутагдлыг давтахгүй байх, ард түмнийхээ зан заншил, уламжлалаас суралцах, түүнчлэн уламжлал, шинэчлэлийн уялдаа холбоотойгоор авч үзэхэд оршино<sup>81</sup>.

Юмс үзэгдлийн ойлголтын тухай тодорхойлолт нь аль ч объектыг шинжлэх ухаанчаар танин мэдэх, түүний мөн чанар, онцлог шинж, агуулгыг нээн илрүүлэх арга зүйн салшгүй бүрэлдэхүүн болдог. Г.Гегель “Ойлголт нь ганц нэг, онцлог, нийтлэг мөчүүдийг агуулдаг... Ойлголт нь өөрийн тодорхойлолтод бүрэн дүүрнээр, нийтлэгээр хадгалагдан үлдэх нийтлэг зүйл юм. Өөрөөр хэлбэл, аливаа зүйлсийн талаарх олон янзын тодорхойлолтууд нэгдмэл байдлаар хадгалагддаг, тийм тодорхой байдал юм”<sup>82</sup> гэж бичжээ.


Аливаа улсын түүхэн хөгжил, дэд бүтцийг зам хөгжлөөр тодорхойлсоор ирсэн бөгөөд судалгааны ажлын хүрээнд эртний төрт улсын түүхээс зам тээврийн хөгжлийн шүүрдэн үзэхэд архиологчдын нээлтээр 1230 оны үеэс буюу Өгөөдэй хааны зарлигаар морин өртөөний албыг байгуулан гадаад оронтой харилцаагаа бэхжүүлэн, өргөжүүлэх зорилготойгоор зам харилцааг бий болгосон байх бөгөөд үе шаттайгаар хөгжсөөр ирсэн. Өгөөдэй хааны өртөөний суурь бүрт 29 улаач, төдий тооны агт сайн морьд, хүнсний эд зүйлсийг тус бүрээр 1232-1233 онд тогтоон зааж, журамласан байна. Тухайн цаг хугацаанд өртөө, улаачийн тухай баримтуудад дурдагдсанаар “Христосын их Пад-Ламын элч Ионани, Де Плано-Карпини Лион 1246 онд Герман, Силеэзи, Польш, Өмнөд Орос, Киев улсаар даялан аялж, Дон мөрөн Ижил мөрний цутгалан Каспин тэнгисийн эргийг даган дорно зүгт эргэж Монгол-Татарын их хаанд бараалхасан байдаг” мөн 1253 онд

<sup>81</sup> Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Гэмт хэргийн тухай сургааль. I боть. УБ. 2009. 326 дахь тал.

<sup>82</sup> Гегель Г.В.Ф. Работы разных лет : в 2 т. /Г.В.Ф. Гегель. М. 1971. Т. 2.

Парижийн Вангийн Вильгелем Де Рүпрүк усан замаар аялан Крымээс Монгол Улс руу аялах аянаа хуурай замаар үргэлжлүүлэн их хаанд бараалхсан тухай баримтууд түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн байх бөгөөд гадаадын зочид төлөөлөгчид Эртний Монгол улсад байнга зорчих болсноор Монгол Улсын гол зам XVIII дүгээр зууны сүүл хэсгээр 146 суурь өртөө байснаас Ховд-Улиастай чиглэлд 14, Улиастай-Хаалган чиглэлд 64, Ховд-улаангом чиглэлд 8, Их хүрээ-Улиастай чиглэлд 32, Их хүрээ-Хиагтын 11 чиглэлд замыг хуваарилан нарийн зохион байгуулалтад оруулан шийдвэрлэж байжээ.

Зураг 1. Шагдар Судар бичгийн хүрээлэнд бэлэглэсэн автомашины гэрэл зураг.



Хувьсгалын он жилүүдэд шарын шашны сүм хийдийн барилга, байгууламж, малчин ардын нүүдэллэн суурьших үйл ажиллагаанд зам харилцааг ашиглан “Чигийн урьдчилсан заалт”, “Чигийн заалт” тэмдэглэгээнүүдийг Монголчууд анх гаргажээ хэмээн үзэж байгаа юм.

XX зууны эхэн үеэс Орос, Хятад улсаас наймаа эрхэлж, манай улсаас түүхий эд авдаг гадаадын худалдаачдын пүүс хоршоодын цөөн тооны автомашин хөдөлгөөн үйлддэг байсан бөгөөд Богд хаан, Сайн ноён хан, Түшээ гүн, Бэйс Лувсанцэрэн зэрэг ноёд 10 тоонд багтахуйц автомашиныг унаж хэрэглэдэг байсан тухай баримт байдаг. Механикжсан техник буюу автомашиныг нэвтрүүлэх саналыг гадаад орнуудаас манай улсад тавьж 1913 онд Германы худалдаачин Вейнерман Нийслэл хүрээ-Хиагтын чиглэлээр хувиараа шуудан тээвэр хийж, 1914 онд автомашин зам ашиглаж эхэлсэн тухай баримт мөн тэмдэглэгдэн үлдсэн байх бөгөөд Хятад Улсаар дамжин европын орноос Монгол улсад олноор ирж, 1918 оноос Их хүрээ-Хаалганы чиглэлийн зам автомашины хөдөлгөөнтэй болж, Монгол хүн ч автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглан авто замыг ашиглаж зам тээврийн хөдөлгөөн эхэлсэн байдаг<sup>83</sup> бол Монгол Улсад 1920 онд Улаан гэлэн хэмээх хүн

<sup>83</sup> <https://mra.mn/>.

1920 онд чийчаан оруулж ирэн Цэцэг Шагдар гэх хөдөө хэд хэдэн гуанзтай, Ардын намын нөлөө бүхий албан тушаалтнуудтай дотно нөхөрлөн тэр үеийн баячуудын нэгэнд арилжжээ. Хоёрдахь машиныг манай оронд ирсэн газарзүй судлаач байгаль зүйч Д.Эндрюс гэх эрдэмтэн эзэмшиж байсан бөгөөд тэрээр нутаг буцахдаа Богд хаан бэлэглэж, Богдын жолооч буриад Бадам Монголын анхны авто ослыг 1921 онд гаргасан бөгөөд уг мөргөлдсөн автомашиныг Цэцэг Шагдар Судар бичгийн хүрээлэнд бэлэглэсэн байна. /зураг 1/

Зам тээврийн харилцаа үүссэнээс хойш хамгийн анх буюу 1896 оны 08 дугаар сарын 17-нд Лондон хотноо анхны авто осол бүртгэгдэн тэр жилдээ 2 хүн зам тээврийн ослоор нас барсан тухай бүртгэгдэн үлджээ. Монгол улсад анх бүртгэгдсэн зам тээврийн ослыг 1920 онд автомашины осол гарах болсноор тухайн үеийн удирдах төрийн байгууллагын анхаарлыг татаж, осол, аюудаас хамгаалах хууль, дүрэм журмыг батлахаар тогтсон бол Хятад пүүсийн жолооч Бронштейн 1923 онд согтуугаар автомашин жолоодож яваад цэргийн албан хаагч Дамчааг дайрч амь насыг нь бүрэлгэж байсан бол Хятад Далайн пүүсийн жолооч Ты Юань Куй 1925 онд автомашинтайгаар хашааны гадаа тоглож байсан П.Долгорсүрэн охиныг дайрч, амь насыг нь хохироосон бол мөн онд “Центрсоюз” Орос хоршооны автомашин Шавь яамны жолооч Загдын унаж явсан машинтай, мөн Цэргийн яамны жолооч Сышиков автомашинтайгаар хурд хэтрүүлж яваад Дотоод явдлын яамны туслах түшмэл Цогбадрахын хүү Доржготовыг дайрч хүнд бэртээсэн зэрэг зам тээвэртэй холбоотой хэрэг учралууд тэмдэглэгдэн үлджээ.

Тухайн цаг хугацаанд зам тээвэр, автомашины талаар мэдлэггүй иргэд зам тээврийн осолд орж, амь нас, эрүүл мэндээрээ хохирсон асуудлын тоо нэмэгдсээр байсантай холбогдуулан, Шүүх явдлын яам хөдөлгөөнийг журамлах, автомашины хурдыг хязгаарлах дүрэм тогтоолгохоор Засгийн газарт уламжлан, улмаар Засгийн газраас дэмжлэг авч 1925 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар хурлаар “Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм” гэгч 21 зүйл бүхий манай улсын анхны Замын хөдөлгөөний дүрмийг баталж байжээ.

Уг дүрмийн 1 дүгээр зүйлд “Энэхүү дүрэг хэмжээг шийтгэн тогтоосон учир нь: Аливаа гал усны хүчээр явдаг юм ачих ба хүнийг зөөх зэргийн тэрэг нааш цааш явахад доор жагсаасан дүрмүүдийг ёсчлон дагаж хойч өдөр хүн малыг дайрах мэтээр хэрэг гаргахыг хянуулбаас зохимой”<sup>84</sup> гэж заасан нь зам тээврийн осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлийг баримталж гаргасан баримт бичиг гэлтэй байна.

Мэдээж хэрэг, бүхэл бүтэн улсын түвшинд хэдхэн тооны автомашин байгаа нь манай иргэдийн хувьд нэн шинэ зүйл байсан нь ойлгомжтой байлаа. Ийм шинэ харилцааг зохицуулах тал дээр ч тэр, туршлага тун сул байсан нь аливаа зам тээврийн холбогдолтой ослыг хэрхэн шийдэх, хэрхэн маргааныг арилгаж, хохирлыг барагдуулах хүртэл асуудал тулгарах нь зүй ёсны хэрэг байсан гэж үзэх үндэстэй.

Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрмийн 2 дугаар зүйлд тээврийн хэрэгслийг тус бүрийн дугаартай, бүртгэлтэй байлгах үүднээс “Монголын хязгаар дотор ажил хийж буй тэрэг бүр Аж ахуйн явдлын яамны шийтгэн үйлдүүлсэн европын ба монголын тоогоор бөгөөд томоор бичсэн зэрэг маяг

---

<sup>84</sup> Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм. 1 дүгээр зүйл.

хэмжээний дугаарыг хоёр хувь авч тэрэгний өмнө хойно хоёрт ил газар өлгөж явбаас зохимой”<sup>85</sup> гэж хуульчилжээ.

Уг дүрэмд “Хот ба хэсэг айлын зэрэг хүн, мал олонтой газруудад уурын тэргийг нэг цагийн дотор 15 миль (24 км/цаг)-ээс хэтрэхгүйгээр явуулваас зохимой”, “Нарийн ба багахан мухар гудамжид буюу зах зээлийн зэрэг олон хүнтэй газруудад цагт 5 миль (8 км/цаг)-ээс хэтрэхгүйгээр явуулваас зохимой” хэмээн тодорхой байдлаар дүрэмд тусгаж, жил бүр буюу 1925 оноос өнөөг хүртэл 11 удаа шинэчлэгдэн батлагдаж, 5 удаа нэмэлт оруулан өөрчлөн сайжруулж, шинэчилсээр ирсэн нь тухайн үеийн хүмүүст тээврийн хэрэгсэлтэй харьцах соёл, хууль сурталчлах үйл ажиллагааны эхлэл болж байв.

Монгол Улсын замын хөдөлгөөнийг зохицуулах тухай анхны дүрмийг 21 зүйлтэйгээр баталж, анхны дүрмийн 21 дүгээр зүйлд “Жолооч нар дотроос энэхүү дагахгүй зөрчигчид гарваас тэд нарыг Эрүүгийн хуулиар шийтгэхээс гадна шүүх таслах газарт онц хүнд ба чухлыг үзэж уурын тэргийг албанд хурааваас болмой. Басхүү жолооч нарын осол олтгойгоос болсон аливаа сүйтгэлийг тэрхүү тэрэгний уг эзний этгээдээс хөөн төлүүлвээс зохимой” хэмээн дүрмийн зөрчил гаргагсдад хүлээлгэх хариуцлагыг тогтоож<sup>86</sup> байсан бол анхны зам тээврийг зохицуулах заавар 17 дугаар зууны сүүл үед “Морин тэрэгний хөдөлгөөн зохицуулах заавар” нэртэйгээр Франц улсад үүссэн байна.

Энэ мэтээр зам тээврийн хөгжил нь өмнө зохицуулж байгаагүй харилцаа бүрийг шинээр дүрэмжүүлж, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн бүтээх ажиллагааны зарчимч байр сууринд тулгуурлах замаар явагдаж, тухайн цаг үеийн нийгмийн чухал харилцаа болох хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтны хэвийн амьдрах боломжийг бүрдүүлэхэд чиглэхээс гадна тээврийн хэрэгслийн цаашдын тархац, нийтийн хэрэглээ зэргийг олон талаас нь харахыг эрмэлзсэн, түүхэн чухал үе шатыг дамжиж өнөөг хүрчээ.

Тэгвэл өнөө цагт хэрэгжиж буй Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журам нь хөгжлийнхөө энэ үе шатад хүрэхийн тулд олон цаг хугацааг дайрсан бөгөөд, онол болон практикийг хослуулах тэргүүн шаардлагын дагуу олон тооны нэмэлт, өөрчлөлттэй нүүр тулан, улам баяжигдаж ирсэн юм.

Монгол Улсын хууль, эрх зүйн хөгжилтөд 1921 оны Ардын Хувьсгал шинэ үеийг нээсэн юм. Алдын хувьсгал ялснаар, хуучин төрийн аппаратыг устгаж, түүний хууль цааз, ёс суртахууныг халахгүйгээр, ардчилсан өөрчлөлтийг гүнзгийрүүлж болохгүй байв.

Хуучин төрийн хуулийг хүчингүй болгох, шинэ хууль ёс, эрх зүйн хэм хэмжээг тогтоох энэхүү хоёр арга хэмжээг Ардын Засгийн Газар нэгэн зэрэг гүйцэтгэж байв. Ардын Түр Засгийн Газар Нийслэл хүрээнд шилжин байрлаж, улс орны дотоод тулгамдсан асуудлыг өөрийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, хуульчилсан актуудыг гаргаж эхэлжээ.

Монгол Улсад хамгийн анхны Эрүүгийн хуулийг 1926 онд “Шүүх цаазны бичиг” хэмээх нэртэйгээр гаргасан гэж судлаачид үздэг. Харин 1934 он гэхэд манай улсын бүх хуулиуд Зөвлөлт холбоот улсын ижил төрлийн хуулийн хэв, загварыг хуулбарлан авсан байна. Шүүх цаазны бичгийг 1942 онд Эрүүгийн хууль болгон өөрчлөн нэрлэжээ. Энэ нь орос үгийг шууд махчлан орчуулсан хэрэг байв<sup>87</sup>.

1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар их хурал хуралдаж, тус улсыг “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж тунхаглаж, анхдугаар Үндсэн хуулийг батлан, Үндсэн хуульд улсын дээд эрхийг барих газрын эрхлэх асуудлын дотор

<sup>85</sup> Мөн тэнд. 2 дугаар зүйл.

<sup>86</sup> <http://www.traffic-institute.mn/>.

<sup>87</sup> <http://uridchilan-sergiileh.police.gov.mn/>.

“Улсын Шүүх Таслах Газрууд ба хэргийг явуулах дүрэм, хэмжээ, мөн Иргэний ба Эрүүгийн хууль зүйлийг тогтооно” гэж заасан байна.

1926 оны Шүүх цаазны бичгийн 14 дүгээр бүлэг (Хүн ардын амгалан байдлыг сахих тухай хууль дүрмийг зөрчих нь)-т тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчихтэй холбоотой хоёр гэмт хэрэг хуульчлагджээ. Тухайлбал, 97 дугаар зүйлд “Аливаа хот ба хүн ард олноор цугларан хуралдсан газрууд дор морь ба тэрэг зэргээр болгоомжгүйгээр довтлон явагсдыг 30 хоног хүртэл хорихгүйгээр үйлдвэр хийлгэх буюу 30 төгрөг хүртэл торговоос зохимой”<sup>88</sup> хэмээн энэ гэмт хэргийн үйлдлийг, оногдуулах ялын хамтаар хуульчилсан байна. Мөн 98 дугаар зүйлд “Уурын тэрэг ба гал усны хүчээр хөдлөх машин бүхий тэргээр явахдаа тогтоосон дүрэм хэмжээг зөрчигсдийг 2 сар хүртэл гяндан хорих буюу 100 төгрөг хүртэл торговол зохино”<sup>89</sup> гэж хариуцлагыг чангаруулсан байна. 97 дугаар зүйлтэй харьцуулахад, хохирол, хор уршгаараа хавьгүй өндөрт тооцогдох гэмт хэрэг учир хариуцлагын тогтолцоог чангатгасан байх ба 97 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь болгоомжгүйгээр үйлдэгдэх тул хариуцлагын тогтолцоо хавьгүй хөнгөн байжээ.

1929 оны Шүүх цаазны бичиг нь дээрх баримт бичгийн сайжруулсан хувилбар болсон бөгөөд уг Шүүх цаазны бичгийн 104, 105 дугаар зүйлд заасан үйлдэл нь 1926 оны Шүүх цаазны бичигтэй тун ижил байдлаар хуульчлагдсан байдаг бол 1934 оны Шүүх цаазны бичигт энэ төрлийн гэмт хэргийг огт тусгаагүй ажээ. Харин 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 74 дүгээр зүйлд “Зам тээврийн ажилчдаас хөдөлмөрийн сахилга бат ба явж зорчих журмыг эвдэж, хэрэв тээврийн хэрэглээнд эвдрэл, сүйтгэл, мөн түүнчлэн хүмүүст аюул тохиолдох явдлыг учруулсан байвал 10 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино”<sup>90</sup> хэмээн заасан нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэж тооцох, тухайн үйлдэлд хариуцлага хүлээлгэх цор ганц зүйл анги хуульчлагдаж, түүгээр зохицуулагдаж байсан нь учир дутагдалтай байжээ.

1942 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулиас хасаж, нийгэмд аюултай зарим үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуульд нэмэлт оруулсан.

Эдгээр нэмэлтээр тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэд хэдэн гэмт хэргийг нийгмийн аюулын шинж өндөртэй гэмт хэрэгт тооцож, шинэ Эрүүгийн хуульд нэмсэн явдал нь одоогийн хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн үзэл баримтлал үүсэх үндэс, суурь болсон байна.

1961 оны Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг (Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг)-т зам тээврийн харилцааг зохицуулах шинжтэй, энэ төрлийн үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх 5 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсан. Үүнд:

| № | Зүйл анги                                | Диспозиц                                                                          | Санкц                                      |
|---|------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|
| 1 | 172 дугаар зүйл.<br>Зам тээврийн ажилтан | Төмөр зам, усан ба агаарын тээврийн ажилтан хөдөлгөөний аюулгүй байлгах ба тээвэр | 2-12 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ |

<sup>88</sup> Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. Уб., 1998. 21 дэх тал.

<sup>89</sup> Мөн тэнд. 21 дэх тал.

<sup>90</sup> Мөн тэнд. 119 дэх тал.

|   |                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                         |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | хөдөлгөөнийг аюулгүй байлгах ба тээвэр ашиглалтын дүрэм зөрчих                                      | ашиглалтын дүрэм зөрчиж хүмүүст аюул учруулсан, онхолдуулж, мөргөлдүүлсэн буюу бусад ноцтой хор хохирол учруулсан эсхүл тээврийн хэрэгсэл, зам, дохио, холбооны хэрэгслийг чанаргүй муу зассанаас дээр дурдсан хор аюулд хүргэвэл                                                      |                                                                                                                                                         |
| 2 | 173 дугаар зүйл. Зам тээврийн талаар дагаж мөрдөж байгаа дүрэм зөрчих                               | Төмөр зам усан ба агаарын тээврийн хөдөлгөөнийг аюулгүй байлгах зорилгоор тогтоосон дүрмийг хэн нэг хүн зөрчсөнөөс хүмүүст аюул учирсан, галт тэрэг онхолдож сүйдсэн буюу бусад ноцтой хор хохирол учирсан бол                                                                         | 7 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ                                                                                                                 |
| 3 | 174 дүгээр зүйл. Хөдөлгөөнийг аюулгүй байлгах автоторт буюу цахилгаан тээврийг ашиглах дүрэм зөрчих | Автомашин, мотоцикл буюу цахилгаан тээврийн болон өөрөө явагч бусад машин, механизм жолоодож явахдаа хөдөлгөөнийг аюулгүй байлгах, автоторт буюу цахилгаан тээврийг ашиглах дүрэм зөрчиж, бусдын бие махбодид гэмтэл учруулсан буюу эд материалын үзэмжхэн хохирол учруулсан жолоочийг | 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэж 2 жил хүртэл хугацаагаар техник жолоодох эрхийг хасна |
| 4 | 174 дүгээр зүйл 1. Автомашин мотоцикл өөрөө явагч бусад машин механизм ашиглах                      | Автомашин мотоцикл өөрөө явагч бусад машин механизмыг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрт зориулан түр ашигласан байвал                                                                                                                                                               | 2 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл 1000 хүртэл төгрөгөөр торгож шийтгэнэ                       |
| 5 | 175 дугаар зүйл. Зам харилцаа тээврийн хэрэгслийг гэмтээх ба сүйтгэх                                | Зам харилцаа, түүний төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүн, хөлөг онгоц, холбооны ба дохионы хэрэгслэлийг санаатайгаар эвдсэн буюу сүйтгэсний улмаас галт тэрэг хөлөг онгоц онхолдож сүйрсэн буюу тээвэр холбооны хэвийн ажиллагааг ноцтой зөрчвөл                                             | 3-15 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ                                                                                                              |

Тээврийн хэрэгслийн төрөл, хэлбэр маш ихээр өргөжиж байсан болох нь төмөр зам, усан ба агаарын тээвэр гэх ангилал үүссэн байгаагаас харагдаж байх бөгөөд автомашин, мотоцикл буюу цахилгаан тээврийн болон бусад машин механизм гэх өргөн хүрээний техник хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын

журам зөрчсөн үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох болсон нь тухайн үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагатай нөхцөлджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, халдлагын зүйлийн төрөл, субъект болон үйлдлийн шинж чанарыг харгалзан хэд хэдэн төрлийн зүйл ангиар хуульчилж, хариуцлага хүлээлгэх болсон нь нийгмийн хөгжлийн түвшин, хүн амын хэрэглээнээс үүдэлтэй хэрэгцээ, улсын хөгжлийн өөрчлөлттэй салшгүй холбоотой байсныг хууль тогтоогч гярхай ажигласны үр дүн бөгөөд тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тогтолцоо, хүлээлгэх хариуцлагыг сайжруулах нөхцөл болсон нь 1961 оны Эрүүгийн хуульд нэмэлтээр хуульчилсан зүйл, ангиудаас харагдаж байна.

Энэхүү сайн үндэс, хөрсөн дээр илүү сайжруулалт хийгдэж, үзэл баримтлал, тогтолцооны түвшинд өөрчлөгдсөн нэг зүйл нь 1986 оны Эрүүгийн хуульд тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг төрөлжүүлж, тусдаа бүлэгт хувааж, олон тооны харилцааг зохицуулж, ялыг ялгамжтай оногдуулж байснаас ажиглагдаж байна.

Урьд өмнөх Эрүүгийн хуулиудад ингэж бүлгээр ангилан, ялгалгүй, зөвхөн нийгмийн хэв журмыг ноцтой зөрчдөг гэмт хэрэг болох дээрэм, танхай гэх мэтийн хэрэгтэй хамт нэг бүлэгт төрөлжүүлж байсан нь тухайн цаг үед манай улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил султай байсны илрэл юм. Өөрөөр хэлбэл, орчин цагт гэмт хэргийг халдлагад өртөгдөж байгаа эрх ашиг, тодорхой бүлэг нийгмийн харилцаанаас хамаарч, бүлгүүдэд хувааж, системтэй хуульчилж байгаа бол тухайн цаг үед энэ ойлголт хараахан тогтоогүй байжээ.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр гэмт хэргүүдийг адил төстэй шинж чанар, халдлагад өртөж буй нийтлэг шинжээр нь тодорхой бүлгүүдэд хуваах тогтолцоо 1986 оны Эрүүгийн хуульд түлхүү ажиглагддаг бөгөөд чухам энэ цаг үеэс эхлэн манай улсын Эрүүгийн хууль харьцангуй системтэй болсон гэхэд болно.

1986 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэг нь “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”<sup>91</sup> гэх нэршилтэй байсан нь энэ бүлэгт зөвхөн тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүдийг хуульчлах гэсэн хууль тогтоогчийн үзэл хандлага харагдана. Энэ бүлэгт тээврийн хэрэгсэлтэй холбоотой олон тооны гэмт хэргийг хуульчилсны дотор бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах буюу согтуу жолоочоор тээврийн хэрэгсэл жолоодуулах, согтуу үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, жолоогоо бусдад дур мэдэн шилжүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь дэвшилттэй алхам болсон.

1980-аад оны дунд үеэс Баруун Европын социалист тогтолцоотой зарим улсууд тэрчлэн ОХУ-д өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт, ил тод байдлыг үзэл санааны нөлөө Монгол улсад хүчтэй нэвтэрч, улмаар 1990 оны эхээр манай улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хуучин тогтолцоог үндсээр нь өөрчилсөн ардчилсан хувьсгал ялах нөхцөл болсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлсэн бусад хуулиудыг бүхэлд нь шинэчлэх шаарлага тулгарсан. Иймээс 1986 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн удаа томоохон хэмжээний нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд, энэ нь улс төрийн ардчилсан дэглэмтэй, хүний эрхийг эрхэмлэн дээдэлсэн төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байсан.

Эрүүгийн хуульд бараг жил тутам шахуу элдэв өөрчлөлт оруулж, засварлах арга хэмжээ авч байсан хэдий ч, шинэ нөхцөл байдалд үр дүнтэй үйлчлэх

<sup>91</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=71066>.

боломжгүй байдалд шууд хүргэж байсан, хуучирсан олон хэм хэмжээ, хийдэл, хоцрогдолыг засах, эрүүгийн хуулийн хамгаалах чиг үүргийг өндөржүүлэх, Үндсэн хуулийн агуулга, үзэл санаа, нийгмийн эдийн засгийн шинэ тогтолцооны бодит хэрэгжилтэнд нийцүүлэх шаардлагууд нь Эрүүгийн хуулийг бүхэлд нь шинэчлэх үндэслэл болсон юм. Эрүүгийн шинэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр ерөнхий ангийг 4 хэсэг, 13 бүлэг, 78 зүйлтэйгээр, тусгай ангийг 7 хэсэг, 16 бүлэг, 225 зүйлтэйгээр баталж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн<sup>92</sup>.

Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн, ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд анхаарал хандуулахыг зорьж, Эрүүгийн хуулийн зарчмуудад хүний эрхийг хамгаалах чиглэлийн үзэл баримтлалыг ихээр шингээж, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн бүтэц, тогтолцоонд өөрчлөлт оруулсан боловч аливаа төрийн эсрэг гэмт хэргийг чухалчлан үздэг байсан жишиг хэвээр үлдсэн.

2002 оны Эрүүгийн хуульд тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тусдаа бүлэг “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” нэртэйгээр, нийт 11 гэмт хэргийг хуульчилсан. Мэдээж хэрэг, өмнөх Эрүүгийн хуулиудтай харьцуулахад, гэмт хэргүүдийн бүтэц, төрөл, хэлбэр сайжирсан. Тэр дундаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газрыг орхиж зугтаах үйлдэлд хариуцлага хүлээлгэх зүйл анги хуульчлагдсан нь нэн шинэ алхам болсон.

Жолооч зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаах явдал түгээмэл байсан боловч ямар нэгэн хариуцлага хүлээдэггүй байсан нь хуулийн хийдэл болж байсан явдлыг 2002 оны Эрүүгийн хуулиар үгүй болгосон.

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжин орсон тул хүний эрхийг дээдэлсэн хуулийг батлан гаргах шаардлага үүссэний зэрэгцээ өмнөх хууль нь практикт хэрэглэхэд төвөгтэй, ялын бодлогын хувьд үр нөлөө багатай олон зүйл, заалтыг төрийн бодлого, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулийг 2015 онд Монгол Улсын Их Хурлаар баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж, хамгийн сүүлд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Шинэ Эрүүгийн хууль нь үзэл баримтлал, зорилго, зорилтын хувьд бусад хуулиас нэлээд өөр байдлаар тусгагдаж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг нэн тэргүүний зорилго болгож, хүний амь бие, эрүүл мэнд, халдашгүй байдлыг анхааран үзэж, улмаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүтэц, тогтолцоонд томоохон өөрчлөлт оруулсан. Эрүүгийн хуулийн тусгай анги “Төрийн эсрэг гэмт хэрэг”-ийн бүлгээр эхэлдэг байсныг өөрчилж, “Хүний амьд явах эрх”-ийн эсрэг гэмт хэргийг тусгасан нь нийгэм дэх хүний үнэ цэн өссөний тод жишээ юм.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.11 дүгээр зүйлийн диспозицод “Энэ хуулийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн жолооч хэргийн газрыг зориуд орхиж зугтаасан бол” гэж заасан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газрыг орхиж зугтаасныг ойлгохоор хуульчилсан явдал нь 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлд заасан “Жолооч зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан” гэх үйлдлийг харьцангуй нарийвчилж, тодорхой болгосон гэж үзэж байна.

## Дүгнэлт

---

<sup>92</sup> Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 108 дахь тал.

1. Зам тээврийн салбар үүсэн би болсон цагаас эхлэн хөдөлгөөний зохицуулалт, хариуцлагын тусгасан баримт бичгүүдийг боловсруулан мөрдүүлж ирсэн байна. Нийгмийн хөгжлийн үе шат, тогтолцоогоо дагаж өөрчлөгдөж нарийвчлан сайжруулах байдлаар хөгжүүлэн авч ирсэн бөгөөд тухайн нийгмийн хөгжил, тогтолцооноос хамаарч зам тээврийн салбарын үйл ажиллагааны дүрэм, журмын болон зохицуулалт хувьсан өөрчлөгдсөөр өнөөг хүрчээ.

2. 1942 оны Эрүүгийн хуулиар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт зохих анхаарал хандуулахгүй байгаа нь энэ үйлдлийг цор ганц зүйл ангиар зохицуулахаар хуульчилснаас харж болох бөгөөд нэлээд учир дутагдалтай байжээ.

3. Хууль тогтоогч энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, халдлагын зүйлийн төрөл, субъект болон үйлдлийн шинж чанарыг харгалзан хэд хэдэн төрлийн зүйл ангиар хуульчилж, хариуцлага хүлээлгэх болсон нь нийгмийн хөгжлийн түвшин, хүн амын хэрэглээнээс үүдэлтэй хэрэгцээ, улсын хөгжлийн өөрчлөлттэй салшгүй холбоотой байдлыг олон талаас харж, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тогтолцоо, хүлээлгэх хариуцлагыг сайжруулсан нь 1961 оны Эрүүгийн хуульд заасан зүйл ангиудаас харж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь цаашдын хөгжлийн сууль болсон.

4. 1986 оны Эрүүгийн хуульд тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг төрөлжүүлж, тусдаа бүлэгт хувааж, олон тооны харилцааг зохицуулж, ялыг ялгамжтай оногдуулж байсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийг үр дүнд хүргэх чухал алхам болжээ.

5. 2002 оны Эрүүгийн хуулиар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газрыг орхиж зугтаах үйлдэлд хариуцлага хүлээлгэх зүйл анги хуульчлагдсан нь нэн шинэ алхам болжээ.

6. 2015 оны Эрүүгийн хуульд тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгээд, энэ гэмт хэргийг үйлдсэн этгээд хэргийн газрыг орхиж зугтаасан тохиолдолд тусдаа гэмт хэрэгт тооцох болсон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог илүү сайжруулсан.

### **Ашигласан материал**

1. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. УБ., 1998.

2. Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм.

3. Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011.

4. Гегель Г.В.Ф. Работы разных лет : в 2 т. /Г.В.Ф. Гегель. М. 1971. Т. 2.

5. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Гэмт хэргийн тухай сургааль. I боть. УБ. 2009.

Цахим эх сурвалж

6. <http://uridchilan-sergiileh.police.gov.mn/>.

7. <http://www.traffic-institute.mn/>.

8. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=71066>.

9. <https://mra.mn/>.

# ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, НИЙГМИЙН АЮУЛЫН ШИНЖ

## UNDERSTANDING OF THE CRIME OF ILLEGAL, SOCIAL HAZARDS

*Б.Энхцогт*

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн тухай ойлголтыг тодорхойлж, нийгмийн хор аюул, мөн чанарын талаар болон Эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн хуульчлан тусгаж өгч байсан, байгаль экологид учруулж буй хор хөнөөлийн талаар тусган, үндэслэлтэй дүгнэлт хийж, санал дэвшүүлэхийг зорилоо.

**Abstract:** The aim is to define the concept of illegal logging as a crime, to make reasonable conclusions and to make suggestions about the dangers and nature of the community, how it has been legislated in criminal legislation, and the harm it causes to the environment.

**Түлхүүр үгс:** Байгаль орчин, байгалийн баялаг, нийгмийн хор аюул, ой мод, ойн сан, экологи.

**Keywords:** Environment, Natural Resources, social hazards, forests, Forestry and ecology.

Хүн төрөлхтөн бид ганцхан дэлхийтэй, хүмүүс орших уу, эс орших уу гэдэг асуудал байгаль дэлхийгээс шууд хамааралтай. Хүн төрөлхтний оршин тогтнох өлгий болсон хүрээлэн буй орчноо танин мэдэж, түүний нөөц баялаг, Ой модыг зүй зохистой ашиглахын зэрэгцээ нөхөн сэргээж хайрлан хамгаалах нь дэлхий нийтийн амин чухал асуудлын нэг билээ. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг нь байгалийн баялгийг ашиглах явцдаа холбогдох хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, хор уршиг учруулсан, нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлдэг.

Хүн байгаль орчинтойгоо зүй бусаар харьцаж эдийн засгийн хөгжлийг гол болгож ирсэний улмаас экологийн тэнцвэрт байдал алдагдан ойн баялаг болох модыг устгаснаар ган, цөлжилт, усны үер, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн гамшгийн цар хүрээ, давтамж урд өмнөхөөс эрс ихсэж дэлхий даяараа дулаарал, озоны давхаргын нимгэрэл, уур амьсгалын өөрчлөлтүүд зэрэг хурц асуудлуудтай тулгараад байна. Эдгээр гамшгийн дотроос дэлхийн олон улс оронд асар их түгшүүр төрүүлж, нөлөө үзүүлж буй нь байгалийн гол хүчин зүйл болсон модыг хууль бусаар бэлтгэн, устгаж буй явдал юм.

Манай орны Ойн сан бүхий газар 2020 онд 11.8 хувь байсан бол 2022 оны байдлаар 14256.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг л эзэлж байна. Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12108.9 мянган га буюу 84.9 хувийг, ой модыг нь огтолсон газар 133.0 мянган га буюу 0.9 хувийг, мод үржүүлгийн газар 63.3 мянган га буюу 0.4 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 719.0 мянган га буюу 5.0 хувийг, ойн сангийн бусад газар 1232.4 мянган га буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна<sup>93</sup>.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь нь цөлжилтөд өртсөн бөгөөд энэ эрчим хэвээр байвал 2080 он гэхэд манай улсын 80 хувь нь элсэн цөл болон хувирах дүр зурагтай байна.

<sup>93</sup> <https://www.gazar.gov.mn/p/527-108>.

“Экологийн эрх зүй” бүтээлд Монгол улс өөрийн нутаг дэвсгэр дэх байгаль орчныг хамгаалах, түүний тэнцлийг хангах асуудлыг төрийн бодлогын хэмжээнд тавьж, хууль тогтоомжоо шинэчлэн үндэсний эрх зүйгээр зохицуулахын хамт олон улсын экологийн эрх зүйн харилцаанд идэвхитэй оролцож байна<sup>94</sup> гэсэн нь Байгалийн баялгийг зүй зохистой ашиглахад зохицсон аж ахуйн уламжлалт болон орчин үеийн нийтлэг хэвшлийг хослуулан хөгжүүлэх замаар байгалийн баялаг болох ой модыг нөхөн сэргээж, төрх байдлыг нь хамгаалж, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход төрөөс экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн сан бүхий газраа хамгаалах, нөхөн сэргээх талаар баримтлах бодлого нь тэргүүн чиглэлийн нэг юм.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд “Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол...”<sup>95</sup> гэж хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.

Байгаль, нийгмийн харилцан үйлчлэлийн хүрээнд байгалийн хязгаарлагдмал нөөц баялгаар улам бүр өсөн нэмэгдэж буй хүний хэрэгцээг хангах асуудал нь экологийн хямралт байдлын эх үүсвэр болдог. Экологийн доройтол, агаар, ус бохирдох, ой мод устгах, байгалийн тэнцвэр алдагдах зэрэг нь хүний зүй бус үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг гэж хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрөөс газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, ой мод, амьтны аймаг, агаарт халдаж хор хөнөөл учруулсан буюу учруулах боломжтой нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсныг хэлнэ.

Байгалийн шавхагдах нөөц баялаг болох ой модыг усгаж гэмтээж байгаа нь экологийн аюулгүй байдал болоод хүмүүсийн өөрсдийн амьдралд шууд сөргөөр нөлөөлж байдаг. Иймд Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилж болдог.

Анх 1986 оны Эрүүгийн хуулийн 187 дугаар зүйлд “...ойг хууль бусаар огтолсон, гэмтээсний улмаас их хэмжээний хор уршиг учирсан бол” гэмт хэрэгт тооцохоор заасан боловч тэр үед их хэмжээний хор уршиг гэдгийг Улсын Дээд шүүхийн тогтоолоор 1.5 сая төгрөгөөс дээш хэмжээний хохирлыг тооцохоор заасан болон 1 шоо метр модны экологи-эдийн засгийн үнэлгээ нь 12,000 төгрөг байсантай холбоотойгоор эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байсан.

2002 оны Эрүүгийн хуулийн 211 дүгээр зүйлд “...зохих зөвшөөрөлгүйгээр ойд үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэсэн. онцшой бүсийн болон ногоон бүсийн ой, хориотой зурвасын ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол” гэж обьектив талыг тодорхойлсон нь амьдралд нийцэхгүй байгаагаас ой модыг дур мэдэн их хэмжээгээр ашиглах болсон. Энэ үед ой модыг үйлдвэрлэлийн зориулалтын дагуу ашиглах эрх олгох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн

<sup>94</sup> Сэнгэдорж Т. Экологийн эрх зүй. УБ., 2009. 277 дахь тал.

<sup>95</sup> Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

бэлтгэх, ой модыг ариун цэвэр, арчилгааны журмаас гадуур огтолж гэмтээх зэрэг үйлдлээр гэмт хэрэг илэрдэг байсан.

2017 оны Эрүүгийн хуульд дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан Ойн тухай хууль зөрчих үйлдлийг Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлээр зөрчилд тооцсон. Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан үйлдэл нь гэмт хэрэг болохоор заасан бөгөөд энэ гэмт хэргийн объектив шинж болно.

- Байнга тогтвортой, бүлэглэж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд халдаж, төрийн албан хаагч үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдал болно;

- Бага бус буюу үлэмж хэмжээний хохирол шаарддаг байсныг халж хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгож томьёолсон;

- Хуулийн нэр, томъёо ухагдахууныг тайлбарлахад Ойн тухай хуулийн зүйл заалтыг үнэлж ашигладаг.

Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн гэж сум дундын болон сум, дүүргийн ойн анги байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтнаас мод бэлтгэх эрхийн бичиг авахгүйгээр эсхүл эрхийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлж, эрхийн бичигт зааснаас өөр төрлийн мод, өөр ойгоос мод бэлтгэснийг ойлгоно.

Мод бэлтгэх эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын нэр хаяг, бэлтгэх модны төрөл, хэмжээ, бэлтгэх, тээвэрлэж дуусах хугацаа газрын нэрийг заана. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглодог.

Гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан гэж иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага нь ойгоос бэлтгэсэн мод, гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдахдаа сум дундын болон сум, дүүргийн ойн анги (байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан)-аас гарал үүслийн гэрчилгээ авалгүйгээр тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсныг ойлгоно.

2017 оны Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл 11-д “Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтыг хүчингүй болгож Ойн тухай хуулийн 35.4 дахь заалтад нэмэлтээр “Мод бэлтгэж байгаа зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд нь талбай тусгаарлалт хийсэн талбайгаас мод бэлтгэхдээ хэтрүүлсэн үйлдэл” гэж нэмж оруулснаар мод модон материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдэх юм.

Хүрээлэн байгаа орчин нь мөнхийн, бодитойгоор оршин тогтнож байдаг, заяагдмал төрөл зүйлс, материаллаг ертөнцийн тогтолцоо, объектуудын нэгдэл бөгөөд Экологийн аюулгүй байдал гэдэг байгаль, цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөц, ой модыг зүй зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байх явдал юм.

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Ой гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг хэлнэ”<sup>96</sup> гэж заасан.

---

<sup>96</sup> Ойн тухай хууль. УБ., 2012. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №22. 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг.

1992 оны Рио-Де-Жанейрогийн чуулга уулзалтаас гаргасан Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаарх тунхаглал, Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гарын авлагад улс орны “Тогтвортой хөгжил гэдгийг Эдийн засгийн үр ашигтай, нийгэм нь шударга хариуцлагатай, байгаль орчинд зохистой хөгжлийн хандлага бөгөөд тогтвортой хөгжлийн үндсэн шаардлага нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг нэгийг нь нөгөөгөөс салгахгүйгээр, ээлж дараалал тогтоохгүйгээр хамтад нь шийдвэрлэж байх явдал”<sup>97</sup> гэж хөгжлийн зарчмыг тодорхойлсон байна.


“Монголын орчин цагийн экологийн эрх зүй” бүтээлд Монголчууд ойн баялгийг бурхантай, ээжтэйгээ зүйрлэн хайрлан хамгаалхаас гадна ахуйн зорилгоор зөв ашиглаж чаддаг өнө эртний сайхан уламжлал нь монгол хүний экологийн мэдлэг, соёл, ухаарал арвин байсны илрэл бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хумигдаж арилж байгаа нь маш том гарз<sup>98</sup> хэмээсэн байна.

Манай орны нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг л ойн сан бүхий газар эзэлдэгийн хувьд энэ төрлийн гэмт хэргийн улмаас байгаль экологи, экологийн тэнцвэрт байдалд учруулж буй хор хөнөөл хүндээр тусч байгаа юм.

Монгол Улсад бүртгэгдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6-д заасан “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэг 2020 оноос огцом нэмэгдэж, бүртгэгдэхийн зэрэгцээ байгаль орчинд учруулж байгаа хор уршиг улам ихэссэн байна. Улсын хэмжээнд сүүлийн 8 жилд буюу 2015-2022 онд бүртгэгдсэн “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэргийн статистик тоон мэдээ, нөхцөл байдлыг авч үзье.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2015-2022 онд нийт 3360 хүрч бүртгэгдсэн бол үүний 1549 буюу 46.1 хувийг “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэг эзэлж байна<sup>99</sup>.

Зураг 1. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн тоон үзүүлэлт (сүүлийн 8 жилээр)



Сүүлийн 8 жилийн хугацаанд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн улмаас 1451 иргэн хохирсны 342 буюу 23.6 хувь нь эмэгтэй, 1109 буюу 76.4 хувь нь эрэгтэй байна. Мөн хугацаанд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн улмаас иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжид нийт 5984.4 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 3994.4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн ба нөхөн төлөлт 66.7 хувьтай байна<sup>100</sup>. Монгол Улсад бүртгэгдсэн хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн сүүлийн 8 жилийн тоон мэдээг үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг цаашид ч өсөх төлөвтэй харагдаж байна. Үүнээс үүдэлтэйгээр сүүлийн 70 жилийн дотор Монгол орчны агаарын жилийн дундаж температур 2.140°C-аар дулаарсан байна, Агаар мандалын гаралтай үзэгдэл жилд 25-30 удаа тохиож, 1990 оноос хойшхи

<sup>97</sup> Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаарх тунхаглал. 1992 оны Рио-Де-Жанейрогийн чуулга уулзалт. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл. Гарын авлага. УБ., 2010. 9-10 дахь тал.

<sup>98</sup> Амархүү О. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ., 2009. 27 дахь тал.

<sup>99</sup> ЦЕГ-ын МДШШУА, ЭкоЦА Монгол Улсад 2015-2022 онд бүртгэгдсэн хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн статистик үзүүлэлт. УБ., 2023. 1 дэх тал.

<sup>100</sup> ЦЕГ-ын МДШШУА, ЭкоЦА Монгол Улсад 2015-2022 онд бүртгэгдсэн хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн статистик үзүүлэлт. УБ., 2023. 5 дахь тал.

хугацаанд гурваны нэг орчим байгалийн гамшгийн хэмжээнд хүрч экологи, эдийн засгийн хохирол эрс нэмэгдэв<sup>101</sup>.

Монгол орны жилийн нийлбэр тунадас сүүлийн 60 жилийн дотор 7 хувь 16 мм-р буурав. Үүнээс үүдэж цөлжилт нэмэгдэв. Манай орны нутгийн 41.3 хувь говь цөл бөгөөд нутгийн 76 хувьд цөлжилт сул, 20 хувьд дунд зэрэг, 4 хувьд хүчтэй илэрч байна<sup>102</sup>.

Улсын хэмжээнд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, дуудлага мэдээлэл ихээр бүртгэгдэж буй аймгууд нь Архангай, Булган, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад байна. Энэ төрлийн гэмт хэрэг Архангай, Булган, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт дийлэнх байгаа нь тухайн бүс нутаг нь монгол улсын ойн сан бүхий газрын дийлэх хувийг эзэлдэг газарзүйн байршил, эко системийн онцлог байдал байгаатай холбоотой нь харагдаж байна.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн 65 буюу 4.2 хувь нь нийслэлд, 1484 буюу 95.8 хувь нь орон нутагт бүртгэгджээ. Энэ төрлийн гэмт хэрэг орон нутагт ихээр бүртгэгдсэнээс Архангай, Булган, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт дийлэнх байгаа нь газарзүйн байршил, эко системийн онцлог байдал болон тухайн бүс нутгийн иргэд амьжиргааны эх үүсвэрээ болгож байгаатай холбоотой байна.

Хэргийн илрүүлэлт 2015, 2016 оны дунджаар 83,3 хувьтай байсан бөгөөд тухайн онуудад гэмт хэрэг харьцангуй бага бүртгэгдсэн, 2017-2019 онд хэргийн гаралт өсөхийн хирээр илрүүлэлтийн хувь буурч байжээ.

Экологийн цагдаагийн алба байгуулагдсанаар бүртгэгдсэн хэрэг өссөн хэдий ч, илрүүлэлт дунджаар 81.1 хувьтай буюу 11.1 хувиар өсөлттэй байгаа нь зохион байгуулж буй ажил, арга хэмжээ үр дүнтэй явагдаж байгаа нь харагдаж байна.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн нийгмийн хор аюул нь Экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгаль орчинд шууд байдлаар сөрөг нөлөө үзүүлдэг, харин хүрээлэн буй орчин болон хүний аюулгүй амьдрах орчин, нөхцөлд дам байдлаар нөлөөлдөг, хор уршиг ихтэй нийгэмд аюултай үйлдэл юм.

Гэмт хэргийн ихэнхийг эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний бичиг баримтын тоо, хэмжээ, он сар, цаг хугацааны тэмдэглэгээг засварлах, өөр аймаг сумын гэрчилгээ, эрхийн бичгийг ашиглах, хууль ёсны зөвшөөрлийг хяналт шалгалтад оруулахгүйгээр нэг бичгийг олон дахин ашиглах замаар хууль бусаар бэлтгэсэн модоо тээвэрлэх, худалдаалах үйлдлүүд эзэлж байна. Эрхийн бичиг гарал үүслийн гэрчилгээгүйгээр явж байгаад баригдах үедээ модны эзэнд нь зөвшөөрлийн бичиг байгаа эсвэл араас ирж байгаа, өөр машинд байгаа гэх зэргээр мэлзэх, гарал үүслийн гэрчилгээ нөөцлөн авч явж тэр дор нь шинээр бичих зэрэг олон арга хэрэглэж хариуцлагаас мултрах оролдлого хийдэг байна.

Зохих ёсны зөвшөөрлийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлэн тээвэрлэх, мод бэлтгэх гэрээг (хяналтын карт) хуурамчаар үйлдэх зэрэг арга мөн түгээмэл хэрэглэж байна.

Ойн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, нөхөрлөлийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, гэрээгээр эзэмшиж ашиглаж буй талбай болон гадна талбайгаас дур мэдэн мод, модон материал бэлтгэдэг. Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтэц, бүрэлдэхүүн, таваарлаг чанарыг сайжруулах, хөнөөлт шавж, өвчин, түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн ойн арчилгааны огтлолыг хийдэг “Ойн мэргэжлийн байгууллага”-д

<sup>101</sup> Сэнгэдорж Т. Экологийн эрх зүй. УБ., 2009. 27 дахь тал.

<sup>102</sup> Мөн тэнд. 44 дэх тал.

байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч байнгын хяналт тавьдаггүй байдал нөлөөлж байна.

### **Дүгнэлт**

1. Хүний нийгэм эд баялаг, хэрэглээний өсөлтөөр төсөөлж байсан амьдралын тухай ойлголтоосоо салж, “Хүний хөгжил, Амьдралын чанар, Амьдралын орчин” гэсэн хэмжигдэхүүний орон зайд хөгжлийг томъёолж “тогтвортой хөгжил”-өөр замнаж байна. Хүн төрөлхтөн оюун ухааныхаа хүчээр орчинтойгоо цуг төгөлдөржиж хойч үедээ эдийн баялаг төдийгүй амьдрах чанартай орчин үлдээх үүрэг хүлээж байна.

2. Ойн сан бүхий газрыг эзлэх хувь маш бага манай улсын өмнө тулгараад байгаа глобал хүндрэлийн нэг болох хууль бусаар мод бэлтгэх, ой модыг устгах, Монгол орны экологийн тэнцвэрт байдлын алдагдуулж буй нь томоохон асуудлын нэг болж байгаа хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг үйлдэгдсэн тохиолдол бүрт хэрхэн зөв зүйлчлэх, мөрдөхөд анхаарах зарим арга зүйн шинжтэй зүйлсийг тодорхойлох явдал юм. Гэхдээ манай улс нь хууль бусаар мод бэлтгэсэн аливаа гэмт хэргийг мөрдөх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялыг шударгаар оногдуулахыг эрмэлзэх, нөхөн сэргээх явдал сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа билээ.

3. Хууль бусаар мод бэлтгэх, байгалийн тэнцэл алдагдах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл улам бүр хомсдож байгаа нь объектив заналхийллийг бий болгож байна. Хүний буруутай үйл ажиллагаа, шунахайн сэдэлтэй үйлдэл нь нийгмийн амьдралд ихээр хор уршиг, аюулд хүргэж, байгаль орчин, эко системд нөлөөлж байна.

### **Санал**

Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Байгаль болоод ойд учирсан хор хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээг гаргахдаа мэргэжлийн байгууллага шинжээчийн дүгнэлтээр хохиролыг гаргуулах, холбогдох зардлыг төсөвт суулгаж өгч, буруутай этгээдээр гаргуулах;

2. Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй мөнгөн торгуулийн хэмжээ, санкцыг нэмэгдүүлэх;

3. Практикт гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эзэмшигч гэмт хэрэг үйлдсэн этгээд бус техникийг бусдаас түрээсэлсэн байдгаас шууд хураан авах, хөрөнгө хамгаалах, дахин гэмт хэрэг үйлдэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэлтийн шатанд битүүмжлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэдэг тул эрх зүйн орчныг засаж сайжруулах;

4. Хүрээлэн буй орчинд хохирол, хор уршиг учруулж буй гол хүчин зүйл нь хүн учир өвөг дээдэс маань хэрхэн байгаль эх, хүрээлэн буй орчноо хамгаалдаг байсан ёс уламжлал, түүхтэй ард түмэн байсныг сэргээн сануулж нөлөөллийн арга хэмжээ болох сошиал мэдээ, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд түгээх ажлыг төрөөс бодлого гарган явуулах, сургалтыг хөтөлбөр боловсруулж Ерөнхий боловсролын сургуулиудад хичээл орох нь үр дүнтэй, ач холбогдолтой гэж үзэж байна.

### **Ашигласан материал**

1. Амархүү О. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ., 2009.
2. Ойн тухай хууль. УБ., 2012. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №22.
3. Сэнгэдорж Т. Экологийн эрх зүй. УБ., 2009.

4. Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаарх тунхаглал. 1992 оны Рио-Де-Жанейрогийн чуулга уулзалт. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл. Гарын авлага. УБ., 2010.

5. ЦЕГ-ын МДШШУА, ЭкоЦА Монгол Улсад 2015-2022 онд бүртгэгдсэн хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн статистик үзүүлэлт. УБ., 2023.

6. Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7.

Цахим эх сурвалж

7. <https://www.gazar.gov.mn/p/527-108>.

## ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, НИЙГМИЙН АЮУЛЫН ШИНЖ

### THE PERCEPTION OF RAPE CRIMES, SIGNS OF SOCIAL DANGER

Т.Одбаатар

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

**Товч агуулга:** Өгүүлэлд хүчиндэх гэмт хэргийн тухай ойлголтыг нэршлээс нь эхлэн тодруулж, хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орох үйлдлийг хүчиндэх гэх нэршил өөртөө бүрэн агуулж байгаа эсэх, энэ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чухам юунд, ямар байдлаар чиглэж байгаа болохыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргаж, санал дэвшүүлэхийг зорилоо.

**Abstract:** The article seeks to clarify the concept of rape from the very name, to examine whether the term rape for the act of sexual intercourse using force is fully contained in itself, what is the nature of the social danger of this crime and in what way it is directed, to draw scientific conclusions and propose proposals.

**Түлхүүр үгс:** Бэлгийн харьцаа, хурьцал, эр, эмийн харилцаа, нийгмийн аюул, хор уршиг.

**Keywords:** Sexual relations, courtship, male-female relationships, social dangers and harms.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй”<sup>103</sup>, “Монгол Улсын иргэн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”<sup>104</sup>, “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”<sup>105</sup>, “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”<sup>106</sup> гэж тус тус тунхагласан. Эдгээр тунхаглалууд нь цаад утгаараа иргэдийн аюулгүй байдлын баталгааг хангахаас гадна нийгэмд тэгш эрхтэй оршин тогтнох нөхцөл, боломжийг бүрдүүлсэн бөгөөд Үндсэн хуулиас салбарласан бусад салбар хуулиудын хэрэгжилтээр хангагдах учиртай.

Монгол Улс нь хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон, хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож ирсний нэгэн илрэл нь энэ үзэл баримтлалыг 1992 оны Үндсэн хуульдаа тодорхойлж, салбар хуулиудыг цаг үетэйгээ нийцүүлэн хэрэгжүүлж байгаа билээ. Хүний эрхийг хангах асуудал нь зөвхөн хүний эрхийг хууль тогтоомжийн хүрээнд хуульчлах асуудал төдий бус, нийгэм, улс төр, эдийн засаг, хүний эрхийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх замаар хүний эрхийг хүндэтгэх, эрхээ хамгаалуулах асуудлыг нийгмийн сэтгэл зүй, хувь хүний ухамсарт суулгаж өгөх зэрэг олон багц асуудлыг багтаадаг.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний хөтөлбөр хэрэгжиж, энэ чиглэлээр олон ажлууд хийгдэж, зохих үр дүнд хүрч байгаа хэдий ч, хүний эрхийн зөрчил буурахгүй байгааг Монгол Улсын хүний эрхийн үндэсний

<sup>103</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>104</sup> Мөн тэнд. 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэг.

<sup>105</sup> Мөн тэнд. 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.

<sup>106</sup> Мөн тэнд. 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

комиссын жил бүрийн илтгэлүүдээс харж болно<sup>107</sup>. Хүний эрхийг хамгаалах, түүний дотор хүүхэд, охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах асуудал олон улсын байгууллага болон үндэсний чиг үүргийн алба, байгууллагуудын анхаарлын төвд орших, голлох асуудал байсаар ирсэн.

Өнөөдрийн байдлаар дэлхийд 300 гаруй сая хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртөж байгаа талаар олон улсын хүний эрхийн байгууллагуудын судалгаа байна. Энэ асуудал ч Монгол Улсыг тойроогүй бөгөөд охид, эмэгтэйчүүд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд автан, хөдөлмөрийн боолчлолын болон хүний наймааны золиос болж байгаа талаар сонин хэвлэлд олноор бичигдэж байгаа бөгөөд энэ нь ч хууль сахиулах байгууллагын албан ёсны тоон мэдээ, баримт, шүүхийн практикаас ажиглагддаг. Тиймээс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн бүлэгт хамаарах хүчиндэх гэмт хэргийн ойлголт, мөн чанарыг судалсны үндсэн дээр шинжлэх ухаанч санал, дүгнэлт гарган, цаашид хэрэгжиж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг эрэлхийлэх нь орчин цагийн хэрэгцээ, шаардлагад нийцэх юм.

Аливаа үзэгдлийн зүй тогтол, шинж, байдлыг судлахын өмнө тухайн зүйлийн ойлголтын талаар судлах асуудал нэн тэргүүнд тавигддаг. Энэ ч утгаараа хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг судлахын өмнө тухайн гэмт хэргийн ойлголтын тухай, лавшруулаад “хүчиндэх” гэх үгийн язгуур, үндсийг судлах нь зүйтэй.

Хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн нэршил нь “хүчиндэх” гэж хуульчлагдсан байх бөгөөд уг нэршил нь 1986, 2002 оны Эрүүгийн хуульд ч мөн адил томъёологдсон байжээ. Эндээс хүчиндэх гэмт хэргийг үе үеийн Эрүүгийн хуулиудад нэгэн төрлийн нэршлээр хуульчилсан байгаа нь ажиглагдаж байна.

Хэдийгээр олон арван жилийн туршид нэрлэж хэвшсэн ойлголт боловч, бусдыг, тэр дундаа эмэгтэй хүнд хүч хэрэглэн, хурьцал үйлдэх, эсхүл бэлгийн харьцаанд орох шинжийг өөртөө агуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, бидний үзэж байгаагаар, “хүчиндэх” гэх ойлголт нь утга санаа, агуулгын хувьд хүчээр бэлгийн харьцаанд (хурьцал үйлдэх) орох үйлдлийг агуулахгүй байгаа юм.

Хууль тодорхой, тухайн хуулийг бүрдүүлж байгаа зүйл, заалт, тэр ч бүү хэл, нэршил нь тухайн үйлдэл, эс үйлдэхүйн шинжийг бүрэн илтгэж, агуулсан байх ёстой. Гэтэл “хүчиндэх” гэх үгийн утга санаа нь бусдад хүч хэрэглэх замаар, хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн харьцаанд орох утга, агуулгыг өөртөө нэгтгэж байгаа эсэх асуудлыг нэг мөр болгохын тулд судлаачдын байр суурийг тодруулахад, Я.Цэвэл “хүчин” гэх үгийг “аливаа юмны хөдлөх, үйлдэх чадал, ид тэнхээ, тамир”<sup>108</sup> гэж тайлбарлаад “Хүчингийн хэрэг” гэх үгийн утгыг “эмэгтэйчүүдтэй хүчирхэн явалдсан хэрэг”<sup>109</sup> гээд, “явалдах” гэх үгийг “хурьцал үйлдэх, сэм явалдах, хүчирхэн явалдах”<sup>110</sup> гэж бэлгийн харьцаанд орох утгаар тайлбарласнаас гадна бусадтай сэм, нууцаар бэлгийн харьцаанд орох тухай хоёрдмол утгаар тайлбарласан. Тэрээр “эзэмдэх” гэх үгийг “эзлэх, эзэрхэх, эзэмших, зүрх сэтгэл эзэмдэх”<sup>111</sup> гэсэн утгаар тайлбарласан нь бусдын хайр бишрэлийг төрүүлэх гэсэнтэй утга дүйхээр байна. “Явалдах” гэх үгийг гэр бүлтэй буюу эхнэртэй, эсхүл нөхөртэй (эсхүл эхнэр, эсхүл нөхөргүй хүн өөр бусад эхнэр, эсхүл нөхөртэй хүнтэй)

<sup>107</sup> Жишээ нь: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлээс үзэж болно.

<sup>108</sup> Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 2021. 1086 дахь тал.

<sup>109</sup> Мөн тэнд. 1086 дахь тал.

<sup>110</sup> Мөн тэнд. 1308 дахь тал.

<sup>111</sup> Мөн тэнд. 1265 дахь тал.

хүн өөр эмэгтэй, эсхүл эрэгтэй хүнтэй гэр бүлээс гадуур, дотно харилцаа буюу бэлгийн харьцаатай байх утгаар тайлбарлаж ирсэн нийгмийн хэвшмэл ойлголт байдаг. Энэ утгаар бол явалдах нь хүчиндэх буюу хүчээр бэлгийн харьцаанд орохоос ангид ойлголт болох нь харагдаж байна. Тэгвэл хүчиндэх гэмт хэргийг ардын хувьсгал ялснаас хойшх хугацаанд хэрэгжиж байсан Шүүх цаазны бичгүүд болон Эрүүгийн хуулиудад хэрхэн хуульчилж байсныг авч үзье.

Хүчиндэх гэмт хэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1926 оны Шүүх цаазны бичигт хүчиндэх гэмт хэргийг “Самуун садарт холбогдох гэмт хэрэг үйлдэх нь” гэх (29 дүгээр бүлэг) бүлэгт хамааруулан, зүйл бүрийг тусгайлан (197 дугаар зүйл гэх мэтээр нэрлэжээ) нэрлэлгүйгээр, шууд диспозиц болон санкцийг дурдах байдлаар тусгажээ. Тодруулбал, 197 дугаар зүйлд “Аливаа хүн 15 наснаас дотогш насны охидтой явалдваас 6 сараас 2 жил хүртэл гяндан хорино”<sup>112</sup>, 198 дугаар зүйлд “Аливаа хүн 16 наснаас дээш насны эмс охид лүгээ албадан хүчирхэн явалдваас 1-3 жил гяндан хорино”<sup>113</sup> гэснээс үзэхэд, “явалдах” гэх үгийг тэр чигт нь “бэлгийн харьцаанд орох”, эсхүл “хурьцал үйлдэх” гэх нэртэй адилаар хэрэглэж байжээ. Энэ дараах зүйл ангид зааснаас тодорхой харагдаж байна. Тухайлбал, 201 дүгээр зүйлд “Аливаа эмс охидыг явалдуулахаар гэр орон бэлдэж, ашгийг хичээгсдийг 1 жилээс 3 жил хүртэл гяндан хорихоос гадна хөрөнгө, хогшлынх нь заримыг буюу бүр мөсөн албадан хураана” гэж зааснаас үзэхэд, аливаа эмс охидыг бусадтай бэлгийн харьцаанд оруулж, ашиг олох зорилготой байна.

Тэгэхээр “явалдах” гэх үг нь тухайн цаг үед гэр бүлээс гадуур харилцаа үүсгэх бус, бэлгийн харьцаанд орох, эсхүл хурьцал үйлдэх утга агуулж байжээ гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Гэхдээ уг үг нь утга, санааны хувьд өөртөө хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орох утгыг агуулахгүй байгааг мөн харж болно.

1929 оны Шүүх цаазны бичгийн 202 дугаар зүйлд анхлан “хүчирхэх” гэх үг орсон нь одоогийн “хүчиндэх” гэх үгний үүсэл байх магадлалтай юм. Энэ зүйлд “Хүчирхэн түрэмгийлэх ба айлган сүрдүүлэх хийгээд өөрийн биеийг хамгаалж үл чадахыг далимдуулан хуурч хүчирхэн явалдагчдыг нэг жил хүртэл хоримой”<sup>114</sup> гэжээ. 1934 оны Шүүх цаазны бичгийн 133 дугаар зүйлд “Бие махбодийг хүчирхэн барьж явалдах хийгээд биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан явалдах буюу түүнчлэн эд амьдрал, албаны хувиар эрхэнд буй ашиглан албадах зарчмаар хүчирхэж явалдсан бол” гэж хүчээр бэлгийн харьцаанд орохыг “хүчирхэн явалдах” гэж тайлбарлаж байжээ. Энэ хуульд нэгэн шинэ нэр томъёо орсон нь 132 дугаар зүйлд заасан “Аливаа нэг этгээдээс төрөлхийн бус ёсоор эр хүн эр хүнтэй харилцан явалдах буюу мал адгуусны зэрэг бусад төрлийн амьтан лугаа хурьцал үйлдвэл”<sup>115</sup> гэж “хурьцал үйлдэх” гэх үгийг анхлан хуульчилсан байна. Гэхдээ аливаа хүн бусад мал, адгуустай бэлгийн харьцаанд орохыг хурьцал үйлдэх гэж анхлан тайлбарласнаас үзэхэд, мал адгуустай бэлгийн харьцаанд орохыг хурьцал үйлдэх гэж ойлгож байсан байж болзошгүй мэт боловч тийм биш болох нь доорх хуулиудаас ажиглагдах болно.

1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 164 дүгээр зүйлд “Хүчирхэн явалдах нь бие махбодийг хүчирхэн барьж явалдах буюу сүрдүүлэн айлгах, залилан мэхэлж явалдах хийгээд нөгөө этгээдийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан явалдах бол”<sup>116</sup> гэж тусгасан бөгөөд “хүчиндэх” гэх нэршлийг хуульд хараахан тусгаагүй байсан бол 1961 оны Эрүүгийн хуульд уг

<sup>112</sup> Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. Уб., 1998. 31 дэх тал.

<sup>113</sup> Мөн тэнд. 31 дэх тал.

<sup>114</sup> Мөн тэнд. 64 дэх тал.

<sup>115</sup> Мөн тэнд. 94 дэх тал.

<sup>116</sup> Мөн тэнд. 136 дахь тал.

нэршлийг анхлан тусгажээ. Тодруулбал, 88 дугаар зүйлийг “Хүчиндэх” гэж томъёолоод, “Хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, түүнчлэн нөгөө этгээдийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдвэл”<sup>117</sup> гэж хуульчилсан явдал нь хүч хэрэглэн, айлган сүрдүүлж хурьцал үйлдэх үйлдлийг “хүчиндэх” гэсэн нэг үгээр тайлбарласан гэж үзэх үндэстэй байна.

1986 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 112 дугаар зүйлд “Хүч хэрэглэж буюу айлган сүрдүүлж, эсхүл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол” гэж хохирогч гэх ойлголтыг шинээр багтааснаас бусад нь 1961 оны Эрүүгийн хуульд заасантай төстэй байдлаар хуульчлагдсан.

Ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулиа баталсан үеэс хойш Монгол Улсад мөрдөгдөж, хүчин төгөлдөр хэрэгжиж байсан Шүүх цаазны бичгүүд болон Эрүүгийн хуулиудад тусгагдсан байсан хүчиндэх гэмт хэргийн зохицуулалт нь тухайн үеийн нийгмийн байдал, хүн ам зүйн өсөлт хөгжилтэй холбоотойгоор хуульчлагдаж байсан бол хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон, хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон 1990 оноос хойших Эрүүгийн хуулиудад тусгагдсан хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, зүйлчлэл илүү боловсронгуй болсноос гадна зүйл, заалт бүрийг нарийвчлан зааж өгчээ.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол”<sup>118</sup> гэж заасан нь өмнөх Эрүүгийн хуулиудад тусгагдсан хүчиндэх гэмт хэргийн шинжүүд уламжлал ёсоор залгамжлан оршиж байгаагийн илрэл юм. Харин 2015 оны Эрүүгийн хуульд “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол”<sup>119</sup> гэж хавьгүй өргөн хүрээтэй хуульчилсан. 2015 оны Эрүүгийн хуулийн тухайн зүйлд “бэлгийн харьцаанд орсон” гэж шинэ ойлголт орсон нь хурьцал үйлдэх гэх үгийг халах шалтгаан, шаардлагатай байжээ гэх ерөнхий дүгнэлт гаргах боломж олгож байгаагаас цааш хэтрэхгүй байна. Мөн бэлгийн харьцаанд орохоос гадна бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийснийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэнтэй адилтган үзэх болсон нь хавьгүй шинэлэг боловч маргаантай зүйл болжээ. Энэ талаар академич С.Нарангэрэл “Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулиас өмнөх Эрүүгийн хуульд “Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн” гэж тодорхойлж ирсэн түүхэн уламжлалтай. Ийнхүү хүчиндэх гэмт хэргийн төгсөх үеийг хурьцал үйлдсэн гэж тодорхойлж ирсэн бөгөөд, өөрөөр хэлбэл, хурьцлын үйлдэл хийж эхэлснээр төгссөнд тооцогддог байв. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуулиар “бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” гэсэн хоёрдмол утга санаа бүхий томъёолол оруулсан нь тайлбарлахад бэрхшээл учруулах болов”<sup>120</sup> гэж өөрийн байр суурийг илэрхийлжээ.

Тэгэхээр “хүчиндэх” гэх үг нь бусдад хүч хэрэглэх замаар бэлгийн харьцаанд орох утгыг дангаараа агуулахгүй байгааг судлаачдын байр суурь болон

<sup>117</sup> Мөн тэнд. 177 дахь тал.

<sup>118</sup> Эрүүгийн хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5. 126 дугаар зүйл.

<sup>119</sup> Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 12.1 дүгээр зүйл.

<sup>120</sup> Нарангэрэл С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Анхны хэвлэл. 2021. 546 дахь тал.

үе үеийн Шүүх цаазны бичиг болон Эрүүгийн хуулиудад зааснаас харах боломжтой байна. Явалдах, хурьцал үйлдэх, эсхүл бэлгийн харьцаанд орох гэх үгс нь мөн адил бусдыг хүчлэн эзэмдэж, хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн харьцаанд орох үйлдлийг дангаараа агуулж, тодорхойлохгүй бөгөөд “Хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орох”, “Хүчлэн бэлгийн харьцаанд орох” зэрэг байдлаар хуульчилснаар энэ гэмт хэргийн ойлголтыг бүрэн дүүрэн харуулах боломжтой юм.

Хүчиндэх гэмт хэрэг нь давхар объектойд гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хүчиндсэн үйлдлийн улмаас хохирогчийн Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хэд хэдэн эрх, эрх чөлөөнд халдаж, зөрчдөг<sup>121</sup>.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд “...хэд хэдэн бүлэг нийгмийн харилцаанд нэгэн зэрэг халдаж байгаа халдлага нь нийгмийн аюулын хэр хэмжээний хувьд бусадтай харьцуулашгүй өндөр” гэх үзэл санаа байдаг<sup>122</sup>. Тэгэхээр хүчиндэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан, хэд хэдэн нийгмийн харилцаанд халдаж, хохирол, хор уршиг учруулдаг байдлаараа нийгмийн аюулын шинж өндөртөйд тооцогдоно. Олон объектод нэгэн зэрэг халдах нь бусад бүх төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг үнэлж, тодорхойлох хэмжүүрүүдийн нэг мөн.


Сүүлийн 5 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2869 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Бодитоор нэг жилд дунджаар 647 бага насны хүүхэд болон эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж, өдөрт дунджаар нэгээс хоёр гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа хэдий ч, нуугдмал, далд хэлбэртэй хэдэн бага насны хүүхэд болон эмэгтэйчүүд хохирч байгааг таашгүй. Жишээлбэл, 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд сумын нэгдүгээр сургуулийн зүүн талын “Мандах наран” хорооллын байрнаас хичээлдээ явахаар гэрээсээ гарсан 12 настай охин сураггүй алга болж, эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулсан боловч хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрэн сурвалжлах ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлснээс болж гэмт этгээд хохирогчийн амь насыг хохироосон байдаг. Энэ мэтээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн эцсийн зорилгоос хазайж, хохирогчийг алах явдал түгээмэл гарах хандлагатай байгааг анхаарах нь зүйтэй байна.

---

<sup>121</sup> Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Сурах бичиг. Уб., 2020. 48 дахь тал.

<sup>122</sup> Амарсанаа В. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн ойлголт, нийгмийн аюулын шинж. // Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2023. №3. 27 дахь тал.

Зураг 2. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээ (2013-2023)<sup>123</sup>



Хүчиндэх гэмт хэргийн тоон үзүүлэлт 2018, 2022, 2023 онуудад тогтмол өссөн үзүүлэлттэй, харин 2019, 2020, 2021 он буюу цар тахлын үед буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч, өмнөх онуудад бүртгэгдсэн гэмт хэргээс хавьгүй өссөн. Мөн 2022, 2023 онд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн тоон үзүүлэлт өмнөх (зарим) онуудад бүртгэгдсэн гэмт хэргээс даруй хоёр дахин их бүртгэгдсэн байгаа нь энэ төрлийн нийгэмд аюултай үзэгдэл хурдацтай газар авч байгаагийн илрэл юм.

Хүчиндэх гэмт хэргийн гаралт ихсэж, гэмт этгээдүүдийн үйлдэл харгислал, алан хядлагын шинжид аажмаар шилжиж байгаа нь энэ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж ямар хэмжээнд байгааг тодорхой харуулж байна. Зарим нэг жишээг дурдвал, иргэн Б.Оюунчимэгийг 2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр үл таних этгээд онц харгис хэрцгий аргаар хүчиндэж, амь насыг хохироон гэмт хэргээ нуун дарагдуулах зорилгоор амь хохирогчийн цогцсыг дундуур нь нугалаад, шуудайнд хийж, Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Зурагтын шинэ эцсийн буудлын орчимд хаясан хэрэг, Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 28 дугаар сургуулийн зүүн талын үерийн далан дотроос 2005 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хар өнгийн цүнхэн дотроос Ц.Баярцэцэгийн цогцос олон тооны шархтай олдсон хэрэг зэргээс харж болно. Сүүлийн хэргийн хувьд, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь 2001 онд бага насны хүүхдийг хүчиндэж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан, 2008 онд насанд хүрээгүй хүнийг хууль бусаар хорьж, бэлгийн дур хүслээ ёс бусаар ханган хүчиндсэн, 2016 онд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан хэргийг нуун далдлах зорилгоор хүнийг онц харгис хэрцгий аргаар алсан гэмт хэрэг тус тус үйлдсэн. Уг этгээд нь амь хохирогчдын хүзүү, хоолойг боож, ухаан алдуулан, бэлэг эрхтэн болон шулуун гэдсэнд гэмтэл

<sup>123</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тайлан. 2013-2023.

учруулж, гадны биет чихэж, бэлгийн дур хүслээ ёс бусаар ханган хүчиндэж, улмаар зарим хохирогчдын хоолойг нь боож, амь насыг нь хохироосон харгис гэмт хэрэг үйлдсэн байдаг.

Нийслэлийн Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Зүүн нарангийн 10 дугаар гудамжинд бага насны хүүхэд нүхэн жорлонд унасан тухай дуудлага, мэдээлэл Онцгой байдлын газарт ирж, дуудлагын дагуу алба хаагчдыг очиход 8 настай Б гэгч нь нэг метрийн гүнтэй нүхэн жорлонд унаж, нас барсан нөхцөл байдал тогтоогджээ. Шалгалтын ажлын үр дүнд бага насны эмэгтэй хүүхдийг 21 настай эрэгтэй хүн хүчиндэж, улмаар амь насыг нь хохироогоод айлын жорлонд хаясан болохыг хөдөлбөргүй нотлох баримтаар тогтоожээ.

Тэгэхээр хүчиндэх гэмт хэргийн гаралт цаашид ихсэх хандлагатай байгаагаас гадна үйлдлийн арга, хэлбэр, гэмт этгээдийн сэдэлт, зорилго нь харгис, догшин, гаж байдалд шилжиж, бага насны хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал болон эрүүл мэнд, амь насанд нөхөж баршгүй хохирол учруулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж ихтэй байгааг бодитоор харуулж байна.

### **Дүгнэлт**

1. Үе үеийн Шүүх цаазны бичигт “явалдах” гэх үгийг тэр чигт нь “бэлгийн харьцаанд орох”, эсхүл “хурьцал үйлдэх” гэх нэртэй адилаар хэрэглэж байсан бөгөөд “явалдах” гэх үг нь тухайн цаг үед гэр бүлээс гадуур харилцаа үүсгэх бус, бэлгийн харьцаанд орох, эсхүл хурьцал үйлдэх утгыг шууд агуулж байжээ. Гэхдээ уг үг нь утга, санааны хувьд хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орох утгыг бүрэн агуулахгүй бөгөөд дангаараа бол бэлгийн харьцаанд орох, харин “хүч хэрэглэн явалдах” гэж холбоо үг болсноор сая нэг бүрэн утга агуулах боломжтой байгаа юм.

2. 1929 оны Шүүх цаазны бичигт анхлан тусгасан “хүчирхэх” гэх үг нь зөвхөн хүч хэрэглэх гэх утга агуулахаас хэтрэхгүй, өөрөөр хэлбэл, хүчиндэх гэмт хэргийн шинж, утгыг дангаараа гаргаж чадахгүй байгааг хуульд “хүчирхэн явалдах” гэж зааснаас харж болно. 1934 оны Шүүх цаазны бичигт хүчээр бэлгийн харьцаанд орохыг “хүчирхэн явалдах” гэж тайлбарлаж байсан нь үүний нэг нотолгоо юм.

3. Хүчиндэх гэмт хэргийн үед гэмт этгээд хохирогчийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдахаас гадна амь нас, эрүүл мэндэд хохирол учруулдаг, хоёр харилцаанд нэгэн зэрэг халддаг, давхар объекттой гэмт хэрэг юм. Хэдий чинээ олон харилцаанд халдана, төдий чинээ нийгэмд аюултай гэмт хэрэг гэх жишгийн дагуу хүчиндэх гэмт хэргийн нийгэмд учруулах хор аюул давхар объекттой байдлаар шууд тодорхойлогдоно.

### **Санал**

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заасан “Хүчиндэх” гэмт хэргийн нэршлийг “Хүчлэн бэлгийн харьцаанд орох”, “Хүчирхийлэн бэлгийн харьцаанд орох”, эсхүл “Хүчээр бэлгийн харьцаанд орох” зэргийн аль оновчтой байдлаар өөрчилж, хуульчлах;

2. Шүүх шинжилгээний байгууллагад хандаж буй бэлгийн хүчирхийллийн бүх насны хохирогчдыг үнэ төлбөргүй шинжилгээнд хамруулж байх, тоо мэдээ гаргах аргачлалыг сайжруулах, боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад статистик мэдээллийг нээлттэй болгох, шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах;

3. Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог болон сэтгэл засал, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг буруутай этгээдээс заавал нөхөн гаргуулдаг эрх зүйн тогтолцоог бий болгож, хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэл зүйд учирсан гэмтлийг тогтоох, сэтгэл санааны хохирлыг

үнэлэх, тооцох аргачлалыг батлах, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн тодорхой зохицуулалт, механизмыг бүрдүүлэх;

4. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж, суллагдсан хүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх.

#### **Ашигласан материал**

1. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшх Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. УБ., 1998.

2. Амарсанаа В. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн ойлголт, нийгмийн аюулын шинж. // Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2023. №3.

3. Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Сурах бичиг. УБ., 2020.

4. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1.

5. Нарангэрэл С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Анхны хэвлэл. 2021.

6. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тайлан. 2013-2023.

7. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2021.

8. Эрүүгийн хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5.

9. Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7.

## ЦЭРГИЙН АЛБАНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

### SOME ISSUES REGARDING CRIMES AGAINST MILITARY SERVICE

*А.Мөнхбат*

*ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Энэхүү сэдвийн хүрээнд цэргийн албаны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, хөтөлбөр боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулахыг зорилгоо.

**Abstract:** With this subject we aimed to develop proposals and programs for the prevention of crimes against military service, and improvement of its legal framework.

**Түлхүүр үгс:** Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх, санал боловсруулах.

**Keywords:** Crimes against military service, prevention, develop proposals.

#### Оршил

1980-аад онд Нью-Йорк хотод өдөрт 1500 гаруй хүнд гэмт хэрэг үйлдэгдэж, үүний дотор 6-7 нь хүн амины хэрэг гардаг байлаа. Шөнийн цагаар гудамжаар алхах нь аюултай байсан бөгөөд метрогоор бол бүр өдөр ч гэсэн явах эрсдэлтэй байв. Метроны хонгилд дээрэмчид, гуйлгачид хог нэгээрээ үүрлэсэн байлаа. Бохир, чийгтэй буудлын тавцангууд бараг гэрэлтүүлэггүй байв. Метро дотор хүйтэн, хөл дор хог новш дүүрэн, хана, тааз нь бүхэлдээ граффити зургаар дүүрсэн байдаг байж. Энэ хот түүхэндээ хамгийн аймшигтай гэмт хэргийн далайд живсэн байлаа. Гэвч удалгүй үл ойлгогдох, тайлагдашгүй үйл явдлууд өрнөсөн нь 1990 он гэхэд дээд цэгтээ хүрсэн гэмт хэргийн гаралт эрс буурсан байна. Сүүлийн хэдхэн жилд хүн амины хэрэг 65%, хүнд гэмт хэргийн тоо хоёр дахин буурчээ. Арван жилийн дотор метронд үйлдэгдсэн гэмт хэрэг эхний үетэй харьцуулахад 75%-иар буурсан байна. Яагаад ч юм хууль зөрчихөө больсон байлаа. Нийгмийн энэ үзэгдлийг “Хагархай цонхны онол”-оор тайлбарладаг байна.

1982 оны гуравдугаар сард Америкийн алдарт социологич Жамэс Күинн Вильсон (James Q. Wilson, 1931-2012), Жорж Кэллинг (George L. Kelling) нар «Broken Windows: The Police and neighborhood safety» (Хагархай цонх: Цагдаагийн байгууллага ба улс орны аюулгүй байдал)<sup>124</sup> нэртэй өгүүлэл нийтлүүлсэн байх бөгөөд чухам энэхүү бүтээлдээ хагархай цонхны онолыг анх удаа олон нийтэд таниулсан үзэл санааг тусгажээ. Тэр онолд... санаандгүй тохиолдлоор олон нийтийн эзэмшил газарт нэг байшингийн цонх хагарчээ. Эзэн тодорхойгүй учир хэн ч хариуцлага хүлээхгүй. Хэн ч дахин шиллэхгүй. Хэсэг хугацааны дараа хоёр дахь, гурав дахь байшингийн цонх хагарч болно. Эзэн тодорхойгүй учир мөн л хэн хариуцахгүй бас шиллэхгүй. Хотын нэг гудамжид хэд хэдэн байшингийн цонх дарааллан хагарчээ. Ганц байшингийн цонх хагарахад хэний ч толгойд ямар ч бодол төрөхгүй. Харин хэд хэдэн байшингийн цонх хагарсан тохиолдолд хүмүүсийн уураг тархинд энэ газар хуулийн хэрэгжилт сул юм байна, үүнийг нь ашиглан гэмт хэрэг үйлдэх, хүсэл сонирхлоо хангах сэдэл бий болдог байна. Ингэснээр гэмт хэргийн гаралт өсч хүн болгон гэмт хэрэгтэн болох орчин нөхцөл бүрддэг байна.

<sup>124</sup> The Atlantic Monthly; March 1982; Volume 249, No. 3; pages 29-38.

Аливаа гэмт хэргийг үйлдэгдсэн байдал, нийгэм, олон нийтэд учруулсан хохирлоор хэмжих нь утгагүй тэнэглэл болно. Учир нь гэмт хэрэг бол их ч байсан, бага ч байсан хууль зөрчсөн, олон нийтийн эсрэг чиглэсэн гэмт үйлдэл л байдаг. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд их, бага ялгалгүй хатуу чанга ял, зэм оноож байх учиртай. Нөгөөтэйгүүр нийгмийн дотоодод сахилга батыг чангатгах хэрэгтэй. Хүмүүсийн тархинд гэмт хэргийн буруу сэдэл төрүүлэх нийгмийн үзэгдлүүдтэй, тэр дундаа граффиттай хатуу аргаар тэмцэх ёстой. Бас олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард олныг самуун, гэмт үйлд уриалан дуудсан өнгө аястай нэвтрүүлэг, кино цацахыг хоригло. Өөрөөр хэлбэл нийгмийг бүхэлд нь хянах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргийг цагдаа, цагдаагийн байгууллагад бүрэн шилжүүлэх, ингэснээр нийгэмд амгалан, аюулгүй байдал бий болно гэсэн санааг Ж. Вильсон, Ж. Кэллинг нар дэвшүүлжээ. Канадын социологич М. Гладуэлл хагархай цонхны онолыг дурдаад гэмт хэрэгтэн бий болоход зөвхөн удамшил, муу хүмүүжил төдийгүй бас орчин нөлөөлж болдог юм байна гэсэн дүгнэлт хийжээ.<sup>125</sup> Үүгээр илэрхийлэх гэсэн зорилго нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Энэ хуулийн тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шийнжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй/-т заасныг журамлаж гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хайхралгүй, хуульд заагаагүй байна гэж орхих нь хагархай цонхыг хайхралгүй орхиж маргааш, нөгөөдөр дахин нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна хэмээн дүгнэж байна.

### **Үндсэн хэсэг**

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 28 дугаар бүлэгт нийт 19 зүйл гэмт хэргийг хамааруулсан.

Энэ хуулиас өмнө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлгийн 274-296 дугаар зүйлд заасан нийт 23 зүйл гэмт хэргүүдийг хамааруулж байсан. 2015 оны Эрүүгийн хууль нь 2002 оны эрүүгийн хуулийг бодвол иргэн, цэргийн албанд алба хаагчийн эрх зүйн байдлыг сайжруулсан мэт харагдаж байгаа боловч бусад эрх зүйн баримт бичгүүдийг нягтлан үзвэл хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн хэм хэмжээний актуудын батлагдсан цаг хугацааны зөрүүнээс үүдэн тус бүлгийн тодорхой зүйлүүдэд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан хэдий ч, 28.1 дүгээр зүйлийн тайлбар нь хуулийн хийдэл байж болохуйц нөхцөл байдал ажиглагдаж байна.

Тодруулбал, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн уулийн Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн “Тайлбар” хэсэгт “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно.”<sup>126</sup> гэж тусгасан байгаа нь Батлан хамгаалах тухай хууль болон Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг эрх зүйн баримт бичигт тусгагдсан бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчдад хамаарахгүй гэж ойлгогдохоор байна. 2015 онд одоогийн Эрүүгийн хуулийг батлах үед Монгол Улсын Засгийн тогтоолоор Дотоодын цэргийн байгууллагыг татан буулгасан<sup>127</sup>, алба хааж байсан офицер, ахлагчийг Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

<sup>125</sup> Отгонбаяр Н. Төрийн захиргаа, удирлагын ухаан. УБ., 2022. Цахим холбоос: <http://public9administration.blogspot.com/2015/04/broken-windows-theory.html>.

<sup>126</sup> Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 28.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<sup>127</sup> Дотоодын цэргийн ангиудыг татан буулгах тухай. Засгийн газрын тогтоол. УБ., 2014. №108. 1 дүгээр зүйл.

албаны харъяанд<sup>128</sup>, хугацаат цэргийн алба хаагчдыг Хил хамгаалах ерөнхий газрын шилжүүлсэн байсан<sup>129</sup>, мөн Онцгой байдлын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн цэргийн байгууллагад хамаардаггүй байсан нь дээрхи бүлэг гэмт хэргийг үйлдсэнд ойлгох харъяалах бүрэлдэхүүнийг тогтооход хамаарахгүй байж болох байсан талтай байна. 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль”-д “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ”<sup>130</sup>. Мөн “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ. Дайны байдлын үед хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх<sup>131</sup>, онцгой байдлын байгууллага нь зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэнэ”<sup>132</sup> (дээрх хэсэгт Монгол Улсын Их хурлын 2022 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг нэмсэн байдаг) гэж тусгасан байдаг. Дээр дурдагдсан 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн тодорхой зүйлүүдэд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлтийг оруулсан байх бөгөөд тус бүлгийн 28.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт яагаад өөрчлөлт оруулаагүй, дээрхи хууль, бодлогын баримт бичгийн холбогдох заалтын агуулгыг яагаад үгүйсгэсэн мэт байгаа нь хачирхмаар байгаа юм. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 28.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт өөрчлөлтийг оруулснаар Зэвсэгт хүчин, Хилийн цэрэгээс бусад 3 төрийн цэргийн байгууллагад алба хааж байгаа бүрэлдэхүүний эрх зүйн байдал дордох мэт харагдах боловч цаад угтаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хэрэгжилт хангагдах, мөн Эрүүгийн хуулийн агуулгын алдаа засагдана гэж ойлгож байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (цаашид ҮСХ гэх)-оос гаргасан статистик мэдээллийг авч үзвэл 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн 189 тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 1. Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн гаралтын байдал. (2022 оны 1 дүгээр сараас 2023 оны 9 дүгээр сарын хооронд)

---


<sup>128</sup> Мөн тэнд. 2 дугаар зүйл.

<sup>129</sup> Мөн тэнд. 3 дугаар зүйл.

<sup>130</sup> Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №17. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг.

<sup>131</sup> Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай. Нэмэлт, өөрчлөлт. Уб., 2022. №40. 1 дүгээр зүйл.

<sup>132</sup> Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай хууль. Уб., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №41. 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.



Одоогийн нөхцөл байдалд дээрхи хуулийн бүлэг гэмт хэрэгт үйлдсэн байж болох гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангасан нөхцөл байдал нь зөвхөн Дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2023 оны байдлаар 23 удаа бүртгэгдсэн байгаа боловч хуульд заасан үндэслэлээр арга хэмжээ авах нөхцөл боломжийг тус 28.1 дүгээр зүйлийн “Тайлбар” хэсэгт зааснаар хязгаарлан, хааж байгаа нөхцөл байдал ажиглагдаж байна.

Энэ зүйлийн тайлбарт яагаад онцгой анхаарал тавиад байна гэхээр Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүд нь ихэвчлэн бодит аюултай хохирол учирсан байхыг шаарддаггүй бөгөөд идэвхитэй үйлдэл эхэлснээр төгсдөг онцлогтой. Жишээ нь тус бүлгийн 28.1 дүгээр зүйлд заасан “Тушаал биелүүлэхгүй байх” гэмт хэргийн ойлголт нь хууль, цэргийн албаны дүрмээр тогтоосон захирах, захирагдах журам, цэргийн албаны ашиг сонирхолд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай эс үйлдэхүй юм<sup>133</sup>. Тус гэмт хэргийн объект нь холбогдох хууль, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн албаны ашиг сонирхол байна. Цэргийн дүрмийн дагуу дарга, захирагчийн өгсөн тушаалыг захирагдагч биелүүлээгүйн улмаас цэргийн албаны ашиг сонирхолд учрах хор уршиг нь Монгол Улсын “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хэрэгжилт хангагдахгүй байх явдал юм. Тухайлбал, тус дүрмүүдийн “Дотоод албаны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт “Ахлах цолтон нь бага цолтноос хууль тогтоомж, цэргийн дүрмийг дагаж мөрдөх, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахихыг шаардана. Бага цолтон нь ахлах цолтны тавьсан шаардлагыг биелүүлнэ”<sup>134</sup> гэж заасан байна. Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-т

<sup>133</sup> Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Уб., 2018. 523 дахь тал.

<sup>134</sup> Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд. Уб., 2018. 8 дахь тал.

“Захирах, захирагдах зарчмыг мөрдөх”, мөн зүйлийн 6.2-т “Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн гэм буруутай эс үйлдэхүй болох нь харагдаж байна.

Мөн Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн 28.5 дугаар зүйл (Цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг)-д заасан гэмт хэрэг нь дээрх шинжүүдийг нэгэн адил агуулсан гэм буруутай, идэвхтэй үйлдэд, эс үйлдэхүй юм. Тус гэмт хэргийн объект нь цэргийн албаны ашиг сонирхол, хугацаат цэргийн албыг тасралтгүй хаах журам<sup>135</sup> байна. Цэргийн албаны ашиг сонирхолд учирсан хор уршиг нь Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ”<sup>136</sup>, 5 дугаар зүйлийн 5.1-т Монгол Улсын иргэн цэргийн жинхэнэ албанд орохдоо: “Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая. Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая. Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангаргаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ”<sup>137</sup> гэж “цэргийн тангараг өргөнө” гэж заасан байх бөгөөд өргөсөн тангарагаасаа няцаж, алба хааж байгаа газраа дур мэдэн орхиж явсан, эсхүл албан томилолт, амралтын чөлөө дууссан, эсхүл эмнэлгээс гарсны дараа эргэж ирээгүйгээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм<sup>138</sup>.

### Дүгнэлт

1. Дээрх гэмт хэргүүд нь Монгол Улсын Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дотоодын цэргийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүйн улмаас дээрхи хуулиудаар зохицуулсан өдөр тутмын үйл ажиллагаа доголдох нөхцөл байдал үүсэж болзошгүй байдлыг ойлгож болох байдал ажиглагдаж байна.

2. 2021, 2022, 2023 оны байдлаар Дотоодын цэргийн байгууллагын хугацаат цэргийн болон алба хаагч, офицер, ахлагч нараас алба хааж байгаа газраа болон ажиллаж байгаа байрлалаа дур мэдэн орхиж явсан, амралтын чөлөө дууссан, гадаад улсад аялах, эмчлүүлэхээр чөлөө авч явсан боловч эргэж ирээгүй хэд хэдэн тохиолдол байгаа боловч холбогдох хууль тогтоомжид заасны эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл тогтоогдоогүй гэх шалтгаанаар цэргийн албаны ашиг сонирхолд хор уршиг учруулсаар байгаа байдал ажиглагдаж байна. Тиймээс цэргийн албаны ашиг сонирхол, цаашлаад Үндэсний аюулгүй байдалд хор уршиг учруулж болохуйц тэдгээр үйлдлийг таслан зогсоох зорилгоор Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулах цаг нь болсон гэж үзэж байна.

3. Хэдийгээр Эрүүгийн хуулийн тус зүйлийн тайлбарт өөрчлөлт оруулан бусад 3 төрийн цэргийн байгууллагад алба хааж байгаа бүрэлдэхүүний гаргасан

<sup>135</sup> Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. Уб., 2011. 662 дахь тал.

<sup>136</sup> Цэргийн албаны тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №36. 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг.

<sup>137</sup> Мөн тэнд. 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг.

<sup>138</sup> Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Уб., 2018. 529 дэх тал.

гэмт хэргийн шинжтэй, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйд тохирсон ялыг оноож, хариуцлагыг хүлээлгэснээр нийт төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын гэмт хэрэгт холбогдсон үзүүлэлтийн тоон мэдээ өсөх сөрөг талтай хэдий ч Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, Батлан хамгаалах бодлогын үндэс, Төрийн цэргийн номлол, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогуудын хэрэгжилтүүд хангагдах эерэг талтай юм.

### **Санал**

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг (Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг)-ийн 28.1 дүгээр зүйлийн тайлбар: “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно” гэж заасныг “Төрийн цэргийн байгууллагад цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно” гэж өөрчлөх;

2. Мөн Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар бүлэг (Хэрэг бүртгэлт)-ийн 30.7 дугаар зүйл (Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах)-ийн 2 дахь хэсгийн 2.5 “Зэвсэгт хүчний анги, байгууллагын нутаг дэвсгэрт цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн зэвсэгт хүчний анги, байгууллагын захирагч” гэж заасныг “Төрийн цэргийн байгууллагын нутаг дэвсгэрт цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн анги, байгууллагын захирагч, дарга” гэж өөрчлөлт оруулах саналтай байна.

### **Ашигласан материал**

1. The Atlantic Monthly; March 1982; Volume 249, No. 3;
2. Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ., 2018.
3. Дотоодын цэргийн ангиудыг татан буулгах тухай. Засгийн газрын тогтоол. УБ., 2014. №108.
4. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2011.
5. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №41.
6. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай. Нэмэлт, өөрчлөлт. УБ., 2022. №40.
7. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №17.
8. Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд. УБ., 2018.
9. Отгонбаяр Н. Төрийн захиргаа, удирлагын ухаан. УБ., 2022. Цахим холбоос: <http://public9administration.blogspot.com/2015/04/broken-windows-theory.html>.
10. Цэргийн албаны тухай хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №36.
11. Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7.

# БЭЛГИЙН ДУР ХҮСЛЭЭ ЁС БУСААР ХАНГАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

IMMORAL SEXUAL DESIRE  
CRIME STORY TRADITION

**Б.Мягмаржав**

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн дэслэгч*

**Товч агуулга:** Өгүүлэлд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг үе үеийн Эрүүгийн хуулиудад хэрхэн хуульчилж байсан түүхэн уламжлал, тэр дотроос бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг хуульчилсан байдал, нийгмийн хөгжлийн аль шатанд энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцож ирсэн талаар судлахыг зорилоо.

**Abstract:** The article aims to examine the historical traditions of how crimes against sexual freedom and inviolability were legalized in the criminal codes of generations, among them the legalization of the crime of indecent sexual desire, and at what stage of social development this type of ACT has been criminalized

**Түлхүүр үгс:** Бэлгийн харьцаанд орох, хурьцал үйлдэх, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал.

**Keywords:** Sexual intercourse, adultery, sexual freedom and neutrality.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн талаарх хуулинд орж ирсэн албан ёсны нэршил 1987 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд орж ирсэн бөгөөд өмнөх хууль тогтоомжуудад хүний бэлгийн эрх чөлөөнд халдах гэдэг ойлголт нь өөрөө манай монгол улсын уламжлалт ёс заншилтай холбоотойгоор “садарлах, самуун явалдах, хурьцах, түрэмгийлэн явалдах, самуурах” зэрэг үгээр хууль цаазын бичгүүдэд оруулж, тусгаж өгсөн Монгол Улсын үе, үеийн түүхийн үечлэлд дээрх хэргийг үйлдлээр нь зүйлчлэн хуульчилж өгсөн байна.

Монголын нийгмийн хөгжлийн үе шатуудад гэмт хэргүүдийн талаар түүнчлэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн талаар тодорхой ойлголтууд тусгагдаж байсан нь тухайн үед үйлчилж байсан хууль тогтоомжуудаас харагддаг. Ингэхдээ хөгжлийн жам ёсоор цаг үеийн хууль тогтоомжуудад тухайн гэмт хэргийн ойлголтуудыг өөртөө агуулсан хэм хэмжээ боловсронгуй болж ирсэн байна. Хүннү гүрний үеэс уламжлагдан хөгжиж ирсэн олон зуун жилийн түүхтэй хууль цаазын бичгүүд дараах байдлаар эрэмблэдэг хэмээн эрдэмтэн мэргэд судлаачид үздэг. Үүнд:

1206 он Их Засаг хууль;

1271 он Монголын Их Юань улсын хууль цаазын бичиг;

1507 он Алтан хааны цааз;

XVIII зууны хоёрдугаар хагаст бичигдсэн 6 хошууны Их цааз;

1640 оны Монгол Ойрадын хууль;

1709 оны Халх журам хууль /1722 он, 1736 оны нэмэлт/;

1723 оны Монгол цаазын бичиг /Өрх зарлагын зүйл хэмээх 2, 7-р дэвтэр/;

Богд хаант монгол улсын үед батлагдсан 1918 оны Зарлигаар тогтоосон Монгол хууль зүйлийн бичиг зэрэг хууль цаазын бичгүүд<sup>139</sup> орно.

XVIII зууны эхээр монгол туургатан тусгаар тогтносон төр улс байгуулж тэр түүхэн явдалд зон олноороо оролцож үлдээсэн “Монголын нууц товчоо”-нд “Эсгий

<sup>139</sup> Гаадамба. Монголын Нууц товчоо. 1990. 19 дэх тал.

туургатан улс энх шударга болж, барс жил /1206 он/ Онон мөрний эхэнд хуралдаж есөн хөлт цагаан тугаа мандуулж Тэмүүжинг Чингис хаан цолыг өргөв” гэж тэмдэглэжээ. Их засаг хуульд “Садарлан самуурваас цаазлах бөгөөд баригдваас газар дээр нь алж болно. Тагнан туршигчид, хуурамч гэрчлэгсэд, шид үйлдэгсэд болон элдэв гаж донтой хүмүүсийг алах ялаар цээрлүүлнэ<sup>140</sup>” хэмээн заасан байна.

Төв Азид байгуулагдсан Монгол туургатны тусгаар улсад хүчтэй төвлөрсөн төрөөс гадна нэгдмэл хууль цааз зайлшгүй шаардлагатай байсан ба төрийн онолын үүднээс аливаа улс төрийн бодлого, үйл ажиллагаа, хууль цааз тогтоон түүнийгээ хүндэтгэн биелүүлэх замаар хэрэгжүүлж иржээ. Монгол улсын тулгар төр байгуулагдахад түүнтэй зэрэгцэн Их засаг хууль нь 1203-1206 оны үед гарсан бөгөөд 13-р зууны үед үйлчилж байжээ. Уг хуулийн мэдэгдэж байгаа заалтыг бүлгүүдэд хуваасны 7 бүлэгт эрүүгийн цааз хуулийн холбогдолтой 40 гаруй зүйл заалтыг хуульчилан тогтоосон гэж хуульчид үздэг. Их засагийн тухай гадаадын болон манай улсын эрдэмтэн судлаачдын 400 орчим сурвалж бичиг, ном бүтээлүүдэд хөндөгдсөн байдаг.

АНУ-ын эрдэмтэн Жорж Вернадский нь Их засаг хуульд эрүүгийн шинжтэй цааз нь төр нийгэмд тайван ёс журам дэг сахиулах гол хэрэгсэл болсон гээд тэр үндэслэлээ Армений түүхч Магакийн “Хүн гэр бүлийн ёс заншлыг бүү зөрч, бүү хулгайл, гэрчлэхээс бүү татгалз, бүү худал хэл, аливаа гэмт явдалд алах ял оноо<sup>141</sup>” гэж томъёолсонтой холбон тайлбарлажээ.

Их засаг хуульд Нэгэн зүйл: Бусдын эхнэр лүгээ садарлагсадыг цаазална гэж эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг энэхүү хуулиар хамгаалж байсны зэрэгцээ, хэрэв зөрчсөн тохиолдолд хамгийн хүнд ял болох цаазаар авах ялаар шийтгэж байсан. “Өгөөдэй хааны цааз” /1234 он/ дээр “Нэгэн зүйл: Аливаа хааны ордонд орж гарахад эр, эм ганцаар явж болохгүй. Эрхиш хааны ард лугаа ирж хэд хэдээр ханилж явагтун. Ингэж явахад самууран явж болохгүй. Зарлигаас давбаас ял хэлэлцэнэ<sup>142</sup>” гэсэн нь тухайн үеийн ард иргэдийн ял оногдуулах нөхцөлийг тайлбарласан байна.

1271 оны Монголын Их Юань улсын хууль цаазын бичиг буюу Их засаг хуулийн дараагаар манай улсад үйлчилж байсан томоохон хууль цаазын дурсгал бол 1320 оны Юань улсын их хааны зарлигаар батлагдсан 10 хэсэгтэй “Нэвтэрхий толь” хууль юм.

Энэхүү цааз бичиг нь монголын эзэнт гүрний нутаг дэвсгэрийг зөвхөн Дорнод хэсэгт үйлчилж байснаараа онцлогтой бөгөөд Хятад дахь Юань гүрний ноёрхол унаж монголчууд Манж чин улсын эрхшээлд орох хүртэл үйлчилж байсан ба өмнөх Их засаг хуулийн нэгэн адил орчин үеийн олон салбар эрхүүдийг өөртөө багтаасан 10 том анги, 60 бүлэг, 2391 зүйл заалтаас бүрдсэн Юань гүрний төрийн байгууллага, төв байгууллагуудын эрх үүргийг хуульчлан баталсан хууль байжээ<sup>143</sup>.

Хубилай хааны үед мөрдөж байсан бас нэг хууль бол 88 бүлэг, 2539 зүйлтэй “Их Юань улсын цааз бичиг” нь Юань гүрний нэвтэрхий хуультай давхардан үйлчилж байсан ба байлдан дагуулагчдын эрх ашгийг хамгаалсан шинжтэй хууль байв. 1271 оны Монголын Их Юань улсын хууль цаазын бичгийн 104-р дэвтэрт буруу хурыцлыг заахдаа: Нэгэн зүйл: Аливаа бяцхан охин хэмээсэн 10 наснаас

<sup>140</sup> Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. 1 дүгээр бүлэг. 2010. 43 дахь тал.

<sup>141</sup> Эзэн богд Чингисийн Их Засаг. 1995. 50 дахь тал.

<sup>142</sup> Мөн тэнд.

<sup>143</sup> Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. 1997. 14 дэх тал.

доошхи болой. Гурван эр нэгэн эмийг түрэмгийлэн явалдваас цөмийг ална гэж заасныг үзвээс Их засаг хуульд заасантай адил цаазаар авах ялтай байна.

Түмдийн Алтан хаан 1507-1582 онд зохиосон “Алтан хааны цаазын бичиг” нь бидэнд монгол эхээрээ бус төвд орчуулгаар уламжлагдан ирсэн байна. Үүнийг академич Ш.Бира бусад хууль цаазын бичигдээгүй харьцуулан судлах аргаар сэргээсэн бөгөөд 13 зүйл ангитай байсан бололтой<sup>144</sup>.

Үүнд оршил, хүн амины хэрэг, бие эрхтэн гэмтээсэн хэрэг, хулгайн хэрэг, эр эм гэр бүлийн хэрэг, эзэн ба зарцын хэрэг, үхэгсэд ба цээрт өвчинтэй холбогдох хэрэг, мал сүргийг аюулаас аврах тухай, ан амьтаныг хамгаалах тухай, хүнд туслах тухай зарим зүйл, улч албан хэрэг, босуулын холбогдолтой хэрэг гэж ангилан үзжээ. Ийнхүү Алтан хааны цааз бичиг бол Монголын нийгмийн харилцааны гол гол талуудыг хуульчлан зохицуулсан хууль цаазын нэн чухал бичиг юм. 1507 оны Алтан хааны цаазад:

Нэгэн зүйл: Эр нь эмийн үсийг тасадваас нэг таваар торго;

Нэгэн зүйл: Хувцсын урваас нэг таваар торго;

Нэгэн зүйл: Эр эм самуурваас долоон есөөр торго;

Нэгэн зүйл: Ор дэвсгэрээс нь татваас гурван есөөр торго;

Нэгэн зүйл: Эхнэр хүнийг татваас, хувцасыг нь урваас морь үхэр ав<sup>145</sup> гэж заажээ.

1640 оны Монгол Ойрадын хууль буюу 1640 оны 8 дугаар сард Эрдэнэбаатар хунтайжийн санаачлагаар Дөрвөн ойрадын нутаг болох Тарвагатайн улаан буурай гэдэг газар халх ойрадын бүх ноёдыг төлөөлсөн чуулганаар хэлэлцэн “Монгол Ойрадын хууль” гэх цаазыг баталсан ба энэ хуулийг 1986 онд Хөх хотод “Ойрадын цааз” нэртэйгээр хэвлэсэн байна. Уг хэвлэлд Ойрадын цаазыг хууль зохиолын дэс дараалалаар нь 120 зүйл болгон хуваарилж 27 төрөл болгож хураангуйлав гэжээ. Хожим Галдан хунтайжийн 2 удаа захиа зарлагаар энэхүү Монгол Ойрадын хуульд өөрчлөлт хийсэн байна. Эхний зарлигт засаг захиргааны аль нэг нэгжид харьяалалгүй сэлгүүцэн явахыг хориглож, эрүү, иргэний холбогдолтой хэргийг шийдвэрлэх журам, өр авлагын тухай асуудлыг тусгасан бол 2 дахь захиа зарлигт хахуул авах, шүүгчид ая тал засан зэргийг таслан зогсоох, улаа илчийн тухай, оргуул босуултай тэмцэх, гэрчийн этгээдийн тухай өргөн асуудлыг багтаан зохицуулжээ. Тус Монгол Ойрадын хуульд:

Нэгэн зүйл: Нөхөртэй эмэгтэйг хүчирхэн явалдваас есөн малаар, боолыг мориор, эмийг хоёр есөөр тус тус торгоно. Нэгэн зүйл: Эм хүний үсийг гэмтээх, малгайн залааг унагавал есөн малаар торгоно гэсэн байна. Мөн түүнчлэн “Хувцасыг урваас 5 малаар торго. Эр эм садарлаваас 7 есоор торго, сэтгэл бээр авбаас 9 есөөр торгож нэг удаа занч, хүүхэн хүнийг ор дэвсгэрээс нь татваас 3 есөөр торго<sup>146</sup>” гэж торгуулах ял оногдуулж байсан нь өмнөх үеийн хууль цаазын бичгүүдэд тусгасан ялын бодлогоос өөрчлөгдсөн байна.

“Бичин жилийн Их цааз”/1620 он/-д “Эс богтолсон охин хүнийг үсэд авч очсон, эм хүн сэтгэл нийлсэн хүнийг эз алсан хүний хэвд оров”, мөн түүнчлэн 1640 оны Их цааз-д “Зургаан эрхтэн урахул бэрхтэй 5 ес, эрхий хомхой урахул 2 ес нэг 5 ав, дундад хуруу урахул ес ав, нэргүй хуруу урахул 5 ав, шигичээс 3 ав, эдгэхүл бэрхтэй ес ав, бага цус гарахул 5 ав, хувцасанд хүрэхүл 1 морь ав” Энд зургаан эрхтэн гэдэгт буддын шашны тайлбар толинд хэл, гар, хөл, хувцас, бөгс, ал болой” гэсэн заалт орж ирсэн нь тухайн гэмт хэрэг хийсэн хүний үйлдэлийн хүндрүүлэх, хөнгөрүүлэх шинжийг тусгаж оруулсан байна. Урахул гэдэг нь гэмтээвэл, гэмтвэл

<sup>144</sup> Алтангэрэл Т. XVI-XVII зууны Монголын цаазын бичгүүд. 1999. 20 дахь тал.

<sup>145</sup> Мөн тэнд 20 дахь тал.

<sup>146</sup> Авирмэд Э., Дашцэдэн Д., Совд Г. Их Монгол Улсын Хууль. 1997. 71 дэх тал.

гэсэн утгатай гэж тайлбарлажээ. Мөн “Эм хүн дургүй болохул хүчээр хийвэл эрээс ес ав. Боол эмээс 1 морь ав. Дуртай болохул гайгүй. Охин нь дургүй болоод унтахул 2 ес ав,. Адгуус хүн унтахул хэн үзсэн хүн адгуусыг ав. Эм хүний хөх атгахул, үнэсэхул нэг инч ав. Арван настайгаас дээш хүүхэн цаазтай, доош цаазгүй<sup>147</sup>” гэж “Бичин жилийн их цааз” бичигт тус бүрчлэн гэмт хэргийн бүрэлдэхүүн бүрийг тусгаж оруулж өгсөн байдаг.

“Энх-Амгалангийн зургадугаар оны хуучин засгийн бичигт нэмж тогтоосон засгийн бичиг” /1667 он/-д “Харц хүний эмийг вангууд татваас 9 ес, засгийн ноёд, хошууны тайж, гүнгүүд болбоос 7 ес, тайж нар болбоос 5 ес богд авмуу. Харц хүн харц хүний эм лүгээ явалдваас мөн түүний эмийг аваад ял 5 есөн бод авму. Явадсан эмийг эрд нь тулгаж өгч алуулмуу. Эс алваас авсан тэр ялын малыг харьяат ноёнд нь өгмү. Биш хүний эмийг татваас ял 3 есөн бод авму<sup>148</sup>”

“Баруун хүрээний халх журам” /1709 он/-д “Ноёд харц хүний эмд орвоос 150 анзаар торго, ноёд ноёдын хатанд орвоос ноёд зуураа сүй эвдсэн лүгээ адил анз эс гүйцээвээс биеийг нь авая. Харц хүн хатанд орвоос хамаг биеийг нь талаад, халуун амийг цөм хатны ноёнд албатын дотор хятадын хятадад барьж өгье. Хөнжлийн захаас татваас гурван ест<sup>149</sup>”.

“Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны дагаж явуулах хууль зүйлийн бичиг” /1760 он/-д “Засаг ба засаг бус ван бэйс гүн тайж тавнан нь харц хүний гэргий лүгээ явалдваас 3 жилийн пүнлүү хас. Басхүү 3 ес мал торгож явалдсан эмийн эрд өг. Пүнлүүгүй тайж тавнанг нугалж 6 есөн мал торгож албанд хадгалуулагтун. Басхүү нэгэн есөн мал торгож явалдсан эмийн эрд өг. Харц хүн хатад лугаа үгсэж явалдваас явалдсан эрийг огтчиж ал. Хатадыг цавчин ал. Явалдсан эрийн эмийг болон хөвгүүдийг айлын чуулганд цөлж боол болго. Аливаа тайж нарын гэргий багахан эм лүгээ магадад явагчдыг нь Шүүх цаазын бичгийн ёсоор , боол гэр тэргүүлэгчийн гэргий багахан эмд явалдваас аливааг хөвчдөн алах ял торгож гянданд хорьж хүлээ. Гэрийн боол лам болбоос бас энэ ёсоор шийтгэ. Тайж нарын бага эм лүгээ явалдсан эр эмийг цөмийг 2 сарын дөнгө дөнгөлж 100 ташуур занч, Явалдсан эмийн ташуурыг занчихыг тасал. Дөнгө дөнгөлөхийг золио ав<sup>150</sup>.”

“Монголын цаазын бичиг” /1795 он/-д “Харц хүн нь харц хүний эм лүгээ явалдваас түүнийг эмийг авч, ял нь 5 есөөр торго. Явалдсан эмийг өөрийн эрд нь тушаан өгөөд алуулна. Эс албал тэр ялын малыг өөрийн ноёнд нь өгнө. Бусдын эхнэрийг татвал ял 3 ес мал авна. Харц хүний эм лүгээ засаг ба засаг бус вангууд явалдвал 9 ес, бэйл, бэйс, гүнгүүд бол 7 ес, тайж, тавнангууд бол таван есөөр торгоод ялын малыг явалдсан эмийн эрд өгнө. Харц хүн хатад лугаа явалдвал явалдсан эрийг огтчиж алсугай. Хатныг цавчиж алсугай<sup>151</sup>”

“Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдалын яамны хууль зүйн бичиг” /1811 он/-д “Засаг ба засаг бус бэйл бэйс гүн тайж тавнан нь харц хүний гэргий лүгээ явалдваас гурваад жилийн пүнлүү хас, басхүү гурваад есөн мал торгож, явалдсан эмийн нөхөрт өг. Пүнлүүгүй тайж тавнанг 6 есөн мал торгож, албанд хадгалуул, басхүү нижгээд есөн мал торгож явалдсан эмийн нөхөрт өгөгтүн. Аливаа тайж нарын гэрийн боол тайж нарын гэргий нар багахан явалдагсдыг Шүүх цаазын бичгийн гэрийн боолын гэрийн тэргүүлэгчдийн гэргий багахан эм лүгээ явалдах хууль ёсоор шийтгэ. Аливаа лам нар өөрийн гэрийн боол жич бус хүний гэрийн боолыг халган адгуулж банди болговоос болохгүй. Хэрэв

<sup>147</sup> Баярсайхан В. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. 2006. 10 дахь тал.

<sup>148</sup> Мөн тэнд. 10 дахь тал.

<sup>149</sup> Мөн тэнд. 10 дахь тал.

<sup>150</sup> Мөн тэнд. 10 дахь тал.

<sup>151</sup> Мөн тэнд. 10 дахь тал.

нуун дарж халган адгуулах нь буй бөгөөс, харьяат ламыг гурваад есөн мал торго. Зоригоор гэрийн боолыг хүргэж банди болгох нь хэрэв засаг ван бэйл бэйс гүн тайж тавнан болбоос өөр өөрийн нэгэн жилийн засгийн пүнлүүг хас. Засаг бус ван бэйл бэйс гүн тайж тавнан жич пүнлүүгүй түшмэд, харц хүн болбоос цөм нугалж хошоод есөн мал торго. Басхүү зоригоор банди болгох хүнийг дээр хөөн үлдэж уг нутагт хүргүүл. Цахар найман хошуу жич сүргийн ард халдах буй бөгөөс, бас ч энэ хууль ёсоор шийтгэ<sup>152</sup>”

### **Дүгнэлт**

1. Дундад зууны үеийн Монголын хууль цаазын бичгүүдэд аливаа хүний эрх чөлөө, бэлгийн эрх чөлөө гэх ойлголт төдийлөн нарийвчилсан зүйлчилэн заасан заалт тус цааз бичгүүдэд хөндөгдөөгүй байгаа юм. Тухайн гэмт явдал гаргасан хүний нийгэмд эзлэх байр сууриас хамаарч ялыг ялгаатай өгдөг байсан бөгөөд:

- Цавчин алах, газар дээр нь алах;
- Нэг тав, долоон есөөр торгох;
- Есөн мал, мориор торгож нэг удаа занчих;
- 9 ес, 7 ес, 5 ес, 3 есээр торгох;
- 150 анзаар торгох;
- Хятадын хятадад барьж өгөх;
- Огтчиж, цавчин алах;
- Тухайн эрийн эм болон хөвгүүдийг боол болгох;
- 3 жил, 1 жилийн пүнлүүг хасах зэрэг ялаар шийтгэдэг байжээ.

2. Түүхэн уламжлалт он дэс дарааллаар авч үзвэл хувь хүний бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэг ойлголт гэхээс илүүтэйгээр ёс суртахууны болон шашны ойлголтонд баригдсан байдалтайгаар үр дагаврыг илүү тогтоон барьж, ХХ зууны эхэн үе хүртэл явж ирсэн хууль цаазын бичигт тусгаж оруулж байсан нь шинэ үеийн Монгол улсын Эрүүгийн хуулийн хууль тогтоомжийг үүсэхэд нөлөөлсөн байна.

### **Ашигласан материал**

1. Гаадамба. Монголын Нууц товчоо. 1990.
2. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. 1 дүгээр бүлэг. 2010.
3. Эзэн богд Чингисийн Их Засаг. 1995.
4. Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. 1997.
5. Алтангэрэл Т. XVI-XVII зууны Монголын цаазын бичгүүд. 1999.
6. Авирмэд Э., Дашцэдэн Д., Совд Г. Их Монгол Улсын Хууль. 1997.
7. Баярсайхан В. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. 2006.

---

<sup>152</sup> Мөн тэнд 10 дахь тал.

# КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙХ ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ ШИНЖ

### LACK OF MEDICAL ATTENTION CRIMINOLOGICAL CHARACTERISTICS OF CRIME

Б.Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,  
криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлд заагдсан “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцлийг сүүлийн 10 жилийн статистикт тулгуурлан гаргаж, урьчилан сэргийлэх арга замыг эрэлхийлсэн болно.

**Abstract:** Based on the statistics of the last 10 years, the reasons for the occurrence of the crime of “failure to provide medical care” specified in Article 15.1 of the special section of the criminal law, and ways of prevention have been sought.

**Түлхүүр үгс:** Эмнэлгийн мэргэжилтэн, их эмч, гэм буруугийн болгоомжгүй хэлбэр, улсын эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг.

**Keywords:** hospital specialist, general practitioner, negligence, public hospital, private hospital.

Их засаг хуулийн 25 дугаар зүйлд “Шашны хэргэмтэн шав нар, эмч сурагчаас бусад ард иргэд гааль гувчуур тушаах үүрэгтэй” хэмээн тусгаснаас харахад эмч оточ хүнийг чухал үүрэгтэй болохыг харуулж байна.

Халх журам нь 1709 оноос 1791 оны хооронд үйлчилж байсан ба халхын ноёдын хурлаас тогтоогдсон юм. Энэхүү журмын 8 дугаар бүлэгт “Хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн тухай дурдсан байх бөгөөд 156 дугаар зүйлд “Бас дотогш орогчин ямар ч хол аянд нөхрөө өвдсөнийг эмчлэлгүй эзгүй газар орхиж ирээд тэр хүн үхвэл тэмээгээр ор босгоод нэг есөн бод авах, эдгэрвээс соёолон хязаалан морь авч бай. Авагч юмыг өвдөгчид өгөх...” зэргээр тусгасан байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 106 дугаар зүйл болон Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлээр зүйлчилсэн хүчинтэй шүүхийн шийтгэх тогтоолуудад дүн шинжилгээ хийхэд 2010-аас 2015 оны хооронд 20, 2015-аас 2020 оны хооронд 11, 2020-оос 2024 оны хооронд 40 шийтгэх тогтоол үйлдэгдсэн байна.

Энэ гэмт хэргийн гаралт нь хүн амын өсөлттэй шууд хамааралтай байна. 2010-2015 оны хооронд бүртгэгдсэн гэмт хэрэг дараагийн 5 жилийхээс их байгаа тухайн үед үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн 106 дугаар зүйлд заасан “Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийн субъекттэй (Эмч, эмнэлгийн ажилтан) хамааралтай байна.

2023 оны байдлаар Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр улсын болон хувийн 4998 эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Эрүүл мэндийн ажилчдын 22.1 хувийг их эмч, 22.0 хувийг сувилагч, 5.9 хувийг эм зүйч, 3.5 хувийг эм найруулагч, 2.7 хувийг бага эмч, 2.2 лабораторийн техникч эзэлж байна. Мөн удирдах ажилтнуудын 21.3 хувь магистрын зэрэгтэй ба 4.7 хувь нь докторын зэрэгтэй байна.

Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн 2010 оноос 2024 оны 2 дугаар сарыг хүртэлх хугацаан дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн нийт 66 эмнэлгийн мэргэжилтэн хамаарагдах хүчинтэй 77 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, судаллаа. Үүнээс 10 хувь нь давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан бол 5 хувь нь хяналтын шатны шүүхэд хандаж шийдэгдсэн байна.

Судалгааны явцад өмнө хорих ял шийтгэл эдэлж байсан, гадаад улсын (БНСУ), тэтгэвэрт гарсан тус тус нэг иргэн тухайн гэмт хэргийг үйлдсэн байх нь тогтоогдсон.

Эрүүл мэндийн судалгаа 2022 оны мэдээллээр нийт ажиллаж буй эмнэлгийн ажилчдын 82.0%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг ба мөн тэдний 32.3%-ийг 30-39 насныхан эзэлж байна. Дээрх шүүхийн шийтгэх тогтоолын тойм судалгаанаас харвал эмнэлэгт идэр насны эмэгтэй мэргэжилтэн илүү ажилладаг тул хэрэгт холбогдсон магадлал нь илүү байгааг буюу нас болон хүйс нь гэмт хэргийн шалтгаан нөхцөл биш байна.

Ажлын байрны тодорхойлолтоос үзэхэд, их эмчийн шууд харьяалагдах ажлын байр, албан тушаалтан нь эмнэлгийн дарга болон эрхлэгч байх бол шууд харьяалах ажлын байр нь сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилчид байна. Их эмчийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсанаар их эмч нь:

- зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний стандарт, түгээмэл үйлдлийн стандарт, удирдамжийн дагуу тогтмол оношилгоо, эмчилгээ хийх;
- сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд эмчилгээ, сувилгааны чиглэлээр тогтмол зааварчилгаа өгөх, хяналт тавих үүрэгтэй байна.

Их эмч нь үүргийнхээ хувьд оношилгоо, эмчилгээг өөрийн биеэр удирдан чиглүүлж, харин бусад мэргэжилтнүүд нь эх эмчийн удирдлага дор, түүний зааврын дагуу үүрэг даалгаврыг гүйцэтгэдэг учир гэмт хэрэгт холбогдох нь бага байна.

2023 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 585 эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг болон оношилгоо, эмчилгээний төв, 1485 хувийн эмнэлэг үйл ажиллагаагаа явуулж байна. Дэлхийн дунджаар 2023 оны байдлаар 10.000 хүн амд дунджаар 15 их эмч ногдож байх бол Монгол Улсын хувьд 41.9 ногдож буй нь стандартад нийцэж байна. Энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд өсөх хандлагатай мөн их эмч, сувилагчийн харьцаа жил бүр 1:1 байгаа нь эмнэлгийн ачаалал мөн адил гэмт хэргийн шалтгаан биш гэдгийг илтгэж байна.

#### 1. Объектив шалгуур:

- Оношлох шинжилгээг хийхгүй байх;
- Эмчилгээний аргыг буруу сонгох;
- Хүндрэлийг хожуу оношлох;
- Зохих эм тариа, багаж хэрэгсэл байхгүй буюу хоцрогдсон;
- Ажилбарыг зохих стандартаар хийхгүй байх;
- Хүнд өвчтөнд асаргаа муу хийх зэрэг нь эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн зонхилох шалтгаан нөхцөл болж байна.

Жил бүр 10.000 хүнд ногдох их эмчийн болон сувилагчийн тоо өсөж байгаа ч “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийн тоо харилцан өсөж байгаа нь тус гэмт хэрэг Монгол Улсын хүн амын өсөлттэй буюу эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоотой шууд хамааралтай байна. Харин “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийн шалтгаан нь эмнэлгийн мэргэжилтний чадавхгүй байдал гэж дүгнэлээ.

Гаднын орнуудын хувьд буруу, хожуу оношлох, мэс заслын алдаа, эмийн алдаа, төрхийн гэмтэл, мэдээ алдуулалтын алдаа, дутуу өгсөн мэдээлэл,

стандарт зөрчсөн үйлдэл, дутуу хяналт зэрэг зөрчлүүд ихэвчлэн гардаг бол тэдгээрийг шийдвэрлэхийн тулд эмч, эрүүл мэндийн ажилчдыг эмнэлгийн дэвшил, шилдэг туршлага, эрүүл мэндийн салбарт шинээр гарч ирж буй чиг хандлагын талаар мэдээллээр хангахын тулд бага хурал, семинар, семинар, онлайн сургалтад тогтмол хамруулах, эмнэлгийн зөвлөлөөс үйл ажиллагааны стандартыг тогтоох, ёс зүй, хайхрамжгүй байдлын талаарх гомдол мэдээллийг шалгаж, зохих сургалтад суулгах, төрөөс эрүүл мэндийн салбарыг дэмжихээр дэд бүтэц, санхүүжилт, эрдэм шинжилгээний хамтын ажиллагаанд хөрөнгө оруулах, эмч нарыг сэтгэл зүйчтэй байлгах зэрэг арга хэмжээнүүдийг авдаг байна. Монгол Улсын хувьд дээрх алдаа дутагдлууд мөн адил гардаг хэдий ч авч буй арга хэмжээ, урьдчилан сэргийлэх ажиллагаа болхи байна. Жишээлбэл: өвчтөнтэй харилцах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг хурал, семинарыг тогтмол явуулдаг хэдий ч тухайн үйл ажиллагаа нь дангаараа ямар ч үр дүнгүй, цагийн гарз болсон үр ашиггүй байна.

### **Дүгнэлт**

Судалгааны явцад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх гэмт хэрэгт холбогдсон дийлэнх буюу их эмчийн үйлдсэн алдаа дутагдал нь ихэнх тохиолдолд өөрөөс хамааралтай ба гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь хуулийн зохицуулалт, тэдний нас, хүйс, ажиллаж буй газрын байршил, ачаалал зэргээс үл хамаарч буюу хувь хүний чадавхаас шалтгаалж байгаа нь харагдаж байна.

Улс орнуудын ижил төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан болсон үйлдлүүд хоорондоо төсөөтэй байна. Монгол Улсын хувьд 10.000 хүн амд ногдох их эмчийн тоогоор бусад өндөр хөгжилтэй орнуудаас давуу хэдий ч тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу эмч нарыг чадавхжуулах ажил үр дүнгээ өгөхгүй байгааг харж болно.

### **Санал**

Улсын үнэт эрдэнэ болсон ард иргэдийн эрүүл мэнд нь төрийн зүгээс анхаарах ёстой нэн тэргүүний асуудал юм. Үүний тулд эрүүл мэндийн салбарт чанартай боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байна.

2023-2024 оны хичээлийн жилд нийтдээ 63 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 16 нь төрийн өмчийнх бол 45 нь хувийн өмчийнх байна. Эдгээрээс 12 их, дээд сургууль эрүүл мэнд, анагаах ухааны хөтөлбөрөөр дээд боловсрол олгож байна. Үүнээс ердөө 4 сургууль 2023-2024 оны хичээлийн жилийн тайланд хамрагдсан байна. Иймд эмнэлгийн байгууллагад эмчээр ажиллах боловсон хүчнийг чадавхжуулах буюу “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргээс алсдаа урьдчилан сэргийлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог Монгол Улсын хэмжээнд салбар харгалзалгүй 500 болгож нэмэгдүүлэх;

2. Анагаахын оюутнууд 3 дугаар дамжаанаас эхлэн дадлагад гардаг байна. Төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын дадлагын хугацааг 1 дүгээр дамжаанаас эхлүүлж оюутнуудыг сувилагчаар удирдуулах, 3 дугаар дамжаанд орох үеэс эхлэн сонгосон чиглэлийг харгалзан удирдуулж, уртаар дадлагад гаргах;

3. Оюутнуудад 1 дүгээр дамжаанаас төгсөх дамжаа хүртэлх хугацаанд эхлэн харилцааны ур чадварын хичээл оруулах;

4. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан сэтгэл зүйчтэй болох;

5. Ижил мэргэжилтний хөндлөнгийн үзлэгийг тогтмол зохион байгуулах;

6. Эрүүл мэндийн салбарын бүх шатны сургалтад анагаах ухааны эрх зүйн сургалтын оруулах;
7. Мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах саналтай байна.

#### **Ашигласан материал**

1. Баярсайхан Б. Монголын төр, эрх зүйн түүх (Дээж бичиг). Уб., 2006.
2. Их эмч, эм зүйчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаал. Уб., 2012. Дугаар 182.
3. Ням-очир Н. Эзэн Чингис хааны их засаг хууль. Уб., 2010.
4. Эрүүл мэндийн үзүүлэлт. 2022.  
Цахим эх сурвалж
5. <https://dnn.mn/news/68199>.
6. [https://www.who.int/data/gho/data/indicators/indicator-details/GHO/medical-doctors-\(per-10-000-population\)](https://www.who.int/data/gho/data/indicators/indicator-details/GHO/medical-doctors-(per-10-000-population)).
7. [https://www2.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_2100\\_008V2&SOUM\\_select\\_all=0&SOUMSingleSelect=\\_0&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2022&viewtype=table](https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2100_008V2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2022&viewtype=table).
8. [https://www2.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_2100\\_008V3&SOUM\\_select\\_all=0&SOUMSingleSelect=\\_0&PH003\\_select\\_all=0&PH003SingleSelect=\\_2\\_4\\_5\\_6\\_3\\_7\\_8\\_9\\_10\\_11\\_12\\_13\\_14\\_17\\_16\\_15&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2022&viewtype=table](https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2100_008V3&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&PH003_select_all=0&PH003SingleSelect=_2_4_5_6_3_7_8_9_10_11_12_13_14_17_16_15&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2022&viewtype=table).

## ГЭМТ ХЭРЭГТЭН БИЕ ХҮНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

### THE CONCEPT OF A CRIMINAL PERSONALITY

*Ш.Алтансоёмбо  
ДХИС-ийн докторант*

**Товч агуулга:** Гэмт хэрэгтэн бие хүнд хамаарах ойлголтын үүсэл ба хөгжлийг судлах нь зөвхөн шинжлэх ухаан хөгжихөд таатай нөлөө үзүүлээд зогсохгүй мөн онол, практикийн чухал ач холбогдолтой. Тиймээс өгүүлэлд криминологийн шинжлэх ухааны нэг чухал судлагдахуун болох гэмт хэрэгтэн бие хүний тухай ойлголтын үүсэл, хөгжил, түүнийг бүрдүүлэгч оюун ухаан, сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэнд, бие бялдрын онцлог, дадал зуршил, зан үйл, байгаль цаг уур, нийгмийн орчин нөхцөл, түүний нөлөө зэрэг нийгэм, биологийн хүчин зүйлс зэргийн заримыг судлахыг зорилоо.

**Abstract:** The study of the origin and development of the concept of belonging to the criminal body has not only a favorable effect on the development of science, but also an important theoretical and practical value. Therefore, the article aims to study some of the important studies of criminology: the origin and development of the concept of the criminal body, its constituent mental, psychological, mental health, physical characteristics, habits, behavior, climate, social environment and its influence, as well as social and biological factors.

**Түлхүүр үгс:** Гэмт хэрэг, гэмт хэрэгтэн бие хүн, үзэл баримтлал, онолын үндэс.

**Keywords:** Crime, Criminal person, concept, theoretical basis.

Бие хүн бол гэмт хэрэг үйлдэх шалтгааныг тээгч байдаг тул гэмт хэрэгтний бие хүн дээр анхаарал төвлөрүүлбэл гэмт хэргээс амжилттай урьдчилан сэргийлэх бүрэн боломж гарна. Бие хүн бол гэмт хэргийн зан үйлийн механизмын бүрэлдэхүүний үндсэн бөгөөд чухал хэсэг нь юм<sup>153</sup>.

Тодорхой гэмт хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэгтэн бие хүний тухай яригдана. Бие хүний хувьд өөрт нь төлөвшин тогтсон гэмт санаа бодол, сэдэл зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эрүүгийн хуулиар хориглосон нийгэмд аюултай, гэм буруутай үйлдлийг санаатай ба болгоомжгүй хийсэн этгээдийг хэлнэ<sup>154</sup>.

Гэмт хэрэгтэн бие хүний онолын үндсэн зорилго нь тухайн тодорхой нөхцөлд эдгээр үзэгдлүүд хэрхэн үүсэн бий болдог, өөрийгөө хэрхэн харуулдаг, нөхцөл байдал, үзэгдэл, субъектив функцийн хуулийг нээн илрүүлэх явдал юм.

Гэмт хэрэгтэн бие хүний онолын хүрээнд нэг бус удаа гэмт хэрэг үйлдсэнээс гадна хэн нэгэн хангалттай тохиолдлын чанартай гэмт хэрэгт холбогдсон, болгоомжгүйгээр, мөн түүнчлэн тухайн этгээдийн хувийн шинж тэмдгүүд нь түүний гэмт хэрэг үйлдэх өндөр магадлалтайг гэрчлэх зэрэг бүх тохиолдлыг судлах юм. Сүүлчийн тохиолдол дахь хүмүүсийг илрүүлэх, тэдэнд чиглэгдсэн хувийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх асуудал нь одоогийн криминологийн шинжлэх ухааны анхаарлын төвд байгаа зүйл юм.

Гэмт хэрэгтэн бие хүний нийгэм, сэтгэл зүй, эрх зүй, ёс суртахуун, биологи, сурган хүмүүжүүлэх, анагаах ба бусад талыг таньж мэдсэнээр бид гэмт хэрэгтний дээрх төлөвүүд ба үүнийг үндэслэн янз бүрийн шинжлэх ухааны харилцан

<sup>153</sup> Болдбаатар Ж., Нямдаваа О. Криминологи. Уб., 2010. 62 дахь тал.

<sup>154</sup> Мөнх-Эрдэнэ Д. Гэмт хэрэг судлалын онол. Уб., 2021. 148 дахь тал.

үйлчлэлийг хангах юм. Энэ нь гэмт хэрэгтэн бие хүний тухай бидний ойлголтуудыг өргөтгөж, гүнзгийрүүлэх боломж олгох юм. Гэмт хэрэгтэн бие хүний тухай онолын арга зүйн үүрэг нь тэр бусад эрх зүйн шинжлэх ухаанд энэхүү үзэгдлийг судлах багаж хэрэгсэл олгоход оршино. Яагаад гэвэл энэхүү асуудлын талаар бусад шинжлэх ухаануудаас илүү ач холбогдолтой олон талт онолын ба практикийн мэдээллийн сантай юм. Түүнчлэн гэмт хэрэгтний бие хүнийг судлахад ашиглахад илүү дөхөмтэй ойлголт, үзүүлэлтүүдийг боловсруулан гаргадаг юм<sup>155</sup>.

Гэмт хэргийн тухай шинжлэх ухаанд эргэлт хийсэн шинэ эрин үе XIX зуунд эрүүгийн антропологи судлал бий болсон үеэс эхэлнэ. Эрүүгийн антропологиог үүсгэн байгуулагч нь австрийн эмч Франц Иозеф Галль (1758-1828) гэж үздэг. Тэрээр физиономийг<sup>156</sup> үгүйсгэж, френологи<sup>157</sup> буюу гавлын хэлбэрээр сэтгэл зүйг судлах онолыг хөгжүүлжээ. Энэ нь краниологи<sup>158</sup> өгөгдөхүүнийг үндэслэн хүний сэтгэцийн онцлогийн талаар дүгнэлт хийх тухай онол юм.

Галлийн бодлогоор хүний оюун ухаан, ёс суртахууны доголдол нь уураг тархины хөгжлийн ялгаагаар илэрдэг ба энэ нь гавлын ясны бүтцэд тулгуурлан хувь хүний шинж тэмдгийг тогтоож болох ажээ. Галлийн сургаалын ач холбогдол нь тархи ба хувийн шинж чанарын хоорондын холбоо нь тогтвортой. Харин гэмт хэрэгтнийг гавлын ясаар нь тогтоох тухай онол нь үндэслэлгүй буруу байсан. Тэрээр бичихдээ “хууль тогтоох ажлын гол объект нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг засаж хүмүүжүүлэх, засаршгүй этгээдүүдээс нийгмийг хамгаалах явдал байх ёстой бөгөөд энэ боломжийг хүний шинж чанар, орчин өөрөө олгож байдаг” гэжээ. Эрдэмтэн нь удаан хугацааны судалгааны үндсэн дээр тархины бүрхүүл, түүний атираа нь онцгой үүрэгтэй тухай одоо ч хүлээн зөвшөөрдөг нээлтийг хийсэн. Хулгайлах болон хүн амины хэрэг хийхийг өдөөж байдаг тархины хэсгийг олж тодорхойлж болно гэж тэр үздэг байжээ.

Тэрээр гэмт хэрэгтэн бие хүний судлалын онолын талаар их зүйл хийсэн юм. Эрдэмтэн гэмт хэрэгтний бүтэц түүний төрлийн асуудалд ихээхэн анхаарал хандуулжээ. Галль гэм буруу ба түүний шийтгэлийн түвшинг гэмт хэргийг судалснаар тогтоох боломжгүй харин түүнийг үйлдсэн этгээдийг судалснаар тогтоох боломжтой гэж үзэж байжээ. Галль үндсэн дүгнэлтүүдээ өөрийнхөө “Тархины үүргүүд” (1822) номдоо илэрхийлжээ. Тэр физиогномикийн байрыг эзэлсэн, гавлын ясны хэлбэрээр сэтгэхүйг судлах френологийн онолыг бий болгожээ.

Галлийн санааг Тулоны шоронгийн ерөнхий эмч Тулоне Ловерний судалгаа үргэлжлүүлжээ. Ловернийн “Хоригдлууд” ном бүхэлдээ гэмт хэрэгтнийг физик, ёс суртахуун мөн сэтгэн бодох чадварын талаас нь судлахад чиглэгдсэн анхны ном байв. Тэр олон гэмт хэрэгтнийг тэдний оршин тогтноход нийгмийн нөхцөл байдал чухал болоход анхаарлаа хандуулан тодорхойлжээ.

Эдгээр бүтээлүүд италийн алдарт сэтгэц судлаач, шүүх эмнэлгийн эмч, эрдэмтэн профессор Чезаре Ломброзогийн боловсруулсан үзэл санааны эхлэлийг тавьж өгчээ. Чезаре Ломброзо анх удаа шоронд хоригдож байгаа гэмт хэрэгтнүүдэд тохиолдлын чанартай ажиглалтаар бус системтэй, үр дүнтэй судалгаа хийжээ. Тэр шинжлэх ухааны бүхэл бүтэн салбар болох криминологийн антропологиог үүсгэн байгуулжээ. Өмнө энэ шинжлэх ухааныг антропологиин байр

<sup>155</sup> Антонян Ю.М., Гульдав В.В. Криминальная патопсихология. М., 1996.

<sup>156</sup> Physiognomy – Нүүр царай судлал буюу хүний зан байдлыг нүүр болон үйл хөдлөлөөр нь тайлбарладаг онол.

<sup>157</sup> Phrenologists – Гавлын хэлбэрээр сэтгэл зүйг судлах онол.

<sup>158</sup> Craniological – хүн, амьтны гавлын ясны хэлбэрийн хэвийн өөрчлөлтийг судалдаг шинжлэх ухааны салбар.

сууринаас судалж байгаагүй байна. Ч.Ломброзогоос өмнө системгүй ч гэсэн сонирхол татахаар авьяаслаг судалгаанууд хийгдэж байжээ.

Ч.Ломброзо үйл ажиллагаа гэмт хэрэгтнийг нийгмийн эсрэг үйлдлийн шалтгааныг тээгчийн хувьд танин мэдэхүйн шийдвэрлэх мөч, шинжлэх ухааны эрэлтийн мөч байв. Ч.Ломброзо 26886 гэмт хэрэгтнийг судалжээ. Хяналтын багт тэр сайн дурын 25447 шударга иргэдийг оролцуулжээ. Ч.Ломброзо амьтан ба ургамлын ертөнцөд ургамал, амьтад бие биеэ алж иддэгтэй адил хүний нийгэмд ч гэсэн гэмт хэрэг байгалийн зүй ёсны хэвийн үзэгдэл юм гэж үзжээ. Эхлээд Ч.Ломброзо гэмт хэрэгтэн бие хүний үндсийг түүний бие организмд удамшлын атавизмийн шинж тэмдгүүд байгаагаас шалтгаалдаг гэж үзэж байжээ.

Тэр гэмт хэрэгтэн бол орчин үеийн соёлт нийгэмд төрсөн, түүндээ дасаж амжаагүй байгаа зэрлэг хүн гэж таамаглажээ. Орчин, хүмүүжил, ойрын хүрээллийн аль аль нь түүнийг гэмт хэргээс татаж авч чадахгүй. Учир нь тэр төрөлхийн гэмт хэрэгтэн бөгөөд анатоми, физиологи ба сэтгэл зүйн шинж тэмдгүүдээрээ ялгаатай юм.

Ч.Ломброзо төрөлхийн гэмт хэрэгтний гавлын яс, нүүрэнд (хялар нүд, тэгш хэмтэй бус, шүдний байрлал хэвийн бус, хамрын сонин хэлбэр, эрэмдэг үрчлээ), биед (хэвийн хэмжээнээс хэт урт гар) нь атавист<sup>159</sup> шинж тэмдгүүд байдаг гэж үзжээ. Ломброзо онолоороо гэмт хэрэгтэн хүнийг гадаад төрхөөр нь тодорхойлж болно гэж үзсэн юм.

Түүний онолын дагуу төрмөл гэмт хэрэгтний 18 шинж байдаг гэж үздэг ба эдгээрээс 5 болон түүнээс дээш шинж тэмдэг илэрсэн тохиолдолд уг онош батлагддаг гэж үзэж байжээ. Ломброзогийн үзсэнээр төрмөл гэмт хэрэгтний гадна төрхийг тодорхойлох шинжүүд<sup>160</sup>:

1. Тухайн арьс өнгө, нутаг усныхнаасаа толгойны хэмжээ болон хэлбэрийн хувьд гажуудалтай;
2. Нүүр хэлбэрийн тэгш хэмт бус байдал;
3. Эрүү болон хацрын ясны хэтэрсэн хэмжээстэй;
4. Нүдний согог болон хачирхалтай хэлбэртэй;
5. Жирийн бус чихний хэлбэртэй, заримдаа маш жижиг хэмжээтэй, шимпанзе шиг чих нь толгойноосоо илэрхий цухуйж гарсан;
6. Хэрэв хулгайч бол далийсан хамартай, сөрдийсөн, эсвэл хавтгай хамартай байдаг бол хүн амины хэрэгтнүүд нь бүргэд шувууны хошуу мэт хамартай аль эсвэл хамар нь хавдсаны улмаас үзүүр нь дээш сөхөгдсөн мэт;
7. Махлаг уруултай, хавдсан аль эсвэл урагшаа цухуйсан;
8. Зарим амьтадтай адил хацар дотроо ууттай;
9. Хорхой идсэн сэртийсэн шүдтэй, мөн сэтэрхий тагнайтай;
10. Шүдний буруу байрлалуудтай;
11. Хойшоо хумигдсан эрүүтэй, хэт урт эрүүтэй, эсвэл бич шиг богино бөгөөд хавтгай эрүүтэй;
12. Төрөл төрлийн үрчлээ ихтэй, нас нь болоогүй байхад үрчлээтсэн байдал;
13. Үсний хэвийн бус үзэгдэлтэй, эсрэг хүйстнийхээ үс шиг үстэй байх;
14. Цээжний ясны гажуудалтай, хэт олон эсвэл хэт цөөн тооны хавиргатай эсвэл хэт олон мөөмтэй;
15. Хүйсийн тодорхойлох бэлэг эрхтний солигдол;
16. Хэтэрсэн гарын урттай;
17. Гарын илүү хуруунуудтай;

<sup>159</sup> Атавист: хүнд хувьслын явцад алдагдсан шинж тэмдэгүүд илрэх үзэгдэл.

<sup>160</sup> Болдбаатар Ж., Дамдинцэрэн Д. Эрүүгийн профайлинг. Уб., 2022. 39 дэх тал.

18.Тархины зүүн болон баруун бөмбөрцгийн тэгш бус байдалтай.

Ч.Ломброзогийн бүтээл гэмт хэрэгтэн бие хүнийг идэвхтэй, зорилготой шинжлэх ухааны үндэстэй судлах эхлэлийг тавьж өгсөн юм. Э.Дюркгейм гэмт хэрэг бүх үед, бүх газарт хүний нийгэмд гэмт хэрэг оршин тогтносоор ирсэн тул хувь хүний хувьд зүй тогтлын зүйл юм гэж дүгнэжээ. Социаль аномийн онолыг залгамжлагч Роберт Мертоны бодлоор социологийн криминологийн байр сууринаас бол гэмт хэрэг үйлдэх нь зөвхөн гэмт хэрэг үйлдэж болзошгүй хувь хүний асуудал биш юм. Түүнийхээр ихэнх хүмүүс хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар зорилгодоо хүрэхийг хичээдэг гэж үздэг. Хууль ёсны дагуу хөдөлмөрлөж зорилгодоо хүрэх боломжийг нь бүлэг хүмүүс эсвэл эрх мэдэлтэй хүмүүс хаах үед аномигийн төлөв байдал үүсэж эхэлдэг байна. Өөрөөр хэлбэл, шударгаар амьдрах боломжийг нь хязгаарлах үед бослого, эмх замбараагүй байдал, гаж зан үйл хувь хүнээс илрэн гардаг байна. Мөн нийгмийн хэвийн нөхцөл байдалд хэвийн бус этгээдийн хэвийн бус хариу үйлдэл, аль эсвэл нийгмийн хэвийн бус үзэгдэлд хэвийн хүний хэвийн хариу үйлдлийг оруулж тооцож болно.

Дараагийн чиглэл нь гэмт хэрэгтэн бие хүнийг хэвийн бус биологийн гаралтай онцлогуудын цогц гэж үзжээ<sup>161</sup>.

Зарим нэг гэмт хэрэгтэн бие хүний онцлог нь органик ба сэтгэл зүйн шинжтэй атавизм, зарим нь зөвхөн сэтгэцийн шинжтэй гэж үзэж байв. Э.Дюркгеймээс ялгаатай нь гэмт хэрэг бол нийгмийн хэрэг явдал мөн боловч гэмт хэрэгтэн бол хэвийн бус үзэгдэл гэж үзжээ. Ч.Ломброзо гэмт хэргийг нийгмийн ба хувийн эмгэг үзэгдэл гэж үзжээ<sup>162</sup>.

Франц фон Лист бүх гэмт хэрэгтнүүдийн хоёр төрөлд хуваасан байна. Үүнд:

- тохиолдлын;
- байнгын. Мөн сүүлчийнхийг нь тэр засал авах боломжтой ба засаршгүй төрөлхийн гэж ялгажээ. Ф.Лист өвчин ба хордлогын шалтгаантай мэргэжлийн, доожоогүй гэмт хэрэгтнүүд гэж ангилжээ.

Атавист шинж тэмдгүүд гэмт хэрэгтнүүдийн олонход илрэхгүй байгаа, тохиолдлын шинжтэй хүмүүст улам бага анзаарагдах болсныг тооцож үзээд Ч.Ломброзо 1884 онд хөгжлийн зогсонги байдал нь атавизмын хамт оршин байгаа ихэнх шинж тэмдгүүдийг нь урьд бидний тэмдэглэж байсан өвчин байгааг зааж өгч байна.

Тэрээр гэмт хэрэгтэн бие хүнийг тайлбарлахдаа атавизмыг эмгэг байдалтай (эпилепси ба ёс суртахууны саатал) хамтатган авч үзэж байв. Гэмт хэрэгтэн нь ёс суртахууны мэдрэмжгүй, чадамжгүй учир сайн сайхныг муу муухайгаас ялгаж чадахгүй, өөрийнхөө гаж сонирхлыг эсэргүүцэх чадваргүй байдаг байна.

Гэмт хэрэгтэн бол өөрийн хүрээлэн буй орчныхоо нөлөөнд автдаг амьтан гэж үзсэн эрдэмтэн бол Италийн криминологич Р.Гарофало юм. Тэрээр Ч.Ломброзогийн шавь хэдий ч түүний онол сургуулийг нэг бүрчлэн дагаж мөрдөөгүй юм.

Р.Гарофало гэмт хэрэгтнийг дөрвөн бүлэгт хуваан авч үзсэн байна. Үүнд:

- Ёс суртахууны мэдрэмжгүй ба харгис инстинкт бүхий алуурчид;
- Хүчирхийлэгч ба буюу өөрийн мэдэлгүй, өөрөөр хэлбэл бусдын шаналлыг ойлгох чадваргүй, өшөө авах, үүрэг хариуцлага, нэр хүндийн тухай буруу балай үзэлтэй гэмт хэрэгтнүүд;
- Үнэнч шударга байдлаа алдсан гэмт хэрэгтнүүд;

<sup>161</sup> Мертон Р.К. Социальная структура и аномия. М., 1966. С. 299.

<sup>162</sup> Ломброзо Ч. Благоедеяния преступления. 1895.

- Бослого, суулт, засгийн төлөөлөгчдөд захирагдахаас татгалзсан гэмт хэрэгтнүүд.

Тухайн үеийн криминологийн урсгалыг судлах явцдаа бидний сонгож авсан гэмт хэрэгтэн бие хүнийг судлахуйн дараагийн чиглэл нь түүний нийгэмд хэрхэн хэвийн бус нөлөөлдгийг тайлбарлахад чиглэгдэж байв.

Туратигийн нийгэм судлалын төлөөлөгчид болох Батаглия ба Лория Так нар гэмт хэрэгтнийг эдийн засгийн сөрөг нөлөөллийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн мөн гэж үзжээ<sup>163</sup>. А.Вакаро гэмт хэрэгтний гарал үүсэлд түүний улс төр-нийгмийн учир дутагдалтай талууд оршино гэж үздэг байв. Гэмт хэрэгтний мөн чанарыг нийгмийн нийлмэл нөлөөллийн цогц юм гэж дараах социологич эрдэмтдийн төлөөлөл үзжээ.

А.Лакассань гэмт хэрэг оршин тогтнох үндсийг нийгмийн өвчтэй организм, харин гэмт хэрэгтнийг хорт нянтай зүйрлэжээ<sup>164</sup>. Ингэхдээ эрүүл биед нянгийн халдвар орсон тохиолдолд тэр түүнтэй тэмцэж өвчнийг цааш нь даамжруулахгүй зогсоох чадвартай, харин өвчтэй бие махбод нь нянгийн үржин олшроход нь таатай нөхцөл бүрдүүлж өгөх юм. Г.Тардын ажлуудад эсрэг тэсрэг антропологи ба социологийн үзлийн өрсөлдөөний дундаас гэмт хэрэгтэн бол нийгмийн хог шаар гэсэн дүгнэлтэд хүрдэг юм.

Г.Тард гэмт хэрэгтэнд эхний ээлжид нийгэмд оршин буй дуурайх ба дасан зохицох хуулиар тайлбарлагдах мэргэжлийн хэв шинжийг олж харжээ.

Хүн гэмт хэрэгтэн болж төрдөггүй, харин эхлээд муу зүйлийг даган дуурайж, дараа нь гэмт хэрэг үйлдсэний дараа түүний хувьд бий болсон нөхцөл байдалд дасан зохицсоор байгаад тийм болдог байна.

Э.Ферри дур хүслийн бүрэн эрхт байдлын тухай классик сургуулийн онолыг шүүрдэн хаяж, гэмт хэрэгтэн бие хүн гурван үндсэн хүчин зүйлийн нөлөөгөөр бий болдог гэж тэмдэглэжээ. Үүнд:

- Бие бялдрын хүчин зүйл (цаг агаар, газар зүйн онцлог энд холбоотой) гэмт хэрэгтнүүдэд ижил нөлөөлдөг;

- Антропологи хүчин зүйл нь гэмт хэрэгтнүүдэд төрөлхийн шуналтай холбоотойгоор тодорхойлогддог;

- Нийгмийн хүчин зүйл нь гэмт хэрэгтнүүдэд өөрийнх нь дадал зуршил болсон зүйлстэй холбоотойгоор бий болно. Э.Ферри гэмт хэрэгтэн бол тусгай биологийн хэвийн бус үзэгдлийн бүтээгдэхүүн юм гэж дүгнэжээ<sup>165</sup>. Тэр үүнийг яаж оновчтой нэрлэхээ мэдээгүй байсан учир загварыг дагаж “гэмт хэргийн мэдрэлийн өвчин” гэж нэрлэжээ. Ингээд Э.Ферри гэмт хэрэгтэн бол нэг доор биологи, физик ба нийгмийн нэгдмэл гаралтай зүйл гэж дүгнэжээ.

Э.Ферри бараг л хамгийн анхны удаа гэмт хэрэгтнийг шинжлэх ухааны дагуу дүгнэсэн шахуу гавьяатай хүн. Тэрээр гэмт хэрэгтэн гэсэн ойлголтод хувь хүний абсолют хэвийн байдал ба доройтлын хамгийн доод хэмжээг хамрах маш олон янзын хэв шинжийг нэгтгэн ойлгож байсныг тэмдэглэжээ.

Э.Ферри гэмт хэрэгтний дараах бүлгүүдийг ялган авч үзжээ. Үүнд:

- удамшлын хандлагатай төрөлхийн гэмт хэрэгтэн;
- сэтгэцийн өвчний клиникийн хэлбэрийн аль нэгэнд өртсөн гэмт хэрэгтэн;
- нийгмийн урьдчилан сэргийлэх орчин үгүй, олдмол зан үйлээр гэмт хэрэгтэн болсон шоронгийн бүтээгдэхүүн;
- тохиолдлын гэмт хэрэгтэн;

<sup>163</sup> Turati...Il delitto e questione sociale. Milano, 1883; Battaglia, La dinamica del delitto. Napoli, 1889; Loria. Les bases économiques de la constitution sociale. Paris, 1893. 39.

<sup>164</sup> Тард Г. Преступник и преступление. М., 1906. С. 324.

<sup>165</sup> Ферри Э. Преступление как социальное явление. М., 1924. С. 12.

- сэтгэл санаа хүчтэй давшилсны нөлөөгөөр гэмт хэрэгтэн болсон хүмүүс.

Э.Ферригийн гол ололт нь тэр анхдагчдын нэг болж хагас солиотой гэмт хэрэгтний хэрэг хариуцах чадварыг хязгаарлах тухай асуудлыг гаргаж тавьжээ.

XIX зууны сүүлч XX зууны эхэн үед гэмт хэрэгтэн бие хүний тухай ойлголтод шинэ чиглэл болох социалист хандлага үүсэн бий болжээ. Энэ чиглэлийг баримталсан эрдэмтэд социалист ухуулга нь гэмт хэргийн өсөлтийг багасгадаг болохыг баталжээ. Гэвч тэднийг эсэргүүцэгч Ч.Ломброзо ба Р.Гарофало нар гэмт хэргийн өсөлтийг интернационализм, анархизм ба социалист ухуулах сурталчилгаанаас шалтгаалж байна гэж үзжээ.

XX зуунд олон ч эрдэмтэд гэмт хэрэгтний оюуны хомсдолын тухай санааг дэмжсэн байна. Үүнд: Х.Годард ба Ч.Давенпорт нар гэмт хэрэгтнүүдийн гэр бүлүүдийг судалж үзээд оюуны хомсдол ба гэмт хэргийн хооронд зүй ёсны шалтгаант холбоо байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Х.Годард өөрийнхөө судалсан гэмт хэрэгтнүүдийн 70% нь оюуны хомсдолтой байсан гэж үзжээ.

Х.Годард үүнд үндэслэн оюуны хомсдолтой хүн бүхэн гэмт хэрэгтэн мөн гэсэн дүгнэлтэд хүрчээ<sup>166</sup>. Үүнийг үндэслэн Америк европын зарим улсуудад гэмт хэрэгтнийг засах, хөнгөлөх, практик бий болжээ.

Гэмт хэрэгтний оюуны хомсдолын тухай санааны эсрэг оюуны хомсдол ба хүний ур чадварын хоорондын холбоог оновчгүй буруу тогтоосон гэж үзэн эсэргүүцэж байв. Тэд хүний генийн бүтцийн эмгэг бус харин нийгмийн хүнд нөхцөл байдал хүмүүст оюунаа хөгжүүлэх боломж олгохгүй байна гэж үзжээ.

Хүчтэй хөгжил нь дотоод шүүрлийн булчирхайнууд гипофиз<sup>167</sup> бөөрний дээд, бамбай ойролцоох булчирхайнууд, бэлгийн булчирхайн дотоод шүүрлийн элементүүд, нойр булчирхайн арланцрууд, сэрээн булчирхай ба эпифиз зэрэг нь хүний гадаад дүр төрх, мэдрэмжид нөлөөлдгийг тогтоожээ. Ийм хүний үйлдэл эдгээр булчирхайн ялгаруулсан гормонуудын үйлчилгээтэй нягт холбоотой болохыг баталжээ.

Эдгээр зүй тогтлууд гэмт хэрэгтэн бие хүнийг судлагч криминологич эрдэмтдийн анхаарлыг мөн татжээ. 1920-иод онд америкийн эрдэмтэн криминологич Макс Шлап хорих байгууллагад ял эдэлж байгаа гэмт хэрэгтнүүдийн дотоод шүүрлийн булчирхайн системийн үйл ажиллагааг нь судалж үзжээ<sup>168</sup>. Түүний судалгаагаар нийт хоригдлын ойролцоогоор 1/3 нь дотоод шүүрлийн булчирхайн өвчинтэй холбоотой сэтгэл зүйн тогтворгүй байдалд орсныг харуулсан байна.

М.Шлапынхаар бол дотоод шүүрлийн үйл ажиллагааны доголдол нь гэмт үйлдлийн шалтгаан болдог ажээ. Эдгээр эмгэгийн гадна шинж тэмдгүүд нь гэмт хэрэгтний бие бялдарт илэрдэг юм. Ийм маягаар гэмт хэрэгт бие бялдын шинж тэмдэг нөлөөлөх тухай Ч.Ломброзогийн биологийн үзэл санаатай адил онол үүсэн бий болж эхлэв.

Мөн Колумбийн их сургуулийн профессор Уильям Шелдон “Залуучуудын гэмт хэргийн төрөл: сэтгэц судлалын эхлэл” номдоо бие махбодийн гэмт үйлдэлтэй шууд холбоотой гэсэн дүгнэлт хийжээ. XX-р зууны дунд үед Уильям Шелдон нь өндөр, туранхай, эсхүл зөөлөн, бөөрөнхий нүүртэй хүмүүс гэхээсээ илүү булчинлаг, спортлог хүмүүст гэмт хэргийн шинжтэй зан үйл хийх нь илүү түгээмэл гэсэн хувь хүний онол<sup>169</sup> дэвшүүлж байв. Тэрээр гаж үзэгдлийн учир

<sup>166</sup> Goddard RH. The Kallikaks Family. NY., 1912; Idem.Feeble-mindedness: Its Causes and Consequences. N.Y., 1914; Davenport C.B. The Nam Family. Lancaster, 1912. 39.

<sup>167</sup> Hypophysis - тархины доод хавсралт, өнчин тархины булчирхай.

<sup>168</sup> Shlapp M.G., Smith EH. The new criminology. N.Y., 1928.

<sup>169</sup> Theory of Personality /Type Theory/

шалтгааныг хүний биеийн анатомын бүтцийн онцлогт байдаг гэж үзээд 3 хэсэгт хуваасан юм. Үүнд:

- Эндоморф: Бөөрөнхийдүү булбарай, ямагт дундыг баримталдаг, зөөлөн намдуу зантай, сэтгэл зүйн хувьд сул дорой талдаа ч ухаалаг, дөлгөөн, тайван гэхдээ биеэ тоосон, дотогшоо, түгшүүртэй зан байдал илэрдэг.

- Мезоморф: Гуалиг тэгшхэн, хүчирхэг биетэй бялдартай, сэтгэл зүйн хувьд хүчирхэг, хатуу ширүүн зантай.

- Экторморф: Туранхай, эмзэг, уян нарийн биетэй бусадтай харьцаж чаддаг, эвийг нь олдог, өөрийнхөөрөө байдаг, нийтэч, аз жаргалтай байж чаддаг, тайван гэхдээ бас залхуу хүмүүс<sup>170</sup>.

Эдгээр бие махбодийн бүтэц нь гэмт хэрэг үйлдсэн хүний зан араншинтай шууд холбоотой гэж Шелдон нотлох гэж хичээсэн. Мезоморфын түрэмгий байдал, дарангуйлах гэж хяналтгүйгээр зан авир гаргах үйлдэл бөгөөд гэмт хэрэгт холбогдох үндсэн шалтгаан гэж үзсэн. Эсийн хромосомын онол хөгжсөнтэй холбоотойгоор гэмт хэрэгтнийг тайлбарлахыг оролдсоор ирсэн шинэ салбар бий болсон. Энэ нь криминологич ба генетикчидэд гэмт хэрэгтний тухай сонирхолтой таамгууд дэвшүүлэхэд хүргэжээ.

Криминологичид ба гэмт хэргийн сэдлийг тайлбарлах үедээ удамшлын шалгуурыг гадаад орчноос ялгаж салгаж ойлгох ба гэмт хэрэг үйлдэхэд удамшлын шинж тэмдгүүд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг гэх үндэслэлийг тогтоохыг оролдсоор иржээ.

### **Дүгнэлт**

1. Манай улсад социализмын үед гэмт хэрэгтэн оршин тогтнох суурь бааз үгүй гэсэн үзэл суртлын үндсэн номлол гэмт хэрэгтэн бие хүний тухай онолын хөгжилд маш сөрөг үүрэг гүйцэтгэж байв.

2. Бид шинэ нийгэмд шилжсэн хэдий ч гэмт хэрэг үйлдэгч нарын тухай, гэмт хэрэгтэн бие хүний онолын тухай дагнасан судалгааг хийж чадаагүй л байна. Гэмт хэрэгтэн бүрэлдэн тогтох эдийн засаг, улс төр, нийгмийн нөхцөл байдал үгүй байтал гэмт хэрэг үргэлжлэн үйлдэгдсээр байвал, анхны хөдөлгүүрийг гэмт хэрэгтний бие хүний онцлог, өөрөөр хэлбэл өөрөөс нь хайх хэрэг гарна шүү дээ.

3. Манай улсад зарим онолын судалгаа нэвтэрч, дэлгэрч амжилгүй тухайн онолын ач холбогдол нь Олон улсад буурах асуудал нэлээдгүй тулгамдаж байна. Тухайлбал бид өнөөдөр гэмт хэрэгтэн бие хүний тухай онолын практик туршилтыг хийх боломжгүй хэмээн өөрсдийгөө үзсээр байна.

4. Чухамдаа Монгол хүний тухай асуудал, нүүдэлчдийн өвөрмөц сэтгэлгээ, бидний бие физиологи, төрх, антропологиин онцлог шинжүүд гээд гэмт хэргийн шалтгаан нөхцөлтэй холбон тайлбарлах, судлах асуудал маш их байна.

5. Цаашид энэ төрлийн суурь судалгааг хийх, шинжлэх ухааны чухал асуудлыг орхигдуулахгүй байх тал дээр залуу эрдэмтэн, судлаачид бид хамтран хийж гүйцэтгэх ажлууд ихээхэн байна хэмээн дүгнэж байна.

### **Ашигласан материал**

1. Goddard RH. The Kallikaks Family. NY., 1912; Idem.Feeble-mindedness: Its Causes and Consequences. N.Y., 1914; Davenport C.B. The Nam Family. Lancaster, 1912.

2. Richard N. Walker. W.H. Sheldon. Nature in Psychiatric Bulletin. Retrieves 2011.

3. Shlapp M.G., Smith EH. The new criminology. N.Y., 1928.

---

<sup>170</sup> Richard N. Walker. W.H. Sheldon. Nature in Psychiatric Bulletin. Retrieves 2011.

4. Theory of Personality /Type Theory/.
5. Turatl..Il delitto e questione sociale. Milano, 1883; Battaglia, La dinamica del delitto. Napoli, 1889; Loria. Les bases economiques de la constitution sociale. Paris, 1893.
6. Антонян Ю.М., Гульдав В.В. Криминальная патопсихология. М., 1996.
7. Болдбаатар Ж., Дамдинцэрэн Д. Эрүүгийн профайлинг. Уб., 2022.
8. Болдбаатар Ж., Нямдаваа О. Криминологи. Уб., 2010.
9. Ломброзо Ч. Благоедеяния преступления. 1895.
10. Мертон Р.К. Социальная структура и аномия. М., 1966.
11. Мөнх-Эрдэнэ Д. Гэмт хэрэг судлалын онол. Уб., 2021.
12. Тард Г. Преступник и преступление. М., 1906.
13. Ферри Э. Преступление как социальное явление. М., 1924.

## ӨСВӨР НАСНЫ ХҮН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛ

WHEN A TEENAGER COMMITS A CRIME OF RAPE  
SOME FACTORS AFFECTING

*М.Болор  
ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** Өгүүлэлд өсвөр насны хүний зүгээс үйлдэж буй хүчиндэх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, шалтгааныг судалсны үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

**Abstract:** The article seeks to identify ways of prevention based on the current situation and reasons for rape committed by a teenager.

**Түлхүүр үгс:** Гэр бүл, боловсрол, хүмүүжил, хүүхэд, хараа хяналт.

**Keywords:** Family, education, upbringing, children, supervision.

Монголчууд эрт цагаас хүүхдийг бага наснаас нь зөв төлөвшилтэй, бие хүн болгох зорилгоор ардын аман зохиол, үлгэр домог, тууль, зүйр цэцэн үг, оньсого, таавар зэрэг ардын аман зохиолуудаас гадна ахуй соёл, аж амьдралаараа үлгэр жишээч байдлаар хүмүүжүүлсээр ирсэн, хүүхэд хүмүүжлийн баялаг өв уламжлал түүхтэй улс билээ.

Хүүхэд бүрийн төрлөх араншин янз бүр байдгаас шалтгаалан, хүүхэд хүмүүжлийн олон арга, сурган хүмүүжүүлэх дадалтай байсан нь түүх, шастирт тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Тухайлбал, омог хурц, ширүүн төлөвтэй хүүхдийг: Омогтой хүнийг дарлаваас хорсох тул нэр цолоор баясга, атаач хүнд нүүр эс өгвөөс гомдох тул сайхан загна, дээрэнгүй хүнийг хөгжөөвөөс хэрэг гарах тул битгий хэрэгс, ууртай хүнд ширүүн хэлбэл аюул болох тул ухуул гэх мэт хүүхэд бүрийн зан араншинд нийцүүлэн нарийн харьцах аргатай байсан бол хүүхдийг өсөж томрохын хэрээр, үлгэр дуурайлалтай, бие хүн болгон төлөвшүүлэх зорилгоор “гашуунаар бүү тэтгэ, амттанаар бүү тэтгэ, өнгөнд бүү шунуул, мөнгөнд бүү шунуул, улай бүү үзүүл, нойронд бүү автуул” гэж сургахаас гадна “гурав настанг хаан мэт дээдэл, таван настанг хатан мэт хайрла, таван наснаас дээш насны хүүхэдтэй харцын ёсоор харьц, арван гурван наснаас дээш хүүхэдтэй найзын ёсоор харьц” хэмээн хүүхдийн нас насны онцлогт тохируулан сурган хүмүүжүүлэх ухаанаар харьцаж байсан түүхэн уламжлалтай.

Монголчууд “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа”, “Буруу эрхэлсэн хүүхэд бухын хүзүүнээс ч хатуу” гэж сурган, хүүхдэд багаас нь энэрэл, хайр, халамж тавьж, амьдралын зөв дадал, хэвшилтэй болгож хүмүүжүүлэхийг ардын аман зохиол, зүйр цэцэн үгээр дамжуулан илэрхийлж, тухайн хүүхдийн ирээдүйг зөв залан жолоодох нарийн ухаанаар хандаж байсан нь хүүхэд хүмүүжлийн онцлог бөгөөд арвин туршлагатай байсныг илтгэнэ.

Хүүхдийг зөв бие хүн болгон хүмүүжүүлж, амьдралын зөв дадал, зуршилтай болгох нь бүх хүүхэдтэй эцэг, эхчүүдийн хуулийн өмнө хүлээсэн үүрэг билээ. 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүүхдийн эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд хүүхдийн хүмүүжил төлөвшлийн тухай, 10 дугаар зүйлд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хариуцлагын тухай тодорхой тусгасан байдаг.

Хувьсан өөрчлөгдөж буй нийгэм, мөнгөний хамаарлаас шалтгаалан цаг үеэ даган хүүхэд хүмүүжүүлэх сургаалт үг, сурган хүмүүжүүлэх арга барил орхигдож, мэдээллийн хэт задгай хэрэглээ, эцэг, эхийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан,

зөвхөн эд зүйл, хэрэглээг ханган хүүхдээ үл хайрхалт дунд орхиж байгаан улмаас хараа хяналтаас гарсан өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэг үйлдэх явдал ихсэж, алгуурхнаар нийгмийн хөндүүр сэдэв болсоор байна.

*Өсвөр насны хүний үйлдэж буй гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн талаар*

Өсвөр насны хүний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг жил ирэх тусам хэрцгий, хүнлэг бус шинжтэй болж, энэ хэрээр хүчиндэх гэмт хэрэг үйлдэж буй өсвөр насны хүний хэргийн гаралт жил ирэх тусам өсөн, нэмэгдэж байна.

Эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс үл хайхрах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг шалтгаан, нөхцөлөөс болж хараа хяналтаас хол оршиж, сургууль завсардаж, өөрийн үнэлэмж буурч, амьдралын бодитой зорилго, төлөвлөгөөгүй, ихэнх цагаа гудамжид өнгөрөөх, мөн мэдээллийн хэт задгай хэрэглээ нь өсвөр насны хүнийг бэлгийн эрт харилцаанд татаж байгааг үгүйсгэхгүй бөгөөд хүүхдийн зүгээс үйлдсэн хүчингийн гэмт хэрэг үйлдсэн орчин, цаг хугацаа, шалтгаан, нөхцөл нь дийлэнхдээ ар гэрийн хараа хяналт сул, гэр бүлийн хүчирхийлэл дунд өссөн, хэт задгай хүмүүжилтэй зэргээс шалтгаалж байна.

Дурдсан хүчин зүйлсээс шалтгаалан, хүүхэд хэсэг, бүлгээрээ нийгмийн сөрөг зан үйлд суралцан, нэг нэгэндээ харилцан гэмт зан үйлээ халдаах явдал амьдралд түгээмэл тохиолддог.

2021 онд насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн 599 буюу 81.7 хувийг хөнгөн, 134 буюу 18.3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 68.9 хувь нь Улаанбаатар хотын нутагд дэвсгэрт үйлдэгдсэнээр, 31.1 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Үүнээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн нийт 7 байна. Тэгвэл 2022 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн 744 буюу 85.8 хувь нь хөнгөн, 123 буюу 14.2 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 73.9 хувь нь Улаанбаатар хотод, 26.1 хувь нь хөдөө, орон нутагт үйлдэгдсэнээр бүртгэгдсэн бол хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 8 тохиолдол бүртгэгджээ.

Хорих ялаар шийтгүүлж, хорих ангид хоригдож буй хүүхдүүдийн 80 хувь нь огт сургуульд суралцаагүйгээс гадна бичиг үсгийн анхан шатны мэдлэгийг дөнгөж эзэмшсэн байсан бол 90 хувь нь гэмт хэрэг үйлдэхээс өмнө ямар нэгэн байдлаар сургалт, сургуульд суралцаж байгаагүй ажээ. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн боловсролын байдлыг авч үзэхэд, 37 буюу 12.3 хувь нь сургуульд суралцаагүй, 89 буюу 29.6 хувь нь бага боловсролтой, 118 буюу 39.3 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байлаа. Эндээс гэмт хэрэг үйлдсэн ихэнх насанд хүрээгүй хүмүүс ямар ч боловсролгүй байсан болох нь харагдаж байгаа бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл гэмт хэрэг үйлдэхээс татгалзахад хүний боловсрол, нийгэмшлийн байдал чухал үүрэгтэй гэж үзэх үндэслэлтэй байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 оны эхний 1 сард 3900 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 хэргээр буюу 2.4 хувиар буурч, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 34 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1 хэргээр буюу 3.0 хувиар өсч, нийт хэргийн 0.9 хувийг эзэлж байна. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн 28 буюу 82.4 хувийг хөнгөн, 6 буюу 17.6 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 44.1 хувь нь нийслэлд, 55.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн дүн мэдээтэй байна.

Гэмт хэргийн өнгөөр нь авч үзвэл, 9 буюу 26.5 хувь нь хулгайлах, 17 буюу 50.0 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4 буюу 11.8 хувь нь залилах, 2 буюу 5.9 хувь нь дээрэмдэх, 1 буюу 2.9 хувь нь хүчиндэх, 1 буюу 2.9 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна<sup>171</sup>.

<sup>171</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тайлан.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний талаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газраас 2017-2022 оны байдлаар судалгаа (Уг судалгаанд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хандсан хүчиндэх гэмт хэргийн хохирогчид хамрагдсан) хийсэн байх бөгөөд дараах үр дүн гарчээ.

Хүснэгт 1. Хүчиндэх гэмт хэрэгт хохирсон насанд хүрээгүй хүний судалгаа<sup>172</sup>

| Газар орон      | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|-----------------|------|------|------|------|------|------|
| Улаанбаатар хот | 86   | 137  | 81   | 101  | 140  | 141  |
| Орон нутаг      | 109  | 173  | 116  | 112  | 205  | 228  |
| Нийт            | 195  | 310  | 197  | 213  | 345  | 369  |

Хүчиндэх гэмт хэрэгт хохирсон насанд хүрээгүй хүний тоо 2017 онтой харьцуулахад, 2018 онд огцом нэмэгдсэн бол 2019 онд энэ тоо 113-аар буурсан бол 2020 оноос өссөн үзүүлэлт ажиглагдаж байгаа бөгөөд 2021, 2022 онд энэ тоо огцом өссөн байна.

Дээрх судалгаа нь хүчиндэх гэмт хэрэгт өртөж, хохирсон насанд хүрээгүй хүний тоон судалгаагаар хязгаарлагджээ. Харин хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн талаар судалгаа тэр бүр хийгдээгүй явдал нь энэ чиглэлээр судалгааны ажлыг гүнзгий хийж, учир шалтгааныг тогтоох шаардлага үүсгэж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна. Магадгүй энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн хүрээнд үйлдэгдэн, гэр бүлийн гишүүд уг нийгэмд аюултай үйлдлийг дарах, нуух байдлаар өнгөрүүлдэгтэй холбоотой байж болох юм.

Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага болох 411 дүгээр хорих ангид хорих ял эдэлж буй хоригдол хүүхдүүдтэй ярилцлагын аргаар асуулга явуулахад, 15 настай Б гэгч нь бага (5 настай) настай байхдаа хамаатны ахдаа хүчирхийлүүлж байсан бөгөөд энэ үйл явдал нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд мартагдашгүй ул мөр үлдээснээс гадна уг үйлдэл нь удаан хугацаанд үргэлжилж, улмаар бага насанд үзэж, туулсан бүхнээ өөрийгөө хамгаалах чадваргүй хүнд үзүүлэх, үүнээсээ таашаал авах хүслийг түрүүлэх болсон талаар дурдсан байна. 15 настай Б нь зуны амралтаар хөдөө байрлах төрөл, садны хамаарал бүхий айлд амрахаар очсон бөгөөд, шөнийн цагаар насанд хүрсэн хүмүүсийн дотно харилцааг харсанаар, тухайн айлын бага насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн тохиолдол гарчээ. Мөн 15 настай С гэгч нь хойт эцгийн дарамтад бага насаа өнгөрүүлсэн, хойт эцэгтээ зодуулсан, үүнээс үүдэн өс хонзон авах зорилгоор төрсөн дүүдээ бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн байдаг бол 13 настай Т нь асрах газарт хүмүүжиж байхдаа хамт хүмүүжиж байсан хөвгүүдтэй бэлгийн харилцаанд орсон байх бөгөөд, энэ явдлын шалтгааныг тогтоохоор шалгалтын ажиллагаа явуулахад, цэвэр өөрсдийн сонирхлоор орсон болох нь тогтоогдсон байдаг. Мөн бас нэг жишээ байгаа нь 14 настай Б гэгч нь насанд хүрсэн эрэгтэй найзуудын ятгалгаар, тэдний санал болгосноор үеийн охинтой харилцан тохиролцож бэлгийн харьцаанд орсон тохиолдол ч байжээ<sup>173</sup>.

Тэгэхээр насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, эсрэгээрээ насанд хүрээгүй хүн бага насны хүнийг хүчиндэх гэмт хэрэг гэр бүл, эсхүл тодорхой хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн дунд түгээмэл үйлдэгдэж, аливаа шалтгаанаар нуугдмал байдалд шилждэг болох нь ажиглагдаж байна. Мөн сургуулийн хүрээний хүүхдүүдийн хооронд үүссэн харилцаанаас үүдэлтэй, нэг нэгэндээ буруу үлгэр

<sup>172</sup> Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газрын 2017-2022 оны судалгааны тайлан.

<sup>173</sup> Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 411 дүгээр хорих ангид хорих ял эдлэж байгаа хүүхдүүдээс авсан судалгааны үр дүнгээ.

дуурайлал үзүүлэх, аливаа гаж болон сургуулийн насны хүүхдүүдэд үл зөвшөөрөгдөх харилцаанд орохыг бие биедээ ятгах, сэнхрүүлэх замаар нөлөөлж буй байдал нь хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Өсвөр насны хүний сэтгэл зүйн байдалд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн талаар

Аливаа хүн хүүхэд, балчир ахуй насандаа авсан сэтгэл, санааны цочролоос болж, эсхүл сонирхол татсан зүйлсийг туршин үзэх хүсэл, сонирхолдоо хөтлөгдөн бэлгийн харилцааны шинжтэй үйлдлийг хийж үзэх хүсэлд автах, улмаар олон тооны давтамжтай хийснээр тухайн үйлдэл болон үр дүн, таашалд донтох байдал түгээмэл байдаг. Өсвөр насанд буюу аливаа зүйлийг олон талаас танин мэдэх насанд үзсэн, мэдэрсэн зүйл сэтгэлд тод үлддэг бөгөөд сэтгэл зүйн хувьд айдас эсвэл, дахин мэдрэх хүслийг төрүүлдэг тухай сэтгэл зүйн онолуудад дурдсан байдаг. Жишээлбэл, хүүхэд оюун санаа, сэтгэл зүй, бие махбодийн хувьд тодорхой өсөлтийн үе шатуудтай байх бөгөөд тухайн насандаа тохирсон сэтгэл зүйн онцлогтой. Хүүхдийн тархи 20 нас хүртэл хөгждөг бөгөөд тухайн хөгжлийн үе шатыг дагаад сэтгэл зүй нь мөн хөгжиж байдаг.

Хүүхдийг бүрдүүлж, нөлөөлж, бие хүн болоход гэр бүл, эцэг, эхийн хүмүүжил, орчин маш чухал нөлөөтэйг дурддаг бөгөөд хүүхдийн сэтгэцийн хөгжлийн үе шатыг доорх байдлаар ангилдаг. Үүнд:

I үе шат: Хөдөлгөөний (1 нас);

II үе шат: Мэдрэхүйн хөдөлгөөний (1-3 нас)

III үе шат: Сэтгэл хөдлөлийн (3-12 нас)

IV үе шат: Сэтгэхүйн (10-12 нас).

Сэтгэцийн эмгэг, өөрчлөлтүүдийн ихэнх нь хүүхэд насанд үүсдэг. Тиймээс эцэг, эхчүүд хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхдээ дараах чадвар, мэдрэмжүүдийг нь хөгжүүлж, суулгаж өгөх нь чухал юм гэж судлаачид үздэг ажээ.

Сургуулийн насны (6-12 нас) үе: Хүүхэд өмнөө тавьсан санаачлагч, эсвэл захирагдсан зан төлөвтэй болох эсэх нь үргэлжлэн хөгжиж байдаг. Идэвх, санаачлагатай байх нь хөдөлмөрч зан чанараар илэрч, ажил хийх дур сонирхол, хүсэл эрмэлзэлтэй, тууштай, цөхрөлтгүй оролдлого хийдэг, эерэг чанарууд үүсэж төлөвшихөд нөлөөлдөг;

Өсвөр буюу идэр насны (12-20 нас) үе: Амьдралын мөчлөгийн бүх үе шатууд дотроос хамгийн чухал үе нь юм. Энэ үед ижилсүүлэлт, тодорхойгүй байдал хоёрын аль нэг нь л бүрэлдэн тогтдог. Өсвөр насны хүүхэд “Би хэн бэ?, хэнийг дуурайх вэ?” гэдэгт хариулт хайдаг. Хэн нэгэн таалагддаг, хүндэлдэг хүнээ үлгэрлэн дуурайж, түүн шиг биеэ авч явах, түүн шиг хувцаслах, бүр түүн шиг ярих гэх мэтээр өөртөө бие хүний тодорхой байдлыг төлөвшүүлдэг.

Харин ижилсүүлэлтийг шийдвэрлэж чадаагүй, үлгэр, дуурайлал авах хүнгүй бол бие хүний тодорхойгүй байдал төлөвшдөг аж. Тодорхойгүй байдалд орсон хүүхэд нийгэм, сэтгэл зүйн дараагийн хөгжлийн үе шатуудад шилжихэд саад тотгортой учрах, сэтгэцийн гажуудал үүсэх, сэтгэл зүйн хөгжлийн өмнөх шат руу ухрах зэрэг сөрөг талтай;

Тэгэхээр хүүхдийн хүмүүжил, зан чанар, сэтгэл зүйн хувьд эрүүл байх, эсвэл асуудалтай байх гол эх үүсвэр нь эцэг, эхээс гадна тухайн суралцаж, амьдарч байгаа орчин, нөхцөл, хамт суралцаж байгаа бусад хүүхдүүд болон гэр бүлийн бусад гишүүд болох ах, эгч, дүү нар, тэдний хоорондын харилцаа ажээ. Халуун, дулаан харилцаатай гэр бүлийн хүүхдүүд хүнлэг сэтгэлтэй, тогтвортой хүн болон хүмүүждэг бол хүйтэн уур амьсгалтай, хоорондоо маргаан, зөрчил, үл ойлголцолтой, зарим үед хүчирхийлэлтэй байдаг гэр бүлийн хүүхдүүд нийгэмшлийн хувьд бусадтай харилцах чадвар султай, бусдаас дөлсөн

байдалтай, зарим тохиолдолд бусдыг үзэн ядах шинжтэй хүн болон хүмүүжих эрсдэл өндөртэй байдаг.

Тиймээс гэр бүлийн орчинд хүүхдүүддээ "...би чамтай хамт...", "...би чиний талд шүү..." гэдгийг мэдрүүлэх нь маш чухал бөгөөд хүүхдээ сонсож, ойлгох хэрэгтэй. Хүүхдийнхээ хэрэгцээг зөв тодорхойлж, зөвхөн эдлэл, хэрэглэл, хоол, хүнсээр хангах бус сэтгэл зүйн хувьд хэн болон төлөвшихөд нь анхаарах хэрэгтэй юм.

### **Дүгнэлт**

1. Өсвөр насны хүний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг жил ирэх тусам өсөх байдал ажиглагдаж байна. Өсвөр насны хүнээс үйлдэж байгаа хүчиндэх гэмт хэргийн гаралт гэмт хэргийн хөдөлгөөнийг дагаж жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

2. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн байдлыг судлан үзэхэд, эцэг, эхийн болон гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн амьдралын хэв маяг, өдөр тутмын үйл явдал, зан үйлээс шалтгаант байдлаас үүссэн байх магадлал тун өндөр байна.

3. Өсвөр буюу идэр насны (12-20 насанд) үе нь өсвөр насны хүний төлөвшлийн хамгийн чухал үе болохыг тодорхойлоод зүгээр орхих нь буруу зүйл бөгөөд энэ насны хүмүүст тавих эцэг, эхийн хараа, хяналтыг өндөржүүлж, гэр бүлийн хүрээнээс гадна сургуулийн орчинд ямар хүмүүстэй нөхөрлөж, ямар үзэл хандлага, төлөвшил тогтож байгааг мэдэх нь ирээдүйд өсвөр насны хүүхэд гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой.

### **Ашигласан материал**

1. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газрын 2017-2022 оны судалгааны тайлан.

2. Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 411 дүгээр хорих ангид хорих ял эдлэж байгаа хүүхдүүдээс авсан судалгааны үр дүн.

3. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тайлан.

# МОНГОЛ УЛС ДАХЬ АМИА ХОРЛОХ ҮЙЛДЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХОР УРШИГ

## SITUATION OF SUICIDE IN MONGOLIA

Б.Алтангэрэл  
ДХИС-ийн магистрант

**Товч агуулга:** Амиа хорлох үйлдлийн талаар дэлхийн зарим улс орнуудын болон Монгол Улс дахь нөхцөл байдал, амиа хорлох үйлдлийн төрөл, үйлдлийн арга, тоон үзүүлэлт, амиа хорлох үйлдэл хийсэн хүний сэтгэл зүй, зан үйлийн хэв шинж, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалж, цаашид амиа хорлох үйлдлээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

**Abstract:** The aim is to study the circumstances of suicide in some countries and Mongolia, the types of suicide, methods of action, quantification, psychological and behavioral patterns of the person who committed suicide, and the factors that contribute to it, and to identify ways to prevent suicide in the future.

**Түлхүүр үгс:** Амиа хорлолт, сэтгэл гутрал, сэтгэцийн эмгэг, амиа хорлохыг завдах, амиа хорлох арга, төрөл.

**Keywords:** Suicide, depression, mental illness, suicide attempts, methods and types of suicide.

Монгол Улс төдийгүй дэлхийн улсуудад амиа хорлох үйлдэл сэтгэл эмзэглүүлсэн асуудал болоод зогсохгүй, түүний гаралт өндөр байгаагаас шалтгаалж, энэ төрлийн үзэгдэл нь сэтгэл эмзэглүүлсэн зүйл байхаас хэтрэхгүй, бүр хэвийн үзэгдэл мэтээр орших болжээ. Тиймээс уг үзэгдлийг цогцоор нь судалж, урьдчилан сэргийлэх, хүний амь нас эрсдэхээс хамгаалах үйлдэл амин чухал асуудал болоод байна.

Амиа хорлох болон хорлох үйлдэл хийх нь манай улсын хувьд төдийгүй дэлхийн олон оронд нийгэм, эдийн засгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ үйлдэл нь анагаах ухаан, философи, нийгэм судлал, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болохоос гадна хүн амын дунд нэмэгдэх хандлагатай байгааг олон судалгаанаас харж болно.

ДЭМБ-ын тайланд дурдсанаар, 2001 онд дэлхийн хэмжээнд сэтгэцийн эмгэгтэй хүний тоо 450 сая орчим байсан бол 2017 онд 792 сая хүн буюу нийт хүн амын 10.7 хувь (10 хүн тутмын 1) нь сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй гэжээ. Үүнээс 284 сая нь сэтгэл түгших, 264 сая нь сэтгэл гутрах эмгэгээр шаналж байгаа талаар тайланд тусгасан. Тэгвэл архи, мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгтэй хүний тоо 970 сая буюу нийт хүн амын 13 хувийг эзэлж байна. Эндээс үзэхэд, дэлхий нийтэд сэтгэцийн эмгэгтэй болон архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгтэй хүний тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

АНУ болон Өрнөдийн орнуудад ёс зүйн нээлттэй асуудлууд хэмээх ойлголт яригдах болсон бөгөөд энэ нь мэргэжлийн хүмүүсийн дотор маргаантай асуудлыг үүсгэдэг байна. Тухайлбал, амиа хорлох үйлдлийг хуулиар зөвшөөрч болох эсэх талаарх хэлэлцүүлэг зохион байгуулах болсон. Амиа хорлох талаар эртний гүн ухаантан О.Шпенглер “Амиа хорлолт нь соёл иргэншлийн төгсгөлийн шатны мөхлийг билэгддэг, том хотын соёлын үр дагавар бөгөөд энэ утгаараа нэлээд орчин үеийн үзэгдэл мөн”<sup>174</sup> хэмээн тодорхойлсон. Орчин үед амиа хорлох, амиа

<sup>174</sup> O.Spengler der Sohnenuntergang in der Abendland.

хорлохоор завдах үйлдлийн шалтгаан, сэдэл, нөлөөлөх хүчин зүйлийг судлан, тогтоох асуудал нь бие даасан шинжлэх ухааны салбар болтлоо хөгжиж байна.

Хүн амын дундах амиа хорлох үйлдлийг суицид (suicide, fatal suicide), амиа хорлохоор завдах тохиолдлыг парасуицид (parasuicide, non fatal suicide) хэмээн шинжлэх ухааны нэршлээр нэрлэдэг. Амиа хорлох үйлдэл, төрх үйл хэмээх ойлголтод амиа хорлох бодол үүсэх, төлөвлөгөө зохиох, оролдлого хийх, амиа хорлох гэсэн ойлголт хамаардаг ба өөр хоорондоо харилцан хамааралтай үйл явц юм.

Амиа хорлох бодол гэдэг нь сэтгэц, нийгэм, сэтгэл зүй, биологийн шалтгаанаар амьд явах хэрэггүй, үхэх юмсан гэсэн бодол төрөхийг хэлэх бөгөөд энэ үед хорлох ямар нэг арга сонгоогүй зөвхөн бодол санааны түвшинд байдаг. Амиа хорлох бодол гүнзгийрсэн үед тухайн хүн амиа хорлож болох аргыг өөртөө төлөвлөдөг. Харин тодорхой аргыг сонгосон бол тухайн үйлдлийг хийх боломжтой орчин нөхцөлийг хайж, тохироо бүрдсэн үед уг үйлдлээ хэрэгжүүлдэг онцлогтой. Амиа хорлох үйлдэл бүр нь үхэлд хүргэхгүй байж болох бөгөөд үүнийг завдсан хэмээн тооцдог хэдий ч, зарим тохиолдолд бусдад үзүүлэх хэлбэрийн үйлдэл байдаг.

Э.Дюркгейм амиа хорлох тохиолдлыг анх 1887 онд судалж, нийгмийн харилцаа, түүнд оролцох байдлаар нь 3 ангилсан байдаг. Үүнд:

1. Аминч буюу эгоист амиа хорлолт - нийгмээр баримталдаг хэм хэмжээ гажуудан, амьдралд нийцэхгүй хууль, дүрэм, журам олноор батлагдах, нийгмийн халамж дутагдсаны улмаас хувь хүн нийгэм, хамт олноос тасран, амьдрал нь утга учиргүй болсон мэт санагдан, өөрийгөө амьдралд гарах гарцгүй болсон хэмээн амиа хорлохыг хэлнэ;

2. Хамтач буюу альтруист амиа хорлолт - хувь хүн өөрөө шийдвэр гаргах, сонголт хийх боломж, эрх чөлөө, бие даасан байдлаа алдан, хувийн эрх, ашиг сонирхол нь хамтын эрх ашигт захирагдах болсноос хувь хүн тэсвэрлэшгүй байдалд орж, амиа хорлохыг хэлнэ;

3. Аноми амиа хорлолт - нийгмийн бүтцийн гэнэтийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлт, уналтын улмаас хүмүүс хуучин үнэт зүйлсийн баримжаагаа алдан, шинэ үнэт зүйл нь бүрдэж амжаагүй завсрын үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч, хүмүүс нийгэмд тогтсон хэм хэмжээг мөрдөхийг хүсэхгүй амиа хорлохыг хэлнэ. Ийм үйлдэл хийж буй хүмүүсийг сэтгэцийн эрүүл мэндийн байдлаар нь харьцангуй эрүүл, сэтгэцийн эмгэгтэй хэмээн 2 ангилж үздэг боловч харьцангуй эрүүл хэмээн үнэлэгддэг хүмүүс нь нийгэм, сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хүмүүс байдаг.

Амиа хорлох үйлдэл хийхэд биологи, нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг. Тухайлбал, амиа хорлосон хүмүүсийн удамд урд нь ийм үйлдэл хийж байсан хүн байх, эдгэшгүй өвчнөөр өвчлөх, цаг агаарын байдал, ажилгүйдэл, хүн хоорондын харилцаа, сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөх, стресс, бухимдлаа зөв тайлах, даван туулах чадваргүй байх зэрэг хүчин зүйлс хамаарна. Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийн амиа хорлоход хүргэж буй нөхцөл байдлыг шалтгаан гэдэг бол сэтгэцийн эмгэгийн улмаас уг үйлдлийг хийж буй шалтгааныг сэдэл гэж нэрлэдэг. Эмнэл зүйн тохироо бүрдсэн үед сэтгэцийн ямар ч эмгэгтэй хүн амиа хорлож болох боловч сэтгэцийн эмгэгүүд дотроос сэтгэл гутрал, шизофрени, архи болон мансууруулах бодисын хамааралд өртсөн, хүчтэй стрессийн улмаас сэтгэл зүйн гэмтлийн дараах хариу урвал, дасан зохицохуйн хямралд өртсөн хүмүүс илүү амиа хорлох үйлдлийг хийдэг бөгөөд үйлдлийн сэдэл нь өвчний байдлаас хамааран харилцан адилгүй байдаг.

Амиа хорлоход насны байдал нөлөөлдөг бөгөөд хувь хүний насны үечлэл бүрд харилцан адилгүй сэтгэл зүйн тааламжгүй нөлөө үүсч байдаг. Тухайлбал,

хүүхэд амиа хорлох үйлдэл хийхэд гэр бүлийн хүмүүжлийн өв тэгш бус байдал, бага насны сэтгэл зүйн гэмтэл, амиа хорлосон хүмүүсийг дуурайх (даган дуурайх сэдэл, Вертерийн хам шинж) сэдэл нөлөөлдөг бол бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд (14.8%) амиа хорлох эрсдэл өндөр байдаг<sup>175</sup> гэсэн судалгаа байна.

Хүүхэд насны бие махбод, бэлгийн хүчирхийллийн улмаас хүүхдэд сэтгэл гутрал, сэтгэл зүйн гэмтлийн дараах хариу урвал, сэтгэл түгшилт үүсэж, амиа хорлох бодол үүсэх буюу тийм эрсдэлд оруулдаг<sup>176</sup>.

Амиа хорлох үйлдлийн хэлбэр нь өөрийгөө боомилох, өндрөөс үсрэх, амин эрхтэн рүүгээ хутгалах, галт зэвсэг ашиглах, өндөр хүчдэлд цохиулах, усанд живэх, хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл доогуур санаатайгаар орох, хортой эм, химийн бодис, хий ашиглах зэрэг олон төрөлтэй ба улс орны ёс заншил, байгалийн орчин, тогтоц зэрэг онцлогоос хамаардаг.

Судалгаанаас үзэхэд, сэтгэцийн хувьд харьцангуй эрүүл болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн амиа хорлох хэлбэр нь адил байдаг гэж үздэг ба ихэнх тохиолдолд ганцаараа амиа хорлодог. Зарим тохиолдолд хоёр ба түүнээс дээш хүн урьдчилан үгсэн тохиролцож, төлөвлөж амиа хорлох явдал байдаг. Үүнийг хамтарсан амиа хорлолт гэдэг. Өөрөө амьдрах аргагүй болсон, эсвэл ойр дотны хүмүүс нь зовж, шаналж байна гэж итгэл үнэмшилд автаж ойр дотныхоо хүмүүсийг хорлож (гомицид- бусдыг алах), дараа нь өөрийгөө хорлох (суицид) үйлдэл хийхийг хамтарсан амиа хорлолт гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Энэ нь сэтгэцийн эмгэгтэй, ялангуяа сэтгэл гутралтай өвчтөнүүд үйлдэх эрсдэл өндөртэй гэж үздэг.

Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх хамгийн гол арга нь тухайн хүний тулгамдсан асуудлыг илрүүлэх, эмнэл зүйн ярилцлага хийх, асуудлыг шийдвэрлэхэд туслах зэрэг зан төлөвт нөлөөлөх явдал юм. Ийм төрлийн хүмүүс нь амиа хорлох бодол, төлөвлөгөөгөө бусдаас нуудаг ба амиа хорлож болзошгүй сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүмүүст танин мэдэхүй, төрх үйл, сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүдээр илэрдэг гэж үздэг. Тухайлбал:

- Танин мэдэхүйн өөрчлөлт нь – ирээдүйд итгэх итгэлгүй, өөрийгөө бусдаас доогуур үнэ цэнэтэй, бусдад тус дэм үзүүлж чадахгүй, эд хөрөнгөгүй, гэр бүл, нийгэмдээ хэрэггүй хүн, амьдрал утга учиргүй болсон гэх мэт буруу итгэл үнэмшил төрөх;

- Төрх үйлийн өөрчлөлт нь – нийгмийн дунд биеэ авч явах байдал нь өөрчлөгдөх, дасан зохицох чадвар муудах, сэтгэлийн бухимдлаа тайлах гэсэн шалтгаар архи, мансууруулах бодис хэрэглэх, найз нөхдөөсөө хөндийрөх, хэн нэгэнд захиас сургаал хэлэх, бусдад түрэмгий төрх үйл гаргах, нийгмийн хэв журам зөрчих зэрэг шинжүүдээр;

- Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт нь - уурлаж бухимдах, гуниглах, хэн нэгнийг үзэн ядах, тулгамдсан асуудлаа даван туулж чадахгүй болсон мэт мэдрэмж төрөх, айдас, түгшүүр төрөх зэрэг шинжүүдээр тус тус илэрдэг.

Харин сэтгэцийн эмгэгтэй хүмүүст сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг, хам шинжээс хамааран харилцан адилгүй шинжүүд<sup>177</sup> илрэх бөгөөд 28 хам шинжийн жагсаалтыг батлан, практикт мөрдлөг болгон ашигладаг.

ДЭМБ-ын 2014 оны “Амиа хорлохоос урьдчилан сэргийлье” тайлангаас үзвэл, өнөөгийн байдлаар дэлхийд 800.000 хүн амиа хорлодог бөгөөд дунджаар

---

<sup>175</sup> John. M Grohol. 2008.

<sup>176</sup> Mehmet Eskin. 2012.

<sup>177</sup> Эрүүл мэндийн сайдын тушаал. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам. Уб., 2014. 180 дугаар тушаалын хавсралт.

40 секундэд нэг хүн амиа хорлодог гэсэн үзүүлэлт байна. Дэлхийн амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх олон улсын холбоо нь (International Association for Suicide Prevention- IASP) жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх өдөр болгон, тодорхой уриан дор олон улсын түвшинд тэмдэглэдэг<sup>178</sup>.

Амиа хорлолт нь бага болон дунд орлоготой орнуудын түвшинд өндөр байгаа төдийгүй 15-29 насныхны нас баралтын шалтгааны хоёрдугаарт амиа хорлолт орж байгаа<sup>179</sup> нь анхаарал хандуулах асуудлын нэг болсон гэж дүгнэж байна. ДЭМБ-ын 2012 оны судалгаанаас үзэхэд, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин илүү амиа хорлож байна. Амиа хорлолтын улмаас нас барах тохиолдол нь дэлхийн хүн амын нас баралтын 1.4 хувь, нас баралтын шалтгааны 15 дугаарт эрэмбэлэгдэж байгаа нь өндөр хувь эзэлж байгааг харуулж байна. Дээрх тайлангаас үзэхэд, аль ч улсад хамгийн их хэрэглэдэг арга нь өөрийгөө боомилох (50%), галт зэвсгээр өөрийгөө хөнөөх (18%) аргууд байна. Галт зэвсэг хэрэглэж амиа хорлох тохиолдол нь АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад их байдаг бол хөдөө аж ахуй сайн хөгжсөн орнуудад хөдөө аж ахуйд хэрэглэдэг химийн бодисууд ялангуяа пестицид хэрэглэх, Гонг-Конг, Хятад, Сингапур зэрэг өндөр барилга бүхий улс орнуудад өндрөөс үсрэх, угаартах, химийн бодисын холимог хэрэглэх (Япон) зэрэг аргуудыг илүүтэй хэрэглэдэг.

Судалгааны дүнгээс үзвэл, амиа хорлох нь ядуурал, дайн, байлдаан, ялгаварлан гадуурхалт, эмнэлгийн тусламжийн хангалтгүй байдал, хүмүүсийн харилцааны зөрчил, сэтгэцийн эмгэг, архи, мансууруулах бодисын хортой хэрэглээ, хүчтэй өвдөлт бүхий архаг өвчнүүд нөлөөлдөг болохыг тогтоожээ. Амиа хорлоход хүргэдэг сэтгэцийн өвчнүүдийн дотор сэтгэл хөдлөлийн эмгэг (12%), архины хамааралд орох (7%), шизофрени (5%) зэрэг нь ихэнх хувийг эзэлдэг ажээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас амиа хорлох тохиолдлыг бууруулах зорилгоор 2013-2020 он хүртэл Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020 он гэхэд 10 хувиар бууруулна хэмээн төлөвлөсөн. 2010 онд АНУ-д галт зэвсгийн хэрэглээнд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд ашигладаг химийн бодист хяналт тогтоох, хүн амд сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлсний үр дүнд амиа хорлолтыг 20 хувиар бууруулсан. Амиа хорлох тохиолдлыг бууруулахад тусгайлсан бодлого, хөтөлбөр шаардлагатай байгаа бөгөөд өнөөгийн байдлаар амиа хорлох үйлдлийг бууруулах асуудлыг тусгасан ямар нэг баримт бичиг боловсруулсан 50 орон байгаагаас 7 улс нь үндэсний хөтөлбөртэй байна. Манай улсад 2012 оны байдлаар амиа хорлох тохиолдол 100.000 хүн амд 15.5 тохиолдол байгаа нь дэлхийн дунджаас (11.4%) дээгүүр байжээ<sup>180</sup>.

ДЭМБ-ын 2022 оны мэдээгээр Монгол Улсад 2018 онд амиа хорлох тохиолдлын тоо 100.000 хүн амд 18.67 гэж гарсан байдаг. Судлаачдын судалгаанаас үзэхэд, ДЭМБ-ын санхүүжилтээр 2013 онд Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэж хийсэн судалгаанд Монгол Улсын 13-17 насны өсвөр насныхан сүүлийн 1 жилийн дотор 23 хувь нь амиа хорлох талаар бодож үзсэн бол 9.3 хувь нь амиа хорлох оролдлого хийсэн, өөрөөр хэлбэл, 4 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох бодолтой байгаа бол ойролцоогоор 10 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох оролдлого хийгээд үзсэн байна.

<sup>178</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. УБ., 2014. 29 дэх тал.

<sup>179</sup> Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэц. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2019. 45 дахь тал.

<sup>180</sup> Хишигсүрэн З, Оюунсүрэн Д, Цэцэгдарь Г, Бямбасүрэн С, Най.Туяа. Монгол Улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан судалгаа. УБ., 2003-2008. 36 дахь тал.

Жилд дунджаар 400 орчим хүн амиа хорлож байгаагаас гадна өсвөр насны хүүхэд болон 29 хүртэлх насны залуусын дундах амиа хорлолт жил бүр өссөөр байгаа нь бүх талдаа анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг харуулсан явдал болов<sup>181</sup>. Сурагчдын дунд явуулсан судалгаагаар, сүүлийн 12 сарын хугацаанд амиа хорлох талаар нухацтай бодож байсан гэж хариулсан нь судалгаанд хамрагдагчдын 26.1 хувь, амиа хорлохыг завдаж байсан гэж 10.7 хувь нь хариулсан<sup>182</sup>. Эндээс хүүхэд, өсвөр насныхны дунд амиа хорлох эрсдэл өндөр байгааг харж болохоор байна.

### **Дүгнэлт**

1. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан амиа хорлолтын тоо хэмжээг харуулсан 2017 оны тоо баримтаар Монгол Улс 100,000 хүн тутамд 28.1 амиа хорлодог гэжээ. Энэ үзүүлэлт нь дэлхийн индексээр өндөр түвшинд байгаагийн илрэл юм;

2. Амиа хорлох үйлдлийг бодитой бүртгэгдэх боломжтой гэдгийг дэлхийн ихэнх улс хүлээн зөвшөөрч байна. Энэ үйлдэлд хэрэглэсэн арга нь тухайн хүний амь насанд аюул багатай үед эмнэлэгт хандахгүй, эмнэлгийн тусламж авдаггүйтэй холбоотой бүртгэлээс гадна үлдэх, нуугдмал байдалд байх явдал байсаар байна;

3. Амиа хорлох үйлдэл хийсэн хүмүүсийн 50 хувиас дээш хувь нь амьдралын боломж муу, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин доогуур байх тохиолдол харьцангуй их байна. Өсвөр насны хүний эцэг, эхийн хараа хяналт дутмаг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд тэдэнд ялгавартай хандах, гадуурхах, доромжлох, дээрэлхэх, тэгш бус хандах зэрэг байдал нь амиа хорлох шалтгаан, нөхцөл болж байна.

4. Гэр бүлийн гишүүдээ сэтгэлийн хямралд оруулахгүй байх, тэдэнтэй байнга харилцан ярилцаж нээлттэй байх, тэдний хэрэглээ, найз нөхдийн хүрээлэл, хүсэл сонирхлыг ажиглаж, хянаж байх, сэтгэл зүйчид хандаж, тогтмол зөвлөгөө авах нь энэ төрлийн үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

### **Санал**

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт сэтгэл зүйн хичээлийг суралцагчийн түвшингээс хамаарч үе шаттай зохион байгуулж хэвших, байнга (Дээрх арга туршлагыг хэрэгжүүлсэн Япон улсад гэхэд сүүлийн хоёр жилийн хугацаанд амиа хорлолт 18 хувиар буурсан гэх мэдээлэл бий) ярилцдаг байх;

- Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх ажиллагааг нэгдсэн сүлжээтэй болгох;

- Судалгааны үр дүнд суурилсан тусламж, үйлчилгээг зохион байгуулах, утсаар зөвлөгөө өгөх тогтолцоог боловсронгуй болгох;

- Гэр бүлийн, үе тэнгийнхний дарамт, хүчирхийллийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах;

- Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, чанарт анхаарах, орчин үеийн арга, техникүүдийг нэмэгдүүлэх, эмч, сэтгэл зүйчийн тоо, цалин, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх зэрэг санал гаргаж байна.

### **Ашигласан материал**

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. УБ., 2014.

<sup>181</sup> Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. Судалгааны тайлан. УБ., 2017. 12 дахь тал.

<sup>182</sup> Монголын Үндэсний телевиз. Шууд нэвтрүүлэг. УБ., 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр.

2. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. Судалгааны тайлан. Уб., 2017.
3. Монголын Үндэсний телевиз. Шууд нэвтрүүлэг. Уб., 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр.
4. Хишигсүрэн З, Оюунсүрэн Д, Цэцэгдарь Г, Бямбасүрэн С, Най.Туяа. Монгол Улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан судалгаа. Уб., 2003-2008.
5. Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэц. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Уб., 2019.
6. Эрүүл мэндийн сайдын тушаал. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам. Уб., 2014. 180 дугаар тушаалын хавсралт.  
Гадаадын эх сурвалж
7. John. M Grohol. 2008.
8. Mehmet Eskin. 2012.
9. O.Spengler der Sohnenuntergang in der Abendland.

## ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ АЛБА ХААГЧДЫН САХИЛГЫН ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

### WAYS TO REDUCE DISCIPLINARY VIOLATIONS OF PRISON OFFICERS

*Ж.Болдбаяр  
ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Хүний эрх, эрх чөлөөнд хуульд зааснаар хязгаарлалт хийх үйл ажиллагаанд эрх хязгаарлагч буюу үүрэг хүлээгч нь өндөр хариуцлага, ёс зүй болон хууль, эрх зүйн мэдлэгтэй байхыг шаарддаг. Тиймдээ ч төрийн албан хаагч, хууль сахиулах байгууллагын алба хаагчийн сахилга, хариуцлагын тухай асуудлыг авч үзэн, судлах нь "Rule of law"<sup>183</sup> хэмээх эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмыг хангаж буй хэрэг болно.

**Abstract:** In the activity of restricting human rights and freedoms according to the law, the person who restricts the rights or the obligee must have a high level of responsibility, ethics, and legal and legal knowledge. Therefore, considering and studying the issue of discipline and responsibility of civil servants and law enforcement officers will satisfy the basic principle of the legal system called "Rule of law".

**Түлхүүр үгс:** Хүний эрх, хариуцлага, төрийн алба хаагч, эрх зүй, зөрчил, шийтгэл, цагдан хорих.

**Keywords:** Human rights, responsibility, civil servants, law, violation, punishment, detention.

### Оршил

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан бүхий төрлийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн тусгай алба юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль<sup>184</sup>, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль<sup>185</sup>, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга ёс зүйн дүрэм<sup>186</sup>, Үйлчилгээний стандарт<sup>187</sup> зэрэг олон эрх зүйн актыг дагаж мөрдөх бөгөөд эдгээрт харшлах аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь сахилгын зөрчил хэмээх ойлголтыг бий болгодог байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга хариуцлагын асуудал багагүй хөндөгдөх болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, тэр дундаа Цагдан хорих байрны алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, түүний хэлбэр, зөрчил гарахад нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, шалтгаан, нөхцлийг арилгах нь нэг талаас ШШГБ-ын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах ажиллагааны нэг бүрдэл болно.

---

<sup>183</sup> Rule of law implies that every citizen is subject to the law. It stands in contrast to the idea that the ruler is above the law, for example by divine right.

<sup>184</sup> Төрийн албаны тухай хууль. УБ., 2018. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1.

<sup>185</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

<sup>186</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн дүрэм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. Дугаар А/183. УБ., 2018.

<sup>187</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал. Дугаар А/81. УБ., 2013.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаас гаргах сахилгын зөрчил, түүнд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой эрх зүйн уламжлал, цагдан хорих байрны алба хаагчдаас үйлдэж буй сахилгын зөрчлийн өнөөгийн байдал, зөрчил гаргахад нөлөөлсөн хүчин зүйл, зөрчил гаргасан алба хаагчдад хүлээлгэж буй сахилгын шийтгэл болон сахилгын зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулснаар алба хаагчийн ажилдаа хандах хандлага, албан үүрэгтээ хандах итгэл үнэмшил нэмэгдэх, байгууллагын үйл ажиллагааны чанар нэмэгдэх ач холбогдолтой.

### **Үндсэн хэсэг**

Төр улс үүсэн, нийлмэл нийгэм бий болохтой зэрэгцэн эхэлсэн хүн төрөлхтний хөгжил, хувьсал одоог хүртэл тасралтгүй үргэлжилсээр байна. Эртний улсуудын төр, эрх зүй, нийгмийн түүхийн судалгаа шинжилгээг өнөөгийн нийгэмтэй харьцуулан үзэхэд, асар их хувьсал, өөрчлөлт, дэвшлийг харж болох ч, хүн төрөлхтөн хөгжин дэвшихийн хэрээр, нийгмийн харилцаанд сөрөг үр дагавар бүхий аливаа хүчин зүйлс ч мөн адил нэмэгдсээр байгаа юм.

Германы философич К.Маркс “Нийгэм бол хамтын үйл ажиллагааны явцад үүссэн хүмүүсийн хоорондын түүхэн харилцааны цогц юм” гэж тодорхойлсон байна. Тиймээс нийгмийн харилцаанд оролцогч хүмүүсийн ёс суртахуун, тэдгээрийн ухамсрын түвшин дэх тодорхой ойлголтуудыг судлахгүйгээр нийгэм, төр, эрх зүйн асуудал, цаашлаад хууль дээдлэх зарчим, хуульд захирагдах ёс, нийгмийн аюулгүй байдлын талаар ярих боломжгүй юм.

Уламжлалт философийн онолоор бол нийгмийн харилцаа гэдгийг “Хүмүүсээс нийгмийн үйл явцад, өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралыг зохион байгуулахад оролцох” үйл явцыг хамааруулдаг ойлголт юм. Тухайлбал, сонгууль, төрийн үйлчилгээ, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх гэх мэт жишээг дурдаж болно.

Аливаа төр, улс оршин тогтнож ирсэн түүхэндээ өөрийн зорилго, чиг үүргийг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж ирсэн нь төрийн алба бөгөөд төрийн алба нь төрийг тодорхойлж ирсэн онол, арга зүй, үзэл хандлагыг дагаж мөн чанар, агуулгын хувьд хувьсаж ирсэн нь бий.

Орчин үед барууны орнуудад “Public service”, “Civil service” хэмээн нэрлэгдэж буй ухагдахуун нь Монгол хэлэнд “Төрийн алба” гэдэг нэр томъёогоор хэрэглэгдэж, төрд зүтгэх, ард түмэнд үйлчлэх гэсэн мөн чанарыг илэрхийлж байна.

Төр “хаан”, “язгууртан”-ы үеэс л ямагт тусгай имунитетийн эрх эдэлж, хариуцлагаас “мултарсаар” ирсэн хэдий ч, нийгмийн хөгжлийн аясаар дэлхийн улс орнууд төрийн албаны үүрэг хариуцлагын асуудалд анхаарал хандуулж, төрийн буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхэд саад болж байсан засаглалын имунитетийн ойлголт мэдэгдэхүйц багасаж, бусдад хохирол учруулсан захиргааны актынхаа төлөө хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрснөөр төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх зарчим нийтийн эрх зүйд аажмаар хөгжиж эхэлсэн байна.

Энэ үеэс төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх асуудал нь хүн төрөлхтний нийгэм, улс төр, эрх зүйн хөгжлийн нөлөөгөөр харилцан адилгүй үзэл санаа, онолд үндэслэн хувьсаж иржээ.

Уламжлалт үзэл санаанд (XVII-XIX зуун) төрийн албаны хариуцлагын асуудал агентын онол (agency theory)-д үндэслэж байсан бөгөөд төр-төрийн албан хаагчийн харилцааг эзэн-агентын харилцаагаар төсөөлөн, хамтын ажиллагааны үр дүнг хамгийн их байлгах талаар санал дэвшүүлэн, энэ нь хариуцлага хүлээлгэх шалгуур болж байжээ. Аажимдаа төрийн албанд улс төрийн нөлөө ихсэж, хариуцлага хүлээх чадвар, шударга ёсыг төлөвшүүлэх асуудал нь улс төрчдийн

ноёрхол дор орсноор улс төрийн албан тушаалтнууд болон мэргэшсэн төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагын ялгаатай байдал багасаж, төрийн мэргэшсэн алба хаагчдыг улс төрийн шалгуураар сонгон шалгаруулах, улмаар хариуцлагын тогтолцоог эвдэх, үл ойлгогдох байдал үүсгэхэд хүргэжээ.

Тиймээс төрийн албыг шинэчлэх, үйл ажиллагааны үр дүн, хариуцлагын механизмыг боловсронгуй болгохын тулд хувь хүмүүсийн сонголтын дээрх онцлогийг харгалзан, харилцааг боловсронгуй болгож, эзэн (хууль тогтоогч)-ийн гаргасан бодлогыг агент (захиргаа) хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх тийм зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим болон үр дүнг тодорхойлох аргыг олох ёстой болжээ.

Академич С.Нарангэрэл “Төр бүхэлдээ бүх ард түмнээс иш үндсээ авч байдаг бөгөөд ... үүнийг нь нийгэм болон төрөөс (бас зарчмын үүднээс болон үзэл санааны хувьд, хүн амын зүгээс ч) хүлээн зөвшөөрсөн байдаг. Нийгэм дэх хууль ёсны зарчим хатуу чанд, яв цав байдаг нь үүнээс үүдэлтэй юм. “Үүрэг”, “Хариуцлага” тэргүүн байранд тавигдаж дараа нь хууль ёсны шинж товойн гарч ирж байгаа ийм байдлаар эрх зүйг ойлгох нь ... үндэслэгээтэй байдаг.<sup>188</sup> Эрх зүйн зорилт нь хэн хүн ... аливааг үйлдэх “эрхтэй”, “эрхгүй” болохыг тодорхойлох үндэслэлийг гаргаж ирдэг ба энэ зорилтыг хууль зүйн хатуу чанд үүрэг, түүнийг биелүүлээгүйн төлөө хүлээх хариуцлагыг тогтоох замаар багагүй хэмжээнд хэрэгжүүлдэг” хэмээн нотолсон байна<sup>189</sup>.

Сахилга гэдгийг Я.Цэвэл “Ямар нэгэн хэсэг бүлгийн бүгдийн дагаж, журамлавал зохих журам, горим”<sup>190</sup> хэмээн тайлбарлажээ. Судлаач Д.Цогт-Очир “Сахилга гэдэг нь амьдралын шаардлагаар нөхцөлдсөн хүмүүсийн үзэл бодол, үйл ажиллагааны нэгдэл, нийгмийн тогтоосон дэг журмыг сахихыг хэлнэ”<sup>191</sup> хэмээн тодорхойлсон байна.

Эрх зүйн эерэг буюу позитив хандлагаар авч үзвэл, хууль зүйн хариуцлагыг үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт, түүнчлэн урамшууллын арга хэмжээг сонгон хэрэглэх нөхцөл гэж ойлгодог байна. Харин сөрөг буюу негатив хандлагаар авч үзвэл, хууль зүйн хариуцлага нь санкцын хэрэгжилт, төрийн албадлагын арга хэмжээ, ял (шийтгэл), эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хууль зүйн үүрэг, албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар, нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр гэж ойлгодог байна .

Доктор (Ph.D) Н.Мөнхзул “Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага” бүтээлдээ “Монголын төрт ёсны түүхэн хугацаанд “нийгэм” аливаа сөрөг үзэгдлээс ангид байж чадаагүй учраас төрд “хүч”-ийг ашиглах замаар хуулийн хүрээнд албадлага хэрэглэн нийгмийн сайн, мууг дэнсэлж ирсэн түүхтэй. Нөгөө талаас хүчийг олсон төр засаглах эрхээ хэрэгжүүлэх явцдаа өөрийн эрх, ямбаа хэтрүүлэх, дураар авирлах, хариуцлага алдаж ирсэн түүх цөөнгүй байна. Тиймээс төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч алба хаагчдын хүч байх ёстой хэм хэмжээнээс хэтрэхээс сэргийлэх, төрийн эрх мэдлийг хязгаарлаж, хууль зүйн түвшинд барьж байх үүднээс тэдэнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг Монгол Улсын үе үеийн эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж иржээ” хэмээн тэмдэглээд төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн эрх зүйн түүхийг

<sup>188</sup> Нарангэрэл С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо . Уб., 2001. 6 дахь тал.

<sup>189</sup> Мөн тэнд. 7 дахь тал.

<sup>190</sup> Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1964. 473 дахь тал.

<sup>191</sup> Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. Уб. 1999. 22 дахь тал.

үечлэн тодорхойлжээ. Энэ нь Монгол Улсын төр, хууль цаазын түүхийг үечилж ирсэн нийтлэг үечлэлийн дагуу:

- Монголын эртний улсуудын хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал;

- Монголын дундад үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал;

- Шинэ үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн уламжлал;

- Нэн шинэ үеийн хууль цааз дахь төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж буй байдал<sup>192</sup> гэсэн үечлэлтэй байна. Эндээс төр улс үүсэхтэй зэрэгцэн, төрийн албан хаагчдад сахилга, хариуцлагын асуудал яригдсаар байсан бөгөөд энэ тийм ч шинэ үзэгдэл биш болох нь тодорхой харагдаж байна.

Эрх хэмжээ буюу эрх зүйн чадамжтай байдлын хувьд сахилгын хариуцлага хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар болж өгдөг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн онолын хүрээнд хууль зүйн хариуцлагыг эрх зүйн зөрчлийн шууд үр дагавар гэж үздэг судлаачид байдаг бол зарим судлаачид түүнийг эрх зүйн хариуцлага хэмээн үзэх тохиолдол байдаг.

Түүхийн эдгээр үечлэлд төрийн алба хаагчдад хэрхэн хариуцлага оногдуулж ирснийг судлан, танилцах нь сахилгын зөрчил хэмээх ойлголтыг хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн харилцааны чухал хэлбэр болохыг ойлгоход дөхөм болно.

Монголын эртний улсуудын эрх зүй дэх төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж ирсэн уламжлалыг МЭӨ 3 дугаар зуунаас МЭ 13 дугаар зуунд хамааруулан үечилснээс заримыг онцолвол, энэ үед төрийн алба буюу шаталсан зэрэг дэв бүхий түшмэл ёс бүрэлдэн тогтсон гэж үзсэн бөгөөд, энэ нь эрдэм, мэдлэг хуримтлуулсан туршлагаараа бусдаас тодорсон албан тушаалтан төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны хувьд удирдах, гүйцэтгэх, өвөрмөц эрх мэдлээ хэрэгжүүлэхийг улс төр, хууль зүйн тухай ойлголтыг илэрхийлж байгаа бөгөөд байнгын шинжтэй төрийн алба чухам энэ үед үүссэн байна.

Тухайн үеийн хууль цаазын уламжлалыг нэгтгэн авч үзэхэд төрийн эсрэг үймээн гаргах, төрөөс урван тэрслэх, төрийн хууль цаазыг зөрчих, төрд тэрслэх гэх мэт зан үйлүүдийг хаан болон түүний угсааны ноёд сайдуудад хамаатуулан хуульчилсан нь тухайн үеийн монголчуудын төрийг дээдлэх санааг хууль цаазын гол мөн чанар болгон авч үзсэнтэй холбоотой юм. Үүний ял шийтгэл нь чулуугаар цохих, цаазлах, цөлөх зэрэг хүнд шийтгэлүүд байсан нь бие махбодид чиглэсэн эрүүгийн шинжтэй хариуцлагын төрөл зонхилж байсныг харуулсан талаар доктор (Ph.D) Н.Мөнхзул өөрийн бүтээлдээ дурдсан байна.

Монголын дундад үеийн эрх зүй дэх төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж ирсэн уламжлалыг XIII-XX зуунд хамааруулан үечилснээс заримыг дурдвал, цаг хугацааны хувьд 700 гаруй жилийг хамаарах энэ түүхэн үечлэлд төр ёсны харилцаа, эрх зүйн уламжлал шинэчлэлийн хамгийн ээдрээтэй үеүд хамардаг. Тухайн үеийн төр засгийн онцлог, нөхцөл байдлаас хамааран хууль, эрх зүйн асар их өөрчлөлт орсон бөгөөд тэдгээр өөрчлөлт, шинэчлэлт дундаас, төрийн албанд зүтгэж буй түшмэдийн сахилга хариуцлагад ихээхэн анхаарал хандуулж, мөн ял шийтгэл нь ч хүнд байсан талаар олон талаас нь тайлбарлаж болно. Тухайлбал, Их засаг хуульд зөвхөн төрийн албан хаагч авлигын гэмт хэрэгт холбогдсон сахилга хариуцлагын асуудлаар олон төрлийн зохицуулалт байсан бөгөөд “Их засаг” хуульд хаан өргөмжлөх, их хуралдайг зарлан хуралдуулах,

<sup>192</sup> Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. Уб., 2019.

гадаад улс оронтой харилцах ёс, цэргийн болон иргэний үүрэг, алба татвар, эрүүгийн болон иргэний шинж чанартай олон асуудлыг хэрхэн зохицуулахыг хуульчлан заасан байдаг.

Түүхэн эх сурвалжуудаас үзвэл "... хэрвээ түмтийн жанжин алдаа, эндэгдэл гаргалаа гэж бодвол, тэр жанжин хоёр нарны хооронд явж хүрэх хол газар байсан ч хаан түүн рүү ганц элч мордуулна. Тэр элч жанжинд хүрч очоод толгойг нь ав гэсэн бол аваад, алт, эрдэнээр торго гэсэн бол торгоод буцаж ирнэ..."<sup>193</sup> (Үүнийг мөн Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэрт Их засаг хуулийн цаазын чанартай сургаальд тэмдэглэн, Нэгэн зүйл: Ноёд дотроос ямар нь боловч гэм халдаад, хаанаас хамаг доорд түшмэлийн албан хүнийг зарж гэсгээлгэхээр явуулбал даруй биеэ тэрхүү элчид өгч өмнө хэвтэж хаанаас тогтоосон амийг авах хэрэг боловч шууд гүйцэтгүүлтүгэй<sup>194</sup> гэж дурдсан байдаг), "... түшмэл түшээ зарж хянан байцаалгах үес хэрэв цэргийн тоо дутах буюу оргодол хийгээд ядуу хүнийг ацаглан нэрийн цэсийг гүйцээсэн байх аваас заавал зэмлэж, ял хэлэлцэх болмуй..."<sup>195</sup>, "... доод тушаалын дарга нар дур мэдэн бичиг шийтгэн олгож цэргийг халж солихыг цаазлах бөгөөд..."<sup>196</sup>, "... ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа буюу хааны зарлиг ёсоор ирээгүй ноёд жанжнуудыг цаазаар авна..."<sup>197</sup> гэж хууль, цаазын хэм хэмжээ тогтоосон зарлиг бичгүүдийг нэрлэн дурдаж болно.

Эдгээр "Их засаг" хуульд тусгасан хэм хэмжээг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн түүхэн уламжлал гарцаагүй мөн гэж үзэх нэг дэх шалтгаан нь уг хэм хэмжээнд тусгасан "түшмэл гэж урьдын цагт албан хэргийн талаар таслан тогтоох явдалд оролцох эрх тушаал бүхий хүнийг, жанжин гэж бүх цэргийг ерөнхийлөн захирах дээд албан тушаалыг, ноёд"<sup>198</sup> гэж хошуу, орон нутгийн дээд албан тушаалтан буюу захирагчийг хэлэх талаар Монгол хэлний их тайлбар толиос харж болох бөгөөд энэ нь одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд заасан нийтийн албан тушаалтан гэдэгтэй адил ойлголт юм.

Түүнчлэн "Монголын эрх зүйн философид Хубилай хааны төр, хууль цаазын үзэл баримтлал чухал байр эзэлдэг"<sup>199</sup> гэж үзвэл, Арван цагаан буянт номын түүхийг энд мөн дурдах нь зүйтэй. "Цагаан түүх"<sup>200</sup> нь хэдийгээр эрүүгийн эрх зүйн шинж чанар агуулаагүй, шашин, төрийн ёсыг тэгш явуулах тухай хууль цааз боловч "Улсыг засахын ёсны тулд шуутган хол бүхүйг өөр нөхөр аваад, засаг зарлигийг бэлгэтэйеэ онож явуулаад, заал заргын эсэх харваас, иргэн оргоныг аврахын дээд эрхлэгч тайш"<sup>201</sup> хэмээхүй, "Хэн гэндэлгүй явбаас баатрын зэрэгт оруул. Алдалгүй төгсвөөс тухалын"<sup>202</sup> зэрэгт оруул. Хэн алагчлалгүй шүүвээс

<sup>193</sup> Ала-Ад-Дин Ата-Мелик Жувеини. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Орч. М.Д.Бадамням. Уб., 2006. 25 дахь тал.

<sup>194</sup> Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Баярсайхан. Уб., 2002. 14 дэх тал.

<sup>195</sup> Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. Уб., 2010. 36 дахь тал.

<sup>196</sup> Гуулин улсын судар. Тэргүүн боть. Пхеньян. 1957. 452-454 дэх тал.

<sup>197</sup> Чимид Б. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд. Уб., 2008. 140 дэх тал.

<sup>198</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. Монгол хэлний их тайлбар толь. Уб., <https://mongoltoli.mn/dictionary/>.

<sup>199</sup> Лүндээжанцан Д. нар. Эрх зүйн философи. Уб., 1998. 191 дэх тал.

<sup>200</sup> Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. Уб., 2010. 44-68 дахь тал.

<sup>201</sup> Тайш - Монгол Улсын үеийн цэрэг захирах ноёны цол. Монголын түүхийн тайлбар толь. <https://mongoltoli.mn/history/h/444>.

<sup>202</sup> Тухал – Хааны зарлигаар улсын сангийн эд ашгийг хуваах үйлийг эрхэлдэг ордны түшмэл.

заргачийн зэрэгт оруул” зэрэг айлтгалуудаас үзэхэд, төрийн алба хаших ёс, дэг жаяг, цааз, цээрийг тогтоосон хэм хэмжээ агуулагдаж байжээ.

Эдгээрээс түүхэн энэ цаг үеэс эхлэн хууль, эрх зүйн харилцаан дахь төрийн албан хаагчид сахилгын хариуцлага оногдуулж буй зохицуулалт аяндаа боловсронгуй болох зарчмаар хөгжиж ирсэн гэж дүгнэхээр байна.

Шинэ үеийн эрх зүй дэх төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж ирсэн уламжлалыг 1921-1990 онд хамааруулан үечилснээс онцолвол, Монгол Улсад 1921 оны Ардын хувьсгал ялж, тухайн үед Монгол орон социализмд хүрэх чиг баримжааг сонгон, түүний онол, үзэл баримтлалын дагуу, түүнд тохирсон нийгэм, улс төр, эдийн засгийн зохих тогтолцоог бүрдүүлэхийн тулд өөртөө тохирсон эрх зүйн үндсийг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн<sup>203</sup>.

Харин энэ цаг үед төрийн албан хаагчийн сахилгын хариуцлагатай холбоотой эрх зүйн хэм хэмжээг улам боловсронгуйгаар төрөлжүүлж эхэлсэн ба үүнийг “Төмөр замын ажилчин, алба хаагчдын сахилга батын дүрэм”, “БНМАУ-ын шүүгчдийн сахилга батын дүрэм” гэх зэргээр нэрлэн баталгаажуулсан сахилгын тусгай дүрмүүдийг дагаж мөрдөж байснаар нотолж болно. Энэ цаг үеийн онцлог нь захирах, захирагдах журмаар сахилгын хариуцлага хүлээлгэх явдал байв. Энэ нь гол төлөв удирдах албан тушаалтанд хамааралтай бөгөөд ажлын газрын захиргаанаас биш, тухайн ажилтан шууд харьяалж, захирах дээд байгууллагаас нь сахилгын шийтгэл оногдуулахыг хэлж байжээ.

Социализмын дундаас хойшх жилүүдэд намын шийдвэр нь илт хүч, нөлөөтэй байсан бөгөөд Намын төв хорооны дэргэдэх Намын хянан шалгах хороо нь намын гишүүд, орлогч гишүүдээс намын сахилгыг сахиж байгаа байдлыг шалгаж, намын дүрэм, журмыг зөрчсөн гишүүд, түүнчлэн намын ёс суртахууныг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх, намаас хөөгдсөн, намын шийтгэл үзүүлсэн шийдвэрт гомдсон гомдлыг хянан үздэг байсан.

Эдгээр нөлөөгөөр эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоо бүрдэж, эрүүгийн, иргэний, сахилгын, олон нийтийн, эд хөрөнгийн, хариуцлага зэргээр салбарлан хөгжсөн ба энэ нь төрийн алба хаагчийн сахилга, хариуцлага нь нам, эвлэлийн гишүүний үүрэг, хариуцлагын тогтолцооноос ихээхэн хамааралтай байсан гэж хэлж болно.

Нэн шинэ үеийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчид хариуцлага оногдуулж буй байдлыг 1990 оноос өнөөг хүртэл хамааруулан үечилснээс онцолвол, ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, хууль, эрх зүйн хувьд олон шинэ өөрчлөлтийг бүтээж, өдгөө ч эрх зүйн шинэтгэлийн олон өөрчлөлт, шинэчлэл явагдаж байгаагийн хувьд, түүхэн үечлэлийн энэ цаг үе ч мөн ололттой, дутагдалтай олон асуудлыг агуулж явдаг, эгзэгтэй цаг үеийн нэг гарцаагүй мөн юм.

1990 оноос хойшх Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн үйл явцыг доктор (Ph.D) Д.Зүмбэрэллхам дараах 4 үе шатад хуваажээ. Үүнд:

1. Ардчилсан нийгмийн мөн чанарт нийцүүлж төрийн байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлэх эхний үе шат (1990-1995 он);
2. Төрийн мэргэшсэн албыг бүрдүүлж, төлөвшүүлэх үе шат (1995-2002 он);
3. Засаглалын институцийн чадавх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үе шат (2002-2008 он);
4. Улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх үе шат (2008 оноос хойш)<sup>204</sup> хамаарч байгаа юм.

<sup>203</sup> Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. Уб., 2019.

<sup>204</sup> Зүмбэрэллхам Д. “Монгол Улсын төрийн албаны шинэтгэл” илтгэл. // “Монгол Улсын төрийн албаны шинэтгэл: Сорилт, боломж” үндэсний чуулган. Уб., 2011.

Энэ хугацаанд Төрийн албаны тухай хуулийг 2 удаа шинээр баталсан бөгөөд уг хуулиудад төрийн жинхэнэ албан хаагчид оногдуулах сахилгын хариуцлагын асуудлыг хөндөн, хуульчилж ирсэн. Харин 2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2021 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 9 дүгээр бүлэгт төрийн нийт алба хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйлийг тодорхойлох болсон. Үүгээр сахилга, хариуцлагын хувьд төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албан хаагч хэмээн ялгах боломжгүй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, энэхүү өөрчлөлтөөр нийт төрийн алба хаагчид ижил түвшний үүрэг, эрх, хориглох зүйлийг бий болгож өгснөөр төрийн бүхий л албан хаагчдын үүрэг, хариуцлага ижил түвшний стандартад нийцэхээс өөр аргагүй болсныг дурдах нь зүйтэй.

Үндсэндээ нийгмийн харилцааны бүхий л цаг үед ёс зүй, ёс суртахууны агуулга нь гарцаагүй чухал байр суурийг эзэлж байсан бөгөөд чухам тэндээсээ салбар бүрд тархан хөгжиж, энэхүү сахилга, хариуцлагын асуудал нь эрх зүйн харилцааны бас нэгэн тулгуур зарчим болж өгснөөрөө сахилгын зөрчил хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар бүхий нэгэн цул ойлголт болжээ. Өөрөөр хэлбэл, энгийн иргэний ёс зүйн асуудал нь төрд алба хашиж буй албан тушаалтны ёс зүйн асуудлаас харьцангуй өөр ойлголт бөгөөд чухам тэндээс сахилга, хариуцлагын асуудал үүсдэг.

Төрийн албан хаагчийн сахилгын зөрчил, сахилга, хариуцлагын тухай ойлголт нь төр улс үүсэхтэй зэрэгцэн бий болсон, үндсэн элемент гэж хэлж болно. Түүхийн бүхий л цаг үед төрийн албан хаагч, түшмэл ноёдтой холбоотой эрх зүйн харилцааг зохицуулж ирсэн эрх зүйн үр дагавар бүхий олон хэм хэмжээг дурдаж болно.

Сахилгын зөрчил нь үндсэндээ эдгээр эрх зүйн хэм хэмжээнүүдийг зөрчих процесст үүсдэг харилцаа бөгөөд үүнийхээ төлөө тухайн албан хаагч тодорхой хариуцлага хүлээдэг. “Хариуцлага” гэдэг нь тухайн субъект үйл ажиллагаагаа явуулсныхаа төлөө эцсийн үр дагаврыг өөртөө хүлээх онцгой чадвар, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн арга хэрэгслийн нэг нь хууль зүйн хариуцлага юм.

Сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл нь ихэнх тохиолдолд сахилгын зөрчил гаргасан байх явдал бөгөөд зарим тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн алба хаагчид сахилгын хариуцлага хүлээлгэдэг.

Төрийн алба хаагчид сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой бөгөөд түүнийг үндэслэн:

- Дотоод дүрэмд заасан журмаар;
- Захирах захирагдах журмаар;
- Сахилгын тусгай дүрэмд зааснаар арга хэмжээ авах гэж ангилдаг.

Харин ШШГБ үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийг цагдан хорих, тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Уг ажиллагаанд холбогдох алба хаагчдын ажлын сахилгын хариуцлага, сахилгын зөрчлийн тухай авч үзэх хэрэгтэй.

Цагдан хорих байрны алба хаагчид нь ажил, үүргийн хувьд иргэдтэй хамгийн ойр байж, цагдан хоригдсон шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болоогүй сэжигтэнтэй тогтмол харьцдаг онцлог бүхий ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг алба хаагч юм.

Цагдан хорих байрны нийт 84 алба хаагчдыг судалгаанд хамруулж, анкет, асуулгын аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийснийг доорх хүснэгтэд харуулав.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын насны байдал

| Нас         | Судалгаанд хамрагдсан алба хаагчдын тоо | Хамрагдсан байдал |
|-------------|-----------------------------------------|-------------------|
| 18-24       | 12                                      | 8.2 %             |
| 25-29       | 27                                      | 23.4%             |
| 30-34       | 24                                      | 34.2%             |
| 35-39       | 11                                      | 26.1%             |
| 40-44       | 8                                       | 6.5%              |
| 45-49       | 2                                       | 1.6%              |
| 50-аас дээш | 0                                       | 0%                |
| Нийт        | 84                                      | 100%              |

Судалгаанд оролцогчдын цагдан хорих байрны алба хаагчдын насны байдлын дийлэнх хувь буюу 23.4 хувийг 25-29, 34.2 хувийг 30-34, 26.1 хувийг 35-39 настай алба хаагчид эзэлж байгаагаас үзвэл, судалгааны оролцогчдын 83.7 хувь нь 25-39 насны алба хаагчид эзэлж байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал

| Боловсрол      | Судалгаанд хамрагдсан алба хаагч | Хамрагдсан байдал |
|----------------|----------------------------------|-------------------|
| Дээд           | 37                               | 74.5 %            |
| Тусгай дунд    | 15                               | 8.2%              |
| Бүрэн дунд     | 32                               | 17.4%             |
| Бүрэн бус дунд | -                                | -                 |
| Бага           | -                                | -                 |
| Боловсролгүй   | -                                | -                 |
| Нийт           | 84                               | 100%              |

Судалгаанд оролцогчдын 37 буюу 74.5 хувь нь “дээд боловсролтой”, 15 буюу 8.2 хувь нь “тусгай дунд”, 32 буюу 17.4 хувь нь “бүрэн дунд” боловсролтой алба хаагчид хамрагджээ.

Цагдан хорих байрны алба хаагчдын 2019-2023 он хүртэлх хугацааны сахилгын зөрчлийн дэлгэрэнгүй мэдээнээс үзвэл, 2019 онд 54, 2020 онд 52, 2021 онд 44, 2022 онд 29, 2023 онд 76 алба хаагч сахилгын зөрчилд холбогдсон байгаа нь цаашид өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Алба хаагчдын гаргаж байгаа зөрчлийн хэлбэрээр авч үзвэл, архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэж гаргасан зөрчил 2022 онд 12 байсан бол 2023 онд 18, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсний улмаас сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол сүүлийн жилд 15 нэгжээр өссөн зэрэг үзүүлэлтийг дурдаж болохоор байна.

Цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын шийтгэлийн нэгтгэсэн тоон мэдээлэлд дурдсанаар, 2019 онд нийт 54 алба хаагч сахилгын шийтгэл хүлээнснээс, ахлагч 33, 2020 онд нийт 52 алба хаагч сахилгын шийтгэл хүлээнснээс, ахлагч 28, 2021 онд нийт 44 алба хаагч сахилгын шийтгэл хүлээнснээс, ахлагч 18, 2022 онд нийт 29 алба хаагч сахилгын шийтгэл хүлээнснээс, ахлагч 12 байна.

Үүнээс үзвэл, цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчлийг тогтмол өсөлттэй гэж хэлэх боломжгүй юм. Харин сахилгын зөрчлийн төрөл зүйлийг нарийвчлан тогтоож судалбал, сахилгын зөрчлийг тодорхой хэмжээнд бууруулах, цаашид өсгөхгүй байх боломжтой харагдаж байна.

2022 онд сахилгын шийтгэл оногдуулсан 29 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 13, архидаан согтуурсан 8, Хүнтэтгэн үзэх шалтгаангүй ажил тасалсан 4, Хоригдогчтой зүй бус үг хэллэг хэлж харьцсан 1, хоригдогчтой хувийн харилцаа тогтоосон 3 тохиолдол байх бөгөөд эдгээрийн 39-ийг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ. Харин 2023 оны сахилгын шийтгэл оногдуулсан 76 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 37, ахуйн хүрээнд архидаан согтуурсан 12, цэргийн дүрэмт хувцас дүрмийн дагуу өмсөөгүй 5, үүрэг даалгавар үл биелүүлсэн 10, харуул хамгаалалтын хүч сулруулсан 12 тохиолдол байх бөгөөд эдгээрийн 55-ыг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Сүүлийн 2 жилд Цагдан хорих байрны алба хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэсний 10 тохиолдол нь өндөржүүлсэн бэлэн байдал болон албаны бэлэн байдал зарласан үед архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэх шалтгаантай байна. Үүнээс гадна 5-15 жил ажиллаж байгаа алба хаагчид сахилгын зөрчилд холбогдох нь их байгаагаас үзвэл, алба хаагчдын давтан сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага үүссэн, ажлын ачаалал ихсэж, нийгэм, цаг үеийн онцлогоос хамаарах ажлын бүтээмж буурч байгаа зэрэг шалтгаанууд байж болно.

Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа нь оновчтой, зөв шийдэл мөн эсэхэд эргэн дүгнэлт хийх шаардлагатай. Түүнээс гадна удирдах албан тушаалтны сахилга, хариуцлагыг сайжруулах, мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж ажиллах туршлагыг бий болгохын тулд тухайн удирдах албан тушаалд томилохдоо удирдахуйн ухааны сургалт, хөтөлбөрт зайлшгүй хамрагдах нь зүйн хэрэг юм. Үүний үр дүнд удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлж өгөх сайн талтай билээ.

Хамгийн чухал асуудал нь сахилга, ёс зүй зөрчигдөхөд нөлөөлдөг тухайн бие хүний зан чанарын онцлогууд гэж байдгийг анхаарч үзэх нь зүйтэй. Тухайлбал, үзэн ядах, хайрлах сэтгэл, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл эрмэлзэл, атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь ёс зүй зөрчихөд өөрийнх нь зүгээс хүргэдэг бөгөөд үүнийг ёс зүйн бус асуудал гэдэг. Өөрөөр хэлбэл, эдгээр нь ёс зүй зөрчих үйлдлийг хийлгэхэд цаанаас нь өдөөж байдаг хүчин зүйл болж өгдөг байна. Шийдвэр гаргагч бүрт аливаа нэг шийдвэр гаргахад хувь хүний зан чанар нь заавал нөлөөлж байдаг бөгөөд энэ зан чанараасаа давж, ёс зүйн дагуу шийдвэр гаргах нь тухайн ажилтнаас ихээхэн шалтгаалдаг.

Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжил дээрээ алдахаас илүү ёс зүйн алдаа гаргах нь илүү байдаг. Ёс зүйн алдаа нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдгийг санах нь зөв бөгөөд, алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчилд энэ байдал давамгайл харагдаж байна. Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа оновчтой, зөв шийдэл эсэхэд эргэн дүгнэлт хийх шаардлагатай. Үүнээс гадна удирдах албан тушаалтны сахилга, хариуцлагыг сайжруулах, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах туршлагыг бий болгохын тулд тухайн удирдах албан тушаалд томилохдоо удирдахуйн ухааны сургалт, хөтөлбөрт зайлшгүй хамрагдах нь зүйн хэрэг юм. Энэ

эргээд нөгөө талаасаа удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлж өгөх нь тодорхой юм.

Цагдан хорих байрны алба хаагчдын сахилгын зөрчлийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдод тавьсан “Та цагдан хорих байранд ажиллаж байхдаа сахилга, ёс зүйн зөрчил гаргаж байсан уу?” гэх асуултад оролцогчдын 23 буюу 15.4 хувь нь “Тийм”, 61 буюу 84.6 хувь нь “Үгүй” гэсэн хариултыг өгсөн байна. Сахилга, ёс зүйн зөрчил гаргаж байсан алба хаагчдаас “Хэрэв та зөрчил гаргаж байсан бол ямар шийтгэл хүлээсэн бэ?” гэсэн асуултад 10 буюу 67.7 хувь нь “Сануулах”, 6 буюу 27.4 хувь нь “Албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар хасах”, 5 буюу 4.8 хувь нь “Цолны мөнгө хасах”, 2 буюу 3.2 хувь нь “Цол бууруулах” шийтгэлийг тус тус хүлээсэн байна. “Цагдан хорих байранд ажиллахад ямар зөрчил давамгайлсан гардаг гэж та үздэг вэ?” гэх асуултад судалгаанд оролцогчдын 12 буюу 5.8 хувь нь “Ажил таслах”, 39 буюу 22.8 хувь нь “Ажлаас хоцрох”, 7 буюу 1.8 хувь нь “Өгсөн үүрэг, даалгавар биелүүлээгүй байх”, 6 буюу 11.7 хувь нь “Дүрэмт хувцасны зөрчил гаргах”, 20 буюу 25.7 хувь нь “Бусад” үйлдэлд хамаарах зөрчил гаргасан талаараа хариулжээ.

Цагдан хорих байрны алба хаагчдаас “Сахилгын зөрчил гаргахад ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ?” гэж асуухад (давхардсан хариулттай), судалгаанд оролцогчдын 42 буюу 23.9 хувь нь “Үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт”, 71 буюу 40.3 хувь нь “Ажлын хүнд нөхцөл”, 67 буюу 38.1 хувь нь “Цалин, хөлс бага”, 84 буюу 55.7 хувь нь “Ачаалал их учир стресст ордог”, 36 буюу 20.5 хувь нь “Удирдлагын арга барил”, 22 буюу 12.5 хувь нь “Хамт олны уур амьсгалын тааламжгүй байдал”, 52 буюу 29.5 хувь нь “Найз нөхдийн нөлөөлөл” гэсэн хариултыг тус тус сонгосноос гадна судалгаанд оролцогчдын 9 буюу 5.4 хувь нь “Хувь хүний асуудал, мэдэхгүй, дарга нар алба хаагчдаа анхаардаггүй, 1 хүн 2 хүний ажил хийдэг” гэсэн хариултуудыг нээлттэй байдлаар өгсөн байна.

Судалгаанд оролцогчдод тавьсан “Цагдан хорих байрны алба хаагчдаас сахилгын зөрчил гаргахад хувь хүний суурь хүмүүжил нөлөөлдөг үү?” гэх асуултад 54 буюу 46.7 хувь нь “Тийм”, 20 буюу 42.1 хувь нь “Үгүй”, 10 буюу 11.2 хувь нь “Зарим тохиолдолд” гэж хариулсан байна.

Хувь хүний суурь хүмүүжил сахилгын зөрчил гаргахад ихээхэн нөлөө үзүүлдэг болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

### **Дүгнэлт**

1. Түүхэн цаг үеэс эхлэн хууль, эрх зүйн харилцаан дахь төрийн албан хаагчид сахилгын хариуцлага оногдуулж буй зохицуулалт аяндаа боловсронгуй болох зарчмаар хөгжиж ирсэн гэж хэлж болохоор ажээ.

2. Эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоо бүрдэж, эрүүгийн, иргэний, сахилгын, олон нийтийн, эд хөрөнгийн, хариуцлага зэргээр салбарлан хөгжсөн ба энэ нь төрийн алба хаагчийн сахилга, хариуцлага нь нам, эвлэлийн гишүүний үүрэг, хариуцлагын тогтолцооноос ихээхэн хамааралтай байсан гэж хэлж болно.

3. Үндсэндээ нийгмийн харилцааны бүхий л цаг үед ёс зүй, ёс суртахууны агуулга нь гарцаагүй чухал байр суурийг эзэлж байсан бөгөөд чухам тэндээсээ салбар бүрд тархан хөгжиж, энэхүү сахилга, хариуцлагын асуудал нь эрх зүйн харилцааны бас нэгэн тулгуур зарчим болж өгснөөрөө сахилгын зөрчил хэмээх ойлголт нь хууль зүйн үр дагавар бүхий нэгэн цул ойлголт болсон байна. Өөрөөр хэлбэл, энгийн иргэний ёс зүйн асуудал нь төрд алба хашиж буй албан тушаалтны

ёс зүйн асуудлаас харьцангуй өөр ойлголт бөгөөд чухам тэндээс сахилга, хариуцлагын асуудал үүсдэг.

4. Алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийн хувьд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах шийтгэлийг нарийвчлан, нэг бүрчлэн зааж өгөөгүйгээс хэлбэр, агуулгын ялгаатай байдлыг үл харгалзан ижил шийтгэл оногдуулж байгаа нь оновчтой биш байна.

5. Байгууллагын удирдах албан тушаалтны ажлын арга барил, менежментийн шинжлэх ухааны ерөнхий ойлголтуудыг баримтлах чадвар цагдан хорих байранд алба хаагчийн гаргаж байгаа сахилгын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг байна. Үр дүнд нь удирдах албан тушаалтны үүрэг, хууль ёсны шаардлага биелүүлээгүйтэй холбоотой үүсдэг сахилгын зөрчил буурах боломжийг бүрдүүлнэ.

6. Сахилга, ёс зүй зөрчигдөхөд нөлөөлдөг тухайн бие хүний, тодруулбал, алба хаагчийн хувийн зан чанарын онцлогууд чухал байр суурь эзэлж байна. Заримыг дурдвал, үзэн ядах, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл, эрмэлзэл, атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь сахилгын зөрчил үүсэхэд нөлөөлөх томоохон хүчин зүйлс болж байна.

### **Санал**

Өгүүллийн хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэр дундаа баривчлах, цагдан хорих ажиллагааны онцлогт тохирсон алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах зан үйл, ёс зүйн үзэл баримтлалыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулах;

2. Цагдан хорих байрны алба хаагчийн сахилгын хариуцлага, түүнд хүлээлгэх шийтгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг боловсруулахдаа, цагдан хорих үйл ажиллагааны онцлогт тохируулан албан хаагчид хүлээлгэх шийтгэх, хариуцлагын тогтолцоог сайжруулан бүрэлдүүлэх;

3. Цагдан хорих байгууллагын удирдах албан тушаалтны үйл ажиллагаа алба хаагчийн сахилга, хариуцлага, алба хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэлд шууд нөлөөлдөг тул алба хаагчийн удирдлагын үйл ажиллагаа, менежментийн бодлогыг сайжруулах үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

4. Алба хаагчаас гаргаж буй сахилгын зөрчилд тэдний зан харилцаа, ажлын байрны орчин нөхцөл, ажлын ачаалал, хүмүүжлийн төлөвшлийн байдалд нөлөөлдөг болох нь судалгаанаас харагдаж байх тул алба хаагчид үзүүлэх сургалт, давтан сургалтын үйл ажиллагаанд сэтгэл зүй, сэтгэл заслын хөтөлбөрүүдийг тусгах шаардлагатай байна.

### **Ашигласан материал**

1. Ала-Ад-Дин Ата-Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Орч. М.Д.Бадамням. УБ., 2006.

2. Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2010.

3. Гуулин улсын судар. Тэргүүн боть. Пхеньян. 1957.

4. Зүмбэрэллхам Д. "Монгол Улсын төрийн албаны шинэтгэл" илтгэл. // "Монгол Улсын төрийн албаны шинэтгэл: Сорилт, боломж" үндэсний чуулган. УБ., 2011.

5. Лүндээжанцан Д. нар. Эрх зүйн философи. УБ., 1998.

6. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Баярсайхан. УБ., 2002.

7. Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ., 2019.

8. Нарангэрэл С, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо . УБ., 2001.

9. Төрийн албаны тухай хууль. УБ., 2018. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1.

10. Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ. 1999.

11. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1964.

12. Чимид Б. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд. УБ., 2008.

13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн дүрэм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. Дугаар А/183. УБ., 2018.

14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал. Дугаар А/81. УБ., 2013.

15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

#### Цахим эх сурвалж

16. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. Монгол хэлний их тайлбар толь. УБ., <https://mongoltoli.mn/dictionary/>.

17. Монгол Улсын үеийн цэрэг захирах ноёны цол. Монголын түүхийн тайлбар толь. <https://mongoltoli.mn/history/h/444>.

18. Rule of law implies that every citizen is subject to the law. It stands in contrast to the idea that the ruler is above the law, for example by divine right.

# ЦАХИМ ОРЧИНД ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ ДЭЭРЭЛХЭХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ГЭМТ ЯВДЛЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

## THE UNDERSTANDING OF CYBERBULLYING AND DISCRIMINATION AGAINST TEENAGERS

**3.Одмаа**

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Өгүүлэлд өсвөр үеийнхэн цахим орчинд бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах гэмт явдлын ойлголт болон Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилго.

**Abstract:** In this article, described and gave an evaluation for the current situation and understanding of cyberbullying and discrimination against teenagers in Mongolia.

**Түлхүүр үгс:** Өсвөр нас, цахим орчин, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт.

**Keywords:** Teenage, cyber environment, bullying, discrimination.

Хүүхэд бол улс орны ирээдүй мөн. Тэд гэмт явдал болон гэмт хэрэг, зөрчлөөс хол, эрх, эрх чөлөөг дээдэлсэн орчинд өсч, торних ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.2-т “Хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах<sup>205</sup>...”, 16.11-т “...гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална<sup>206</sup>...”, 16.13-т “Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй<sup>207</sup>...” гэж заасан нь хүүхдийн эрхийг хангах баталгаа болсон заалт төдийгүй Хүний эрхийн түгээмэлд тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй<sup>208</sup>”, 2 дугаар зүйлд “Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьсны өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой<sup>209</sup>” гэж заасан нь ялгаварлан гадуурхалт бол гэмт явдлын нэгэн хэлбэр болоод зогсохгүй цаашлаад зөрчил, гэмт хэргийн тохоомон шалтгаан нөхцөл гэдгийг харуулжээ.

Дээрэлхэх үзэгдэл нь хоёр буюу түүнээс дээш хүн цугласан газарт хүч, эрх мэдлээрээ дагуу нэгэн нь дутмаг нэгэнрүүгээ янз бүрийн аргаар дарамт шахалтыг давтамжтайгаар үзүүлдэг үйл явц юм. Улаанбаатар хотын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт 275 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулснаас хувийн 127, улсын 148 сургууль байна. Ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь, бүрэн дунд боловсролыг 2022-2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 166,816 сурагч төгсөж 2021-2022 оны төгсөгчдөөс 12,681-ээр буюу 8.2 хувиар өссөн байна. Бага боловсролыг 72,366 сурагч, суурь боловсролыг 60,372 сурагч, бүрэн дунд боловсролыг 34,078 сурагч тус тус төгссөн байна. Тэгвэл энэ онд буюу 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулиудад улсын хэмжээнд нийт 771.722 сурагч суралцаж байна<sup>210</sup>.

<sup>205</sup> Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>206</sup> Мөн тэнд. 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэг.

<sup>207</sup> Мөн тэнд. 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.

<sup>208</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 3 дугаар зүйл.

<sup>209</sup> Мөн тэнд. 2 дугаар зүйл.

<sup>210</sup> Боловсрол, Шинжлэх ухааны яам цахим хуудас [https://www.meds.gov.mn/statistics-industry?category\\_id=11397](https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11397).

Өсвөр насныхны дунд бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах явдал сургуулийн орчинд ил, далд хэлбэрээр их гардаг тул эрдэмтэн, судлаач нар ч мөн энэ чиглэлээр олон төрлийн судалгаа, шинжилгээ хийж байгаагийн жишээ нь ХЭҮК, Гүүб нэйборс олон улсын байгууллагатай хамтран 2017 онд явуулсан “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа бөгөөд энэ судалгааны үр дүнд 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг хэлбэрээр хүчирхийлэлд өртдөг, 36.2 хувь нь сургуулийн орчинд бусдын дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөж эрх нь зөрчигддөг гэсэн тоон мэдээ гарсан байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн 2021 оны “Дэлхийн хүүхдийн байдал 2021” тайланд жил бүр 45.800 өсвөр насны хүүхэд амиа хорлодог буюу 11 минут тутамд нэг өсвөр насны хүүхэд амиа егүүтгэж нас барж байна гэж тусгагджээ. 10-19 насны хүүхэд буюу өсвөр насныхны нас баралтын хамгийн түгээмэл шалтгаануудын тавдугаарт амиа егүүтгэх тохиолдол орж байгаа бөгөөд шалтгаан нөхцөл нь ихэвчлэн үе тэнгийн дээрэлхэлтээс үүдэлтэй<sup>211</sup> гэжээ.

Аливаа хүчирхийллийн үйлдэх түрэмгий зан үйл нь ихэвчлэн өсвөр насанд буюу бие хүн болж төлөвших явцад хамт суудаг ба хувь хүний төрөлх зан араншин гэхээс илүүтэй гэр бүл, хүрээлэн буй орчин, нийгмийн хүчин зүйлүүдийн нөлөөллөөр бий болдог.

Өсвөр насныхан бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах гэмт явдал нь бие махбод, сэтгэл зүй, эд хөрөнгөд нөлөөлөхүйц үйлдэл, үг, дохио зангаа, цахим хэлбэрээр илэрдэг ил, далд, шууд, шууд бус үйлдэл юм. Энэ насныхан дээрэлхэх, ялгаварлан гадуурхах явдлын улмаас ямар нэг байдлаар хохирол амсах явдалд дээрэлхэлтийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас үүдэн хохирогч болсноо мэдэхгүй, гарч болох сөрөг үр дагаврыг ойлгож ухамсарлаагүй байх, хүчирхийлэл үйлдэж байгаагаа тоглоом гэж ойлгох зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Дэлхий дахинд нийт сурагчдын 30 хувь нь сургуулийн орчинд дээрэлхүүлснээс үүдэн сурлагын амжилт нь буурч, сургууль завсардаж, мөн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирсон байдаг. Манай улсад сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд дээрэлхүүлсэн, хүчирхийлэлд өртсөн сурагчдын ихэнх нь өсвөр насны хүүхдүүд байжээ<sup>212</sup>.

ЮНЕСКО-оос эрхлэн хэвлүүлсэн “Тоо, баримтын цаана: Сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох нь” тайланд дурдсанаар Монгол улсын хувьд сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд дээрэлхүүлсэн, хүчирхийлэлд өртсөн сурагчдын ихэнх нь 14 настай хүүхдүүд байсан бөгөөд, 43.8 хувь нь зодоон хийсэн бол 30 хувь нь бие махбодын халдлагад өртсөн байна<sup>213</sup>.

Дээрэлхэлтэд өртөж буй объект нь эрүүгийн болон бусад хуулиар хамгаалагдсан хүний эрх бол объектив талыг криминологийн онолд тулгуурлан судлах нь үр дүнтэй. Учир нь өсвөр насандаа яваа хүүхдийн ирээдүйд их, бага хэмжээгээр нөлөөлөхүйц энэ гэмт явдал нь криминологийн дарамт, сэтгэл зүйн онолтой шууд хамааралтай. Мөн өсвөр үеийнхэн бие биеэ даган дуурайж, хэн нэгэнд дээрэлхүүлсэн бол өөрөө бусдыг дээрэлхэх зэрэг гинжин хэлхээгээр үргэлжилдэг үйлдэл тул криминологийн зан үйлийн онолтой холбон тайлбарлаж болох юм.

Өсвөр үеийнхэн бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах асуудал нь зөвхөн сургуулийн орчинд үйлдэгддэг асуудал биш бөгөөд нийгмийн бүхий л орчин тэр тусмаа цахим орчинд нилээдгүй үйлдэгддэг. Цахим хүчирхийлэл бол гар утас,

<sup>211</sup> ХЭҮК, Гүүб нэйборс ОУБ “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа. 2017.

<sup>212</sup> Цахим эх сурвалж <https://eagle.mn/r/78707>

<sup>213</sup> Юнеско, “Тоо баримтын цаана: Сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох нь” тайлан. 2019.

компьютер, таблет гэх мэт дижитал төхөөрөмж дээр гардаг дарамт, дайралтыг хэлж байгаа юм. Цахим хүчирхийлэл нь мессеж, аппликейшнуудаар эсвэл онлайн контент үзэх, оролцох, хуваалцах боломжтой олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, форумгаар илэрч болзошгүй. Цахим орчинд хүчирхийлэл дарамт үйлдэх нь “offline” буюу цахимаас бусад хэлбэрийн дээрэлхэлтээс илүү үйлдэхэд амар хялбар байдаг. Учир нь цаг хугацаа болон орон зайн саадгүйгээр шууд тухайн хүн рүү дайралт хийх боломжтой болгодог мөн нэрээ нууж болдог буюу бусдад мэдэгдэхгүйгээр сэтгэлзүйн дарамтад оруулж чадаж байгаа нь дээрэлхэгч нэгэнд улам таатай нөхцөл болдог. Цахим хүчирхийлэл нь хэн нэгний тухай сөрөг, хортой, хуурамч, бүдүүлэг агуулга илгээх, байршуулах, бусадтай хуваалцах, өөр хүний тухай хувийн мэдээллийг бусдад тарааж ичгүүр, доромжлол мэдрүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх гэх мэтээр үйлдэгддэг. Ихэвчлэн хоёр төрлийн хүмүүс бусдад дарамт үзүүлэх нь түгээмэл байдаг. Бусдын дунд нэр хүндтэй, алдартай хүмүүс болон нийгэмд гадуурхагддаг хүмүүс. Энэхүү үзэгдэл бүх л насанд тохиолдож болох ч өсвөр насны хүүхдүүд дунд илүү тохиолддог.

Үе тэнгийхэн дундаа дээгүүр байр суурьтай хүүхдийн бусдыг дээрэлхдэг шалтгаан:

- Ингэснээр бусдын дунд алдартай, нэр хүндтэй байна гэж боддог;
- Бусдыг зовоосноор өөрийгөө хүч чадалтай байгаагаар мэдэрдэг;
- Бусдын дунд байр суурь муутай хүүхдүүдийн бусдыг дээрэлхдэг шалтгаан:
- Өөртөө итгэлгүй байдалтайгаа нүүр тулахад нь тусалдаг;
- Ингэснээр үе тэнгийнхэнтэйгээ хөл нийлнэ гэж боддог;
- Гомдоосон хүмүүсээ ойлгох тал дээр муу.

Товчхондоо, бусдыг дээрэлхэгчдийн үйлдэл тэдэнд өөрсдөд нь тулгардаг асуудлаас урган гардаг. Ийм хүүхдүүдийн эцэг эх нь анхаарал халамж бага тавьдаг, хичээл сургуульдаа дуртай биш, түгшүүр, сэтгэл гутралтай байх нь түгээмэл. Тэд сэтгэл хөдлөлөө хянах, дүрэм журам дагахдаа муу.

Мөн цахим орчинд дарамт, дээрэлхэл явагддаг бусад шалтгаан:

- Нэрээ нууцлах—Цахим орчинд дээрэлхэж буй хүнтэйгээ нүүр нүүрээ харж харьцахгүй учир зориг бага шаардаж, баригдахгүй гэсэн төөрөгдөл үүсдэг.
- Үр дагаврыг бодолцохгүй байх—Хүүхдүүд хөгжилтэй гэж боддог учир цахим орчинд нэгнээ дээрэлхэж, шоглох нь түгээмэл. Дээрэлхүүлж буй хүний хариу үйлдлийг нүдээр хардаггүй учир ямар их сэтгэл зүйн хохирол учруулж байгаагаа мэддэггүй.
- Нийгмийн дарамт—Зарим хүмүүс тэдний энэ үйлдэл нь хэвийн, нийгэмд байж болох үзэгдэл гэж боддог. Найз нөхдийн нөлөө, ятгалга их нөлөөлдөг.

Цахим дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт явагддаг хамгийн түгээмэл платформд:

- Facebook, Instagram, Snapchat, Tik Tok, Youtube зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл;
- Гар утас эсвэл таблет төхөөрөмжүүд дээр зурвас бичих программууд;
- Онлайнаар зурвас илгээх;
- Reddit гэх мэт онлайн форум, чат өрөө, мэдээллийн самбар зэрэг багтана.

Түрэмгийллийг цахим орчинд хийж байгаа нь түрэмгийлэгч нэрээ нууцлахыг илүүд үздэгтэй холбоотой. Энэхүү статус нь тухайн хүнд уг үйлдлээ хийх илүү их эрх чөлөөг өгдөг ба баригдах боломж нь багасдаг гэсэн үг.

Цахим хүчирхийлэл нь өөрийн гэсэн өвөрмөц шинж чанартай байдаг. Үүнд:

- Тогтмол - Дижитал төхөөрөмжүүд нь 24 цагийн турш шууд, тасралтгүй харилцах боломжтой байдаг.

- Байнгын - Цахимаар дамжуулдаг ихэнх мэдээлэл нь холбогдох хүмүүст мэдээлэгдэхгүй, устгагдаагүй тохиолдолд олон нийтэд үргэлж нээлттэй байдаг.

- Анхаарахад хэцүү – Багш нар болон эцэг эх нь хүүхдийг цахим дээрэлхэлтэд өртөж байгааг мэдээгүй, сонсоогүй эсвэл харж чадахгүй тохиолдол байдаг.

Цахим дарамт, дээрэлхэлт, ялгавар гадуурхалт, хүчирхийллийг үйлдэж буй хүнд хүйс, нас, арьс өнгөний ялгаа гэж байдаггүй ба дарамтлагч нь хохирогчийн хариу үйлдлийг нүдээр хардаггүй учир ямар сэтгэл зүйн хохирол учруулж байгааг бодитоор мэддэггүй нь энэхүү төрлийн дарамтыг улам хүнд шатанд хүргэхэд голлон нөлөөлдөг. Цахим хүчирхийлэгч үйлдэгчийн дээрх үйлдлээ хийх шалтгааныг дотоод ба гадаад сэдэлтэй холбож тайлбарладаг. Дотоод сэдэл нь өөрийн дотоод зөрчлөө бусдад гаргах, өшөө авах, бусдаас илүү дээгүүр гэж бодох, бусдад атаархах, цаг нөхцөөх зэрэг байдаг бол гадаад сэдэл нь хохирогчийн бусдаас ялгаатай байдлыг жигших, өөрийн үйлдлийн үр дагаврыг ухамсарлахгүй байх, бодит амьдрал дээр бусадтай нүүр тулж зөрчлийг шийдвэрлэхээс эмээх зэрэг шалтгаан байж болох юм.

Хүний үндсэн хэрэгцээний нэг болох бусдаар хайрлуулах, нийгмийн нэг хэсэг байх хэрэгцээ нь өсвөр насныхныг улам ихээр цахим сүлжээнд донтуулж, эргээд тухайн хэрэгцээ хангагдахгүй байх эсвэл цахим орчин дахь хүчирхийллийн хохирогч болж, сэтгэл гутралд автах байдлыг үүсгэдэг. Ингэснээр тухайн хүн өөрийгөө бусдад хэрэггүй нэгэн, хайрлагдахгүй нэгэн хэмээн дүгнэж, бусдаас хөндийрч, зайгаа барьж эхэлдэг байна. Ингэснээр сөрөг бодол болон сөрөг сэтгэл хөдлөлийг үүсгэж ганцаардалд хүргэдэг тул эцэг эхчүүд хүүхдийнхээ ашигладаг нийгмийн сүлжээний тухай мэдлэгтэй болж, цахим дээрэлхэлтийн тухай ойлголтыг хүүхэддээ өгөх, цахим орчинд хүүхэд хэрхэн өөрийгөө хамгаалж сурах болон хэрхэн интернетийг аюулгүй ашиглах тухай ярилцах нь чухал юм.

Манай улсад интернет хэрэглэгчдийн гуравны нэг нь хүүхдүүд. Монгол хүүхдүүдийн 27 хувь нь бусдад дээрэлхүүлдгээс тал нь цахим хэлбэрийн гадуурхалт, дайралтад өртсөн байдаг. Монгол улсад цахим орчны гадуурхалт, дарамт шахалтаас болж 2012-2016 онд 92 хүүхэд амиа хорлосон судалгаа байдаг.. Мөн үндэсний суурь судалгааны дүнгээс үзэхэд, 18 хүртэлх насны хүүхдүүдийн 82.5 хувь нь үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртсөн, 37 хувь нь цахим орчинд үл таних хүмүүсээс садар самуунд уруу татсан, айлган сүрдүүлсэн чат, мессэж авч байжээ<sup>214</sup>. Японы хүүхдийг ивээх сангаас 2017 онд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль (тусгай хэрэгцээтэй хүүхдүүд суралцдаг 2 сургууль багтана) –иудаас 14 сургуулийг сонгон авч 6, 8, 10 дугаар ангийн 1236 сурагчийг хамруулж хүүхдийн эрхийн талаар мэдлэг, үе тэнгийнхний дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалт, цахим орчны аюулгүй байдалтай холбоотой судалгаа авахад 767 сурагч буюу судалгаанд оролцогчдын 62.1 хувь нь тус хичээлийн жилд дээрэлхэлтэд өртөөгүй гэсэн бол 393 буюу 31.8 хувь нь заримдаа дээрэлхүүлдэг, 75 буюу 6.1 хувь нь олон удаа дээрлэхүүлсэн, 36 буюу 15.4 хувь нь бусдад дээрэлхүүлж, доромжлуулах вий гэж санаа зовдог гэсэн байх ба хөвгүүд охидоос илүүтэйгээр үүнд санаа зовдог гэсэн байна. Мөн судалгаанд оролцогчдын 234 буюу 19 хувь нь дээрэлхэлтэд өртсөнөөс болж амиа хорлох оролдлого хийсэн, 123 буюу 10 хувь нь амиа хорлох оролдлого хэд хэдэн удаа хийж байсан, 153 буюу 12.4 хувь нь амиа хорлох талаар бодож байсан гэж хариулсан. Нийт судалгаанд оролцогчдын 1082 буюу 87.6 хувь нь цахим орчинд нэгнээ дээрэлхэх асуудлыг зогсоох арга хэмжээ авах хэрэгтэй гэж хариулсан

---

<sup>214</sup> МУИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо “Цахим орчны хүүхэд хамгаалал 2023” хэлэлцүүлэг.

байгаагаас харвал өсвөр насныхны бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах асуудал аюултай нөхцөлд хүрчээ гэж дүгнэхээр байна. Түүнчлэн, сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн төлөөх олон улсын байгууллагын хүүхдийн цахим бэлгийн мөлжлөгийн асуудлаар хийсэн судалгааны талаарх CyberTips мэдээллийн сангийн статистик мэдээнд 2019-2020 онд цахим орчин дахь гэмт хэрэг зөрчил дэлхий дахинд 28 хувь өссөн байхад, Монгол Улсад 132 хувь өссөн гэсэн тоон үзүүлэлт гарсан нь маш их анхаарал татаж байна.

2023 оны байдлаар Монголчуудын нийгмийн сүлжээний хэрэглээ “ердийн, аюулгүй, зохистой” гэдэг хэмжээнээс хоёр дахин их болсны дотор хүүхдүүдийн социал медиа, цахим платформ ашиглалт 96 хувьтай байна<sup>215</sup>. Үндсэндээ 100 хувь гэж хэлж болох энэхүү тоо баримтын цаана Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаггүй, гадны улс орон, хилийн чанадаас холбогддог цахим платформууд байгаа нь цахим орчинд үйлдэгдэж буй янз бүрийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, дарамтыг шийдэхэд бэрхшээл учруулж байгаа юм. Монгол Улс дангаараа хууль, тогтоомж мөрдүүлэх замаар энэ асуудлыг зохицуулах боломжгүй.

Нийгмийн сүлжээ ашиглаж байгаа хүүхдүүд хэт олон цагийг интернэтэд өнгөрүүлэх, хоёр буюу түүнээс олон хаяг нээх, эцэг, эхийнхээ хяналтаас зугтах, хувийн мэдээллээ дэлгэх зэргээр өөрсдийн аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг, чадваргүйгээр интернэт ашиглаж байгаа нь тулгамдаж буй асуудлын суурь шалтгаан болж байна. Хүүхэд хамгааллын тухай болон бусад хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улсын төрийн байгууллагууд тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулсаар байгаа боловч өнөөдрийн байдлаар зөрчилтэй вебсайтуудыг хаахаас өөр дорвитой үр дүн гарахгүй байна.

БНСУ, ХБНГУ, Их Британи, Австрали гэх мэт улс орнууд нь хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу цахим орчны сөрөг агуулгатай контентоос хүүхдийг хамгаалах, сөрөг нөлөөтэй контентын хандалтыг хязгаарлах, арилгах зэрэг технологийн зохицуулалт хийх чиглэлээр ихэвчлэн тухайн орны харилцаа холбооны газруудад үүрэг болгодог. Харин аливаа онлайн контентын агуулгыг хүүхдэд сөрөг нөлөөтэй мөн эсэхийг ихэвчлэн тусгайлан байгуулсан хороо, хууль зүйн яам эсвэл түүнтэй холбоотой эрх бүхий байгууллагууд шийддэг. Харин энэхүү асуудлыг Монгол улсад хэрхэн шийдэх, цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээнд зохицуулалт хэрхэн хийх вэ гэдэг асуудал бидэнд тулгарч байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.2-р заалтаар Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг тогтоож өгсөн байдаг ба энэхүү хуулийн заалтын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2013 оноос хойш [www.ekids.mn](http://www.ekids.mn) веб сайтыг ажиллуулж, цахим орчны ёс зүйтэй хэрэглээ, цахим орчинд хэрхэн аюулгүй оролцох талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг олон нийт, хүүхэд залуучуудад зориулан хийсээр ирсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим орчинд үйлдэгдэж буй хүчирхийлэлтэй холбоотой дараах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой байдаг. Үүнд:

- Хүүхэд, цөөнхийн эрх ашгийг хамгаалах;

---

<sup>215</sup> Эрхэмбаатар Ж. Цахим орчин дахь хүүхэд хамгаалал, хууль эрх зүйн орчин. Илтгэл. Уб., 2023.

- Зүй зохисгүй зар сурталчилгаа, мэдээ мэдээлэл, хүчирхийлэл, бэлгийн зан үйлийг талаар мэдээллийг хязгаарлах;
- Хүний ёсноос гажууд үйлдлээс сэргийлэх;
- Яс үндсээр ялгаварлан гадуурхах, үзэн ядах үзэл суртлыг дэмжих үзлийг сурталчлахыг зогсоох;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах. Нууц мэдээлэл алдагдах, хуурамч мэдээлэл түгээх үйлдлээс сэргийлэх, таслан зогсоох;
- Иргэний аюулгүй байдлыг хангах. Хувь хүний мэдээлэлд халдах, хувь этгээдийг интернэт ашиглан дарамтлахаас урьдчилан сэргийлэх;
- Нэр хүндэд халдахаас хамгаалах. Гүтгэлгийн шинж чанартай эсвэл бусадтай харьцуулсан сурталчилгаа хийхийг хориглох.

Харилцаа, холбооны зохицуулах хорооноос 2020 онд үндэсний хэмжээний цахим хэрэглээний судалгаа хийхэд хамрагдсан хүүхэд бүр ямар нэг байдлаар цахим орчинд хүчирхийлэлд өртөж байсан гэсэн байна. Тодруулбал, цахим орчинд хүчирхийлэлд өртөж байсан хүүхдүүдийн 53 хувь нь таньдаг хүн, сургуулийн найз нөхдийнхөө, 47 хувь нь огт танихгүй хүмүүсийн хүчирхийлэлд өртсөн гэж хариулжээ. Дээрэлхэлт нь хохирогч хүүхдийн сурах, хөгжих, эрүүл байх эрхийг ноцтой зөрчиж цаашлаад оюун санаа, бие бялдарын өсөлт, хөгжилт, амь насанд эрсдэл учруулж болзошгүй том асуудал. Ийм асуудлыг гадны олон оронд хууль тогтоомжуудаараа зохицуулдаг. Гэтэл манай улсад сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийг зохицуулсан нарийвчилсан хууль тогтоомж байхгүй. Бүр хэн хариуцах нь тодорхойгүй байдаг. Сургуулийн орчин, багш, сурагчтай холбоотой болон хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох, эрхийг хамгаалах асуудал нь БШУЯ хариуцах авч эрхийг хангах төсөв, зарцуулалт нь ХНХЯ хариуцдаг. Гэвч асуудал үүсэхэд аль ч талаас дорвитой арга хэмжээ авалгүй байсаар орхигддог тал их бий.

2019 оны 11 дүгээр сард хуралдсан ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар жил бүрийн 11 дүгээр сарын эхний долоо хоногийн Пүрэв гарагийг 05-ны өдрийг “Сургуулийн орчны хүчирхийлэл, дээрэлхэлт, цахим дарамтыг устгах олон улсын өдөр” болгон тэмдэглэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд олон сая хүүхэд, залуучуудын сурч боловсрох үндсэн эрхийг нь хязгаарлаж байгаа сургуулийн орчны дээрэлхэлт, үе тэнгийнхний дарамт шахалт болон цахим дарамтын асуудалд дэлхий нийтээрээ анхаарал хандуулж урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлж эхэлж байна.

БНСУ, Австрали, Сингапур, Финланд улс хүүхэд хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг тусгайлсан хуультай. Хуулиар дээрэлхэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх, сэтгэл зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгаж зохицуулдаг. Мөн АНУ, Герман дээрэлхэлтийн эсрэг үндэсний хөтөлбөр, бодлого хэрэгжүүлдэг. Улс орнууд ийм нарийн зохицуулалттай, үүнд чухалчлан анхаардаг байхад манайд дээрэлхэлтийг төдийлөн ноцтой зүйлд үздэггүй сургуулийн орчинд болон цахимаар үйлдсэн дээрэлхэлтийг зохицуулсан заалт байхгүй. Угаас байдаг зүйл мэт ойлголттой байдаг. Иймд нэн даруй дээрх гэмт явдлыг криминолийн шинжлэх ухаанд тулгуурлан судалж, тусгайлан зохицуулсан хууль, тогтоомж, хариуцах эзэнтэй болгох нь нэн тэргүүний шаардлага гэж үзэж байна.

### **Дүгнэлт**

1. Өсвөр үеийнхэн цахим орчинд бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах гэмт явдал нь цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудал мөн. Хүүхэд ямар нэг шалтгаанаас болж гэр бүлтэйгээ харьцахын оронд цахим хэрэглээг сонгох нь элбэг бөгөөд өсвөр насныханд насны онцлогтой хямрал явагддагаас сэтгэл

гутралд орох, түгших гэх мэт өөрчлөлтүүд гардагтай холбоотойгоор өөрийгөө тайвшруулах зорилгоор цахим орчинд байнга байх нь элбэг эсвэл ар гэрийнхэн нь тухайн хүүхдэд анхаарал халамж тавьдаггүй бол хүүхэд өөртөө цаг зарцуулж байгаа байдал нь цахим хэрэглээ болж байгаа юм.

2. Өсвөр насныхан бие биеэ дээрэлхэж, ялгаварлан гадуурхаж байгаа асуудал нь нийгмийн хөгжлийн явцад өргөжсөөр цахим хэлбэрт шилжиж байгаа нь анхаарал татсан асуудал бөгөөд энэ төрлийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, дарамтад өртсөнөөр хүүхэд сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй байх эрхээ ноцтой зөрчүүлж байна. Мөн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд олон тооны сөрөг үр дагавар авчирч, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц эрсдэлт зан үйлд татагдан орох, хүчирхийлэлд дахин өртөх, хүчирхийлэл үйлдэх, сурлагаар хоцрох, эрүүл мэндээрээ хохирох зэрэг олон төрлийн сөрөг нөлөө учирч байгаа юм. Энэ гэмт явдлын улмаас дээрэлхэлтэд өртсөн хүүхэд дангаараа биш түүний гэр бүл, найз нөхдөд ч мөн нөлөө үзүүлнэ. Үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт Монгол Улсад дутмагийн улмаас хүүхдийн эрх ашиг хангалттай хэмжээнд хангагдахгүй байгааг олон эрдэмтдийн судалгааны үр дүнгээс харж болно.

3. Мөн өсвөр насныхны бие биеэ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах гэмт явдлаас үүдэлтэй гарч буй гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллагуудаас гаргаж байгаа тоон үзүүлэлт, статистик мэдээ хэт ерөнхий байгаа нь дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

### **Санал**

1. Нийгэмд байх ёстой, байсаар ирсэн зүйл мэтээр хүлээн зөвшөөрөгдсөн энэ гэмт явдлыг таслан зогсоохын тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, талуудын хамтын ажиллагааг дэмжих, эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нарыг чадавхжуулах, цахим орчинд тулгарч буй эрсдлийн талаар хүүхдийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай.

2. Гадаадын олон улс орнуудад цахим дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалттай холбоотой сургууль бүр дотоод журам батлан мөрдөж байгаа сайн туршлагаас Монгол улсад нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна

3. 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдах үед цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал нэгэн бүлэг болж тусгагдсан боловч хэлэлцэх явцад хасагдан, хуульд тусгалаа олж чадаагүй. Цахим орчин дахь нийгмийн сүлжээний компаниуд нь технологийн зохицуулалт хийх, энэ талаар улс орнуудтай хамтран ажиллах боломжтой боловч эдгээр арга хэмжээнүүд нь цахим орчин дахь нийгмийн сүлжээний асуудлыг шийдвэрлэхэд хангалттай байж чадахгүй тул бие даасан хууль гаргаж, нарийвчилсан зохицуулалт мөрдүүлэх шаардлагатай шаардлагатай.

### **Ашигласан материал**

1. Боловсрол, Шинжлэх ухааны яам цахим хуудас [https://www.meds.gov.mn/statistics-industry?category\\_id=11397](https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11397).

2. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1.

3. МУИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо “Цахим орчны хүүхэд хамгаалал 2023” хэлэлцүүлэг.

4. Хүний эрхийн түгээмэл тунхаглал.

5. ХЭҮК, Гүүб нэйборс ОУБ “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа. 2017.

6. Цахим эх сурвалж <https://eagle.mn/r/78707>.

7. Эрхэмбаатар Ж. Цахим орчин дахь хүүхэд хамгаалал, хууль эрх зүйн орчин. Илтгэл. УБ., 2023.

8. Юнеско, “Тоо баримтын цаана: Сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох нь” тайлан. 2019.

# МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

## ORGANIZING GAMBLING CIRCUMSTANCES OF THE CRIME

**Т.Саруултөгс**

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж болон одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг үйлдэгч этгээдийн нас, хүйсийн байдал, тэдгээрт оногдуулсан ялын төрөл, хэмжээг тодорхойлох замаар эрүүгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, санал гаргахыг зорьсон.

**Abstract:** it seeks to assess and make recommendations on the criminal situation by analyzing the criminal legal nature and current situation of gambling offences, determining the age and gender of the perpetrators, and the type and extent of the punishment imposed on them.

**Түлхүүр үгс:** Мөрийтэй тоглоом зохион байгуулах, казино, эрүүгийн хууль, мэдээллийн технологи, шүүхийн шийтгэх тогтоол, дүн шинжилгээ

**Keywords:** Gambling organization, casinos, Criminal Law, Information Technology, court verdict, analysis.

“Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг 2002 оны Эрүүгийн хуульд “Мөрийтэй тоглох” гэмт хэрэг гэсэн нэрээр Эрүүгийн хуулийн 243.1 дүгээр зүйлд “Мөрийтэй тоглох”, “Мөрийтэй тоглоом зохион байгуулах”-ыг аль алиныг нь оруулж, давтан үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнээр тооцож хуульчилсан байсан. Харин 2015 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэнээс хойш Мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байгаад Эрүүгийн хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлтөөр Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг (ЭХ-ийн 20.17 дугаар зүйл)-ийг үндсэн ба хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр шинээр хуульчилсан.

Хууль санаачлагдын зүгээс мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь “Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан”-аар төгсдөг, хүндрүүлэх бүрэлдэхүүн нь “Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан” үеэс төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байдлаар хуулийг баталсан байна.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулсан” гэж хүн ам олноор цуглардаг үзвэр, үйлчилгээний нийтийн зориулалттай газар, эсхүл мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан ашиг хонжоо олох зорилгоор шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ, электрон хэрэгсэл зэрэг мөрийтэй тоглох зориулалтаар өрөө, тасалгаа, тоног төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог тоглоомын хууль бус орчныг бүрдүүлснийг ойлгоно.

Эрүүгийн хуулийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг нь хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, ажиллуулсан шинжийг агуулдаг. Монгол улсын хуулиар хориглосон мөрийтэй тоглоом бол казино юм. “Хуульд өөрөөр

заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно”<sup>216</sup> гэж заасан.

“Казино” гэж үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулдаг зориулалтын өрөө, тасалгаа, танхим бүхий мөрийтэй тоглоомын газрыг хэлнэ. Монгол улсын нутаг дэвсгэр дээр казино байгуулсан, ажиллуулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх юм. Казино тоглуулах, түүнийг зохион байгуулах зорилгоор хууль бусаар слот машин (мөнгө, түүнийг орлогч токенос хэрэглэж тоглодог электрон хэрэгсэл), слот машин тоглуулахад хэрэглэдэг мөнгө орлогч металл, чип (хуванцар зоос) казиногийн ширээ, бусад тоног төхөөрөмж хийх, олж авах нь түүнийг зохион байгуулсан гэдэгт хамаарна.<sup>217</sup>

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2020 оны хуулийн төслийн танилцуулга болон үзэл баримтлалд “Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дарамт учруулах, гүтгэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах зэрэг гэмт хэргийг тусгах, зарим гэмт хэргийн шинжийг ерөнхий ангид заасан нэр томъёотой нийцүүлсэн” гэж тухайн зохицуулалтын талаар дурдсан байна<sup>218</sup>. Уг төслөөр хамгийн анх “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг:

1. “Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”;

2. “Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”<sup>219</sup> гэх хэлбэртэйгээр санаачилжээ.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйл нь анхны төслөөс “Мэдээллийн технологи ашиглан” үйлдэж болох үйлдлийн аргаар болон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялын хэмжээ өөрчлөгдөж хуульчлагдсанаар ялгаатай байна.

Цагдаагийн байгууллагаас 2021 онд нийт 735 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 189 хэргийг шүүхэд шилжүүлж, 7 хэргийг нэгтгэж, 83 хэргийг хааж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Тухайн жил шинээр 686 хэргийг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна<sup>220</sup>.

2022 онд нийт 472 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 45 хэргийг шүүхэд шилжүүлж, 6 хэргийг нэгтгэж, 111 хэргийг хааж

<sup>216</sup> Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль. Уб., 1999. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5. 1 дүгээр зүйл.

<sup>217</sup> Галдаа Б. Эрүүгийн эрх зүй /ерөнхий, тусгай анги/. Уб., 2021. 392-393 дахь тал.

<sup>218</sup> Энххүслэн О. Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийн зүйлчлэл, нөхцөл байдал, түүнд хамаарах асуудал. Уб., 2022. 2-3 дахь тал.

<sup>219</sup> Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Уб., 2019.


<sup>220</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2021. Уб., 2022. 78 дахь тал.

шийдвэрлэсэн байна.Тухайн жил шинээр 85 хэргийг үүсгэж мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна<sup>221</sup>.


Монгол Улсын хэмжээнд 2020-2024 оны хоорондох хугацаанд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” 259 гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна<sup>222</sup>.

Гэмт хэргийн давхар зүйлчлэлийн тухайд авч үзвэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Мөнгө угаах)-2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Залилах)-1, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах)-1, нийт-4 гэмт хэргийг давхар зүйлчилж шийдвэрлэжээ.

Зураг 1.



Зураг 2.



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргүүдээс Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 252 гэмт хэрэг буюу нийт шийдвэрлэсэн гэмт хэргийн 97.2 хувь, Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 7 гэмт хэрэг буюу нийт эцэслэн шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 2.8 хувийг шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчилж 2023 оноос 2024 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд эцэслэн шийдвэрлэсэн 26 гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж 2020-2023 оны хоорондох хугацаанд эцэслэн шийдвэрлэсэн 7 гэмт хэргийг сонгон авч нийт 33 гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоолтой уншиж, танилцан ял шийтгэгдсэн этгээдийн нас, хүйс, оногдуулсан ял шийтгэлийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн арга хэлбэр болон гэмт хэрэг үйлдэж олсон ашиг орлогын талаар дүн шинжилгээг хийсэн.

<sup>221</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022. УБ., 2023. 108 дахь тал.

<sup>222</sup> Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://www.shuukh.mn/>.

Зураг 3. Яллагдагчдын нас

| Нас               | Тоо | Эзлэх хувь |
|-------------------|-----|------------|
| 19-22             | 7   | 15.9       |
| 23-26             | 7   | 15.9       |
| 27-30             | 6   | 13.6       |
| 31-34             | 2   | 4.5        |
| 35-38             | 3   | 6.8        |
| 39-42             | 1   | 2.2        |
| 43-46             | 1   | 2.2        |
| 47-55             | 1   | 2.2        |
| 56-64             | 2   | 4.5        |
| (нас бичигдээгүй) | 14  | 31.8       |

Зураг 4. Хүйсийн байдал



Нийт 33 гэмт хэргээс анхан шатны шүүхээс 32 гэмт хэрэгт 40 эрэгтэй, 4 эмэгтэй хүнийг гэм буруутайд тооцож ял оногдуулсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилсэн 1 гэмт хэргийг цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2023 оноос хойш шийдвэрлэгдсэн 33 гэмт хэрэгт 20,000-338,751,000 төгрөгийн хооронд ойролцоогоор нийт 1.1 тэрбум гаруй төгрөгийг гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус ашиг орлого хэмээн үзэж, улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна.

Зураг 5. Ял шийтгэгдсэн этгээдийн хүйсийн байдал

| Ялын төрөл                     | Тоо | Эзлэх хувь |
|--------------------------------|-----|------------|
| Зорчих эрхийг хязгаарлах ял    | 4   | 12.5       |
| Торгох ял                      | 25  | 78.1       |
| Хорих ял                       | 1   | 3.1        |
| Хорих ял оногдуулахгүй тэнссэн | 2   | 6.2        |

Зураг 6. Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдал

| Арга хэлбэр                                     | Тоо | Эзлэх хувь |
|-------------------------------------------------|-----|------------|
| Цахим сайт, домайн хаяг ашигласан               | 3   | 9.3        |
| Гар утасны апплекейшн ашигласан                 | 14  | 43.7       |
| Фэйсбүүк хаягаар лайв хийж шоо, хөзөр ашигласан | 9   | 28.1       |
| Зочид буудалд хасаа, хөзөр ашигласан            | 2   | 6.2        |
| Гэр орон, сууцанд хасаа, хөзөр ашиглаж          | 4   | 12.5       |

Дээрх судалгаанаас дүгнэхэд, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хүмүүсийн 45.4 хувь нь 19-30 насны буюу залуу үеийнхэн үйлдэж, гэмт хэрэг үйлдсэн арга хэлбэрийн 81.1 хувийг мэдээллийн технологи ашиглан үйлдсэн байгаа нь тус гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход олон улсын туршлагыг нэвтрүүлэх, техник технологийн ололт амжилтыг үр дүнтэй ашиглах хэрэгцээ шаардлага үүссэнийг харуулж байна.

### Дүгнэлт

1. Технологийн дэвшлийн нөлөөгөөр гар утасны программуудаар дамжуулан цахим платформуудыг ашиглан цахим тоглоом тоглох боломжтой болсноор энэ зах зээл хурдацтай тэлж байна. Түүнчлэн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хүмүүс хөл хорионд орж, хоорондоо биечлэн

харилцах нь багассанаас болж гэрээс гаралгүй чөлөөт цагаа өнгөрөөх нэг хэлбэр нь цахимаар тоглоом тоглох болсон.

2. Монгол улсын хувьд 2015 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээс хойш Мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байгаад Эрүүгийн хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэж оруулан гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Тус зүйл заалтад “Мэдээллийн технологи ашиглан” үйлдэж болох үйлдлийг аргыг тусгасан нь цахим мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн.

3. Судалгааны ажлын хүрээнд “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоолуудын тодорхой хэсэгт дүн шинжилгээ хийхэд гэмт хэрэг үйлдсэн арга хэлбэрийн 70 орчим хувийг цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн байна. Иймд дээрх шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход олон улсын туршлагыг нэвтрүүлэх, техник технологийн ололт амжилтыг үр дүнтэй ашиглах хэрэгцээ шаардлага үүссэнийг харуулж байна.

### **Санал**

1. Ард, иргэдэд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг, түүнээс үүсэх хор хоршиг, тухайн гэмт хэргийн нийгэмд учруулж буй аюулыг ойлгон таниулах талаар соён гэгээрүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах;

2. Тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын сайн туршлагыг судлан нэвтрүүлэх;

3. Цагдаагийн байгууллагаас мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах зэрэг санал гаргаж байна.

### **Ашигласан материал**

1. Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль. УБ., 1999. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №5.

2. Галдаа Б. Эрүүгийн эрх зүй /ерөнхий, тусгай анги/. УБ., 2021.

3. Энххүслэн О. Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийн зүйлчлэл, нөхцөл байдал, түүнд хамаарах асуудал. УБ., 2022.

4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. УБ., 2019.

5. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2021. УБ., 2022.

6. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022. УБ., 2023.

7. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://www.shuukh.mn/>.

# ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

### THEORY AND METHODOLOGY OF LEARNING SOME PROBLEMS

*Д.Бямбахүү  
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн  
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,  
цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүхий л шатанд боловсролын онол, арга зүй асуудал, орчин үеийн мэдээлэл технологийн дэвшилд суурилсан сургалтын хэрэгцээ нэмэгдсээр байна. Олон улсын судалгаа, туршлагаас харахад сургалтын хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэхэд онол, арга зүй, хандлага нэн чухал хүчин зүйл болж байна. Иймээс энэхүү өгүүлэлд сургалтын онол, үзэл баримтлалын талаарх судлаачдын үзэл баримтлал, олон улсын жишиг, чиг хандлагын талаар авч товч үзлээ.

**Abstract:** Due to the trends of global development and the current situation, the need for education based on the theory and methodology of education at all levels and the advancement of modern information technology is increasing. According to international research and experience, theory, methodology and attitude are very important factors in successful implementation of training methods. Therefore, in this article, we have briefly discussed the views of researchers, international standards and trends regarding the theory and concept of education.

**Түлхүүр үгс:** Онол, сургалт, арга зүй, сургалтын технологи, суралцагч, хөгжил.

**Keywords:** Theory, training, methodology, learning technology, learner, development.

Мэдлэг олгох үйл нь хүн төрөлхтний түүхтэй хамт урт цаг хугацаанд хөгжин ирсэн бөгөөд "...неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед...өсвөр үеийнхээ хүүхдүүдийг өдөр тутмын ажил, амьдралын практикт дагуулж, оролцуулдаг"<sup>223</sup> байснаас эхлэн сургалтын хөгжлийн түүхийг судлаачид эхлүүлсэн гэж тооцдог байна. Улмаар хүн төрөлхтөн нийгэмшиж, ажил хөдөлмөрийн хуваарь, бичиг үсэг үүсэж, хүүхэд багачуудыг харилцан ялгаатай зүйлд сургах шаардлага бий болсноор "...МЭӨ IV зууны үед анхны сургууль үүсжээ."<sup>224</sup>

Орчин үеийн сургалтын онолын хөгжил нь Бихевиеризмын онол үзэл баримтлалаас Когнитив, Конструктивизмын онолын чиг хандлага давамгайлах байдалтай байна.

Бихевиористүзлийн дагуу "...хүрээлэн байгаа орчны гадаад хүчин зүйлд идэвхгүйгээр хариу үзүүлэх үйлдлийг мэдлэг..." [[photos.state.gov/libraries/mongolia/](https://photos.state.gov/libraries/mongolia/)] гэж нэрлэдэг байна.

<sup>223</sup> Батхуяг С, нар. Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй. УБИС. УБ., 2003. 148. 13 дахь тал.

<sup>224</sup> Мөн тэнд. 14 дэх тал.

Суралцагч хүрээлэн буй орчны өөрчлөлтөд хариу өгч дасан зохицох буюу сургалт нь хэвшсэн шинэ зан төлөвийг харуулсан идэвхгүй үйл явц гэж үздэг.

Бихэвиорист онолоор сургалтын үр дүнг голлон чухалчилж хүний амьтантай адилтгаж, дасгал сургууль хийлгэснээр сургаж болно гэж үздэг байна. Энэхүү онол нь 20-р зууны эхээр үүсэж дэлгэрсэн бөгөөд "...хүний оюун ухаан, тархинд таагдашгүй үйл, бодол санаа агуулагдаж, түүнийг олж илрүүлж боломжгүй учраас харанхуйгаар хандахаас өөр аргагүй гэж судлаачид үзсэн байна."<sup>225</sup>

Иймээс үйл хөдлөл нь оюун ухаан шиг нуугдмал биш, ил тод, хэн ч ажиглан судалж, тодорхойлох боломжтой гэсэн онол юм.

Бихэвиорист онолын агуулгыг дараах 2 хэлбэрээр загварчилдаг байна. Үүнд:

1. Өдөөлт буюу стимул;
2. Хариу үйлдэл буюу реакц тус тус болно.

Бихэвиорист үзэл баримтлалын дагуу сургалтын онолыг Монголын боловсрол судлалын эрдэмтдийн тодорхойлсноор "Багш төвтэй мэдлэг дамжуулах сургалт, уг сургалтын технологийг гадны удирдлагаар суралцахуй" буюу уламжлалт сургалтын онол гэдэг байна.

Когнитив буюу танин мэдэхүйн үзэл нь хувь хүний оюун ухаанд байгаа бэлгэдлийн чанартай оюун санааны төсөөллийг мэдлэг хэмээн тодорхойлдог.

Энэ үзлийн дагуу оюун ухааны идэвхтэй боловсруулалт хийх үйл явц болоод мэдээлэл боловсруулалтад анхаардаг байна. Хувь хүний зан төлөвт гарч байгаа өөрчлөлтийг анхааран үзэх боловч түүнийг хүний оюун ухаанд гарч буй өөрчлөлтийн илэрхийлэл гэж үздэг.

Мэдлэг нь өгөгдсөн хүчин зүйл бөгөөд туршлагын явцад дахин бүрэлддэг гэж үздэг байна. Уг онолоор "...Хүн эхлээд доод түвшний дараа нь дээд түвшний ойлголтыг танин мэдэх боломжтой гэж үздэг"<sup>226</sup>. Зохион байгуулагдсан мэдлэг гэдэг нь хүний ертөнцийг ойлгох ойлголтыг харуулсан хийсвэр оюун ухааны хэсгүүдийн нэгдмэл бүтэц бөгөөд энэ хандлагын дагуу суралцагчид бүдүүвч схем гарган, өөрийн санаануудаа нэгтгэн холбох ёстой юм байна.

Энэхүү үзэл баримтлал, онолын гол төлөөлөгч нь Швейцарын эрдэмтэн Жан Пиаже бөгөөд "...орчин нөхцөлийн өдөөлтийн үр дүнд олсон амжилтыг бэхжүүлэх онолоос илүүтэйгээр сурагчийн хувийн үр бүтээлчээр эзэмшсэн мэдлэг боловсрол чухал үзэж байжээ.

Судлаач хүүхдийн хөгжлийн үе шатыг "...гадаад орчныг мэдрэн хүлээн авах үе шатаас эхлээд бодит орчноос сэдэлтэй үйл ажиллагаанд шилжин эцэст нь албан ёсны оюуны үйл ажиллагааны түвшинд хүрч очих дарааллыг дамжина..." гэсэн дараах 4 үе шатыг дамжина гэж тодорхойлжээ. Үүнд:

1. Хүртэх хөдөлгөөний үе шат;
2. Оюуны үйлдэл төлөвшлийн өмнөх үе шат;
3. Тодорхой үйлдэл төлөвших үе шат;
4. Хийсвэр үйлдэл төлөвших үе шат тус тус болно.

Хүртэх хөдөлгөөний үе шат нь 2 нас хүртэлх хугацаанд үргэлжлэх бөгөөд хүүхэд эхийн сүүгээ хөхөхөөс эхлээд юм авах, халуун хүйтэн, хатуу зөөлнийг мэдрэх үйлдлийнхээ үр дүнг мэдэрч ойлгож эхэлдэг хэсгийг авч үздэг байна"<sup>227</sup>.

Оюуны үйлдэл төлөвшлийн өмнөх үе нь 2-7-н насны хооронд үргэлжлэх бөгөөд хүүхдийн анхан шатанд мэдэрч ойлгосон эд юмстайгаа харьцаж, хэрэглэхэд суралцаж, хэл яриа нь хөгжих, тоглож сурах эхний суурь нь тавигддаг.

<sup>225</sup> <http://physicsdida.blogspot.com/p/resource.html>.

<sup>226</sup> <http://www.edub.edu.mn/v/>.

<sup>227</sup> <http://mnutulgatan.blogspot.com/2015/04/3.html>.

Гэвч тэдний бодол санаа нь хараахан бүрэн ухаарлын шинжтэй болдоггүй гэж үзсэн байна.

Тодорхой үйлдэл төлөвших үе шат нь 7-11 насны хугацаанд үргэлжлэх бөгөөд аливаа юмсын учир шалтгааныг олох гэж оролдож, ангилан ялгах чадвар сууж эхэлдэг боловч бодол санаа нь бодит ахуй нөхцөлөөс хамааралтай хэвээр, өөрөөр хэлбэл хийсвэр сэтгэлгээ нь хөгжөөгүй байдаг.

Хийсвэр үйлдэл үе шат нь 11 наснаас эхлэн төлөвших бөгөөд энэ үед хүүхдийн хийсвэр бодол сэтгэлгээ хөгжиж эхлэн урьд хэрэглэж сурсан боловч зүй тогтол, учир шалтгааныг нь бүрэн ойлгодоггүй байсан бодит зүйлийг танин мэдэж эхэлнэ. Аливаа зүйлээс гарч болох сайн үр дүн, муу үр дагаврыг олон талаас нь ялган ухаарахад суралцах чадамжтай болдог байна.

Танин мэдэхүйн онолын энэхүү ангилалт нь хэдийгээр хүүхдийн хөгжлийн орчин, нөхцөл байдлаас хамаарч хугацааны хувьд хувьсах болон цаашид үргэлжлүүлэн ангилах шаардлага үүсэж болох талтай ч сургалтын технологи нь хүний оюуны хөгжлийн төвшинтэй салшгүй уялдаатай байх зүй тогтлыг тодорхой болгосноор ач холбогдолтой юм.

Жан Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн тухай үзэл онол нь “...биологийн дасан зохицохын үзэл дээр үндэслэн амьтад байгаль орчиндоо дасан зохицдог шиг хүүхдийн оюун ухаан орчин ахуйдаа зохицон дэлхий ертөнцийн амьдралын асуудлыг бодит орчныхоо сэтгэлгээгээр шийдвэрлэдэг...” бөгөөд тухайн “...хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшин, багтаамж, хуримтлуулсан мэдлэг туршлага, нөгөө талаас хүүхэд оюун ухаан, сэтгэлгээгээ шинэ мэдлэг туршлагаар баяжуулан хөгжүүлэх үйл явц хоёрын хоорондох зохицох замаар хөгжил явагддаг гэж үзжээ<sup>228</sup>.

Тиймээс “...оюун ухааны хөгжлийн түвшин, багтаамж буюу акомодаци, оюун ухаанаа баяжуулан хөгжүүлэх боломж буюу асимилияц...”[www.stf.mn] гэсэн хоёр хамааралтай үйл явцаас хүний оюуны хөгжил тодорхойлогдох бөгөөд “...тухайн сурагчийн оюуны хөгжлийн төвшин, чадвар болон хун төрөлхтний нээж олсон амжилт, туршлага, мэдээллийн цар хүрээ зэргийн тэнцвэрт байдал, зохицлын үйл явц гэж дүгнэж болно.

Монголын эрдэмтэд хүний үйл ажиллагаа нь байгаль нийгмийн орчны шууд нөлөөгөөр үүсэн хөгжиж байгаа нь орчиндоо дасан зохицох үйл явц гэж үзсэн бөгөөд ассимилияц гэдэг “...хүн орчныхоо нөлөөллийг өөртөө буй боломжийн хирээр хувирган зохицох...”, аккомодаци гэдэг нь “...хүн өөрөө өөрчлөгдөж орчиндоо дасан зохицох...” гэж тодорхойлсон байна<sup>229</sup>.

Ийнхүү Жан Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онол нь аливаа мэдлэг мэдээллийг хүлээн авч эзэмших нь тухайн сурагчийн танин мэдэхүйн төвшин чадвараас хамааралтай. Хэрэв мэдлэгийг хүлээн авах төвшин чадвар нь шинэ мэдлэгийн цар хүрээнээс доогуур төвшинд байвал тэнцвэрт байдлын зөрчил гарч, суралцагчаас сэтгэлгээний илүү өндөр төвшин, чадвар шаардагдаж, мэдлэгээ тэлэх хэрэгцээ үүснэ гэсэн агуулгаар тайлбарласан байна.

Танин мэдэхүйн онолын агуулга, Жан Пиажегийн оюуны хөгжлийн ангилалтыг шүүмжлэх судлаач нар байдаг хэдий ч түүний сурах үйл явцын онолд, ялангуяа сургууль, танхимын сургалтад хүчтэй хувьслын нөлөөлөл бий болгосныг нийтээр хүлээн зөвшөөрдөг байна.

Сургалтын хөгжлийн суурь онолуудын нэг нь Конструктивизмын чиг хандлага бөгөөд “Construction” буюу байгуулах гэсэн латин үгнээс гаралтай юм.

---

<sup>228</sup> <https://ru.wikipedia.org/>.

<sup>229</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам. Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр. Монгол хэл, уран зохиолын хичээлийн технологийн шинэчлэл. Уб., 2000. 96 дахь тал.

Энэхүү онолыг баримтлагч эрдэмтэд мэдлэг гэх ойлголтыг “...хувь хүн өөрийн туршлага хийгээд сургалтын үйл явцад бий болгодог бүхэл бүтэн цогц зүйл...” гэж тодорхойлсон. Онолын зарчмаар хүн өөрийн туршлагадаа үндэслэн ертөнцийг үзэх үзлээ төлөвшүүлдэг бөгөөд энэ нь суралцагсад юуг хэрхэн яаж шинээр бүтээлчээр сурч эзэмшиж байна гэдэгт анхаарал хандуулдаг.

Тухайн сурагчийн сурч эзэмшсэн мэдлэг чадвар, хүсэл сонирхол л сургалтын нэн тэргүүнд тавигдах чухал зүйл бөгөөд сургалтын зорилгыг тодорхойлох суурь үндэслэл болдог гэж үздэг.

Тиймээс суралцагч өөрийн сонголт, хүсэл ба хэрэгцээ шаардлагын хүрээнд өөрийн идэвхтэй үйлдлээр мэдлэгээ бүтээх ба сургалтын үнэлгээ үр дүнг суралцагч мэдлэгээ хэрхэн бүтээж буй явц, аргачлалд чиглүүлэн тодорхойлох шаардлагатай болно.

Конструктивизмын онолын чиг хандлагаар мэдлэг бүтээх үйл ажиллагааг дараах байдлаар хоёр хуваан авч үздэг байна. Үүнд:

1. Классик шинжтэй буюу ажиглалт хийлгэх, харилцан ярилцах, тайлбарлах, турших замаар тусгай болон ерөнхий чадварыг хөгжүүлэх;

2. Прагматик шинжтэй буюу амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх байгаль, нийгмийн энгийн болоод нийлмэл тодорхой үзэгдлийг тайлбарлуулах тус тус болно.

Конструктивист онолыг баримтлагч эрдэмтэд суралцагч, суралцах явцдаа шинэ төлөвлөсөн мэдлэг амжилттай сурахын үндэс нь сургуульд элсэхээсээ өмнө тухайн чиглэлээр суурь мэдлэг, тодорхой хуримтлуулсан туршлагатай байх шаардлагатай бөгөөд тэрхүү мэдлэг, туршлага дээр нь суурилсан сургалт илүү үр бүтээлтэй гэж үзэж, анхан шатны суурь мэдлэгт маш их ач холбогдол өгдөг байна. Энэ нь “...сурагчид багшийн өгч буй мэдээллийг өөрийн өмнөх эзэмшсэн суурь боловсрол дээр үндэслэн ойлгож хүлээн авснаар, багшийн зааснаас арай шинэлэг, өргөн цар хүрээтэй мэдлэгийг өөртөө бүрдүүлэн авч чаддаг...” гэсэн тодорхойлолтод үндэслэгдэж байгаа юм.

Конструктивист онолоор сургалтын нь сургалцагчийн хэрэгцээнд нийцсэн байх бөгөөд суралцагчаас зорилготой суралцаж, өөрийн өмнөх суурь мэдлэг, туршлага, тухай чиглэлийн ерөнхий ойлголт дээрээ шинээр сурч буй мэдлэгээр баяжуулан өөрийгөө хөгжүүлнэ гэсэн зарчимтай байгаа нь Монгол Улсын өнөөдрийн боловсролын зорилготой нийцсэн бөгөөд бага боловсрол нь бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааны үндсэн суурь болохыг илэрхийлж байна гэж үзэж байна.

Сургалтын онолын чиг хандлагын агуулгыг судлаач “...Жорж Хейн конструктивист онолчдын гаргасан үзэл санаанаас шүүн тунгааж, суралцагсдад зориулан дараах есөн гол зарчмыг тодорхойлон гаргаж санал болгосон байдаг. Үүнд:

1. Суралцана гэдэг бол сурагч авч буй мэдээллийн (өдөөлт) утга учрыг үр бүтээлчээр судлах идэвхтэй үйл явц;

2. Нэгэнт та суралцахаар шийдсэн бол аливаа мэдээлэл, түүний утга учрыг ойлгохдоо сурах арга барилд суралцана гэсэн үг;

3. Суралцах үйл явц нь оюуны үйл ажиллагаа;

4. Суралцах үйл, хэл хоёр нягт холбоотой;

5. Суралцах гэдэг нь нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа бөгөөд бусадтай хэрхэн харилцаж байгаагаар илэрдэг;

6. Сурах гэдэг нь өмнөх ба одоогийн хамарсан цогц шинжтэй. Бидний урьдын мэддэг бүх зүйл, итгэл үнэмшил маань олж авч буй шинэ мэдлэгтэй харилцан шүтэлцэнэ;

7. Өмнөх суурь мэдлэг бол суралцахын үндсэн нөхцөл байдаг;

8.Суралцах үйл явц нь олж нээсэн мэдлэг, ойлголтоо дахин давах хэлбэрээр дадал чадвар болгох урт удаан хугацааны үйл явц юм;

9.Сурагчдад сэдэл тэмүүлэл төрүүлэх нь амжилттай суралцахын гол түлхэц юм.

Сургалт нь шинэ туршлага эзэмшихийн тулд хүн өөрийн оюун ухааны загвараа өөрчлөн нийцүүлэх үйл явц юм. Констрактивист онолчид тодорхойгүй нөхцөл байдалд суралцагч асуудал шийдэх чадвартай болох хэрэгтэй гэж үздэг бөгөөд дараах хоёр чиглэлтэй гэж үздэг байна. Үүнд:

1. Хувь хүний хөгжлийн чиглэл;
2. Нийгмийн харилцааны хөгжлийн чиглэл тус тус болно.

Сургалтын талаарх дээрх үзэл баримтлалуудын дэвшилтэд санаа, аргачлалын бага боловсрол олгох сургалт, сургалтын технологийг боловсронгуй болгох үндэслэл болох бөгөөд зохимжтой хувилбараар ашиглах шаардлагатай юм. Бихэвиористууд нь үйл байдлын холбоотой сургалтын зорилтуудыг томъёолох, дасгалын дэвтэр гаргах, компьютерийн тусламжтай явуулах сургалт, институтын шинжтэй өвөрмөц тусгайлсан сургалтуудад голчлон нөлөө үзүүлнэ.

Когнитивист онол нь онолын үзэл баримтлалуудыг ашиглах, хөтөлбөр боловсруулах болоод сургалтын хэлбэрүүдийг тодорхойлоход ач холбогдолтой.<sup>53</sup> Констрактивист онолын санааг хамтын сургалт, онлайн шууд сургалт болоод аливаа асуудалд анализ хийн үнэлэлт дүгнэлт өгөх явцад ашигладаг байна<sup>230</sup>.

Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг даган 1990 оны эхэн үеэс нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлтийг хийж эхэлсэн бөгөөд энэхүү шинэчлэлт нь боловсролын салбарыг тойроогүй билээ. Боловсролын салбарын шинэчлэлийн ажлын хүрээнд шийдвэрлэгдэж байгаа нэг чухал асуудал сургалтын технологи юм.

Сургалтын технологи хэмээх ойлголт Сурган хүмүүжүүлэх ухааны тулгуур ойлголтын нэг юм. 1950-иад оноос эхлэн "технологи" гэсэн үгийг Сурган хүмүүжүүлэх ухааны ном, сурах бичигт хэрэглэх болсон байна. Гэвч энэ үеэс эхлэн сургалтад "технологи" бий болсон гэсэн үг хараахан биш юм. Учир нь урьд өмнөх үеийн сургалтад технологи байсан ба Сурган хүмүүжүүлэх ухааны хөгжил энэ үгийг хэрэглэх түвшинд хараахан хүрч чадаагүй байсан гэж үзэж байна. Жишээ нь, шавь төвтэй сургалтын технологи, төсөлт хичээлийн технологи, сурагчдаар мэдлэг бүтээлгэх сургалтын технологи гэх зэрэг.

1950-1960-аад оны үед өндөр хөгжилтэй улс орнууд сургалтаа чанартай болгохын тулд сургалтад орчин үеийн техникийн ололт амжилтыг ашиглаж эхэлсэн ба үүнийгээ "Сургалтын технологи" хэмээн нэрлэсэн байна. Сургалтын технологийн суурийг анх Б.Скиннер, С.Пресс, Э.Торндайк, Б.Блумзэрэг эрдэмтэн судлаачид тавьсан байна<sup>231</sup>.

Сургалтын технологи гэдэг ойлголт нь боловсрол судлалын ухаанд нэлээд хожуу нэвтэрсэн ойлголт бөгөөд өнөөдөр дэлхий дахинд боловсролын бодлогыг үндэс, боловсрол сургалтын төвшнийг тодорхойлох хэрэгсэл болсон байна.

Сургалтын технологи бол тогтолцоот шинжтэй процесс гэсэн санаа илүү агуулагдаж байна. Тэгэхлээр сургалтын технологи нь дараах бүрдэл хэсэгтэй гэж үзэж болох юм. Үүнд сурган хүмүүжүүлэх ухааны эрдэмтэн, судлаачдын тодорхойлсноор сургалтын технологи нь сургах, суралцах үйлийн үр ашигтай, оновчтой хувилбаруудын зүй тогтолтой, дэс дараалал байна гэж хэлж болох юм. Тэгэхээр хичээлийн технологи нь багш сурагчийн хамтарсан тухайн хичээлийнхээ

<sup>230</sup> Даваа Ж., Эрдэнэчимэг Ш нар. Дээд сургуулийн сургалтын технологи. УБ., 2016. 160 дахь тал.

<sup>231</sup> Сургалтын технологийн шинэчлэл. Эмхэтгэл. УБ., 1999. 94 дэх тал.

агуулгад тулгуурласан танин мэдэх үйл, үйлдлийн оновчтой дэс дараалал байна гэж ойлгож болох юм.

Дээд боловсролын байгууллага бол оюун ухаан, мэдлэг чадвар, хүмүүжлийн цогц “бүтээгдэхүүнийг” үйлдвэрлэж, үйлчилгээ явуулдаг онцгой маягийн үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, харин энэ үйлдвэрлэл нь олон янзын хэрэглэгч бүхий зах зээлтэй бөгөөд, тэдний хэрэгцээг хангах өөрийн гэсэн арга технологитой байдаг юм байна. Сургалт бол нийгэм-түүхийн туршлагыг хойч үедээ дамжуулах үйл явц буюу тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлэх явц юм.

Сургалт-мэдлэг, чадвар, төлөвшлийн чанарын өөрчлөлт болох суралцхуйг хэрэгжүүлдэг зохион байгуулалтын тогтолцоо-суралцах, сурахуйн нэгдэл юм. Иймд сургалт нь мэдлэг, чадвар, дадлыг дамжуулах, үйл явц, түүнчлэн тасралтгүй боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах танин мэдэх үйл ажиллагааны арга ч гэж үзэж болох юм.

Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг даган 1990 оны эхэн үеэс нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлтийг хийж эхэлсэн бөгөөд энэхүү шинэчлэлт нь боловсролын салбарыг тойроогүй ба Монгол Улс ардчилал зах зээл, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн хүмүүнлэг ардчилсан иргэний нийгэм байгуулах зорилт дэвшигдсэнтэй холбоотой Монголын боловсролыг хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх өөрийн болон улс үндэстний соёл иргэншлийн нийтлэг үнэт зүйлс, дэвшилтэт ёс заншил, орчин үеийн шинжлэх ухааны ололтуудад тулгуурласан байх үндсэн зарчимтай болжээ. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 онд, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай багц хуулиудыг шинэчлэн найруулж, Мэргэжлийн боловсролын тухай хуулийг шинээр Монгол Улсын Их Хурлаас 2006 онд батлан гаргасан байдаг.

Сургалтын технологи хэмээх ойлголт Сурган хүмүүжүүлэх ухааны тулгуур ойлголтын нэг юм. Судлаач В.П. Беспалько “Сургалтад дэвшигдэн гарч буй зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, сургалтыг зохион байгуулах арга, хэлбэр, хэрэгслийн дэс дарааллыг сургалтын технологи” гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолтод сургалтын технологи бол тогтолцоот шинжтэй процесс гэсэн санаа илүү агуулагдаж байна.

Сургалтын технологийг боловсруулахад боловсролын салбарт баримталж буй төрийн бодлого, үзэл онол, сургалтын үндсэн үүрэг, онцлог, нөөц боломж, давуу тал, бодит бэрхшээлүүд, багшлах боловсон хүчний чадал чансаа, ур чадварын түвшин, сурагчдын сурах чадавх, сургуулийн уламжлал зэрэг хүчин зүйлийг мөн давхар харгалзан үзнэ.

Сургалтын технологийг боловсруулж амжилттай хэрэгжүүлэхийн тулд мөрдвөл зохих зарчмын чанартай хэд хэдэн нийтлэг шинжтэй зүйл байна. Үүнд:

- Сургалт нь хэрэгцээнд тулгуурласан байх;
- Сургалтын зорилго, зорилт тодорхой, ойлгомжтой, хоёрдмол санаагүй байх;
- Агуулгын багтаамж, сургалтын цаг, хугацаа тохирч байх;
- Сурагчдын туршлага, мэдлэг бүтээх үйл ажиллагаанд тулгуурласан байх;
- Сургалтын явц, үр дүнг бодитой харуулах тест, бүтээлч даалгавар зэрэг тус тус болно.

Сургалтын үр дүн нь сургалтын үйл явцаас шууд шалтгаалдаг нь сургалтын технологийн ач холбогдлыг илэрхийлж байна гэж үзэж болох юм. Сургалтын технологийн дээрх агуулгаас үндэслэн сургалтыг үүсэн бий болж болзошгүй хилийн цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэн зохион байгуулахад чухал хэсэг нь “Сургалтын хэлбэр”

юм. Сургалтын хэлбэрийг сургалт явагдах зохион байгуулалт, хичээл сургуулийн бүтэц, түүнийг явуулах газар, үргэлжлэх хугацаа, сургуулийн асуулт бүрд оногдох цаг гэх мэтнөхцөлийн нэгдэл мөн хэмээн ойлгож болох юм.

### **Дүгнэлт**

1. Дэлхий дахинаа сургалтын талаарх шинжлэх ухаанч сэтгэлгээ XV зууны эхэн үеэс бүрэлдэн тогтсон бөгөөд тухайн үеийн Сэргэн мандалтын үеийн сурган хүмүүжүүлэгчид гэж нэрлэгддэг "...Витторин ба Фельтте, Франсуа Робле, Мишель Монтено, Эразм Раттердамский, Томас Мор нар номчирхохуй шашны сургаалын суртлын үндсийг халж, шашны бус утга зохиол судлуулахын чухлыг зааж эхэлсэн үеэс орчин үеийн боловсролын онол, шинжлэх ухаанч сургалтын технологийн хөгжлийн суурь тавигдсан хэмээн үзэж байна.

2. Олон улсын түвшинд хийгдэж байгаа сургалт, судалгааны ажлуудын үр дүнгээс харахад орчин үеийн мэдээлэл технологийн дэвшил төдийгүй нийгэм, эдийн засгийн байдал бүх шатны боловсролын үйлчилгээг цаашид цахимаар эсвэл танхим болон цахим хосолсон буюу холимог /blended/, хосолмол /hybrid/, тонгоруу /flipped/ гэх зэрэг сургалтын аль нэг хэлбэрт хурдацтай хөгжиж байгааг анхаарч хөл нийлүүлэн алхах шаардлага тулгарч байна.

3. Сургалт зохион байгуулах онол, үзэл баримтлал нь Боловсролын салбарын шинэчлэлийн үндэс суурь болж. Тэрхүү ажлын хүрээнд шийдвэрлэгдэж байгаа нэг чухал асуудал нь сургалтын технологийн бүтэц, мөн чанарыг нээн илэрхийлэх явдал гэж дүгнэж болохоор байна. Энэхүү технологи нь багш сургалтын зорилго, зорилтыг дэвшүүлэх, (сурагчид юу мэддэг чаддаг болохыг урьдчилан томъёолох); сурагчдын мэдлэг чадвар төлөвшилд өөрчлөлт хийх үйл ажиллагааг багш бэлдэж төлөвлөх, (сурагчдын сурах үйлдлүүдийн оночтой дэс дарааллыг тогтоох, эдгээрийг бүтээлчээр хэрэгжүүлэх, хяналт засвар залруулга хийх); сургалтын үр дүн, үнэлгээ,(сурагчдын мэдлэг чадвар төлөвшилд гарсан ахиц өөрчлөлтийг тогтоох тест, бие даасан ажил зэргийг бэлдэн хэрэглэх) гэсэн гурван үе шат бүхий үйл байна хэмээн үзэж болно.

### **Санал**

1. Сургалтын танин мэдэхүйн болон Конструктивизмын онол, Когнитивист онол зэрэг онол, үзэл баримтлалыг хөгжүүлэх сургалтын онол, үзэл баримтлалын ололттой талыг хууль сахиулах байгууллагын хүний нөөцийг бэлтгэж буй их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтанд нэвтрүүлэх;

2. Сургалтын онолын судалгааг олон талаас нь хийх, боловсролын суурь зарчимд түшиглэсэн туршилт сургалтууд хэрэгжүүлэх, судлагдахууны онцлогоос шалтгаалан сургалтын хэлбэрийг сонгох;

3. Суралцах үйл явц нь олж нээсэн мэдлэг, ойлголтоо дахин давтах хэлбэрээр дадал чадвар болгох урт удаан хугацааны үйл явц бөгөөд сурагчдад сэдэл тэмүүлэл төрүүлэх нь амжилттай суралцахын гол түлхүүр гэдэгтэй санал нийлж байгаа учир сургалтын онол, арга зүйлд тохирсон, сургалтын технологи боловсруулж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд уялдуулах, суралцагчдын сурах үйлд нь дэмжлэг үзүүлэх гэх мэт.

### **Ашигласан материал**

1. Батхуяг С, нар. Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй. УБИС. УБ., 2003.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам. Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр. Монгол хэл, уран зохиолын хичээлийн технологийн шинэчлэл. УБ., 2000.

3. Даваа Ж., Эрдэнэчимэг Ш нар. Дээд сургуулийн сургалтын технологи. Уб., 2016.
4. Сургалтын технологийн шинэчлэл. Эмхэтгэл. Уб., 1999.  
Цахим эх сурвалж
5. <http://mnutulgatan.blogspot.com/2015/04/3.html>.
6. <http://physicsdida.blogspot.com/p/resourse.html>.
7. <http://www.edub.edu.mn/v/>.
8. <https://ru.wikipedia.org/>.

# ЭРДЭМТЭН, СУДЛААЧИЙН БАЙР СУУРЬ

## МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### POLICY OF LEGAL REFORM IN MONGOLIA, IMPLEMENTATION AND RESULTS

Х.Батбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын  
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Монгол Улс дахь эрх зүйн шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилт, эрх зүйн хөгжлийн үе шат, үр дүн, эрх зүйн шинэчлэлийн талаарх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, сургамж, цаашид анхаарах асуудлын талаар дурдсан.

**Түлхүүр үг:** Эрх зүй, төр, эрх зүйн шинэтгэл, эрх зүйн шинэчлэл, төрийн бодлого, хууль тогтоомж, хууль тогтоох эрх бүхий байгууллага, хэрэгжилт.

**Abstract:** The policy of legal reform in Mongolia, its implementation, the stages and results of legal development, the implementation of policy documents on legal reform and issues to be considered in the future are mentioned.

**Keywords:** Law, state, legal reform, state policy, legislation, legislative authority, implementation.

1921 онд Ардын хувьсгал ялсны дараа хуучин төрийн хууль цаазыг хүчингүй болгох, хувьсгалт хууль цаазыг шинээр тогтоох ажлыг Ардын Засгийн газар эхлүүлж, улмаар 1926 онд Монголын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр анхлан зохицуулсан “Шүүх цаазын бичиг”, 1926 онд Монгол Улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх хууль, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль тус тус баталж, мөрдүүлсэн.

Улмаар нийгмийн харилцааг зохицуулах, гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил үргэлжлэн хийгдэж, 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүд, 1942, 1961, 1986 оны Эрүүгийн хуулиуд, 1935 оны БНМАУ-ын Аливаа хэргийг байцаан шийтгэх хууль, 1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиуд, 1952, 1963, 1994 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль батлагдсан. Эдгээр хуулиуд түүхэн үүргээ гүйцэтгэсэн болохыг түүх бэлхэнээ илтгэдэг.

1980-1990 онд дэлхийн социалист системийн дийлэнх улсад өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт, ил тод байдлын үзэл санааны нөлөө Монгол оронд нэвтэрч, 1990 оны эхээр манай улс улс төр, эдийн засгийн цоо шинэ тогтолцоонд шилжсэн билээ.

1990 оноос хойшхи Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийн хөгжлийн асуудлыг шинэ Монгол Улсын Үндсэн хууль батлагдах хүртэлх үе /1990-1992/, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэлх үе /1992-1998/, өнөө үе /1998 оноос хойш/ хэмээн үечлэн авч үзэж болно. Эдгээр зурвас үеүдэд Монгол Улсын эрх зүйн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн дараах үйл явц өрнөсөн юм.

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль батлагдах хүртэлх үе /1990-1992/

1990-1992 онд Монгол Улсад эрх зүйн сэтгэлгээ шинэ үзэл хандлага, үнэт зүйлээр баяжигдан нийгэмд зарчмын өөрчлөлтүүдийг бий болгосон. 1990 оны 3 дугаар сард 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр парламентат ёс, олон намын тогтолцооны үндсийг хүлээн зөвшөөрч, төвлөрсөн

төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих чиг баримжааг баталгаажуулснаар эрх зүйн сэтгэлгээний өөрчлөлт бодит зохицуулалт болох эхний алхам хийсэн байна.<sup>232</sup>

1992 онд “Ардчилсан” Үндсэн хууль баталж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон, хүний эрх, эрх чөлөөг улам бүр баталгаажуулсан билээ. Шинэ Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлагаар 1993 онд Эрүүгийн хууль, 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг–суурь нийгмийн харилцааг зохицуулсан хуулиудыг шинэчлэн баталсан.

Хоёр. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэлх үе /1992-1998/

1992-1998 онд төрийн эрх мэдлийг зөвхөн хуваарилан зааглах төдий биш зарчмын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрх хэмжээгээр дамжуулж нэг нь нөгөөдөө хяналт тавих замаар эрх мэдлийн тэнцвэржилтийг хангах үзэл онолыг хуульчилсан юм. Түүнчлэн, хүний эрхийг дээдлэх зарчмыг иш үндэс болгон олон улсын стандартад нийцүүлэх замаар Монгол Улсын иргэний эдлэх эрх, үүргийг хуульчлан баталгаажуулсан төдийгүй эрх зүйн сэтгэлгээний цар хүрээг тодорхойлох “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арванесдүгээр зүйлд хуульчилсан билээ. Мөн төрийн эрх мэдлийн хуваарилалтаар төрийн байгууллагууд үүрэг хүлээж байгаа нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийн тулд төрийн эрх мэдлийн хуваарилалт хийдэг ардчилсан зарчмын баталгаа болсон юм.

1998 он хүртэл төрийн байгуулал, батлан хамгаалах, гадаад харилцаа, төсөв, татвар, гааль, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, газар, байгаль орчин, аж ахуйн үйл ажиллагаа, дэд бүтэц зэрэг нийгмийн гол харилцааг зохицуулсан 180 гаруй хуулийг УИХ-аас батлан гаргасан байна.<sup>233</sup> Хууль тогтоомжийн энэхүү шинэтгэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн зарчимд тулгуурлан яаралтай хийж, хэрэгжүүлэх шаардлагатай ажлын эхлэл байсан юм. Эдгээр арга хэмжээний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуульд нэр заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиас бусад олон хуулийг баталж, өмнө нь батлагдсан хууль, байгуулагдсан олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөх ажлыг эхлүүлсэн.

1992-1997 онд Монгол Улсын эдийн засгийн харилцааг зохицуулахад шаардлагатай хууль тогтоомжийн шинэтгэл эрчимтэй хийгдсэн ба үүнийг эрдэмтэн, судлаачид хууль тогтоомжийн шинэчлэлийн өрнөлтийн үе гэж тодорхойлсон байдаг.

Гурав. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдснаас хойш буюу өнөө үе /1998 оноос одоог хүртэл/

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрдэж эхэлсэн боловч эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэмд шинээр үүсч буй харилцааг хуульчлан зохицуулах, тэдгээрийг олон улсын жишиг, загварт нийцүүлэх, хуулийг дээдлэх, хүндэтгэн хэрэгжүүлэх

<sup>232</sup> “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011. 20 дахь тал

<sup>233</sup> “Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил” илтгэл болон зөвлөмжүүдийн эмхэтгэл. УБ., 2003. 86 дахь тал

нийгмийн ухамсарыг төлөвшүүлэх шаардлага байсаар байсан. Иймд эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, төлөвлөгөө тогтоох зорилгоор УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан.

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт эрх зүйн шинэчлэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэл<sup>234</sup>-ийн нийт 56 зорилтот арга хэмжээг төлөвлөсөн. Уг хөтөлбөрт “Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан ташаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршино” гэж заасан.

УИХ-аас хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг тодорхой хугацаатайгаар төлөвлөн зохион байгуулах үүднээс “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д нийцүүлэн “Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2001 оны 44, 2005 оны 26, 2009 оны 38 дугаар тогтоолыг тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байв. Харин 2013 онд “Хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн төслийг Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн барьсан боловч улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан батлах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд энэ хугацаанд эрх зүйн шинэчлэлийн үзэл баримтлалгүйгээр хууль тогтоомжийг шинэчлэх, өөрчлөх ажил хийгдсэн гэж хэлж болно.

Энэхүү байдлыг дахин үүсгэхгүй байх үүднээс Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл боловсруулах асуудлыг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд улам өргөжүүлэн томьёолж, хууль тогтоомж боловсруулах ажлын төлөвлөгөөг Үндсэн чиглэлд тусгах, Үндсэн чиглэлийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх суурь зарчмыг тодорхойлсон юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдээс гадна “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”<sup>235</sup>, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”<sup>236</sup>, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”<sup>237</sup>, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”<sup>238</sup> зэрэг бодлогын баримт бичиг, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлснээр “Эрх зүйн шинэтгэлийн

---

<sup>234</sup> Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх, Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх; Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох; Олон Улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх.

<sup>235</sup> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсон.

<sup>236</sup> УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан.

<sup>237</sup> УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан.

<sup>238</sup> УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан.

хөтөлбөр”<sup>239</sup>-т дэвшүүлсэн зорилтот арга хэмжээнүүд тодорхой хэмжээгээр хэрэгжиж ирсэн.

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ тусгайлан хийх шаардлагыг харгалзан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 36 дугаар тушаалаар “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж”, “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын ерөнхий график”-ийг баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тушаалаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг, 8 дэд хэсгийг байгуулан ажиллуулж<sup>240</sup> “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 он хүртэлх хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан”-г гаргасан.

Энэхүү тайлангаас үзэхэд, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” үндсэндээ хэрэгжиж, эрх зүйн шинэтгэлийн зорилт хууль тогтоомжийн түвшинд биелэгдсэн байна. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрэлджээ. Харин хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн эрх зүйн ухамсарыг бүрдүүлэх зорилт зохих хэмжээнд хангагдаагүй байна гэж дүгнэсэн байна.

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн эхний 10 жилийн хэрэгжилтэд 2008 онд дүн шинжилгээ хийснээс хойш хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар тусгайлсан судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх ажил зохион байгуулаагүй. Зөвхөн хөтөлбөрт тусгагдсан хуулиуд батлагдсан эсэхийг хянаж, эдгээр хуулийн жагсаалтыг шинэчлэх асуудлыг голлон анхаарч ирсэн. Харин 2017 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааг хийж, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгааны тайланд:

- “...Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд хийсэн үнэлгээний тайлангийн Эрх зүйн шинэтгэлийн дараагийн шатны хөтөлбөр боловсруулж мөрдөх ерөнхий санал, зөвлөмжийг өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй;
- Эрх зүйн шинэтгэлийн дараагийн шатны хөтөлбөр батлагдаагүй ч шинэ хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэхийг санал болгож зөвлөсөн 5 зорилт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж зохих хэмжээнд хэрэгжиж ирсэн байна;
- Шинээр батлах хөтөлбөрт тусгахыг зөвлөсөн зорилтуудын хэрэгжилтэд дүгнэлт хийхэд зарим зорилт харьцангуй сайн хэрэгжиж байгаа /тухайлбал, “Хууль нийтээр дагаж мөрдөх журам агуулсан эрх зүйн хэм хэмжээний актын төслийг боловсруулах, хянах, батлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагааг шинэчлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгадаг болох” тухай зөвлөмж/, зарим зорилтод дэвшүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг үргэлжлүүлж эцсийн үр дүнг үзэлгүй орхисон /тухайлбал, “Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хуулийн агуулга, эх бичвэр, хууль зүйн нэр томъёог дахин хянан нягталж, сайжруулах арга хэмжээг тодорхой үе шат

<sup>239</sup> УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан.

<sup>240</sup> Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2008. 6 дахь тал

төлөвлөгөөтэйгээр ойрын 3 жилд авч хэрэгжүүлэх” тухай зөвлөмж/, зарим зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, богино хугацаанд өөрчлөгдөх /тухайлбал, ...хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог дахин хянаж өөрчлөх” тухай зөвлөмж/, зарим зорилтыг тухайлсан хөтөлбөрийн дагуу цогц байдлаар хэрэгжүүлсэн боловч асуудалд судалгаа, тооцоотой хандах байдал бүрэн хангагдаагүйгээс хэрэгжилтэд хүндрэл, бэрхшээл үүсэх /тухайлбал, “Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын чадавх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай зөвлөмж/ зэрэг байдал ажиглагдаж байна. Энэ нь эрх зүйн шинэчлэлийн асуудалд системтэй, нэгдсэн бодлого, залгамж чанар, хариуцлагатай хандах хандлага хэрэгцээ, шаардлагатай байгааг илэрхийлнэ” гэж дүгнэсэн байна.

Ийнхүү эрх зүйн шинэчлэлийн нэг хэсэг болох хууль тогтоомжийн шинэчлэл нь 1990-1992 онд буюу Монгол Улсын Үндсэн хууль батлах хүртэл шилжилтийн үеийн нэн шаардлагатай хууль тогтоомжийг батлах, 1992-1998 онд Үндсэн хуулийн хавсралт хуульд заасны дагуу, 1998 оноос “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн дагуу хэрэгжиж иржээ.<sup>241</sup>

Одоо зарим хүрээний эрх зүйн шинэчлэл, түүний үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар товч дурдъя.

#### **Захиргааны эрх зүйн шинэчлэл, үр дүн, анхаарах асуудал:**

Төвлөрсөн эдийн засгийн харилцаанд оролцогч захиргаа өөрийн үйл ажиллагаа, түүний арга, хэлбэрийг зах зээлийн эдийн харилцаанд оролцохдоо өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу захиргаа нь үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх зарчмыг ягштал баримтлан ажиллах шаардлага одоо ч ач холбогдолтой байсаар байна. Эдгээр шаардлага захиргааны эрх зүйн шинэтгэлийн суурь үндэс болсон.<sup>242</sup>

2000 оны эхэн үеэс эхэлсэн захиргааны эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн тэсрэлтийн үндсэн дээр батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль захиргааны эрх зүйн шинэтгэлийн бааз суурь болж байна. Энэ хуулиар “Захиргааны байгууллага”, “Захиргааны акт” хэмээх суурь ойлголтуудыг шинэчлэн зохицуулж, нийгмийн амьдралд хэвшүүлсээр ирлээ. Өөрөөр хэлбэл, эрх зүйн болон оюун санааны хүрээнд эдгээрийн талаар нэгдмэл ойлголт бий болсон нь нэгэн эерэг үр дүн мөн.

2008 оноос хойшхи шинэтгэлийн гол баримт бичиг нь Захиргааны ерөнхий хууль мөн боловч анхаарал татсан асуудал байсаар байна.

Захиргааны байгууллагын тогтолцоог тодорхойлох хууль тогтоомжийн шинэтгэл удаашралтай явагдаж байна. Үүнд: Засгийн газрын тухай /1993 он/, Яамны эрх зүйн байдлын тухай /1996 он/, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай /1996 он/, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006 он/ зэрэг хуульд зарчмын шинэтгэл, өөрчлөлт ороогүйгээс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо ямар зарчим, үзэл санаанд тулгуурлан хөгжиж байгаа нь тодорхойгүй болж

<sup>241</sup> “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011. 7 дахь тал

<sup>242</sup> Хууль зүй үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. УБ., 2017. 90 дахь тал

байна.<sup>243</sup> Энэ байдал нь тодорхой салбар, хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг тодорхой байгууллагын эрх зүйн зохицуулалтад сөргөөр нөлөөлж байна. Захиргааны байгууллагын тогтолцооны эрх зүйн зохицуулалтын асуудал нь эрдэмтэн, судлаачдын анхаарлыг төдийлөн татахгүй байгаа нь практикт эрх зүйн зохицуулалт сул байхад зохих ёсоор нөлөөлж байна.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ажиллагсад төрийн чиг үүргийг хэрэгжүүлж, бусдыг засаглан захирах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд төрийн жинхэнэ алба хаагчид билээ. Төрийн жинхэнэ албан хаагч захиргааны шийдвэр гаргахад оролцогчийнхоо хувьд захиргааны эрх зүйн харилцааны голлогч субъект юм. Түүний эрх зүйн байдал, үйлдлийг тодорхойлогч хууль-Төрийн албаны тухай хуулийг 2002 онд баталж, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 онд шинэчилсэн найруулсан гэж байгаа боловч дараах асуудал нааштай шийдэгдэхгүйгээр өнөөг хүрлээ. Үүнд: 1/Төрийн албан хаагчийн эрх зүй, эдийн засгийн баталгаа, 2/Төрийн албан хаагчид хүлээлгэх хууль зүйн болон эдийн засгийн хариуцлагын асуудлыг дурдаж болно.

2008 оноос хойш захиргааны эрх зүйн шинжлэх ухаанд гарсан том дэвшил бол Захиргааны ерөнхий хууль батлагдсан явдал юм. Цаашид уг хуулийг суурь үндэс болгон эрх зүйн системчлэл, эрх зүйн ухамсар төлөвшүүлэх алхмыг хийх шаардлагатай гэж үзэж байна.

#### **Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудал:**

2008-2012, 2012-2016 онд хийгдсэн эрх зүйн шинэтгэл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, түүний дотор эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, чиг хандлагын талаар товч авч үзье.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдсан Эрүүгийн хууль /2015/, Зөрчлийн тухай хууль /2017/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /2017/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017/, Прокурорын тухай /2017/, Цагдаагийн албаны тухай /2017/ хуулийг эцэслэн баталж чадсан нь сүүлийн 15 жилд хийгдээгүй томоохон шинэчлэл болж чадсан.<sup>244</sup>

УИХ-аас шинээр болон шинэчлэн баталсан хуулиуд эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө хангах, шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх дэвшилттэй зохицуулалт цөөнгүй тусгагдсан хэдий ч хэрэгжүүлж эхэлсэн 11 сарын хугацаанд хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэхэд ойлгомжгүй, хийдэлтэй, давхардсан зохицуулалт цөөнгүй байгаа болох эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд, эрүүгийн эрх зүйн шинэчлэл бодлогын судалгаанд үндэслээгүй хийгдсэн төдийгүй, төрөөс баримтлах эрүүгийн эрх зүйн нэгдсэн бодлого байхгүй байгааг харуулж байна. Тухайлбал, 2012 онд Хууль зүйн сайдын тушаалаар Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж байсан бол уг Эрүүгийн хуулийн төсөл 2 Улсын Их Хурал, 3 Засгийн газар дамжиж, УИХ-д 3 удаа өргөн баригдаж, 2 удаа буцаагдсаны эцэст УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс

<sup>243</sup> “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, УБ., 2011, 316 дахь тал

<sup>244</sup> “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”. Монголын криминологичдын холбоо. УБ., 2017. 33 дахь тал

хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна. Эрүүгийн хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлж, батлуулах явцад төрийн эрх барих улс төрийн хүчнээс өөрсдийн эрх ашгийг хамгаалсан шинжтэй зохицуулалтыг ихээр тусгасан нь эрх зүйн шинэтгэлийн нэгдсэн бодлого байхгүй байгааг харуулахын зэрэгцээ цаашид гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг боловсруулж, тогтвортой баримтлах, эрх зүйн уламжлал, шинэчлэлийг хослуулах нь шаардлагатай болохыг илтгэж байна.

### **Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудал:**

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тогтоох үндэс суурь билээ. Шүүх бие даасан, шүүгч хараат бус байх нь иргэний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хүчирхэг механизм, шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа мөн. Тийм учраас бие даасан хараат бус шүүхийг тогтоох нь эрх зүйт төрийн нэг гол зорилт, шалгуур болдог.<sup>245</sup>

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдснаас хойш шүүхийг шинэ Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлэн байгуулах, шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлж, төлөвшүүлэх талаар хэд хэдэн шинэтгэл хийсэн.

Уг шинэтгэлээр хийгдсэн ажлуудыг он дарааллаар нь судлан дүгнэлт хийвэл дараах үечлэлд хуваан авч үзэж болно. Үүнд:

- 1993-2002 он шилжилтийн үеийн шүүхийн шинэтгэл;
- 2002-2012 он шилжилтийн дараах үеийн шүүхийн шинэтгэл;
- 2012 онд Шүүхийн багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойших үе.

2012 онд Шүүхийн тухай багц хуулиуд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш хийгдсэн шинэтгэлийг дараах зургаан үндсэн дэд хэсгүүдэд хуваан авч үзэж үзэж болно. 1/Шүүхийн тогтолцоо 2/Шүүхийн бие даасан байдал, 3/Шүүгчийн хараат бус байдал, 4/Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт, 5/Шүүхийн ил тод, нээлттэй байдал, 6/Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллага.

Дээрх дэд хэсгүүдийн шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс санаачлан боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар зөвлөмж болгосон “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан 2014-2020 онд Шүүхийн хөгжлийн стратегийг 5 дэд хөтөлбөрт заагдсан үзүүлэлтэд тулгуурласан.<sup>246</sup>

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг болох шүүхийн тогтолцооны өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийхэд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр буюу шүүхийг дагнан байгуулснаар шүүгч илүү мэргэшэх, энэ нь шүүхийн шийдвэрийн чанарт нөлөөлж, улмаар ажлын ачаалал буурах эерэг үзүүлэлттэй судалгааны дүн гарсан боловч хууль санаачлагчийн зүгээс шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдлийг гаргахдаа хууль, тогтоомжийн онолын буюу суурь судалгаа хангалттай хийгээгүй, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг хийгээгүйгээс шалтгаалан шүүхийн шинэтгэлийн томоохон ажлуудын нэг болох шүүхийн дагнасан тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл учирсан. Иймд аливаа шинэтгэл, хууль тогтоомжийг батлахдаа хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг сайтар хийх нэгдмэл ойлголттой байх шаардлага шүүхийн салбарт мөн тулгарч байна.

<sup>245</sup> Кристофер Осаевь. “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги”. Орч.Ж.Нямдорж, Л.Намхай, Л.Ундрах. УБ, 2005. 54 дэх тал

<sup>246</sup> Хууль зүй үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. УБ., 2017. 101 дэх тал

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тогтмол шүүмж дагуулж байдаг асуудал нь шүүхийн ил тод, нээлттэй байдлын тухай асуудал байсаар байна. “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь дэвшилттэй алхам болжээ. Иймд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг цаашид гүнзгийрүүлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, судалгааны эргэлтэнд оруулах нь эрх зүйн шинэтгэлийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой.

Шүүхийн шинэтгэлтэй холбоотойгоор бусад байгууллагууд ч шинэтгэл хийгдэж байна.

### **Дүгнэлт**

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Хүний эрхийг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт, эрх зүйн шинэчлэлийн байдлаас үзэхэд, эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн бодлогогүй, 4 жил тутам сонгуулийн үр дүнгээр олонх болсон улс төрийн нам, эвслийн үзэмжээр эрх зүйн шинэчлэл хийгдэж, эрх зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

1990 оноос хойш эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг боловсруулан УИХ-аар батлуулан мөрдөж ирсэн уламжлал 2012-2016 онд улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан тасарсан нь эрх зүйн шинэтгэлийн нэгдсэн бодлого алдагдахад хүргэсэн гэж үзэж болохоор байна.

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд дүн шинжилгээ хийснээс хойш шинээр эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, хэрэгжүүлэлгүй өдийг хүртэл явж ирсэн нь учир дутагдалтай байна.

Монгол Улс 2200 гаруй жилийн төрт ёс, хууль цаазын баялаг уламжлалтай улс хэдий ч уламжлалаа огт харгалзахгүй, судлахгүй, залгамжлуулан авч явалгүй, түүнийг үгүйсгэх хандлага газар авч, гадаадын улсуудын эрх зүйн зохицуулалт, туршлагыг нэвтрүүлэх нэрээр үндэсний онцлог, ахуй, амьдралын хэв маяг, ёс заншил, зан суртахуунд нийцээгүй гадаадын улсуудын хууль тогтоомжийг орчуулан баталж, хэрэгжүүлэхээр оролдож байгаагаас хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Нийтийн ашиг сонирхлыг бус, хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль тогтоомжийг хууль тогтоох дээд байгууллагаас баталж байгаа нь иргэдийн төрд итгэх итгэл, хууль дээдлэх ёс, шударга ёсны тогтолцоог гажуудуулахад хүргэж байна. Тухайлбал, Өршөөлийн тухай хуулийг баталж, авлига, албан тушаал, эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль батлах замаар их хэмжээний татвар, хөрөнгөө нуусан аж ахуйн нэгж, иргэдийг өршөөх, стратегийн зарим ордыг ашиглах, хөрөнгө оруулах асуудалд нийтийн ашиг сонирхлыг харгалзалгүй, хэсэг бүлэг, хөрөнгө оруулагчийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргасан зэргийг дурдаж болно.

Эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн бодлогогүйн улмаас хууль тогтоомжийн болон хуулийн байгууллагын шинэчлэлийг судалгаанд үндэслэлгүй “таамгаар”, УИХ, Засгийн газрын гишүүний хувийн бодол, үзэмжээр хийж, түүнийг дагаад шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд бүтэц, тогтолцоо, чиг үүрэг өөрчлөгдөж, улмаар үйл ажиллагаанд саад учруулж байна. Тухайлбал, Дотоодын цэргийг татан буулгаж, буцаан байгуулсан, Тахарын албыг шинээр байгуулж, татан

буулгасан, Шилжилт хөдөлгөөний ерөнхий газрыг байгуулж, хил хамгаалах байгууллагад буцаан нэгтгэсэн г.м

Монгол төрийн залгамж чанар байхгүй, өмнөх УИХ, Засгийн газрын ажил, эхлүүлсэн, хэрэгжүүлсэн эрх зүйн шинэчлэлийг улс төрийн өршөө авах, эсрэг намыг “харлуулах” зорилгоор дараагийн УИХ, Засгийн газар үгүйсгэж, гацааж, үгүй хийх байдал түгээмэл болсон.

Захиргааны эрх зүй, эрүүгийн эрх зүй, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн шинэтгэл нь ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсыг тогтооход чиглэгдсэн чухал алхам болсон хэдий ч цаашид улам боловсронгуй болгох олон асуудал байсаар байна. Эрх зүйн шинэтгэлийн үр дүн нь хамгийн багадаа 12 жилийн тогтвортой бодлогын үр нөлөөгөөр илэрдэг болох нь эрдэмтэн, судлаачдын бүтээл, өндөр хөгжилтэй улсуудын туршлагаас харагддаг.

### **Санал**

1. Монгол Улсын Их Хурлаас “Эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн хөтөлбөр 2020-2032” бодлогын баримт бичиг баталж, хэрэгжүүлэх;
2. Хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах нэгдсэн судалгааг гүйцэтгэж, хууль санаачлах эрх бүхий субъектүүдэд хүргүүлэх, хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
3. Хуулийн төсөл боловсруулах мэргэшсэн чиг үүрэг бүхий Хууль зүйн хороо байгуулах;
4. Эрх зүйн шинэчлэл хийхдээ хууль цаазын уламжлалдаа тулгуурлан өндөр хөгжилтэй гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, өөрийн улсын онцлогт тохируулан нэвтрүүлэх;
5. Нийтийн ашиг сонирхлыг бус, хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль тогтоомжийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас батлах явдлыг таслан зогсоох, төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх;
6. Шүүхийн ил тод, нээлттэй, бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг шударга, ил тод болгох, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах;
7. Эрх зүйн шинэчлэлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын сэтгэлгээ, хандлагын шинэчлэлийг хууль тогтоомжийн шинэчлэлтэй хамтад нь хийх.

### **Ашигласан материал**

Нэг.Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012. №11
- Прокурорын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24
- Цагдаагийн албаны тухай // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №8
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24

- Шүүхийн шинжилгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2010. №2
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012. №11

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл

- “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”. Монголын криминологичдын холбоо. УБ., 2017
- Кристофер Осаевь. “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги”. Орч.Ж.Нямдорж, Л.Намхай, Л.Ундрах. УБ, 2005
- “Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил” илтгэл болон зөвлөмжүүдийн эмхэтгэл. УБ., 2003
- “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011
- Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2008
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. Хууль зүй үндэсний хүрээлэн. УБ., 2017